МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМ

ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛЬ

МОНГОЛ УЛС ДАХЬ ХУВИЙН ЭРХ ЗҮЙН ШИНЭТГЭЛИЙН ЯВЦ, ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ

ОЛОН УЛСЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРЛЫН ЭМХЭТГЭЛ

Улаанбаатар хот
2021 он

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

MINISTRY OF JUSTICE AND HOME AFFAIRS

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМ

UNIVERSITY OF INTERNAL AFFAIRS

MONGOLIA: THE PROCESS OF PRIVATE LAW REFORM AND ITS CHALLENGES

International Conference

Ulaanbaatar
2021

Хянасан: Хууль зүй, дотоод хэргийн яамны Олон улсын гэрээ, хамтын ажиллагааны газрын дарга Т.Бат-Өлзий
Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээ эрхэлсэн дэд захирал, хууль зүйн доктор, дэд профессор, цагдаагийн хурандаа О.Зоригт

Эмхэтгэсэн: Хууль зүйн доктор, дэд профессор Б.Мөнхдорж
Хууль зүйн докторант Э.Дашгаадан
Орчуулга хянасан: Хууль зүйн доктор, дэд профессор Ш.Чулуунбат

Цаасны хэмжээ: B5 (176x250)

Хэвлэсэн он, сар: 2022.03.10
Хэвлэсэн тоо: 300

Хэвлэлийн эхийг “Мөнхийн үсэг” ХХК-д бэлтгэж хэвлэв.

АГУУЛГА

ӨМНӨХ ҮГ 14

Монгол Улсын Их Хурал, Засгийн газрын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатарын хурлыг нээж хэлсэн үг 16

Монгол Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүйн байнгын хорооны дарга С.Бямбацогтын хурлын нээлтэд хэлсэн үг 19

ИЛТГЭЛҮҮД

МОНГОЛ УЛС ДАХЬ ХУВИЙН ЭРХ ЗҮЙН ШИНЭТГЭЛ: СОРИЛТ БА БОЛОМЖ 24
Хишгээгийн Нямбаатар
Монгол Улсын Их Хурал, Засгийн газрын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд

ОЛОН УЛСЫН ХУВИЙН ЭРХ ЗҮЙН ГААГИЙН БАГА ХУРЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА: МОНГОЛ УЛСАД ХАМААРАХ АСУУДАЛ 36
Броди Варрен
Олон улсын хувийн эрх зүйн Гаагийн бага хурлын Ерөнхий нарийн бичгийн даргын атташе бөгөөд Нарийн бичгийн дарга нарын газрын хуулийн ахлах ажилтан

МОНГОЛ УЛС ДАХЬ ХУВИЙН ЭРХ ЗҮЙН СУДАЛГАА БА ЭРХ ЗҮЙН ДИНАМИК: ЧИГ ХАНДЛАГЫГ ТОДОРХОЙЛОХ НЬ 54
Батболдын Амарсанаа
Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургуулийн захирал, хууль зүйн доктор, профессор

ХУВИЙН ЭРХ ЗҮЙН ШИНЭТГЭЛ БА ИРГЭНИЙ ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА 68
Пунцагийн Золзаяа
Улсын Дээд шүүхийн шүүгч

БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛСАД ДИЖИТАЛ ХЭЛБЭРЭЭР ШҮҮХЭД МАРГААН ШИЙДВЭРЛЭЖ БУЙ АСУУДАЛ 77
Пак Жон Вон
Бүгд Найрамдах Солонгос Улсын Күүкминий Их Сургуулийн Хууль зүйн сургуулийн профессор, хууль зүйн доктор

БҮГД НАЙРАМДАХ КАЗАХСТАН УЛСЫН ИРГЭНИЙ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ШИНЭЧЛЭЛ: ӨНӨӨГИЙН БАЙДАЛ БА ХӨГЖЛИЙН ЧИГ ХАНДЛАГА 86
Горячева Елена Васильевна
Бүгд Найрамдах Казахстан Улсын Хууль тогтоомж, эрх зүйн мэдээллийн институтын тэргүүлэх судлаач, доктор

МОНГОЛ УЛСЫН ЭРХ ЗҮЙН ТОГТОЛЦООНЫ БҮХЭЛЛЭГ (НЭГДМЭЛ) БАЙДЛЫГ ХАНГАХ НЬ 99
Содовсүрэнгийн Нарангэрэл
Хууль зүй, дотоод хэргийн сайдын зөвлөх, Монгол Улсын Төрийн шагналт, Шинжлэх ухааны гавъяат зүтгэлтэн, Академич, Монгол Улсын Их Сургуулийн Эмерит профессор

МОНГОЛ УЛС ДАХЬ ОЛОН УЛСЫН ХУВИЙН ЭРХ ЗҮЙН ХӨГЖИЛ, БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ АСУУДАЛ 117
Энх-Амгалангийн Байгал
Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургуулийн дэд профессор, хууль зүйн доктор

ОРОСЫН ХОЛБООНЫ УЛС ДАХЬ НИЙГЭМД ТУСТАЙ АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭЛТ БА ХУВИЙН ЭРХ ЗҮЙН ШИНЭТГЭЛ 131
Ульяна Борисовна Филатова
Оросын Холбооны Улсын Эрхүүгийн Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургуулийн профессор, хууль зүйн доктор

ЯПОН УЛСЫН АРИЛЖААНЫ ЭРХ ЗҮЙН ХӨГЖИЛ, ТҮҮНИЙ БАЙР СУУРЬ БА ОНОЛЫН ЗАРИМ АСУУДАЛ 140
Токүмото Минору
Япон Улсын Кюшүгийн Их Сургуулийн Хуулийн сургуулийн дэд захирал, профессор, хууль зүйн доктор

ОЛОН УЛСЫН ХУДАЛДААНЫ ЭРХ ЗҮЙН КОМИСС БОЛОН ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ УЯЛДУУЛАХЫН АШИГ ТУС 152
Атида Коминдр
Нэгдсэн Үндэстний Байгууллагын Олон улсын худалдааны эрх зүйн комиссын Ази Номхон далайн бүсийн төвийн дарга

ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭР, АЖ АХУЙН НЭГЖҮҮДИЙН ТӨЛБӨРИЙН ЧАДВАРГҮЙ БАЙДАЛД ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ТАЛААР ӨГӨХ ЗӨВЛӨМЖҮҮД 161
Ли Янг Ин
Нэгдсэн Үндэстний Байгууллагын Олон улсын худалдааны эрх зүйн комиссын хуульч

ХЯЛБАРШУУЛСАН АРБИТРЫН ТАЛААРХ ЗОХИЦУУЛАЛТ 169
Ли Жай Сүн
Нэгдсэн Үндэстний Байгууллагын Олон улсын худалдааны эрх зүйн комиссын хуульч

ШҮҮХИЙН ЦАХИМЖУУЛАЛТ 175
Эрик Хилгендорф
Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Вюрцбург хотын Юлиус-Максимилианы Их Сургуулийн профессор, философийн доктор, хууль зүйн доктор

ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙН МАРГААНЫГ ЗАЛИЛАХ ГЭМТ ХЭРГЭЭС ЯЛГАН ЗҮЙЛЧЛЭХ АСУУДАЛД 185
Ш.Ариунбилэг
Дотоод хэргийн их сургуулийн Эрх зүй, нийгмийн ухааны сургуулийн Хувийн эрх зүйн тэнхимийн эрхлэгч, хууль зүйн доктор, дэд профессор, цагдаагийн хурандаа
Г.Батжаргал
Дотоод хэргийн их сургуулийн хувийн эрх зүйн тэнхимийн багш, докторант, цагдаагийн хошууч

ИРГЭНИЙ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ХУУЛИЙГ ШИНЭЧЛЭХ ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА 201
С.Энхбаяр
Санхүү эдийн засгийн их сургуулийн ахлах багш, хууль зүйн доктор, дэд профессор

ШҮҮХИЙН ШИНЭТГЭЛ БА ХУВИЙН ЭРХ ЗҮЙ: ХУУЛЬ ХЭРЭГЛЭЭНИЙ НЭГДМЭЛ БАЙДЛЫГ ХАНГАХАД УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ГҮЙЦЭТГЭХ ЧИГ ҮҮРЭГ, ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ 211
Н.Норовсамбуу
Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургуулийн Хувийн эрх зүйн тэнхимийн багш

ХҮҮХДИЙН ЭД ХӨРӨНГИЙН ЭРХ 233
О.Отгонтуяа
Дотоод хэргийн их сургуулийн Эрх зүй, нийгмийн ухааны сургуулийн Хувийн эрх зүйн тэнхимийн ахлах багш, цагдаагийн хошууч

ЦАХИМ ШИЛЖИЛТ: АЖ ҮЙЛДВЭРЖСЭНИЙ ДАРААХ НИЙГЭМ-СОЁЛ, ЭРХ ЗҮЙН ӨӨРЧЛӨЛТ 237
Ц.Батбаяр
Дотоод хэргийн их сургуулийн Эрх зүй, нийгмийн ухааны сургуулийн Нийгмийн ухааны тэнхимийн эрхлэгч, доктор, дэд профессор, дэд хурандаа

237МОНГОЛ УЛС ДАХЬ ХЭРЭГ, МАРГААНЫ УЛМААС ХОХИРСОН ИРГЭНИЙ ЭРҮҮЛ МЭНД, АМЬ НАС, СЭТГЭЛ САНААНЫ ХОХИРЛЫГ ТООЦОХ ЭРХ ЗҮЙН ШИНЭТГЭЛИЙН АСУУДАЛ 249
Ч.Отгонсүрэн
Дотоод хэргийн их сургуулийн Хилийн албаны сургуулийн ахлах багш, докторант, дэд хурандаа

ЭВЛЭРҮҮЛЭН ЗУУЧЛАХ АЖИЛЛАГААНЫ ХӨГЖЛИЙН ОРЧИН ҮЕИЙН ЧИГ ХАНДЛАГА 259
Ч.Мягмарбаяр
Хил хамгаалах ерөнхий газрын Хууль, эрх зүйн хэлтсийн хуулийн зөвлөх, дэд хурандаа
Ж.Уганчимэг
Дотоод хэргийн их сургуулийн Эрх зүй, нийгмийн ухааны сургуулийн Хувийн эрх зүйн тэнхимийн дэд профессор, ахмад

259МОНГОЛ УЛС ДАХЬ МӨНГӨН ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ 273
П.Долгормаа
Их Засаг Олон Улсын их сургуулийн Хууль зүйн сургуулийн ахлах багш
Б.Нацагдорж
Их Засаг Олон Улсын их сургуулийн Хууль зүйн сургуулийн Хууль зүйн сургуулийн багш, доктор, дэд профессор

МОНГОЛ ДАХЬ ИРГЭНИЙ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН КОДЧИЛОЛ 286
Б.Намсрай
Унгар Улсын Печийн их сургуулийн докторант

ГЭР БҮЛИЙН НАСАНД ХҮРЭЭГҮЙ ХҮНИЙ ЭД ХӨРӨНГИЙН ЭРХ: ОНОЛ, ПРАКТИК 308
Д.Батчимэг
Дотоод хэргийн их сургуулийн магистрант

ХАРЬЯАЛЛЫН АСУУДЛААР ТАТГАЛЗАХ БОЛОМЖУУД 317
Майкл Нолан
Камил Айтелаж
Милбанк хуулийн фирмийн хуульч

ОРОСЫН ХОЛБООНЫ УЛСАД ГЭР БҮЛИЙН ИНСТИТУТИЙГ ХАМГААЛАХ АСУУДАЛ 330
Андреев А.В.
Оросын Холбооны Улсын Дотоод хэргийн яамны харьяа Уралын хуулийн дээд сургуулийн иргэний эрх зүйн тэнхимийн эрхлэгч, хууль зүйн доктор

ГЭЭГДМЭЛ ЭД ХӨРӨНГӨ ЗАВШИХ ХУУЛИЙН ЗҮЙЛЧЛЭЛИЙН ЗАРИМ АСУУДАЛ 336
Рахимов Эльдар Харисович
Оросын Холбооны Улсын Дотоод хэргийн яамны харьяа Уфагийн хуулийн дээд сургуулийн Иргэний эрх зүйн тэнхимийн эрхлэгч, хууль зүйн доктор, дэд профессор

ОЛОН УЛСЫН ХУВИЙН ЭРХ ЗҮЙ ДЭХ ХӨДӨЛМӨРИЙН ХАРИЛЦААНЫ ОНЦЛОГ 341
Кадыркулов Мухамеджан Тынысбаевич
Оросын Холбооны Улсын Дотоод хэргийн яамны харьяа Сибирийн хуулийн дээд сургуулийн сонсогч
Ермолаева Маргарита Игоревна
Оросын Холбооны Улсын Дотоод хэргийн яамны Сибирийн хуулийн дээд сургуулийн Иргэний эрх зүй, иргэний хэрэг хянан шийдвэрлэх эрх зүйн тэнхимийн багш

НИЙГЭМ, ЭРХ ЗҮЙН КОМПАНИЙ ӨМЧ БИЙ БОЛОХ ЭХ СУРВАЛЖИЙН ТУХАЙ АСУУДАЛ 346
Федорова Екатерина Анатольевна
Оросын Холбооны Улсын Эрхүүгийн Улсын их сургуулийн докторант

МОНГОЛ УЛС БОЛОН ОРОСЫН ХОЛБООНЫ УЛСЫН ДИЖИТАЛ /ЦАХИМ/ ЭРХ ЗҮЙН ХАРИЛЦААНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ОНЦЛОГУУД 352
Ксения Юрьевна Филипсон
Оросын Холбооны Улсын Дотоод хэргийн яамны харьяа Сибирийн хуулийн дээд сургуулийн Иргэний эрх зүй ба процессын тэнхимийн ахлах багш, цагдаагийн ахмад
Мөнхболдын Мөнхсүлд
Оросын Холбооны Улсын Дотоод хэргийн яамны харьяа Сибирийн хуулийн дээд сургуулийн оюутан

ОРОСЫН ХОЛБООНЫ УЛСЫН ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙ ДЭХ АРИЛЖААНЫ БАЙГУУЛЛАГЫГ ТАТАН БУУЛГАХАД ШҮҮХИЙН ОРОЛЦООНЫ ЗАРИМ АСУУДАЛ 359
Людмила Александровна Варнакова
Оросын Холбооны Улсын Эрхүүгийн улсын их сургуулийн Хууль зүйн сургуулийн докторант

ЭРХ ЗҮЙН ЧАДАМЖГҮЙ БОЛОН ХЯЗГААРЛАГДМАЛ ЧАДАМЖТАЙ ЭТГЭЭДИЙГ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХ НЬ: ЭРХ ЗҮЙН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА 368
Белозерцева Виктория Владимировна
Оросын Холбооны Улсын дотоод хэргийн яамны харьяа Дорнод Сибирийн институтын Иргэний эрх зүйн тэнхимийн эрхлэгч, доктор, профессор

ВЬЕТНАМ УЛСЫН ШҮҮХИЙН ШИНЭТГЭЛИЙН ОРЧИН ДАХЬ ПРЕЦЕТЕНТИЙН ХӨГЖИЛ 381
Нгуен Ван Нам
Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсын Ардын аюулгүй байдлын академийн Хууль зүйн факультетийн дэд захирал, доктор

ВЬЕТНАМ УЛСЫН ШҮҮХ ЭРХ МЭДЛИЙН ШИНЭТГЭЛ БА ТУРШЛАГА 393
Nguyen Ly Ly
Ta Viet Duong
Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсын Ардын цагдаагийн академийн Захиргаа удирдлагын газрын ажилтан

ВЬЕТНАМ УЛС ДАХЬ ШҮҮХ ЭРХ МЭДЛИЙН ШИНЭТГЭЛ, ШИЙДВЭРЛЭХ ЗАРИМ АСУУДАЛ 400
Ну Тай Ту Хуеэн
Буй Ван Дат
Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсын Ардын Цагдаагийн Академийн Захиргаа, удирдлагын газрын ажилтан

ЗӨВЛӨМЖ 408

CONTENT

FOREWORD 14

Opening statement by **Mr. Nyambaatar Khishgee** 16
The Minister for Justice and Home Affairs,
The Member of the Parliament and Member of the Cabinet of Mongolia

Greetings by **Mr. Byambatsogt Sandag** 19
The Member of the Parliament and Chairman of the Standing Committee of Legal Affairs, the Parliament of Mongolia

PRESENTATIONS

PRIVATE LAW REFORM IN MONGOLIA: CHALLENGES AND OPPORTUNITIES 24
Mr. Nyambaatar Khishgee
The Minister for Justice and Home Affairs,
The Member of the Parliament and Member of the Cabinet of Mongolia

LIVING IN A GLOBAL WORLD: THE HAGUE CONFERENCE ON PRIVATE INTERNATIONAL LAW, ITS WORK & ITS RELEVANCE FOR MONGOLIA 36
Mr. Brody Warren
Attache to the Secretary General and Senior Legal Officer at the Permanent Bureau of the Hague Conference on Private International Law

RESEARCH ON PRIVATE LAW AND LEGAL DYNAMICS IN MONGOLIA: INQUIRING THE FUTURE 54
Mr. Amarsanaa Batbold
Dean of School of Law, National University of Mongolia, Prof, LL.D

PRIVATE LAW REFORM AND CIVIL PROCEEDING 68
Ms. Zolzaya Puntsag
Justice, Supreme Court of Mongolia

THE ELECTRONIC LITIGATION SYSTEM OF KOREAN COURTS 77
Mr. Jeong Won Park
Director of College of Law, Kookmin University, Korea, Prof, Ph.D

MODERNIZATION OF THE CIVIL LEGISLATION OF KAZAKHSTAN: CURRENT STATUS AND PROSPECTS OF DEVELOPMENT 86
Ms. Goriacheva Elena Vasilievna
Leading researcher, Institute of Legislation and Legal Information of the Republic of Kazakhstan, Ph.D

ENSURING THE INTEGRITY OF THE LEGAL SYSTEM OF THE LEGAL OF MONGOLIA 99
Mr. Narangerel Sodovsuren
Advisor to the Minister for Justice and Home Affairs of Mongolia,
State Prize Laureate of Mongolia, Merit Scientist, Academician, Emeritus Professor of the National University of Mongolia

DEVELOPMENT OF PRIVATE INTERNATIONAL LAW IN MONGOLIA, SOME ISSUES TO FURTHER IMPROVEMENT 117
Ms. Baigal Enkh-Amgalan
Associate Professor, School of Law, National University of Mongolia, Ph.D

SOCIAL ENTREPRENEURSHIP AND PRIVATE LAW REFORM IN RUSSIA 131
Ms. Uliana Borisovna Filatova
Professor, Law Institute of the Irkutsk State University, Russia, Ph.D

COMMERCIAL LAW DEVELOPMENT IN JAPAN: THE POSITION OF COMMERCIAL LAW AND IT'S THEORETICAL ISSUES 140
Mr. Minoru Tokumoto
Professor, Vice Dean of Graduate School of Law, Kyushu University, Japan, LL.D

UNCITRAL AND THE BENEFITS OF LEGAL HARMONIZATION 152
Ms. Athita Komindr
Head, The United Nations Commission on International Trade Law, Regional Centre for Asia and the Pacific

LEGISLATIVE RECOMMENDATIONS ON INSOLVENCY OF MICRO- AND SMALL ENTERPRISES 161
Ms. Yanying Li
Legal Officer, The United Nations Commission on International Trade Law

UNCITRAL EXPEDITED ARBITRATION RULES 169
Mr. Jae Sung Lee
Legal Officer, The United Nations Commission on International Trade Law

DIGITISATION OF THE JUDICIARY 175
Mr. Eric Hilgendorf
Dean of Law Faculty, Julius-Maximilians University, Wűrzburg, Germany, Prof, Dr, Dr.

CLASSIFYING AND DIFFERENTIATING CIVIL LAW DISPUTES FROM FRAUDULENT 201
Ariunbileg Sh.
Dean, Department of private law, of Law and Social Science Institute, University of Internal Affairs, Ph.D, Assistant Professor, Police Colonel
Batjargal G.
Lecturer of Department of private law, of Law and Social Science Institute, University of Internal Affairs, Ph.D student, Police Major

A NEED AND REQUIREMENT FOR REVISION AND REFORM OF THE CODE OF CIVIL PROCEDURE 211
S.Enkhbayar
Senior Lecturer of University of Finance and Economics, Ph.D, Associate Professor

JUDICIAL REFORM AND PRIVATE LAW: THE ROLE AND PROBLEMS OF THE SUPREME COURT IN UNIFYING THE APPLICATION OF LAWS 233
N.Norovsambuu
Lecturer of National University of Mongolia School of law, Department of Private law

PROPERTY RIGHTS OF CHILDREN 237
Otgontuya.O
Senior Lecturer of Department of private law, Law and Social Science Institute, University of Internal Affairs, Police Major

ELECTRONIC TRANSITION: POST-INDUSTRIAL SOCIETY AND CULTURE, LEGAL REFORM 249
Batbayar.Ts
Head of the Department of Social Sciences, University of Internal Affairs, Ph.D, associate professor, lieutenant colonel

LEGAL REFORM ISSUES IN MONGOLIA IN CALCULATION OF HEALTH, LIFE AND MENTAL HEALTH DAMAGE OF CITIZENS SUFFERED IN DISPUTES 259
Ch. Otgonsuren
Senior lecturer, School of Border Services, University of Internal Affairs, Ph.D student, Lieutenant Colonel

CONSTITUTIONAL DEVELOPMENT MODERN TRENDS 273
Ch.Myagmarbayar
General Department of Border Protection Legal Adviser, Legal Division, Lieutenant Colonel
J.Uuganchimeg
Department of Private Law, Law and Social Science institute, University of Internal Affairs Associate Professor, Captain

THE LEGAL REGULATION AND CHALLENING PROBLEM FOR CASH LOAN ACTIVITY IN MONGOLIA 286
P. Dolgormaa
Senior teacher of Law School of IZIU, Mongolia, Master of Law
B.Natsagdorj
Assistant professor of Law School of IZIU, Mongolia, Ph.D

THE LEGAL BACKGROUND OF CIVIL LAW IN MONGOLIA 308
Namsrai.B
Ph.D student at University of Pйcs, Hungary

THEORY AND PRACTICE OF FAMILY MINORS PROPERTY RIGHTS 317
Batchimeg.D
Master student, University Internal Affairs, Mongolia

JURISDICTIONAL CHALLENGES 330
Michael Nolan
Kamel Aitelaj
Senior associate at Milbank LLP

PROBLEMS OF PRESERVING THE INSTITUTE OF THE FAMILY IN THE RUSSIAN FEDERATION 336
Andreev A.V.
Head of the Department of Civil Law Disciplines of the Ural Law Institute of the Ministry of Internal Affairs of Russia, Ph.D

PROBLEMATIC ISSUES OF LEGAL QUALIFICATION OF APPROPRIATION OF FOUND PROPERTY 341
E. Kh. Rakhimov
Head of the Department of Civil Law Disciplines, Ufa Law Institute of the Ministry of Internal Affairs of Russia, Ph.D, Associate Professor

PECULIARITIES OF LABOR RELATIONS IN INTERNATIONAL PRIVATE LAW 346
Kadyrkulov Muhamedjan Tynysbaevich
Cadet of Siberian Law Institute under the Ministry of Internal Affairs of the Russian Federation Krasnoyarsk
Ermolaeva Margarita Igorevna
Lecturer, Department of Civil Law and Civil Procedure, Siberian Law Institute, Ministry of Internal Affairs of the Russian Federation

SOURCES OF PROPERTY FORMATION OF PUBLIC-LAW COMPANY 352
Fedorova Ekaterina Anatolievna
Postgraduate student of the Irkutsk State University, Russia

FEATURES OF LEGAL REGULATION OF DIGITAL LEGAL RELATIONS IN MONGOLIA AND THE RUSSIAN FEDERATION 359
Ksenia Yurievna Phillipson
Senior Lecturer of the Department of Civil Law and Procedure Siberian Law Institute of the Ministry of Internal Affairs of the Russian Federation, Police Captain
Munhbold Munhsuld
Student of Siberian Law Institute of the Ministry of Internal Affairs of the Russian Federation

SOME ASPECTS OF JUDICIAL PARTICIPATION IN THE LIQUIDATION OF A COMMERCIAL CORPORATE ORGANIZATION IN THE CIVIL LAW OF RUSSIA 368
Ludmila Alexandrovna Varnakova
Doctoral candidate at the Institute of Law, Irkutsk University, Russian Federation

RECOGNITION OF THE LEGAL INCAPACITY AND LIMITED LEGAL CAPACITY OF MINORS: A COMPARATIVE LEGAL ASPECT 381
Belozertseva Victorya Vladimirovna
Head of the Civil Law Department of the Eastern Siberian Institute under the Ministry of Internal Affairs of the Russian Federation, Ph.D, Professor

THE DEVELOPMENT OF PRECEDENT IN THE CONTEXT OF JUDICIAL REFORM IN VIỆT NAM 393
Mr. Nguyen Van Nam
Deputy Dean of Faculty of Law People's Security Academy, Ph.D

JUDICIAL REFORM IN VIETNAM AND SOME PRACTICE EXPERIENCE
Nguyen Ly Ly
Ta Viet Duong
PPA's Administration Office

SOME SOLUTIONS TO PROMOTE JUDICIAL REFORM IN VIETNAM 400
Ngo Thi Thu Huyen
Bui Van Dat
PPA's Administration Office

RECOMMENDATION 408

ӨМНӨХ ҮГ

Монгол Улсад орчин цагийн хууль зүйн алба үүсэж хөгжсөний 110 жилийн ойг тохиолдуулан Хууль зүй, дотоод хэргийн яамнаас Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо, Дотоод хэргийн их сургуультай хамтран “Монгол Улс дахь хувийн эрх зүйн шинэтгэлийн явц, тулгамдаж буй асуудал” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурлыг 2021 оны 12 дугаар сарын 16-ны өдөр амжилттай зохион байгуулсан билээ.

Олон улсын эрдэм шинжилгээний хурлаар Монгол Улс дахь хувийн эрх зүйн шинэтгэлд тулгарч буй сорилт, боломжууд, хувийн эрх зүйн судалгаа, олон улсын хувийн эрх зүйн хөгжил болон иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд тулгамдаж буй асуудлууд, Олон улсын хувийн эрх зүйн Гаагийн бага хурлын үйл ажиллагаанд Монгол Улсын оролцох боломж, гадаад улс орнуудын иргэний хууль тогтоомжийн шинэчлэл, хандлага, арилжааны эрх зүйн хөгжил, дижитал хэлбэрээр шүүхэд маргаан шийдвэрлэж буй асуудал, дампуурлын эрх зүй, хялбаршуулсан арбитрын талаарх зохицуулалт, шүүхийн цахимжуулалт зэрэг асуудлыг хөндсөн нийт 14 илтгэлийг хэлэлцэж, санал бодлоо солилцлоо.

Уг олон улсын эрдэм шинжилгээний хуралд дотоод, гадаадын эрдэмтэн, судлаачид болон хувийн эрх зүйн салбарын мэргэжлийн холбоод, хууль зүйн их, дээд сургуулийн 120 гаруй багш, зочид төлөөлөгчид оролцсон бөгөөд цахимаар 300 гаруй эрдэмтэн, судлаач, төрийн байгууллагуудын албан тушаалтнууд оролцсон болно.

Хуралд оролцогсод энэхүү хурал нь эрх зүйн шинэтгэлийн үйл явц, үр дүнг нэгтгэн дүгнэх, хувийн эрх зүйн шинэтгэлийг эрчимжүүлэх, хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох, гадаад улс орнуудын эрх зүйн шинэтгэлийн сайн туршлагаас суралцах, нэвтрүүлэх чухал ач холбогдолтой, үр дүнтэй хурал боллоо гэдгийг онцолж, сэтгэл хангалуун байгаагаа илэрхийлж байв. Олон улсын эрдэм шинжилгээний хуралд биечлэн болон цахимаар оролцсон эрхэм хүндэт зочид, төлөөлөгчид, эрдэмтэн, судлаачдад талархсанаа илэрхийлье.

Олон улсын эрдэм шинжилгээний хурлаар хэлэлцсэн илтгэлүүдийг эмхэтгэн, хэвлэмэл болон цахим хэлбэрээр олон нийтийн хүртээл болгож байна.

Хурлын үеэр өрнөсөн хэлэлцүүлэг болон илтгэлүүдээс дэвшүүлсэн санал, шүүмжийг үндэслэн хувийн эрх зүйн хууль тогтоомжийг боловсронгуй болгох, хувийн эрх зүйн сургалт, боловсролыг дээшлүүлэх, олон улсын хувийн эрх зүйн асуудлаар олон улсын байгууллага, бусад

улстай хамтран ажиллах зэрэг чиглэл бүхий зөвлөмж гаргасан ба уг зөвлөмж нь цаашид Монгол Улсад хувийн эрх зүйн шинэтгэлийг гүнзгийрүүлэх, хөгжүүлэх үндсэн чиглэл баримжаа болно гэдэгт найдаж байна.

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМНЫ
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА П.САЙНЗОРИГ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ, ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮН, ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД Х.НЯМБААТАРЫН ХУРЛЫГ НЭЭЖ ХЭЛСЭН ҮГ

Олон улсын эрдэм шинжилгээний хуралд хүрэлцэн ирсэн болон цахимаар оролцож байгаа эрхэм хүндэт зочид, төлөөлөгчид, эрдэмтэн судлаачид та бүхний энэ өдрийн амар амгаланг айлтган мэндчилж, Монгол Улсад орчин цагийн хууль зүйн алба үүсэж хөгжсөний түүхт 110 жилийн ойн баярын мэндийг өргөн дэвшүүлье.

Эдүгээгээс 110 жилийн өмнө Монгол оронд өрнөсөн үндэсний эрх чөлөөний хувьсгалын үр дүнд Монгол Улс тусгаар тогтнолоо сэргээн мандуулж, Олноо өргөгдсөн Богд Хаант Монгол Улсын Засгийн газрын анхны таван яам үүсэн байгуулагдаж байсан түүхтэй.

Тэр үед төрийн тулгуур таван яамны нэг болж Шүүх Таслах Хэргийг Бүгд Захиран Шийтгэгч Яам нэртэй байгуулагдаж байсан Хууль зүй, дотоод хэргийн яам 110 жилийн түүхэн хөгжлийнхөө хугацаанд улс орны тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, дотоод аюулгүй байдлыг бататган бэхжүүлэх, хүний эрх, эрх чөлөөг хангах, нийгмийн харилцааг зохицуулагч гол хүчин зүйл болох хууль тогтоомж, эрх зүйн тогтолцоог боловсронгуй болгох, хөгжүүлэх үндсэн чиг үүргээ амжилттай хэрэгжүүлж, Монгол Улсын хөгжил дэвшилд жинтэй хувь нэмэр оруулж ирснийг тэмдэглэн хэлэхэд таатай байна.

Манай улсын эрх зүйн тогтолцооны өнгөрсөн 110 жилийн түүхийг Богд хаант Монгол Улсын буюу 1911-1921 оны үе, социалист Монгол Улсын буюу 1921-1990 оны үе, Монгол Улс ардчилал, зах зээлийн харилцаанд шилжсэнээс өнөөг хүртэлх үе буюу 1990-2021 оны үе гэж үечлэн авч үзэх боломжтой юм.

1911 онд Монгол Улс тусгаар тогтнолоо тунхаглан зарласан нь монголчуудын төрт ёсны уламжлал, үндэсний соёл, бахархал, эрх зүйн сэтгэлгээ сэргэхэд үнэлж баршгүй чухал нөлөө үзүүлсэн бөгөөд Манжийн үеийн хуулийг халж, шинэ улсын хууль цаазыг боловсруулж мөрдөх явдал шинэ тутам байгуулагдсан төрийн хамгийн тулгамдсан асуудал болж байсныг түүхэн эх сурвалжууд гэрчилдэг. 1911 оноос 1917 оны 4 сар хүртэлх хугацаанд хааны зарлигаар тогтоосон хууль цаазын шинжтэй 63 бичиг бүртгэгдэж байсан түүхэн баримт бий.

Богд хаан номч мэргэн хүмүүст даалгавар өгч Америк, Япон, Европын зарим орны Үндсэн хуулийн эх сурвалжийг судлуулж байснаас үзвэл тухайн үед барууны буюу Өрнийн эрх зүйн үзэл, сэтгэлгээ, соёлыг

нэвтрүүлэх, хөгжилтэй орнуудын жишгээр Үндсэн хуулийн төрийн байгуулал тогтоохыг эрмэлзэж байжээ гэж дүгнэж болно.

1921-1990 оны үе буюу социалист Монгол Улсын үеийн эрх зүйн тогтолцоо 1917 оны Оросын октябрийн хувьсгалаас хойш бий болсон төрийн (социалист) өмчийг дээдлэн хамгаалсан, коммунист үзэл сурталд суурилсан улс төрийн байгууллыг тогтоосон, нийтийн болон хувийн эрх зүйн зааг ялгааг үгүйсгэсэн, эрх зүйг коммунист нийгэм байгуулах гол хүч хэрэгсэл болгох үзэл баримтлал бүхий социалист эрх зүйн бүлийн нийтлэг жишгийн хүрээнд бүрэлдэн бий болж, үйлчилж байсан бол 1990 онд Монгол Улс ардчилал, чөлөөт зах зээлийн замыг сонгож, нийгмийн эрс, том шилжилт хийснээс хойш манай улсад ардчилал, хүний эрх, эрх чөлөө, тэгш эрх, өмчлөх эрхийг дээдэлж, өмчийн олон хэлбэр, олон намын тогтолцоог хүлээн зөвшөөрсөн эрх зүйн тогтолцоо бий болон хөгжиж байна.

Аливаа улсын эрх зүйн тогтолцоо нийгмийн хөгжлөө даган шинэчлэгдэж байдаг зүй тогтолтой. Өөрөөр хэлбэл, эрх зүйн шинэчлэл тасралтгүй явагддаг процесс гэж хэлж болно.

Өнөөдөр бид аж үйлдвэрийн IV хувьсгал, цахим хөгжил, тоон хувьслын үед амьдарч, залуу үе маань “digitalhuman” хүн болон төлөвшиж байна. Энэ байдлыг мэдээллийг маш хурдан боловсруулж, олон ажлыг зэрэг амжуулж чаддаг, бие даасан байдлыг эрхэмлэж, бүх зүйлд дахин давтагдашгүй байдлыг эрэлхийлдэг, энтерпренерлэг Z үеийнхэн дээр тодорхой харж болно. Тоон орон зайд тоон иргэн, тоон сургууль, тоон мөнгө, тоон эдийн засаг бий болж, хиймэл оюун ухааны эрин үе ойртож байна. Энэ бүхэн дэлхийн улс орнуудын нийгэм, эдийн засаг, төр, эрх зүйн тогтолцоонд шийдвэрлэх нөлөө үзүүлэх боллоо. Монгол Улс ч энэ зүй тогтол, хөгжлийн шинэ эринээс ангид байж чадахгүй.

Цахим хөгжлийн үр дүнд цахимаар мөрдөн шалгах, гэм бурууг цахимаар тогтоох, цахимаар шүүн таслах, хэрэг, маргааныг хиймэл оюун ухаан шийдвэрлэх цаг үе ирж байна.

Үүнийг дагаад эрх зүйн үзэл баримтлал, сэтгэлгээ, эрх зүйн онолын зарим суурь ойлголт, эрх зүйн тогтолцоо эрс өөрчлөгдөх нь ойлгомжтой.

Манай улсын хувийн эрх зүйн салбарын тухайд дорвитой шинэчлэл хийж, илүү боловсронгуй болгох, арилжааны эрх зүйн орчныг сайжруулах, олон улсын хувийн эрх зүйг хөгжүүлж, хөгжингүй орнуудын жишигт хүргэх, шүүхийн үйл ажиллагааг цахимжуулах, хэрэг маргааныг шуурхай шийдвэрлэдэг болгох, бизнесийн ёс зүй, гэрээний болон санхүүгийн сахилга батыг сайжруулах, хуульчдыг мэргэшүүлэх, хууль зүйн бүх шатны

сургалтын чанар, үр дүнг дээшлүүлэх зэрэг олон асуудал шийдлээ хүлээж байна. Зарим талаар бид бүс нутгийн болон дэлхийн өндөр хөгжилтэй орнуудаас ихээхэн хоцорч яваагаа ч хүлээн зөвшөөрөх ёстой.

Тиймээс ч бид ойрын хугацаанд хувийн эрх зүйн шинэтгэлд голлон анхаарч ажиллахаар төлөвлөж, “Эрх зүйн шинэтгэл-2” хөтөлбөрийг боловсруулсан. Бид энэхүү шинэтгэлийг хүн төрөлхтний нийтлэг үнэт зүйл болсон хүний эрх, эрх чөлөө, ардчиллын үзэл баримтлалд тулгуурлан, монгол улсын эрх зүйн соёл, уламжлалыг хадгалан, шинэ үеийнхний зан, сэтгэхүйн онцлогт нийцүүлэн, хөгжингүй орнуудын жишиг, туршлагыг харгалзан цогц байдлаар, үр дүнтэй явуулах болно.

Энэ удаагийн олон улсын эрдэм шинжилгээний хурлын сэдвийг дээр дурдсан нөхцөл байдалтай уялдуулан сонгон авсан гэдгийг хэлье.

Ингээд бидний урилгыг хүлээн авч хүрэлцэн ирсэн, цахимаар оролцож буй нийт хүндэт зочид, эрдэмтэн судлаачдадаа болон үе үеийн сайд нар, ахмад ажилтнууддаа дахин баярын мэнд дэвшүүлж, талархал илэрхийлье.

Олон улсын эрдэм шинжилгээний хурал нээснийг мэдэгдэж, хурлын ажиллагаанд амжилт хүсье.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН, ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА С.БЯМБАЦОГТЫН ХУРЛЫН НЭЭЛТЭД ХЭЛСЭН ҮГ

Эрхэм хүндэт зочид оо

Эрхэм хүндэт эрдэмтэн, судлаачид аа

Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе!

Юуны өмнө Монгол Улсын эрх зүйн салбарыг хөгжүүлэх үйлсэд мэдлэг оюун, авьяас билэг, хөдөлмөр бүтээлээ зориулан хүчин зүтгэж ирсэн ахмадууд, үе үеийн сайд нар, одоо ажиллаж буй ажилтан, албан хаагчид, эрдэмтэн, судлаачдадаа болон тус хуралд уригдан оролцож байгаа гадаад, дотоодын хүндэт зочид та бүхэнд Монгол Улсад орчин цагийн хууль зүйн алба үүсэж хөгжсөний 110 жилийн ойн баярын мэндийг Монгол Улсын Их Хурал, Хууль зүйн байнгын хорооны нэрийн өмнөөс болон хувиасаа өргөн дэвшүүлье.

Баганагүйгээр гэр оршин тогтнох боломжгүйтэй адил нийтийн болон хувийн эрх зүйн тэнцвэр, шинэчлэлгүйгээр хуулийн засаглал оршин тогтнох боломжгүй юм. Ийм ч учраас эрх зүйн шинэтгэлээс хувийн эрх зүйн шинэтгэлийг ангид авч үзэх аргагүй билээ. Өнөөдөр бид нэг талаас хуулийн засаглал, нөгөө талаас эдийн засгийн тусгаар тогтнолын талаар онцгойлон ярьж байна. Тэгвэл хараат бус эдийн засгийг тогтоох эрх зүйн чухал үндэс нь чухамдаа хувийн эрх зүй гэж би хувьдаа ойлгодог.

Эдийн засаг, арилжаа, бизнесийн үйл ажиллагаанд хуулиар дэгээ тавьж, төрийн албан хаагч өөрийн чиг үүргээ гүйцэтгэхдээ хүнд суртал гаргадаг биш харин дэмжин хөгжүүлдэг байхад хувийн эрх зүйн шинэтгэл онцгой үр нөлөөтэй.

Одоогоос 20 гаруй жилийн өмнө буюу 1998 оны 1 дүгээр сарын 22-ны өдөр Монгол Улсын Их Хурлаас “Монгол Улсын эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр 1”-ийг батлан хэрэгжүүлсэн нь Монгол Улс ардчилал, зах зээлийн эдийн засагт шилжин хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэх Үндсэн хуульд тунхагласан зарчим, зорилгыг биелүүлэхэд төрийн бүх шатны байгууллага, албан тушаалтны үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тодорхойлж, улс төр, нийгэм, эдийн засгийн хөгжил дэвшлийг хангах эрх зүйн үндэс, таатай орчинг бүрдүүлэх суурь нөхцөл бүрдсэн юм.

Тус хөтөлбөрт хувийн эрх зүйн харилцааны амин сүнс болсон Иргэний хуулийг нийгмийн тодорхой харилцааг зохицуулах чиглэлээр иж бүрэн шинэчлэхээр тусгасантай холбогдуулан Улсын Их Хурлаас 2002 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр Иргэний хуулийг шинэчлэн баталснаас хойш багагүй хугацааг өнгөрүүлээд байна.

Иргэний хууль нь өнгөрсөн хугацаанд иргэний эрх зүйн харилцаанд оролцогчдын эрх тэгш, бие даасан байдал, өмчийн халдашгүй байдал, гэрээний эрх чөлөө, талуудын эрх, үүргийн тэнцвэрт байдал зэрэг олон асуудлын тайлал байж, зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэхэд баримтлах зохицуулалт болж байгаа хэдий ч өдөр бүр өөрчлөн шинэчлэгдэж байгаа харилцаа, техник, технологийн дэвшил, хүний ухамсарт хүчин зүйлээс давсан давагдашгүй хүчин зүйлийн нөлөөллийг нарийн тодорхой зохицуулах шаардлагатай гэдгийг улам тодорхой харуулсаар байна.

Бид дэлхий нийтэд үүсээд байгаа коронавируст халдвар (ковид 19)-ын цар тахлын нэн амаргүй орчинд ажил, амьдралаа зохицуулан бараг 3 жилийн нүүр үзээд байна. Энэ хугацаанд иргэд, аж ахуйн нэгжийн амьжиргаа, бизнесийн үйл ажиллагаа доголдож ашиг орлого буурсан төдийгүй энэ нь нөгөө талдаа банк, санхүүгийн байгууллагатай байгуулсан гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлэх боломжгүйд хүрч үүргийн гүйцэтгэлийн зөрчилд орсоор байгаа нь энэ харилцааг нарийвчлан зохицуулах шаардлагатай гэдгийг нотлон харуулж байгаа тод жишээ юм.

Улсын Их Хурлаас 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсныг Та бүхэн тодхон санаж байгаа.

Тус өөрчлөлтөөр Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлт тогтвортой байхаар заасан бөгөөд Үндсэн хуулийн энэ үзэл баримтлалын хүрээнд Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 5 дугаар сарын 13-ны өдөр “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-ыг баталсан. Өөрөөр хэлбэл, Монгол Улс, Монголын төр ирээдүйн 30 жилийнхээ тоглоомын дүрмийг тодорхойлсон.

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод заасан үндэсний нэгдмэл үнэт зүйл, хүний хөгжил, амьдралын чанар, дундаж давхарга, эдийн засаг, засаглал, ногоон хөгжил, амар тайван, аюулгүй нийгэм, бүс орон нутгийн хөгжил, Улаанбаатар ба дагуул хотын хөгжлийн зорилтын хүрээнд хувийн эрх зүйн шинэтгэл явагдах болно.

Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 8 дугаар сарын 20-ны өдөр “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг баталсан бөгөөд эх газрын эрх зүйн бүлийн хэв шинж, философид суурилсан Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхолд нийцсэн, хүний эрхийг дээдэлсэн, эдийн засгийн өсөлтийг дэмжсэн урт хугацааны “Эрх зүйн шинэтгэл II” арга хэмжээг боловсруулж, хэрэгжүүлэх талаар тодорхой зохицуулсан.

Аливаа эрх зүйн шинэтгэл нь өмнөх алдаа дутагдлаа зассан, иргэдийн амьдралд шууд болон дам утгаараа үр өгөөжөө өгөх зохицуулалт орсноор жинхэнэ утгаараа эрх зүйн шинэтгэл болох учиртай төдийгүй улс орны нийгэм, эдийн засаг, хөгжлийн чухал суурийг бүрдүүлэх нэг гол хүчин зүйл болох ёстой.

Улсын Их Хурлаас 2021 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлийг” баталсан бөгөөд шүүхийн урьдчилан шийдвэрлэх ажиллагааны зохицуулалтыг нарийвчлах, оновчтой механизмыг бүрдүүлэх, үндэслэл, журмыг тодорхой болгох, арилжаа эрхлэгчид хоорондын маргаан шийдвэрлэх болон бага үнийн дүнтэй хэрэг хянан шийдвэрлэх процессыг хөнгөвчлөх, олон улсын чиг хандлагад нийцүүлэн цахим орчинд хийгдсэн гэрээ, хэлцлийг шүүхэд нотлох баримтаар тооцох гэх мэт олон зорилгын хүрээнд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх хуулийг шинэчлэн боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Засгийн газарт үүрэг болгосон.

Бизнес эрхлэгчдийн хоорондын харилцаанд баримтлах онцлог зарчим болон зарим гэрээ, хэлцлийг Иргэний хуулиас ялгаатай зохицуулах, цахим хэлбэрээр гэрээ, хэлцэл хийх, арилжааны нэр ашиглах зохицуулалтыг боловсронгуй болгох, гэрээний талуудын итгэлцлийг нэмэгдүүлэх зорилгоор арилжаа эрхлэгчийн зарим мэдээллийг нээлттэй болгох, хууль тогтоомжоос гадна бизнес эрхлэгчдийн хооронд тогтсон заншлын хэм хэмжээг шүүх илүү өргөн хүрээнд хэрэглэх боломжийг бүрдүүлэх, хэрэглэгчийн эрхийг бодитой хамгаалах үүднээс гэрээнд өөрийн саналаа тусгах боломжийг бий болгох, гэрээний стандарт нөхцөлд тавигдах шаардлагыг нарийвчлан тогтоох гэх мэт харилцааг зохицуулсан Арилжааны тухай болон Хэрэглэгчийн гэрээний тухай хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Засгийн газарт үүрэг болгосон.

Бас нэг тулгамдаад байгаа асуудал бол гэр бүлийн эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох асуудал юм. Манай улс 1999 онд Гэр бүлийн тухай хуулийг баталснаас хойш бодлогын шинэчлэлийг хараахан хийгээгүй байна. Сүүлийн жилүүдэд гэр бүл салалт нэмэгдэх хандлагатай болсон талаар эрдэмтэн, судлаачдын судалгаа, тоо баримт гарсаар байгааг Та бүхэн мэдэж байгаа. Гэр бүл салалтаас шалтгаалан хамгийн их хохирдог хохирогч нь хүүхэд байдаг. Гэрлэлт нь хэдийгээр сайн дурын үндсэн дээр бий болдог ч гэр бүлийн харилцаанаас үүсэх үүрэг, хариуцлага, хүүхдийн эрхийг хамгаалах, зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх асуудлыг төрийн бодлогоор зохицуулах нь зүйн хэрэг юм. Иймд энэ шинэчлэлийг бид хийх ёстой.

Ром-Германы болон Англо-Саксоны эрх зүйн бүлүүд өөр хоорондоо уялдахгүй юм шиг ойлголт, сэтгэлгээ байсан хэдий ч хүн төрөлхтний даяаршлын нөлөөн дор эрх зүйн бүлүүд нэгдэн нягтарч, харилцан шүтэлцээнд орших үйл явцаар орчин цагийн эрх зүйн хөгжлийн ерөнхий чиг хандлага тодорхойлогдох боллоо.

Ийнхүү даяаршлын болон хувийн эрх зүйн хамаарлын зүй тогтол, хүчин зүйлийг харгалзан үзэж, эрх зүйн даяаршлын сөрөг үр дагаврыг багасгаж чадсанаар үндэсний эрх зүйн тогтолцооны тогтвортой, найдвартай байдлыг хангах боломж бүрдэнэ. Бид хувийн эрх зүйн шинэтгэлийг эрчимжүүлж, эрх зүйн энэ салбарыг хөгжүүлэхэд гадаад улс орнуудын тэргүүн туршлагыг өөрийн орны уламжлал, эрх зүйн соёл ухамсарт шингээн буулгах шаардлага байгааг онцлон тэмдэглэхийг хүсэж байна.

Хувийн эрх зүй түүн дотроо бизнесийн харилцаан дахь төрийн оролцоо зохицуулалтыг зохистой түвшинд байлгах, харилцаанд оролцогчдын үүрэг хариуцлагыг тодорхой зохицуулах, иргэний эрх зүйн харилцааг зохицуулах эх сурвалжуудын тогтолцоог өөрчлөх алхмыг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Өнөөдрийн олон улсын эрдэм шинжилгээний хурал нь цаг үеэ олсон төдийгүй хувийн эрх зүйн тулгамдсан асуудлыг олон талаас нь шүүн тунгааж үнэн зөв, бодитоор дүгнэн хэлэлцэж, Монгол Улс дахь хувийн эрх зүйн шинэтгэлийг эрчимжүүлэх, хөгжүүлэх гарц, арга замыг тодорхойлоход чухал ач холбогдолтой, үнэтэй санал, дүгнэлт гаргана гэдэгт миний бие эргэлзэхгүй байна.

Эцэст нь хэлэхэд аливаа шинэтгэл нь улс орон, иргэдийн ахуй амьдралд бодитой үр өгөөжөө өгч байж гэмээнэ жинхэнэ эрх зүйн шинэтгэл болно гэдгийг онцлон тэмдэглэхийг хүсэж байна.

Хурлын үйл ажиллагаанд амжилт хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

ИЛТГЭЛҮҮД

МОНГОЛ УЛС ДАХЬ ХУВИЙН ЭРХ ЗҮЙН ШИНЭТГЭЛ: СОРИЛТ БА БОЛОМЖ

PRIVATE LAW REFORM IN MONGOLIA: CHALLENGES AND OPPORTUNITIES

Хишгээгийн Нямбаатар
Монгол Улсын Их Хурал, Засгийн газрын гишүүн,
Хууль зүй, дотоод хэргийн сайд
Mr. Nyambaatar Khishgee
The Minister for Justice and Home Affairs,
The Member of the Parliament and Member of the Cabinet of Mongolia

Хураангуй:
Энэхүү илтгэлд Монгол Улсад 2002 оноос хойш 20 орчим жил дорвитой хэлэлцэж яригдаагүй хувийн эрх зүйн шинэтгэлийн үйл явц, тулгамдаж буй асуудал, сорилт, хөгжлийн чиг хандлага, Хууль зүй, дотоод хэргийн яамны баримталж байгаа бодлого, байр суурийг тусгасан байна.

Түлхүүр үг: *Хувийн эрх зүй, арилжааны эрх зүй, технологи, хүний нөөц.*

Abstract:
This study explains the policies and positions of the Ministry of Justice and Home Affairs on the process of private law reform in Mongolia, which has not been discussed for nearly 20 years since 2002, and its complexity, challenges, and future trends.

Keywords: *Private law, commercial law, technology, human resource.*

Энд хуран цугласан эрхэм зочид, төлөөлөгч, оролцогч та бүхний энэ өдрийн амар амгаланг айлтгахын ялдамд бидний урилгыг хүлээн авч, Монгол Улсад орчин цагийн хууль зүйн алба үүсэж хөгжсөний түүхт 110 жилийн ойг тохиолдуулан зохион байгуулж байгаа “Монгол Улс дахь хувийн эрх зүйн шинэтгэлийн явц, тулгамдаж буй асуудал” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хуралд хүрэлцэн ирсэнд гүн хүндэтгэл илэрхийлье.

Миний бие өнөөдөр 2002 оноос хойш 20 орчим жил дорвитой хэлэлцэж яригдаагүй хувийн эрх зүйн шинэтгэлийн үйл явц, тулгамдаж буй асуудал, сорилт, хөгжлийн чиг хандлага, Хууль зүй, дотоод хэргийн яамны баримталж байгаа бодлого, байр суурийг дараах агуулгын хүрээнд илтгэхээр бэлтгэлээ.

I. Монгол Улс дахь хувийн эрх зүйн шинэтгэлийн үйл явц
II. Арилжааны эрх зүй ба сорилт
III. Технологи ба сорилт
IV. Хүний нөөц ба сорилт
V. Дүгнэлт

Нэг. Монгол Улс дахь хувийн эрх зүйн шинэтгэлийн үйл явц

Монгол Улсын шинэ Үндсэн хууль батлагдаж, “БНМАУ-ын Үндсэн хуулиас Монгол Улсын Үндсэн хуулийг бүрнээ дагаж мөрдөхөд шилжих тухай” Монгол Улсын Үндсэн хуулийн хавсралт хуульд заасны дагуу хууль тогтоомжийг Монгол Улсын Үндсэн хуульд тунхагласан зарчим, үзэл санаанд нийцүүлэн бүрэн шинэчлэх ажлыг зохион байгуулсан.

Уг ажлын хүрээнд Монгол Улсын Их Хурал 1998 онд “Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр”-ийг баталж, боловсронгуй болгох шаардлагатай хууль тогтоомжийн үндсэн чиглэлийг баталсан. Тус хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээг 2008, 2016 онд тус тус хийсэн бөгөөд судалгаагаар Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр анх дэвшүүлсэн зорилгодоо ерөнхийдөө хүрсэн боловч зөвхөн хууль тогтоомжийг шинэтгэх бус хуулийн хэрэгжилтийг хангах, хууль хэрэглэх тогтолцоо, арга ажиллагаа, хууль зүйн мэргэжлийн боловсрол, хууль зүйн эрдэм шинжилгээний ажлын зохион байгуулалт, арга зүйг, нийгэмд эрх зүйн ухамсар төлөвшүүлэх ажлыг хамтад нь авч хэрэгжүүлэх талаас нь дүгнэвэл эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрт дэвшүүлсэн зарим зорилт хангалттай хэмжээнд хэрэгжээгүй байна.[1]

Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрийн “Эдийн засгийн харилцааны эрх зүйн үндсийг боловсронгуй болгох” зорилтын хүрээнд өнгөрсөн хугацаанд Иргэний хууль, Компанийн тухай, Нөхөрлөлийн тухай, Өрсөлдөөний тухай, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай, Хөрөнгө оруулалтын тухай, Зохиогчийн эрхийн тухай, Патентын тухай, Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай, Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай, Газрын тухай, Үнэт цаасны зах зээлийн тухай, Аялал жуулчлалын тухай, Зар сурталчилгааны тухай гэх зэрэг үндсэн чиглэлд дурдсан хуулиудыг баталсан боловч Гадаад худалдааны тухай, Газрын хэвлийн тухай, Иргэн хуулийн этгээд байгуулахгүйгээр аж ахуй эрхлэх тухай хуулийг шинээр болон шинэчлэн боловсруулж батлуулаагүй орхигдуулжээ.

Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлын нэг баталгаа нь эдийн засагтай шууд холбоотой. Эдийн засгийн аливаа шийдвэр ардчилал, зах зээлийн тогтолцоонд тулгуурлан, хүний эрхийг хамгаалахад чиглэгдэж байх, төр, иргэн, хуулийн этгээд өмчлөгчийн хувьд эрх тэгш байх, эдийн засаг дахь төрийн оролцоо зохистой байх үндсийг бүрдүүлэх талаар өнгөрсөн хугацаанд эрх зүйн шинэтгэлийг нэлээдгүй өргөн хүрээнд хэрэгжүүлсэн байна. Гэхдээ эрх зүйн шинэтгэлийн бодлого, тэр дундаа хууль тогтоомжийн шинэтгэлийн бодлого цаг үеийн хөгжил, технологийн дэвшил, нийгмийн хэрэгцээ, шаардлагаа даган тасралтгүй үргэлжилж байж бизнес эрхлэгчдэд бизнесээ амжилттай, таатай эрхлэх боломжийг бүрдүүлж, улмаар эдийн засаг сайжирч, хөгжиж байх учиртай. Тиймээс

[1] “Эрх зүйн шинэтгэлийн бодлогын баримт бичиг боловсруулахад дэмжлэг үзүүлэх нь” судалгааны үндсэн тайлан, Хууль зүйн судалгааны төв, 2016, хуудас 5

Хууль зүй, дотоод хэргийн яам 2002 оноос хойш 20 орчим жил дорвитой хэлэлцэж яригдаагүй хувийн эрх зүйн хөгжлийн чиг хандлага, шинэтгэлийн бодлогын асуудалд голлон анхаарч, энэ бодлогын хүрээнд хийгдэх ажлууд “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл” зэрэг бодлогын баримт бичигт тусгалаа олоод явж байна. Тухайлбал,

Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрт Иргэний хуулийг “иж бүрэн шинэчилнэ” гэсний дагуу 1994 оны Иргэний хуулийг хүчингүй болгож, 2002 онд 552 зүйл бүхий шинэ Иргэний хуулийг баталсан. Иргэний хууль нь “эрх зүйн этгээдийн хооронд үүсэх эдийн болон эдийн бус баялагтай холбоотой харилцааг зохицуулах” зорилготой боловч аж ахуйн үйл ажиллагаанд төдийлөн тохиромжтой бус байгааг сүүлийн үед эрдэмтэд, судлаачид онцлох болсон. Өөрөөр хэлбэл, арилжаа эрхлэгчдийн хооронд үүсэх бизнесийн онцлог харилцаа буюу B2B, B2C харилцааг цогц байдлаар зохицуулсан хэм хэмжээг эдийн засгийн агуулгаар баяжуулах, тодруулах шаардлагатай болж байна. Түүнчлэн, дээр дурдсан Гадаад худалдааны тухай, Газрын хэвлийн тухай, Иргэн хуулийн этгээд байгуулахгүйгээр аж ахуй эрхлэх тухай эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож чадаагүйгээс гадна Газрын тухай, Гэр бүлийн тухай, Өрсөлдөөний тухай, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай гэх мэт хуулиудыг Иргэний хуулийн суурь зохицуулалт, үзэл баримтлалд нийцүүлж чадаагүй өдийг хүрсэн. Жишээ нь, Газрын тухай хуульд заасан газрын эрхийн төрлүүдийг Иргэний хуульд нийцүүлэх, хэрэглэгчийн эрхийг шуурхай хангах, сэргээх, хэрэглэгчийн гэрээнд тавигдах шаардлагыг нарийвчлан тогтоох, гэр бүлийн эрх зүйд гэр бүлийн хөрөнгийн эрх буюу гэрлэгчдийн дундаа хэсгээр өмчлөх, эсхүл хамтран өмчлөх эд хөрөнгийн эрхийн зохицуулалтыг сайжруулах, түүнчлэн хүйс солиулах асуудал гэрлэлтэд ямар үр дагавар үүсгэх, тээгч эхээр хүүхэд тээлгэх, зохиомлоор үр суулгах асуудал гэр бүл, өв залгамжлалын эрх зүйгээр хэрхэн зохицуулагдах, гэм хорын эрх зүйд эдийн болон эдийн бус гэм хор учруулснаас үүсэх үүргийн харилцааг дэлгэрүүлэх, тухайлбал, мэргэжлийн ажил, үйлчилгээ үзүүлдэг этгээд буруу мэдээлэл, зөвлөгөө өгсний улмаас үүсэх гэм хорын асуудал, гэм хорыг арилгах арга хэлбэр, хүрээ хязгаарыг нарийвчлах, гэрээний үүргээ зөрчсөнөөс үүсэх гэм хорын хэмжээг талууд гэрээгээр хязгаарлаж тогтоох нь гэм хорыг арилгах хуулийн зохицуулалттай хэрхэн уялдах, шударга бус өрсөлдөөний улмаас үүсэх хохирол, бизнесийн нууцыг задруулснаас үүсэх хохирол зэрэг онцлог асуудлыг анхааралтай судалж, зохицуулах шаардлага үүссэн байна.

Түүнчлэн, өмчийн харилцааны тодорхой төрөл, хүрээг зохицуулсан Оюуны өмчийн тухай, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай, Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай зэрэг хууль шинээр батлагдсан бол Төрийн болон орон нутгийн өмчийн тухай 1996 оны хууль одоо болтол шинэчлэгдэж чадаагүй байна.

ХЗДХЯ-ны зүгээс тэргүүн ээлжид хувийн эрх зүйн шинэтгэлийн бодлогын хүрээнд эдийн бус хөрөнгөд хамаарах оюуны өмчийн багц хуулийн төслүүдийг боловсруулж, УИХ-аар батлуулаад байгаа бол төрийн өмчит хуулийн этгээдийн эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгохоор ажиллаж байна. Тухайлбал төрийн болон орон нутгийн өмчит компанийг зөвхөн стратегийн ач холбогдолтой салбарт, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх чухал ач холбогдолтой томоохон төслийг хэрэгжүүлэх зорилгоор байгуулдаг байх, хувийн хэвшилтэй тэгш, нөхцөл, ижил дүрмээр үйл ажиллагаа эрхэлдэг байх, өрсөлдөөнийг хязгаарлах эрсдэлээс зайлсхийх, төрийн өмчит хуулийн этгээдийн менежмент, зохион байгуулалтын асуудлыг оновчтой загварт шилжүүлэх зэргээр Төрийн болон орон нутгийн өмчийн компанийн тухай хуулийн төслийг боловсруулаад байна.

Түүнчлэн, шүүхийн үйлчилгээг иргэд, арилжаа эрхлэгчдэд чирэгдэлгүйгээр цаг хугацааны хувьд түргэн шуурхай хүргэх, мөнгө, санхүүгийн хувьд хэмнэлттэй байх, нөгөөтээгүүр шүүх талаас иргэдийн хэрэг, маргааныг төвөггүй, түргэн шуурхай шийдвэрлэдэг байх зарчмыг түргэсгэх, шүүхийн ачааллыг бууруулах, ингэснээр иргэд болон арилжаа эрхлэгчдийн хэрэг, маргааныг шүүхээр хянан шийдвэрлэх процессыг хөнгөвчлөх, шат дамжлагыг багасгах, бага үнийн дүнтэй хэргийг шийдвэрлэх онцлог зохицуулалтыг бий болгох зэргээр Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийг боловсронгуй болгох хэрэгцээ, шаардлага тулгараад байна. Тухайлбал, бага үнийн дүнтэй хэргийн нэхэмжлэлийн үнийн дүнг улс орнууд харилцан адилгүй тогтоодог бөгөөд манай улсын хувьд бага үнийн дүнтэй нэхэмжлэлийг 10 сая хүртэлх гэж үзвэл сүүлийн 3 жилийн /2017-2019/ хугацаанд Иргэний хэргийн анхан, давж заалдах, хяналтын шатны шүүхээр хянан шийдвэрлэгдсэн бага үнийн дүнтэй хэрэг маргааны эзлэх хувийг Улаанбаатар хотын 9 дүүрэг, 21 аймгийн түвшинд судалж үзэхэд шат шатны шүүхийн түвшинд өндөр байна. Анхан шатны шүүхийн тухайд 3 хэрэг тутмын 1 нь буюу 33%-ийг, давж заалдах шатны шүүхийн тухайд 4 хэрэг тутмын 1 нь буюу 24.7%-ийг эзэлж байгаа бол хяналтын шатны шүүхийн нийт хэргийн 23.8%-ийг эзэлж байна.

Түүнчлэн иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дахь хугацаа (жишээ нь зээлийн гэрээний маргааныг шийдвэрлэж байгаа дундаж хугацаа 6.2 жил байгаа бол хамгийн их хугацаа нь бүх шатны шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэсэн хугацааг оруулаад 16.6 жил байна), улсын тэмдэгтийн хураамжтай холбоотой зохицуулалтыг боловсронгуй болгох, иргэн болон захиргааны хэргийн шүүхийн хэрэг, маргааны харьяаллын давхардлыг арилгах, олон улсын чиг хандлагад нийцүүлэн цахим орчинд хийгдсэн гэрээ, хэлцлийг шүүхэд нотлох баримтаар тооцох, стандарт нөхцөлтэй хэрэглэгчийн гэрээнээс үүдэлтэй маргаанд олон тооны хэрэглэгчийн эрхийг хамгаалж нэхэмжлэл гаргах (class action) эрх зүйн зохицуулалтыг бий болгох зэргээр сайжруулах шаардлагатай байна.

Мөн иргэний шүүхийн шийдвэр гүйцэтгэлийг сайжруулах үүднээс иргэн, захиргааны шүүхийн шийдвэр гүйцэтгэх чиг үүргийг шүүх эрх мэдлийн байгууллагад шилжүүлэх, төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааг хэрэгжүүлэх, шийдвэр гүйцэтгэлийн урамшууллын тогтолцоог сэргээх зэрэг асуудлыг судална. Тухайлбал, ШШГЕГ-аас ирүүлсэн сүүлийн 5 жилийн иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны мэдээнээс харахад жил бүр ойролцоогоор 1 тэрбум төгрөгийн гүйцэтгэх баримт бичиг биелэгддэггүй байна. 2021 оны 8 дугаар сарын байдлаар биелүүлбэл зохих 1,685,737,340,400 төгрөгийн гүйцэтгэх баримт бичгээс 1,507,804,577,400 төгрөгийн гүйцэтгэх хуудас биелэгдээгүй үлдсэн байна.

Түүнчлэн, шүүхийн бус журмаар өр барагдуулах механизмыг бий болгож, өр барагдуулах үйл ажиллагааны стандартыг тогтоож, биелэгдэхгүй байгаа дээрх өр төлбөрийг харилцан ашигтай, түргэн шуурхай гүйцэтгэх эрх зүйн орчныг Шүүхийн бус журмаар өр авлага барагдуулах үйл ажиллагааны тухай хуулийн төслөөр бүрдүүлээд байна. Дээрх хуулиудаас гадна эдийн засаг, бизнесийн харилцаанд голлох ач холбогдол бүхий арилжааны эрх зүйн зохицуулалтын талаар нарийвчилж санал бодлоо хуваалцъя.

Хоёр. Арилжааны эрх зүй ба сорилт

Монгол Улсад бизнес эрхлэхэд хэр таатай вэ, эрх зүйн орчин хэр хангалттай вэ гэдэг асуултын хүрээнд Дэлхийн банкны “Бизнес эрхлэхүй” судалгааны[2] статистикийг гол баримжаа болгож харвал 2010-2020 он хүртэлх 10 жилийн хугацаанд Монгол Улс 59.9 онооноос 67.8 оноо болж өссөн үзүүлэлттэй байгаа бол тус судалгааны нэг чухал бүлэг шалгуур үзүүлэлт болох “гэрээний хэрэгжилтийг хангах” үзүүлэлтийн хувьд 2004-2013 онд 71.8, 2014-2015 онд 70.2, 2016-2018 онд 58.5, 2019-2020 онд 61.4 оноо болж тогтмол буурсан үзүүлэлтэй гарсан байна.

Гэрээний хэрэгжилтийг хангах нөхцөлийг бүрдүүлж өгснөөр бизнес эрхлэлтийг дэмжиж, эдийн засагт ихээхэн эерэг үр дагавар бий болгох учраас гэрээний хэрэгжилтийг хангах шалгуур үзүүлэлтийн үнэлгээг сайжруулах арга хэмжээ авах шаардлага, сорилт бидэнд тулгараад байна. Тус шалгуур үзүүлэлтийн хувьд арилжааны маргааныг тусгайлан шийдвэрлэх институц байгаа эсэхийг голчлон анхаарч үнэлдэг. Үүний цаана арилжааны эрх зүйн харилцааг зохицуулсан хэм хэмжээ, зарчим бүрэлдсэн үү гэдгийг давхар анхаарах ёстой. Манай улсад өгсөн үнэлгээгээс арилжааны шинжтэй маргааныг иргэний хэрэг маргаанаас ялгаатай, онцлог журмаар шийдвэрлэх дэд бүтцийг бий болгох шаардлага үүссэн гэдгийг харж болохоор байна. Иргэний хуульд мөн аж ахуй эрхлэгч болон хэрэглэгч хоорондын B2C, C2B, эсхүл иргэд хоорондын C2C харилцааг илүүтэйгээр зохицуулсан. Харин ашгийн төлөө үйл ажиллагаа эрхлэх бизнес эрхлэгчдийн хооронд үүсэх B2B бизнесийн онцлог харилцааг цогц байдлаар зохицуулсан, талуудын ашгийн төлөөх зорилгыг

[2] https://www.doingbusiness.org/en/data/exploreeconomies/mongolia#DB_ri

хамгаалах, гэрээний талуудын чөлөөт байдал, хэлцэл хийхэд хялбар, түргэн шуурхай, зардал багатай байх, хэлцлийн хэлбэрийг тохирох уян хатан байх, хэлцэлд итгэх итгэлийг хамгаалах, хариуцлагатай байх зэрэг зарчмуудыг дэлгэрүүлсэн эрх зүйн тогтолцоо байхгүй байна.

Хувираа аж ахуй эрхлэгчдийн хувьд компани, нөхөрлөлийн нэгэн адил бизнесийн үйл ажиллагаа эрхлэхэд бүртгэл шаарддаггүйгээс гэрээ хэлцлийн баталгаат байдал, гэрээний нөгөө талын хаяг, эд хөрөнгийн байдал, үйл ажиллагаа явуулдаг эсэх, жижиг дунд хэмжээний бизнес эрхлэгчийг дэмжих хөнгөлөлттэй зээл тусламжид хэрхэн хамруулах, ямар журмаар орлого, зарлагын тайланг хүлээн авах, татвар ногдуулах зэрэг олон асуудал шийдвэрлэгдээгүй өдийг хүрч байна.[3] Уг асуудлыг 1998 оны Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрт тодотгож, Иргэний хуулиас гадна Иргэн хуулийн этгээд байгуулахгүйгээр аж ахуй эрхлэх тухай хуулийг хамт боловсруулахаар тусгаж байсныг эргэн санаж, нөхөн зохицуулалтыг хийх ёстой. Харин Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар уу, эсхүл бие даасан Арилжааны хууль байх уу гэдэг сорилт тулгарч байна.

Нэгэнт арилжаа эрхлэхэд нийтлэг хийгддэг үйл ажиллагааг зохицуулсан материаллаг хэм хэмжээг бий болговол дагаад процессын хуульд бизнес эрхлэгчдийн хэрэг, маргааныг шүүхээр хянан шийдвэрлэх процессыг хөнгөвчлөх, шат дамжлагыг багасгах чиглэлд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлага үүснэ. Ийнхүү материаллаг болон процессын хуулиа сайжруулснаар бизнес эрхлэгчдийн ашгийн төлөө зорилгыг дэмжих, гэрээнд итгэх итгэлийг нэмэгдүүлэх, үүссэн хэрэг маргааныг нь түргэн шуурхай шийдвэрлэх, бизнесийн ёс зүй, хариуцлагыг төлөвшүүлэх, бизнес эрхлэгчдийн ажил үүргийн хүрээнд тогтсон практик, заншлын хэм хэмжээг хэрэглэх боломжтой бүрдэх юм.

Арилжааны шинжтэй маргааныг иргэний хэрэг маргаанаас ялгаатай, онцлог журмаар шийдвэрлэх дэд бүтцийн асуудлыг арилжааны дагнасан шүүх байгуулах, эсхүл иргэний шүүхдээ арилжааны хэргийн танхим байгуулах, зарим нарийн төвөгтэй арилжааны маргааныг давж заалдах шатны шүүх анхан шатны журмаар шийдвэрлэх, шүүгчдийн мэргэшүүлэх, шүүхийн дэргэд шинжээч ажиллуулах зэрэг аргаар шийдвэрлэж болно.

Энэ сэдвийн хүрээнд дараагийн дугаарт тодотгох хэсэг бол “Арилжааны заншил, ажил үүргийн хүрээнд тогтсон практик”-ийн асуудал юм.

Иргэний хуулийн 4 дүгээр зүйлд Иргэний хуулийг төсөөтэй хэрэглэх талаар зохицуулсан. Тус зүйлд зааснаар иргэний эрх зүйн харилцаанд орсон талуудын хооронд үүссэн асуудлыг зохицуулах хэм хэмжээ байхгүй бол иргэний эрх зүйн агуулга, зарчим, нийтээр хүлээн зөвшөөрсөн зан суртахууны хэм хэмжээнд нийцүүлэн зохицуулна. Харин ажил үүргийн хүрээнд тогтсон заншил, талуудын хооронд тогтсон практикийг эрх зүйн эх

[3] Арилжаа (худалдаа)-ны хуулийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах судалгааны тайлан, ХБНГУ-ын Ханнс- Зайделийн сан, “Эрх зүйн боловсрол” академи, 2019

сурвалжийн хувьд хүлээн зөвшөөрөөгүй тул талуудын хооронд асуудлыг шийдвэрлэх боломжгүй болж байна. Харин цөөн хэдэн тохиолдолд буюу гэрээ байгуулсанд тооцох, гэрээ тайлбарлах, хэлцлийн хэлбэрт тавигдах шаардлага зэрэгт ажил үүргийн хүрээнд тогтсон заншлыг харгалзаж болохоор заасан байна. Гадаадын зарим улсад заншлыг эрх зүйн эх сурвалжид тооцон харилцааг нөхөн зохицуулдаг байна. Тухайлбал, Япон Улсад заншил нь нийтийн дэг журам, ёс суртахуунд харшлахгүй байх ёстой бөгөөд хуулиар зөвшөөрсөн эсхүл тухайн харилцааг зохицуулсан хууль байхгүй бол дагаж мөрддөг, БНХАУ-д иргэний эрх зүйн маргааныг шийдвэрлэх хууль байхгүй бол заншлын хэм хэмжээг хэрэглэж болох бөгөөд заншил нь нийтийн дэг журам, ёс суртахуунд харшлахгүй байх ёстой байна. Англиийн эрх зүйн тогтолцоонд шүүх тухайн маргаж байгаа журмыг заншил болохыг хүлээн зөвшөөрч, шийдвэрийнхээ үндэслэл болгох замаар заншлыг тогтоодог бол Германд мөн адил заншлыг хүлээн зөвшөөрөх эсэх асуудал нь шүүхтэй салшгүй холбоотой байдаг байна.

Хууль зүй, дотоод хэргийн яам, ХБНГУ-ын Ханнс-Зайделийн сангийн захиалгаар хийсэн “Арилжааны заншил, тогтсон практикийн судалгаа”[4]-гаар Монголын бизнесийн орчинд арилжаа эрхлэгчдийн дунд тодорхой хэмжээгээр арилжааны заншил, тогтсон практик мөрдөгдөж байна, нийтээр хүлээн зөвшөөрсөн зан суртахууны хэм хэмжээнд харш байж болох арилжааны заншил, тогтсон практик байна, түүнчлэн шүүх, арбитр арилжааны заншил, тогтсон практикийг хэрэглэж хэрэг маргааныг шийдсэн тохиолдол төдийлөн түгээмэл биш, тэдгээрийн хэрэглээг практикт дэлгэрүүлээгүй гэсэн дүгнэлт гарсан байна (2011-2021 он гэхэд ердөө 7 хэрэгт хэрэглэсэн)[5]. Онцолбол, 2013 оны сүүлчээс 2020 оны хооронд гаргасан иргэний хэргийн 223,826 шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийж үзэхэд “заншлын хэм хэмжээ”, “талуудын хооронд тогтсон практик”-ийг шүүх хэрэг хянан шийдвэрлэхдээ авч үзэж, шийдвэртээ дурдсан тохиолдол ердөө 15 удаа байсан байна.[6] Эдгээр 15 шийдвэрийг судлахад ихэнх тохиолдолд маргааны талууд байгуулсан гэрээнээсээ гадна талуудын хооронд тогтсон практик, ажил хэргийн хүрээнд тогтсон заншил зэрэг нөхцөл байдлыг харгалзан үзэхийг шүүхээс хүссэн боловч шүүх шийдвэрээ гаргахдаа тус үндэслэлийг нь харгалзан үзээгүй, эсхүл ямар үйлдлийг нь, ямар шалтгаанаар “талуудын хооронд тогтсон практик”, “ажил хэргийн хүрээнд тогтсон заншил” гэж тооцсон болохоо тайлбарлахгүйгээр хэргийг шийдвэрлэсэн байдал нийтлэг байжээ.

Бизнесийн харилцаа байнгын хөдөлгөөнтэй, хувьсан өөрчлөгдөж байдаг динамик шинжтэй харилцаа. Тиймээс шинээр үүссэн бизнесийн харилцаанд үйлчлэх хуулийн зохицуулалт байхгүй бол арилжааны заншлыг эрх зүйн эх сурвалжийн хэмжээнд ашиглаж болохоор, хэрэв

[4] Арилжааны заншил, тогтсон практикийн судалгааны тайлан, ХБНГУ-ын Ханнс-Зайделийн сан, Өмгөөлөл судлалын академи, 2020 он.
[5] Шүүхийн ерөнхий зөвлөлөөс ирүүлсэн статистик мэдээлэл, 2021 он.
[6] Арилжааны заншил, тогтсон практикийн судалгааны тайлан, ХБНГУ-ын Ханнс-Зайделийн сан, Өмгөөлөл судлалын академи, 2020 он, 33 дахь тал.

тухайн заншил нь нийтээр хүлээн зөвшөөрсөн зан суртахууны хэм хэмжээнд харш бол тухайн заншлыг хязгаарлаж, зохих эрх зүйн хэм хэмжээг бий болгох байдлаар хувийн эрх зүйг хөгжүүлэх тогтолцоог бүрдүүлэх нь бизнесийн харилцааг хурдан шуурхай явуулахад дэмжлэг болох юм. Харин арилжаа эрхлэгчдийн дунд тогтсон практикийг гэрээг тайлбарлах, үйл баримтыг үнэлэхэд харгалзах шалгуур болгон ашиглах нь оновчтой байна.

КОВИД-19 цар тахлын улмаас зарим улс орнууд түр хугацаанд хэрэгжих болон шаардлагатай бусад эрх зүйн зохицуулалтыг бий болгожээ[7]. Тухайлбал цар тахлын улмаас үйл ажиллагаа нь доголдсон аж ахуйн нэгжид дампуурлын хэрэг үүсгэх хугацааг сунгах, мораториумын хугацааг сунгахаар заасан бол арилжааны гэрээ хэлцэлд нэг талын эрх ашгийг хамгаалсан зохицуулалт болон урьдчилсан мэдэгдэл өгөлгүйгээр гэрээг цуцлах асуудлыг хориглосон байна. Түүнчлэн, ХБНГУ, Нидерланд, Унгар зэрэг улсад төлбөрийн чадваргүйдлээс урьдчилан сэргийлэх зорилгоор аж ахуйн нэгжид бүтцийн өөрчлөлтийн ажиллагаа явуулах эрх зүйн орчныг бүрдүүлээд байна. Монгол Улсын хувьд Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн төсөлд төлбөрийн чадваргүйдлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны процессыг нарийвчлан тусгаснаас гадна төлбөрийн чадваргүйдлээс урьдчилан сэргийлэх бүтцийн өөрчлөлтийн ажиллагаа буюу хуулийн этгээдийн үйл ажиллагааг сэргээх, дампуурахаас урьдчилан сэргийлэхтэй холбоотой ажиллагааны талаар шинэлэг зохицуулалтыг тусгаад байна.

Эцэст нь, зөвхөн хууль тогтоомжийг боловсронгуй болгосноор бус үүссэн аливаа асуудлыг хуулийн үзэл санаа, зорилгод нийцүүлэн тайлбарлаж хэрэглэх замаар хувийн эрх зүйн харилцааг хөгжүүлэхэд шүүгч, өмгөөлөгч, хуульч, судлаачдын хувь нэмэр, үүрэг оролцоо өндөр ач холбогдолтой болохыг онцолмоор байна.

Гурав. Технологи ба сорилт

Дэлхийн эдийн засгийн форумыг үндэслэгч Клаус Шваб “Дэлхийн технологийн засаглалын чуулга уулзалт-2021”-д оролцохдоо КОВИД-19 аж үйлдвэрийн IV хувьсгалын эрин үед шилжих шилжилтийг хурдасгаж байгааг онцлоод “дижитал болон биологийн, физикийн ертөнц дэх шинэ технологууд хүн-төвтэй үлдэж, нийгэмд бүхэлд нь буюу хүн бүр тэгш, шударга хүртэх байдлаар ашиглагдах ёстой”-г анхааруулсан байна. Тус чуулга уулзалтаар шинэ технологид суурилсан ирээдүйн 5 төсөөллийг[8] хэлэлцсэн байна. Тухайлбал, синтетик биологийн тусламжтайгаар генийн инженерчлэлээр зөвхөн организмын ДНХ-г өөрчлөхөөс гадна генетикийн шинэ код бичих замаар дэлхийг өөрчлөх боломжтой талаар, ирэх 10 жилд гар утас, таблет, зөөврийн компьютер зэрэг төхөөрөмж хэрэглэх

[7] EY Global Legal Commercial Terms Handbook 2020. file:///Users/user31/Downloads/ey-global-legal-commercial-terms-handbook-v1%20(1).pdf

[8] Global Technology Governance Summit 2021, World Economic Forum, https://www.weforum.org/agenda/2021/04/global-technology-governance-summit-gtgs-future/

шаардлагагүй болох талаар, хүний капиталд оруулах хөрөнгө оруулалт хувьсан өөрчлөгдөх талаар, мөн хиймэл оюун ухаан буюу робот хүн төрөлхтний ажлыг булаахаас илүүтэй шинэ ажлын байр бий болгох талаар хэлэлцжээ. Энэ талаар Япон гаралтай Америкийн физикч доктор Мичио Какугийн “Ирээдүйн физик”[9] номд бидний амьдралын хэв маягийг өөрчлөх шинжлэх ухааны нээлтүүдийн талаар бичсэнтэй мөн давхцаж байгааг онцолъё. Түүний таамаглаж байгаагаар ирэх 100 жилд нийгэм аажмаар түүхий эдийн эдийн засгаас оюуны инновацийн үйлдвэрлэл, оюуны эдийн засаг руу шилжинэ. Харин бид үүнд бэлэн үү? Хэдэн жишээ татъя.

Сүүлийн үед анхаарал татаж байгаа сэдвүүдийн нэг бол блокчэйн технологид суурилсан крипто валют буюу виртуал хөрөнгийн асуудал. Монголын зах зээлд нэлээдгүй олон этгээд койн хэмээх тодотголтой виртуал хөрөнгийг олон нийтэд санал болгох замаар хөрөнгө босгож, арилжаа идэвхтэй хийгдэж байна. Гэвч одоогийн байдлаар энэ төрлийн үйл ажиллагааг зохицуулсан, хөрөнгө оруулагчдын эрхийг хамгаалсан эрх зүйн орчин тодорхойгүй байна. Уг харилцааг зохицуулах эхний оролдлого бол Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн төсөл юм. Тус хуулийн төслөөр виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдэд тавих шаардлагыг тодорхойлох, бүртгэх, үйл ажиллагаанд нь хяналт тавих, холбогдох эрх, үүргийг тодорхойлох, үйл ажиллагааг хязгаарлах, бүртгэлээс хасах үндэслэлийг тодорхойлсон. Цаашид бид виртуал хөрөнгийг албан ёсны төлбөрийн хэрэгсэлд тооцох эсэх, төлбөр тооцоонд ашиглаж болох эсэх, цаашид технологийн хөгжлийг дагаад шинэ санхүүгийн үйлчилгээнүүд бий болох тоолонд үндэслэл бүхий хариу өгдөг технологийн судалгааны институт болон түүнд суурилсан эрх зүйн орчныг тасралтгүй хөгжүүлэх гарцаагүй шаардлага үүссэн байна.

2021 оны 10 дугаар сард Фэйсбүүк компани нэрээ өөрчилж, Метавэрс хэмээх дэлгэцээс хардаг биш, дотор нь орж болдог хийсвэр виртуал ертөнцөд ажиллаж амьдрах орчныг бүрдүүлэхээр зорьж байгаагаа зарласан. Цахим орчинд хүний эрхийг хамгаалах асуудал яригдана. Үүнээс том асуудал бол нүдэндээ зүүдэг виртуал төхөөрөмж ашиглан хоорондоо харилцах, ажиллах, худалдаа наймаа хийх, эд хөрөнгө өмчлөх гэх мэт харилцаанууд үүсэх бөгөөд энэ хил хязгааргүй виртуал ертөнцөд ямар хууль эрх зүйн орчин бүрдэх вэ гэдэг асуудал тулгарч байна. Шинэ ертөнцөд хуульчид шинээр хууль бүтээх шаардлагатай юу. Ёс зүйн асуудал анхаарал татаж байна. Бид ямар байр суурь баримтлах вэ.

Нью-Йорк Таймсын 2020 оны 1 дүгээр сард гарсан мэдээгээр Африк Америк гаралтай хүнийг нүүр таних технологи буруу таньсны улмаас гэмт хэрэгт сэжиглэгдэж 30 цаг баривчилсан байна. Энэ мэт нүүр царай таних, блокчэйн, зүйлсийн интернэт буюу IoT, дрон болон бусад технологи ашиглан нийгмийн харилцаанд оролцсоны улмаас үүсэх эрх зүйн үр

[9]Physics of the Future, Michio Kaku, 2011

дагаврыг хэрхэн шийдвэрлэх талаар эрх зүйн орчин хангалттай бүрдээгүй байгааг анхааралдаа авч, дижитал эдийн засгийн сорилтууд, шинэ үзэгдлүүдийг хойноос нь биш зэрэгцэн судлах, улмаар “угтаж харах” алсын хараатай байх хэрэгтэй, үүнд хуульчид бид одооноос бэлтгэх шаардлагатай болж байна.

Түүнчлэн, “ирээдүйн эрх зүй судлал” буюу “legal futurism, legal futurology” гэх ойлголтын талаар хуульчид яриад эхэлсэн байна. Энэ талаар манай улсад хуулийн сургуулиудаас эхлээд төрийн бодлогын түвшинд яригддаггүй сэдэв, ирээдүй судлалыг хуульчдаас илүү социологи, эдийн засаг, бизнесийн сургуульд ерөнхийд нь дурдаад өнгөрдөг байх магадлалтай. Гэхдээ ирээдүйн төсөөллийн талаар эдийн засагчдаас гадна хуульчдын хувь нэмэр чухал байр суурь эзлэх хандлагатай байна. Угтаа хууль зүйн шинжлэх ухаанд танин мэдэхүй, арга зүйн, хэрэглээний чиг үүргээс гадна таамналын чиг үүрэг мөн хамаардаг. Ирээдүйн эрх зүйн судлалын зорилго бол эхлээд ирээдүйн чиг хандлага, үзэгдлийн талаар сайн төсөөлөөд, дараа нь эрх зүйд буулгах явдал бөгөөд манай улсад ихэнх хуульчид эрх зүйн уламжлалт онол, номын хүрээнд батлагдсан хууль тогтоомжийг тайлбарлах, аль нь болох, болохгүйд төвлөрч ажиллаж байна, харин ирээдүйд ямар харилцаа шинээр үүсэх, үүнд хэрхэн бэлтгэх зэрэг асуудалд бэлэн биш байна. Энэ чиглэлээр эрх зүй судлалыг онцолж анхаарах, олон улсын хамтын ажиллагаанд идэвхтэй оролцох цаг ирснийг онцолж байна. Тухайлбал, Гаагийн Эрх зүйн даяарчлалын институт ирээдүйн чиг хандлагыг тодорхойлох салбар хоорондын судалгааг эхлүүлсэн байна. Хүн амын өсөлт, хүнс, байгалийн нөөцийн хомсдол, аюулгүй байдлын заналхийлэл, эдийн засгийн глобалчлал, дэлхийн эрчим хүчний тархалт, мэдээллийн хүртээмжийн өсөлтийн асуудалд дүн шинжилгээ хийсэн байна.

Зарим улс орон цахимаар хэрэг маргааныг шийдвэрлээд (online dispute resolution) эхэлсэн байна. Тухайлбал, БНХАУ-ын Бээжин, Гуанжоу, Ханжоу хотод интернэт шүүхүүд бий болсон бөгөөд тус шүүхээр голчлон оюуны өмч, домайн нэр, цахим худалдаатай холбоотой маргаан, интернэт орчинд бусдын эд хөрөнгийн эрх, ашиг сонирхлыг зөрчсөнөөс үүссэн маргааныг хэлэлцдэг байна. Канад Улсад талууд сайн дурын үндсэн дээр B2B, B2C, C2C харилцаанд цахим шүүхийг сонгож болохоор заасан бол Эстони Улсад бага үнийн дүнтэй буюу 7,000 еврогоос бага дүнтэй хэргийг робот шүүгчээр шийдвэрлүүлж эхлээд байна. Гэтэл манай улсад цахим гэрээ, хэлцэлтэй холбоотой хэрэг, маргаан тэр бүр гардаггүйгээс[10] гадна иргэний хэргийн нэхэмжлэл, хүсэлт, гомдлоо шүүхэд цахимаар гаргах боломжгүй байна.

E-Mongolia төслийн хүрээнд төрийн зарим үйлчилгээг амжилттай цахимжуулсан, бид дараагийн шатанд шүүхийн байгууллагын зарим үйлчилгээг цахимаар хүргэх, хиймэл оюун ухаанаар шийдвэрлүүлэх

[10] Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2021 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн 01/1040 дугаар тоот албан бичигт цахим гэрээ хэлцэлтэй холбоотой хэрэг, маргааны талаар шүүхийн шүүн таслах ажиллагааны статистик мэдээ гардаггүй байна.

боломжийг хамтран судлах хэрэгтэй. Хэрэг маргааныг хүнд сурталгүй, ил тод, шуурхай, зардал багатай шийдвэрлэх нь бизнес эрхлэх орчны чухал шалгуур үзүүлэлт юм.

Товчхондоо хил хязгааргүй ашиглагдах технологийн дэвшил хуульчдад маш олон асуудал тавьж, үүссэн асуудлыг хэрхэн зохицуулах, шийдвэрлэх талаар улс орнуудын хамтын ажиллагааг шаардана. Хил дамнасан цахим орчинд үүссэн гэмт хэргийн шүүхийн харьяалал, хэрэглэх хууль, робот шүүгчийн шийдсэн шийдвэрийг хүлээн зөвшөөрч биелүүлэх зэрэг асуудлыг улс дангаар шийдвэрлэх нь ач холбогдолгүй, улс орнуудын харилцан туслалцаа, хамтын ажиллагааг шаардана.

Дөрөв. Хүний нөөц ба сорилт

Сүүлийн таван жилийн Монгол Улсын Дээд шүүх, Шүүхийн ерөнхий зөвлөл, Хууль зүйн үндэсний хүрээлэн, Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургууль, Дотоод хэргийн их сургууль, Хуульчдын холбоо, Өмгөөлөгчдийн холбооноос эрхлэн гаргадаг хууль зүйн эрдэм шинжилгээ, судалгаа, онол, практикийн ном, сэтгүүл, эмхэтгэл, тайлангийн судалгаанаас харахад нийт бүтээлийн 15-35 хувь нь хувийн эрх зүйн чиглэлийн судалгааны бүтээл эзэлдэг байна. Түүнчлэн, 2017 оны байдлаар Монгол Улсад бүртгэлтэй хуульч эрдэмтдийн эрдмийн зэрэг хамгаалсан сэдвийн ангиллаар авч үзвэл хувийн эрх зүйн чиглэлийн сэдэв нь 8.9 хувь[11] байна. Монгол Улсад хувийн эрх зүйн чиглэлээр дагнан ажиллаж байгаа, судалгаа хийж байгаа хуульчид хангалтгүй буюу маш бага байна.

Хувийн эрх зүй хөгжихгүйгээр нийтийн эрх зүй хөгжихгүй болох нь тодорхой болсон. Бизнесийн нарийн төвөгтэй асуудлууд, шинэ арга хэрэгслүүдийг ойлгохгүйгээр бид эрүү, зөрчлийн асуудлаа шийдвэрлэж чадахгүй. Ялангуяа, технологийн дэвшлээ дагаад цахим орчинд үйлдэгдэх гэмт хэргийн тоо сүүлийн үед өсөн нэмэгдсэн байна. Цахим шинэчлэлтэй холбоотойгоор хуурамч баримт бичиг бүрдүүлэн татвараас зайлсхийх, хуурамч мэдээлэлд хөнгөмсгөөр найдаж, өндөр эрсдэлтэй, баталгаагүй зүйлд хөрөнгө оруулах, цахим орчинд мөрийтэй тоглох, олон шатлалт пирамид хэлбэрийн болон бусад залилан, санхүүгийн гэмт хэргүүд ихээр үйлдэгдэх болсон. Цагдаагийн ерөнхий газраас ирүүлсэн мэдээгээр сүүлийн 10 жилийн хугацаанд Монгол Улсад бүртгэгдсэн нийт гэмт хэрэгт өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 37-53 хувь, эдийн засгийн гэмт хэргийн хувьд 0.6-1 хувь эзэлж байна. Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгээс ирүүлсэн статистик мэдээлэлд сүүлийн 10 жилд эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр шийдвэрлэгдсэн нийт гэмт хэрэгт эдийн засгийн болон өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн эзлэх хувь 24-32 хувь байна.

[11] Ж.Амарсанаа, “Монголын хууль зүйн шинжлэх ухааны хөгжлийг тольдохуй” сэдэвт илтгэлээс. Хуульч эрдэмтдийн үндэсний анхдугаар чуулган, 2017 он.

Хувийн эрх зүйн шинэтгэлийн хүрээнд хүний нөөцөө үе шаттай бэлтгэх бодлогоор бид Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлдөө эрх зүйн бакалаврын сургалтын хөтөлбөрт суралцагч нь хууль зүйн мэргэжлийн боловсрол эзэмшиж төгсөхдөө судалсан нийт багц цагийн 30-аас доошгүй хувь нь хувийн эрх зүйн чиглэлийн хичээл байхаар тусгаад байна. Түүнчлэн, хувийн эрх зүйн чиглэлээр судалгаа хийдэг хуульч, судлаачдад судалгааны тэтгэлэг олгодог хөтөлбөрүүдийг нэмэгдүүлэх чиглэлд төр, их, дээд сургуулиуд, хувийн хэвшил аль аль нь дэмжиж ажиллах хэрэгтэй.

Цаашлаад институтын хэмжээнд хувийн эрх зүйн хөгжлийг харах шаардлагатай гэж үзэж байна. Учир нь өнөөдөр эдийн засаг, бизнесийн харилцаа цаг мөчөөр хэмжигдэж, асар хурдтай өөрчлөгдөж байна. Бид тухайн өөрчлөлт бүрд тохирох эрх зүйн орчныг хурдтай бүрдүүлж өгснөөр бизнесийн давуу талыг бий болгож, эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх боломжтой юм. Үүний тулд судалгааны дэд бүтэц, хүний нөөцийг бүрдүүлэх, бэлтгэх нэн шаардлагатай байна. Цаашлаад шинэ технологийн дэвшил хуулийн салбарын техникийн бичиг цаасны ажлыг хиймэл оюун ухаанаар шийдвэрлээд ирэхийн цагт роботууд хийх боломжгүй оюуны бүтээлч сэтгэлгээ, инновац, манлайллын чанаруудад суурилсан хуульчдыг төрүүлэх нь гарцаагүй болох биз ээ.

Тав. Дүгнэлт

Манай улсын зах зээлийн эдийн засгийн суурь хууль бол яах аргагүй Иргэний хууль юм. Иргэний хуульд 2002 оноос хойш жижиг нэмэлт, өөрчлөлтүүд орж байсан боловч бид Иргэний хуулиа бүхэлд нь эргэн харж, зарчмын хувьд хэрэгжихгүй байгаа, эсхүл өөрчлөх, нэмэх шаардлагатай зохицуулалтаа тодорхойлоогүй явж иржээ. Бидэнд арилжааны шинжтэй зохицуулалтаа иргэд хоорондын харилцаанаас ялган зааглах, Иргэний хуулийн амьдралд хэрэгждэггүй зохицуулалтуудыг анхаарч судлах, технологид суурилсан эрх зүйн харилцаанд хэрэглэх хэм хэмжээг тусгайлан тохируулах шаардлага үүсэж байна. Уламжлалт өмчийн эрх зүйн ойлголт аажмаар өөрчлөгдөж байна. Бизнесийн эрх зүйн харилцааг одоо, ирээдүй цаг дээр төвлөрч цаг алдалгүй шаардлагатай зохицуулалтыг хийх, олон улсын чиг хандлагад ойртуулах сорилт бидний өмнө тулгарч байна. Бид эдгээр сорилтыг боломж гэж харж хурдтай урагшлах ёстой.

Бид “технологи” тодотголтой ирээдүйд оршин тогтнох нь гарцаагүй тул технологийн эрх зүйн хуульчдыг үе шаттай бэлтгэхээс гадна технологийн уугуул иргэдэд зориулж эрх зүйн орчныг бүтээх шаардлагатай болж байгааг онцолмоор байна. Эцэст нь хууль тогтоомжийн хэрэгжилтийг тогтмол үнэлж, эдийн засаг, нийгмийн хэрэгцээ шаардлагад тулгуурласан алсын хараатай эрдэм шинжилгээ, судалгааг бие даан хийх мэргэшсэн институцийг бий болгож, үйл ажиллагааг нь бэхжүүлэх, нөгөө талаас бизнесийг дэмжсэн төрийн бодлогыг тогтвортой хэрэгжүүлэх нь бизнес амжилттай эрхлэх хамгийн чухал шалгуур үзүүлэлт болоод байгааг хүлээн зөвшөөрөх цаг иржээ.

LIVING IN A GLOBAL WORLD:
The HCCH, its Work & its Relevance for Mongolia

Brody Warren
Attaché to the Secretary General | Senior Legal Officer
16 December 2021 | Özyeğin University

WHY HCCH...?

Hague Conference on Private International Law

Conférence de La Haye de droit international privé

WHAT IS THE HCCH?

- An intergovernmental organisation, 1893 origins
- Legislative mandate: "progressive unification of the rules of private international law" (Art. 1, Statute)

90 HCCH MEMBERS

89 States + European Union



Member States

Admitted States

Colombia

Lebanon

El Salvador

NB: Boundaries on this map are based upon those used by the UN Cartographic Section. The number of States reflects the Parties as recorded by the Depositary (NL MFA). Neither should be taken to imply official endorsement or acceptance.

MEMBERSHIP GROWTH



156 CONNECTED PARTIES



90 Members

66 Other Connected Parties

NB: Boundaries on this map are based upon those used by the UN Cartographic Section. The number of States reflects the Parties as recorded by the Depositary (NL MFA). Neither should be taken to imply official endorsement or acceptance.

MONGOLIA

HCCH Member
since 1 July 2021

Party to 3 HCCH Conventions:

- 1954 Civil Procedure (2014)
- 1961 Apostille (2009)
- 1993 Adoption (2000)

REGIONAL PRESENCE



NB: Boundaries on this map are based upon those used by the UN Cartographic Section. The number of States reflects the Parties as recorded by the Depositary (NL MFA). Neither should be taken to imply official endorsement or acceptance.

Permanent Bureau
Main Office
The Hague, Netherlands
(est. 1955)

Regional Office for Asia and the Pacific
Hong Kong SAR, China
(est. 2012)

Regional Office for Latin America and the Caribbean
Buenos Aires, Argentina
(est. 2005)

PIL: KEY QUESTIONS

Jurisdiction
The authorities of which State are competent to decide on questions arising from a cross-border situation?

Applicable Law
The law of which State applies to a cross-border situation?

Recognition & Enforcement
How can judgments or decisions of a State be recognised or enforced abroad?

Cooperation
How can authorities better cooperate to improve efficiency and overcome the obstacles arising in cross-border situations?

LEGISLATIVE MANDATE

- 37 HCCH Conventions, 2 Protocols, 1 soft law instrument, dealing with:
  1. International Family & Child Protection Law
  2. International Legal Cooperation & Transnational Litigation
  3. International Commercial & Financial Law

HCCH CORE CONVENTIONS

Family and child protection law

- 1961 Form of Wills
- 1970 Divorce
- 1980 Child Abduction
- 1993 Adoption
- 1996 Child Protection
- 2000 Protection of Adults
- 2007 Child Support
- 2007 Maintenance Protocol

Transnational litigation and legal cooperation

- 1961 Apostille
- 1965 Service of Process
- 1970 Taking of Evidence
- 1980 Access to Justice
- 2005 Choice of Court
- 2019 Judgments

Commercial and financial law

- 1985 Trusts
- 2006 Securities
- 2015 Choice of Law Principles

HCCH CORE CONVENTIONS



BRIDGING THE GAP

- **Designation** of an applicable law
- **Accommodation** of different options and methods
- **Recognition** and **incorporation** of existing legal concepts/norms
- **Development** of new notions
- Increasing **cooperation** of lines of communication between authorities

KEY ACTIVITIES

Normative Work

- Research
  identifying (other) legal needs within mandate
- Proposals
  for new instruments
- Expert Discussion & Negotiation
  drafting process leading to new instruments: Conventions, Protocols, soft law

Post-Convention Work

- Promotion
  of HCCH & its instruments
- Monitoring
  Special Commissions on practical operation
- Publications
  Guides to Good Practice, Handbooks
- Post-Convention Assistance
  implementation & practical operation; priority given to Members

NORMATIVE PROJECTS

- Parentage / Surrogacy
- Jurisdiction
- Intellectual Property
- Insolvency
- Digital Economy

THE HCCH IN A GLOBAL WORLD

Removing legal obstacles

- Facilitating trade, commerce, and investment
- Supporting access to justice and dispute resolution
- Promoting rule of law and respect for human rights

Creating a coherent cross-border framework

- Providing legal certainty and predictability
- Enabling effective cooperation in an established network
- Respecting diversity of legal systems

Fostering economic and social development

- Long-term sustainability and encouraging use of technology
- Regular monitoring of operation, post-Convention assistance

Brody Warren

Attaché to the Secretary General | Senior Legal Officer

www.hcch.net

“ОЛОН УЛСЫН ХУВИЙН ЭРХ ЗҮЙН ГААГИЙН БАГА ХУРЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА: МОНГОЛ УЛСАД ХАМААРАХ АСУУДАЛ”

Броди Варрен
Олон улсын хувийн эрх зүйн Гаагийн бага хурлын Ерөнхий нарийн бичгийн даргын атташе бөгөөд Нарийн бичгийн дарга нарын газрын хуулийн ахлах ажилтан

2021 оны 12 дугаар сарын 16 | Özyeğin Их Сургууль

ЯАГААД ОЛОН УЛСЫН ХУВИЙН ЭРХ ЗҮЙН ГААГИЙН БАГА ХУРАЛ ГЭЖ...?

ОЛОН УЛСЫН ХУВИЙН ЭРХ ЗҮЙН ГААГИЙН БАГА ХУРАЛ

ОЛОН УЛСЫН ХУВИЙН ЭРХ ЗҮЙН ГААГИЙН БАГА ХУРАЛ ГЭЖ ЮУ ВЭ?

- Олон улсын засгийн газрын нэгдсэн байгууллага, 1893 онд байгуулагдсан
- Бүрэн эрх:
  “олон улсын хувийн эрх зүйн хэм хэмжээг нэгтгэн зохицуулах”

90 ГИШҮҮН ОРОНТОЙ

89 Улс + Европын холбоо



Гишүүн орнууд

Зөвшөөрөгдсөн орнууд
Колумб
Ливан
Эл Салвадор

NB: Boundaries on this map are based upon those used by the UN Cartographic Section. The number of States reflects the Parties as recorded by the Depositary (NL MFA). Neither should be taken to imply official endorsement or acceptance.

ГИШҮҮДИЙН ӨСӨЛТ



156 ХАМТЫН АЖИЛЛАГААТАЙ ОРНУУД



90 Гишүүд

66 Хамтын ажиллагаатай орнууд

NB: Boundaries on this map are based upon those used by the UN Cartographic Section. The number of States reflects the Parties as recorded by the Depositary (NL MFA). Neither should be taken to imply official endorsement or acceptance.

МОНГОЛ УЛС

2021 оны 7 дугаар сарын 1-нд гишүүнээр нэгдсэн

ОЛОН УЛСЫН ХУВИЙН ЭРХ ЗҮЙН ГААГИЙН БАГА ХУРЛЫН 3 КОНВЕНЦД НЭГДСЭН

- 1954 Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа (2014)
- 1961 Апостиль (2009)
- 1993 Үрчлэлт (2000)

БҮС НУТГУУДАД



NB: Boundaries on this map are based upon those used by the UN Cartographic Section. The number of States reflects the Parties as recorded by the Depositary (NL MFA). Neither should be taken to imply official endorsement or acceptance.

Төв байр
Голланд, Гааг хот
(1955 оноос хойш)

Ази, Номхон далайн орнууд дах байр
Хятад улс, Хонг Конг
(2012 оноос)

Латин Америк, Карибын тэнгисийн орнууд дах байр
Аргентин, Буэнос-Айрэс
(2005 оноос)

НАСМ: ТҮГЭЭМЭЛ АСУУЛТУУД

Эрх мэдэл
Хил дамнасан нөхцөл байдлаас үүссэн асуудлыг аль улсын эрх баригчид шийдвэрлэх эрхтэй вэ?

Холбогдох хууль
Хил дамнасан нөхцөл байдалд аль улсын хууль үйлчлэх вэ?

Хүлээн зөвшөөрөх ба хэрэгжүүлэх
Аливаа улсын шүүхийн шийдвэрийг гадаад улс хэрхэн хүлээн зөвшөөрч, хэрэгжүүлэх вэ?

Хамтын ажиллагаа
Хил дамнасан нөхцөл байдалд үүссэн саад бэрхшээлийг даван туулж, хамтын ажиллагааг үр дүнтэй дээшлүүлэхэд эрх баригчид хэрхэн хамтран ажиллах вэ?

БҮРЭН ЭРХ

- Конвенц 37, тогтоол 2 , зарим бүс нутагт үйлчлэх хууль, дүрэм, журам 1 болон дараах үйл ажиллагааг эрхлэж байна:
  1. Олон улсын гэр бүл, хүүхэд хамгааллын хууль
  2. Олон улсын эрх зүйн хамтын ажиллагаа ба үндэстэн дамнасан шүүх ажиллагаа
  3. Олон улсын арилжаа, санхүүгийн тухай хууль

ҮНДСЭН КОНВЭНЦУУД

Гэр бүл болон хүүхэд хамгааллын хуулиуд

- 1961 Гэрээслэлийн хэлбэрүүд 1970 Гэр бүл салалт
- 1980 Хүүхдийн хулгай
- 1993 Үрчлэлт
- 1996 Хүүхэд хамгаалал
- 2000 Насанд хүрэгчдийн хамгаалалт
- 2007 Хүүхдийн тусламж
- 2007 Олон улсын баримт, бичиг

Үндэстэн дамнасан шүүх хурал, олон улсын хамтын ажиллагаа

- 1961 Апостиль
- 1965 Процессын ажиллагаа
- 1970 Нотлох баримт авах
- 1980 Шударга ёсны хүртээмж
- 2005 Шүүхийн сонголт
- 2019 Шүүхийн тогтоолууд

Худалдааны болон санхүүгийн хууль

- 1985 Итгэлцүүр
- 2006 Аюулгүй байдал /Хамгаалалт
- 2015 Хуулийн зүй тогтлыг сонгох

ҮНДСЭН КОНВЭНЦУУД



ЯЛГААГ АРИЛГАХ

- Холбогдох хуулийн тодорхойлолт
- Төрөл бүрийн сонголт болон аргуудын зохицуулалт
- Хэрэгжиж буй хуулийн агуулга болон хэлбэрүүдийг хүлээн зөвшөөрөх, нэгтгэх
- Шинэ ойлголтыг хөгжүүлэх
- Эрх баригчдын хоорондын харилцаа, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх

ГОЛЛОХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Өдөр тутмын үйл ажиллагаа

- Судалгаа
  бүрэн эрхийнхээ хүрээнд (бусад) хууль эрх зүйн хэрэгцээг тодорхойлох
- Санал боловсруулах
  шинээр хэлэлцээр хийх
- Мэргэжилтнүүдийн хэлэлцүүлэг ба хэлэлцээр
  конвенц, протокол, зарим бүс нутагт үйлчлэх хууль зэрэг шинэ баримт бичгүүдэд хүргэдэг төсөл боловсруулах үйл явц

Конвенцын дараах ажиллагаа

- Түгээн дэлгэрүүлэх
  Олон Улсын Хувийн Эрх Зүйн Гаагийн бага хурлаас гарсан хэлцэл
- Ажиглалт
  Практик ажиллагааны тусгай комисс
- Хэвлэн нийтлэх
  Заавар, зөвлөмж, гарын авлага
- Конвенцийн дараах тусламж
  хэрэгжилт, практик үйл ажиллагаа; гишүүдэд олгогдсон давуу эрх

ТӨСЛҮҮД

- Эцэг эх / тээгч эх
- Шүүх эрх мэдэл
- Оюуны өмч
- Төлбөрийн чадваргүй байдал
- Цахим эдийн засаг

ОЛОН УЛСЫН ХУВИЙН ЭРХ ЗҮЙН ГААГИЙН БАГА ХУРАЛ ДЭЛХИЙ ДАХИНД

Хууль эрх зүйн хүндрэл бэрхшээлийг арилгах

- Худалдаа, хөрөнгө оруулалтыг дэмжих
- Шүүхэд хандах, маргааныг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх
- Хууль дээдлэх, хүний эрхийг хүндэтгэх

Хил дамнасан уялдаа холбоотой тогтолцоог бий болгох

- Хууль эрх зүйн тодорхой хэрэгжилтийг хангах
- Тогтвортой хамтын ажиллагааг тогтоох
- Хуулийн тогтолцооны ялгамжит байдлыг харгалзан үзэх

Эдийн засаг, нийгмийн хөгжлийг дэмжих

- Урт хугацааны тогтвортой байдал, технологийн хэрэглээг дэмжих
- Үйл ажиллагааны байнгын хяналтыг хэрэгжүүлэх, шаардлагатай тусламж үйлчилгээг тухай бүр үзүүлэх

Броди Варрен

Олон улсын хувийн эрх зүйн Гаагийн бага хурлын Ерөнхий нарийн бичгийн даргын атташе бөгөөд Нарийн бичгийн дарга нарын газрын хуулийн ахлах ажилтан

www.hcch.net

HCCH

Connecter Protéger Coopérer Depuis 1893
Connecting Protecting Cooperating Since 1893

Монгол Улс дахь хувийн эрх зүйн судалгаа ба эрх зүйн динамик: чиг хандлагыг тодорхойлох нь

Research on Private Law and Legal dynamics in Mongolia: Inquiring the future

Батболдын Амарсанаа
МУИС-ийн Хууль зүйн сургуулийн захирал, хууль зүйн доктор, профессор

"Монгол Улс дахь хувийн эрх зүйн шинэтгэлийн явц, тулгамдаж буй асуудал" олон улсын эрдэм шинжилгээний хурал, 2021.12.16, Шангри-Ла, Улаанбаатар, Монгол Улс

v. 20211222

Агуулга

I. Ухагдахууныг тодруулах нь
II. Асуудал, эрх зүйн шинэтгэл, академик судалгаа
III. Жишээ: Арилжааны хуулийн төсөл
IV. Дунд хугацаанд хийгдэх Хувийн эрх зүйн шинэтгэлийн асуудал: хувийн ажиглалт
V. Нэгтгэн үзэхэд

I. УХАГДАХУУНЫГ ТОДРУУЛАХ НЬ

Хувийн эрх зүй, эрх зүйн динамик

- Хувийн эрх зүй /private law/ = иргэний /civil law/ + **арилжааны /commercial law/** + ... Эрх зүй/

- Эрх зүйн динамик /Legal dynamics, dynamics of law/ - цаг хугацааны хэмжигдэхүүнд өөрчлөлтийг тайван замаар хийхийг илэрхийлнэ
  - зөвхөн норматив хэм хэмжээ бий болгох нь нийгэмд хүлээн зөвшөөрөгдөхгүй, эргэж буцах (хуулийг хүчингүй болгох, өөрчлөх) хандлага байдаг, үүнээс хэтдээ зайлсхийх

Эрх зүйн динамик ба Эрх зүйн статик байдал

- Эрх зүйн динамик ба Эрх зүйн статик байдал /static law/-г эсрэгцүүлэх нь
  - Эрх зүйн статик байдал гэдэг нь хүчин төгөлдөр мөрдөгдөж буй эрх зүй/хууль/-ийг ойлгодог.
  - Тиймээс хуульд нэмэлт, өөрчлөлт орох, хүчингүй болох тохиолдолд эрх зүйн динамик байдал бий боллоо гэж үзнэ.
- Статик байдалд буй эрх зүй /хууль/ нь батлагдах/хүчин төгөлдөр байх үедээ итгэл үнэмшлийн систем /belief system/ гэж тооцогдоно.
  - Хуулийн нэмэлт, өөрчлөлт, хүчингүй болгох явдал
    - =
  - итгэл үнэмшлийн тогтолцоог өөрчилж байгаа хэрэг

II. АСУУДАЛ, ЭРХ ЗҮЙН ШИНЭТГЭЛ, АКАДЕМИК СУДАЛГАА

Чөлөөт уналт: Монголын нийгэм дэх **ИТГЭЛ (trust, confidence)**



ҮР ДАГАВАР: 2 туйлт үзэл
+ Хуулиар бүхнийг зохицуулах ухамсарлаагүй хариу үйлдэл
+ Хуулийг үгүйсгэх, эрх зүйд үл итгэх төөрөгдсөн үзэл

АСУУЛТ: Унасан итгэлийг хэрхэн эрх зүйн хувьд сэргээх, хамгаалах вэ?

ХАРИУЛТ: Хувийн ажиглалт, дүгнэлт (social impact)-ээ хуваалцахуйд

Судалгааны үр дүн: Арилжааны эрх зүйн харилцаанд

- Ханнс-Зайделийн сангийн санхүүжилт, ХЗДХЯ-ны захиалгаар хийсэн Арилжааны хууль тогтоомжийн зохицуулалтын талаарх бизнес эрхлэгчдийн байр суурь Судалгааны тайлан, 2020

- Арилжаа эрхлэгчдийн бие биедээ, нийтлэг эрх зүйн тогтолцоонд итгэх итгэл унасан, маш доогуур байдал
    - Жишээ: гэрээг бичгээр хийх хэтийдсэн хандлага ба нотлох баримтын зорилго голлох хандлага

Монголын нийгэм дэх итгэлийг хэрхэн сэргээх вэ?

- *Итгэл үнэмшлийн тогтолцоо (belief system)*-г өөрчлөх замаар буюу эрх зүй /хууль/-ийг өөрчлөх замаар хэрхэн асуудлыг шийдвэрлэх вэ.

- Үүнийг хийхийн тулд эрх зүйн шинэтгэл гаргалт ба академик судалгаа хэрхэн хамаарахыг энд хөндөнө.

Эрх зүйн шинэтгэлийн шийдвэр гаргалт ба судалгааны үр дүн: холбоо хамаарал

- Эрх зүйн шинэтгэл ≈ Улс төрийн шийдвэр /Эрх зүйг гол агуулагч нь хууль тогтоомж байгаа цаг үе/
- Улс төрийн шийдвэр гаргалт:
  - Сонгуулийн өмнөх ≈ 1 жил /Улс төрийн намын мөрийн хөтөлбөр/

    +
  - сонгуулийн дараахь ≈ 6 сар /Засгийн газрын мөрийн хөтөлбөр/

    +
  - Бэлтгэл ажил ба **судалгаа** /холбогдох яамд болон УИХ-ын гишүүний ажлын алба/ ≈ Хууль тогтоомжийн хуульд заасан баримт бичгийн бүрдэл
    - - Ажиглалт: хүн/цагаар харьцангуй богино цаг зарцуулагддаг

Шинэтгэлийн шийдвэр гаргалт ба судалгааны үр дүн (2)

- Академик судалгааны үр дүн:
  - Бие даан/хараат бусаар судалгааны сэдвээ тодорхойлох /хугацаанд баригдахгүй/
    - +
  - Судалгаа хийх /хугацаанд баригдахгүй/
    - +
  - Судалгааны үр дүн улс төрийн шийдвэр гаргалтын үндэс, суурь болох баталгаагүй
    - Маш их хүн/цагийг зарцуулах, зориулах боломжтой

III. ЖИШЭЭ: АРИЛЖААНЫ ХУУЛИЙН ТӨСӨЛ

Арилжааны тухай хуулийн төслийн шийдвэрлэх үндсэн асуудал /Статик эрх зүйн хувьд/

- Итгэлийг хамгаалах
- Итгэлцлийг хамгаалах – эрх зүйн харилцаанд оролцож буй хүмүүсийн үйлдлийн хууль зүйн хувьд хүчин төгөлдөр байдлыг хангах (олон жилийн туршид хамтран бизнес хийсэн хүмүүс тухайн тохиолдолд үнэ тохиролцолгүй, шууд нэрлэн заалгүйгээр /Амар: Базар аа, нөгөөдөхөө өгөөд явуулаарай"/ худалдааны харилцаанд ороход энэ нь хууль зүйн хамгаалагдах эсэх эргэлзээтэй байна)
- "Гэмгүй" гуравдагч этгээдийн эрх ашиг /итгэл/-ийг эрх зүйн тогтолцоо хамгаална, онцын хүндрэлгүйгээр сэргээнэ гэх итгэл
- Итгэлийг сэргээх – Дээр дурдсан нийтлэг тохиолдлуудтай холбоотойгоор унасан "ерөнхий" итгэлийн төвшинг дээшлүүлэх

Шинэтгэлийн шийдвэр гаргалт ба судалгааны үр дүн: Арилжааны хуулийн төслийн жишээ (1)

- Арилжааны эрх зүйн талаарх байр суурь эргэн сэргэсэн нь 2015 оны сүүлээс эхлэлтэй (2000-2003 оны орчим Жайка-гийн төсөлтэй хамтран хурал/хэлэлцүүлэг зохион байгуулж байсан)
- 2016.04.08 /ХЗҮХ-д/ - МУИС-ийн ХЗС (УИХТГ, ХЗЯ, МХХ, ШУА-ын ФХ, ХЗҮХ-тэй хамтран) зохион байгуулсан *"Хууль зүйн нэр томьёоны судалгаа, хэрэглээ" сэдэвт эрдэм шинжилгээний хурал"*Хувийн эрх зүйд аж ахуйн (худалдааны) эрх зүйн нэр томьёоны эзлэх байр суурь" илтгэл

- 2016.10.21 /Төрийн ордонд/ - МУИС-ийн ХЗС, УИХТГ, ХЗДХЯ, МХХ, Ханнс-Зайделийн сан хамтран зохион байгуулсан *"Монгол Улсын Хувийн эрх зүйн тулгамдсан асуудал: Иргэний болон Худалдааны хууль тогтоомжийн олон улсын жишиг" Олон улсын симпозиум*

- 2017.09.16 – МУИС-ийн ХЗС хамтран *"Монгол Улс, Япон Улсын хууль тогтоомжийн хөгжил: худалдаа (арилжаа)-ны эрх зүй"* олон улсын хурал

Шинэтгэлийн шийдвэр гаргалт ба судалгааны үр дүн: Арилжааны хуулийн төслийн жишээ (2)

- АЛБАЖИХ ШАТ

- 2018.05.31 - ХЗДХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын А/30 дугаар тушаалаар Арилжааны хууль боловсруулах хэрэгцээ, шаардлага бий эсэхийг урьдчилан тандан судлах шийдвэр
  - Арилжаа /худалдаа/-ны хуулийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах Судалгааны тайлан, 2019 /108 нүүр/
- 2019.05.27- ХЗДХ-ийн сайдын А/30 дугаар тушаалаар Арилжааны хуулийн төсөл боловсруулах шийдвэр
- 2020.09.09 - ХЗДХ-ийн сайдын А/45 дугаар тушаалаар Арилжааны хуулийн төсөл боловсруулах шийдвэр

Арилжааны хуулийн төсөл: Судалгаа, судалгааны өгөгдөхүүн бэлтгэх үе шат

- **Гадаад улсуудын холбогдох хуулийг хэвлэж судалгааны эргэлтэд оруулах /МУИС-ийн ХЗС/:**
  - ХБНГУ-ын Иргэний хууль /BGB/ 2017.01
  - ХБНГУ-ын Арилжаа /худалдаа/-ны хууль /HGB/ 2018.12
  - Японы Арилжаа /худалдаа/-ны хууль /日本国商法典/
  - Японы Иргэний хууль /日本国民法典/ 2016.10, 2018.09
  - БНХАУ-ын Иргэний хууль /中华人民共和国民法典/ - 2021.12
  - Эх газрын эрх зүйн бүлд хамаарах 60 орчим улсын Иргэний ба Арилжааны хуулийн эмхэтгэл /21 боть 10 мянга орчим нүүр/ 2018.09 /T.Ginsburg – Comparative Constitutions Project UChicago 2016/
  - БНСУ-ын Иргэний хууль /민법/ 2019
- Гадаадын улсууд /ОХУ, Франц, Япон, ХБНГУ/ арилжааны эрх зүйн тодорхой сэдвээр хамтын монограф /хэвлэгдээгүй/
- Гадаад орнуудын арилжааны /худалдааны/ тухай хуулиудын харьцуулсан судалгаа /судалгааны ажлын тайлан/, ХЗДХЯ-ны захиалга, 2019 /100 орчим нүүр/

Арилжааны хуулийн төсөл: Гүнзгийрүүлэн ойлгох нь: эрх зүйн соёлын ялгаа (cultural difference) болон түүхэн хөгжлийн үе шатыг тооцох

- Шалтгаан: 1. Гадаадын зарим хуулиуд хэт хуучин тул эрх зүйн хэм хэмжээнээс эрх зүйг шууд ойлгох боломжгүй. /Шүүхийн тайлбар, онолын тайлбар г.м./ 2. Ирээдүйн хандлага
- Санал солилцох уулзалтууд
  - Японд 2 /2018, 2019 он/ удаа /20 хүнтэй баг 10 гаруй хуульч, эрдэмтэд, албан хаагчтай уулзалт/
  - ХБНГУ-д 1 /2018 он/ удаа /7 хүнтэй баг 10 гаруй хуульч, эрдэмтэд, албан хаагчтай уулзалт/
  - Франц-д 1 /2020 он/ удаа /2 хүнтэй баг 10 гаруй хуульч, эрдэмтэд, албан хаагчтай уулзалт/
  - Монголд олон удаа /ХБНГУ шүүгч др. Фишер, Канновски, Япон-Проф. Токумото, Проф. Минова, Проф. Като, Өмгөөлөгч Ешино, өмгөөлөгч Ока г.м., БНСУ-Проф. Ким Дон Хүн/
  - Онлайн /АНУ-Аризона Проф Козольчук .../
- Жишээ:
  - Unternehmen vs. Kaufmann,
  - Хувийн эрх зүйд арилжааны эрх зүй орох уу? Private law vs. commercial law)
  - Арилжааны гэрээ ба Арилжаа эрхлэгч ба Холимог систем (Commercial contract or Merchant or Mixed system)-ийн аль нь оновчтой эсэх

Арилжааны хуулийн төсөл: Path-dependent trajectory – үйл хөдлөлийг өөрчлөхөд уламжлалыг анхаарах

- Эрх зүйн уламжлал: Судалгаанаас хайх нь
  - Монголын хувийн эрх зүйн судалгааны товчоон (1928-1990), 2019 – 1050 нүүр эмхэтгэл, аж ахуй, аж ахуйн гэрээ г.м.-д холбогдох судалгааны өгүүлэл, баримт материал
- Хууль тогтоогчийн хүсэл зоригийг тандахуйд:
  - 1930.08.06 – БНМАУ-ын Худалдааны тухай хууль
  - Монгол Улсын Иргэний хуульд холбогдох баримт бичиг (2001-2002), 2018, МУИС-ийн ХЗС, Өмгөөлөл судлалын академи – арилжаанд холбогдох хэм хэмжээний тухайд, 1500 нүүр баримт
  - БНМАУ-ын Иргэний хууль (1963)-ийн нэмэлт, өөрчлөлтөд холбогдох баримт бичиг (1990), МУИС-ийн ХЗС, Өмгөөлөл судлалын академи – тухайлсан асуудал хэрхэн хөндөгдсөн тухайд, 166 нүүр баримт

Арилжааны хуулийн төсөл: Монголын эрх зүй дэх статик байдлыг тогтоох нь

- Арилжааны заншил, тогтсон практик бий эсэх /одоо байгаа байдал ба статик эрх зүй/
  - Арилжааны заншил, тогтсон практикийн судалгааны тайлан, Ханнс Зайделийн сангийн Эрх зүйн боловсролын академи, Өмгөөлөл судлалын академи ТББ, 2020 /180 орчим нүүр/
- Монгол болон Япон Улсын арилжааны эрх зүйн хууль тогтоомж, арилжааны заншил зэрэг асуудлын судалгаа, МУИС, Кюшюгийн их сургууль, Япон Улсын Хууль зүйн яам, 2021 /япон хэлээр 207 нүүр/
- Иргэний хуулийн III хэсэг /Гэрээний эрх зүй/-т заасан арилжааны гэрээний төрлүүдийн судалгаа /Судалгааны ажлын тайлан/, ХЗДХЯ-ны захиалга, 2019 /122 нүүр/

Арилжааны хуулийн төсөл: Нийгмийн импакт (social impact)-ийг тандах нь

- Хуулийн төслийн нөлөөлөл үүсэх, үйл хөдлөлийг нь өөрчлөхөд хүргэх субьектэд чиглэсэн судалгаа
  - Арилжааны хууль тогтоомжийн талаарх бизнес эрхлэгчдийн байр суурь, Ханнс Зайделийн сангийн Эрх зүйн боловсрол академи, Өмгөөлөл судлалын академи ТББ, ХЗДХЯ-ны захиалга, 2020 – Социологийн судалгаа /86 нүүр/
    - Цаашид хийгдэх судалгаа: Хэлцлийн зардал буурах эсэхийг тооцох хэрэгтэй байна

Арилжааны хуулийн төсөл: Systems thinking – Академик судалгаанд системийн үүднээс хандах нь

- Академик судалгаа өргөнөөс нарийвчлан судлах хандлагатай /ерөнхийгөөс тусгай руу/
- Дор дурдсан зүйлсийн хамаарлыг тогтоох, учрыг олох шаардлага:
  - Хувийн эрх зүйн цар хүрээ, харилцан хамаарал
  - Иргэний эрх зүйн хамаарал
  - Хэрэглэгчийн эрхийг хамгаалах ба хэрэглэгчийн гэрээ
  - Захиргааны үйл ажиллагаа эсэх – Хуулийн этгээдийн бүртгэл, түүний эрх зүйн үр дагавар

Шинэтгэлийн шийдвэр гаргалт ба судалгааны үр дүн: ОЮУН ДҮГНЭЛТ

- Улс төрийн шийдвэр гаргагч судлаачдаас үр дүнг шаарддаг хугацаа ≤ академик судалгааны үр дүн гардаг хугацаа /ЗӨРҮҮ/
  - Академик судалгаа мөн чанарын хувьд цаг хугацаа их шаарддаг тул түрүүлж эхлэх ёстой
  - Улс төрийн шийдвэр гаргагчид үндэслэл бүхий судалгааг анхаарч байх нь зүйтэй
  - Олон хүний цаг хугацаа (хүн/цаг), их хэмжээний хөрөнгө, байнгын анхаарал тавих шаардлага
  - Академик судалгаа - ерөнхийгөөс нарийвчилсан шинж давамгайлах нь олонтой

Цаг үеийн шаардлагыг бүхэлд нь дүгнэхэд

- Итгэлийг хамгаалах, сэргээхэд чиглэгдсэн
- **Монгол Улсын хувийн эрх зүй дэх арилжааны шинжийг тодотгох үйл явц** буюу **”Commercialization of Private Law in Mongolia” movement эхлэх шаардлага**

Нэгдмэл байдал, мэтгэлцээнд ач холбогдол өгөх нь ба бусад анхаарах асуудлууд

- Шинэтгэлийн шийдвэр гаргалт ба судалгааны үр дүнгийн нэгдмэл байдал /+ дотоод мэтгэлцээн/ чухал
  - Шинэтгэлийг эхлүүлэхээс гадна бүх үе шат /боловсруулах, нийгэмд таниулах г.м./-д харилцан хүндэтгэлтэй хандах
- Хэт яарахгүй байх
- Хэт томоор сэтгэх, хийхээс зайлсхийх /Улсуудын туршлагаас үзэхэд жишээлбэл, Иргэний хуулийн нэг институцийг нэг удаадаа шинэчилдэг/

IV. ДУНД ХУГАЦААНД ХИЙГДЭХ ХУВИЙН ЭРХ ЗҮЙН ШИНЭТГЭЛИЙН АСУУДАЛ: ХУВИЙН АЖИГЛАЛТ

Эрх зүйн шинэтгэлийн ирээдүйн давалгаанд бэлтгэх нь (1):
Онолын үндэс, статик эрх зүйг өөрчлөх нь:

- Иргэний процесс /шийдвэр гүйцэтгэл/ – практик хүндрэлийг нэг бүрчлэн шийдвэрлэх хандлага, улмаар зүй ёсны эрх зүйн хэм хэмжээ биелэлээ олохгүй байх, материаллаг эрх зүйг үгүйсгэх, өөрчлөх төөрөгдөл

- Гэм хор – гэрээний бус үүрэг, маш их асуудал

Эрх зүйн шинэтгэлийн ирээдүйн давалгаанд бэлтгэх нь (2): Онолын үндсийг төгөлдөржүүлэх, статик эрх зүйг “өөрчлөх”

- Өв залгамжлал /+нийтийн эрх зүйн хүрээний онол, бодлоготой уялдуулах, шударга ёсны шалгуур тавигдах магадлал/
  - Нөхцөл байдал: Монголын нийгэм дэх хөрөнгийн хэмжээ ихэссэн, анхдагчид хөрөнгөө хуваж эхлэх, үйл явц, байгалийн жам
- Өмч, түүнийг гол тээгч хуулийн этгээдийн асуудал – нэг мөр ойлгох шаардлага

V. Нэгтгэн үзэхэд

- Цаашдын чиг хандлагыг бүхэлд нь дүгнэх боломжгүйг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй.
- Монгол Улсын хувийн эрх зүй дэх арилжааны шинжийг тодотгох үйл явц “Commercialization of private law” movement эхлэх нь зүйтэй.
- Хувийн эрх зүйн тогтолцоо (ер нь эрх зүйн тогтолцоо өөрөө) бусдад өгөх итгэлийг сэргээх, хамгаалах ёстой бөгөөд Монголын нийгэм, аж ахуйн харилцаа, хувийн харилцаан дахь итгэлийг сэргээх нь дунд хугацааны зорилго юм.
- Статик эрх зүйгээс эрх зүйн динамикийг бий болгох үйл явцад судлаачид академик судалгааг урьдаас хийж, эрх зүйн шинэтгэл эхлэхэд судалгааны бэлтгэлтэй байх хэрэгтэй.
- Цаашид эх газрын эрх зүйн тогтолцоонд нийтлэг байдаг хандлага – Хувийн эрх зүйн бүх институц /гэрээ, гэм хор г.м./-ийг нэг мөсөн бус тухайлсан институцэд шинэчлэл хийх хандлага зонхилох нь зүйтэй

ХУВИЙН ЭРХ ЗҮЙН ШИНЭТГЭЛ БА ИРГЭНИЙ ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА

PRIVATE LAW REFORM AND CIVIL PROCEEDING

Пунцагийн Золзаяа
Улсын Дээд шүүхийн шүүгч
Ms. Zolzaya Puntsag
Justice, Supreme Court of Mongolia

Хураангуй:

Илтгэлд эрх зүйн шинэтгэлийн эрх зүйн цогц асуудал, хувийн эрх зүйн шинэтгэлд иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үзүүлэх үр нөлөө, шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд тулгарч буй бэрхшээл, шийдвэрлэх арга замын талаар дурдсан.

Abstract:

This report aims to address the complex legal issues of private legal reform, the impact of civil proceedings on private law reform, the challenges of the proceedings facing, and possible its solutions.

Түлхүүр үгс: *Хүний эрх, хууль тогтоомж, худалдааны эрх зүй, шүүгчийн мэдлэг, ур чадвар, иргэдийн эрх зүйн ухамсар, эрх зүйн соёл, иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа.*

Key words:

Human rights, law, legislation, trade law, knowledge and skills of judges, legal awareness of citizens, legal culture, civil proceedings.

Нэг.

Хувийн эрх зүйн шинэтгэл эрх зүйн талаасаа дараах цогц асуудлаас шууд хамаараалтай. Үүнд:

1.Зах зээлийн эдийн засаг, төрт ёсонд нийцсэн хуультай байх;

2. Хуулийг хэрэгжүүлж чадах мэдлэгтэй, ур чадвартай, ёс зүйтэй шүүгч байх;

3. Иргэдийн эрх зүйн ухамсар, эрх зүйн соёл;

4. Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа.

Тодруулбал, сайн хууль байх ёстой, уг хуулийг хэрэглэх чадвартай шүүгч байх ёстой, иргэдийн эрх зүйн ухамсар, соёлын төлөвшил, хөгжил болон оновчтой зохистой иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хувийн эрх зүйн шинэтгэлийн гол хүчин зүйл юм.

1.1 Монгол Улсад одоо цагт эрх зүй нь нийгмийн зохион байгуулалтын хэм хэмжээний үүргээ ямар хэмжээнд гүйцэтгэж байгаа вэ гэдэг дээр хуульч, судлаач, эрдэмтдийн зүгээс дүгнэж, үзэл бодол, саналаа дэвшүүлсээр байна. Парламентаас баталсан хууль тогтоомж

улсынхаа эдийн засаг, уламжлал, зан заншилд нийцсэн эсэх, эрх зүйн субъектын зан үйлийн хэм хэмжээг хязгаарласан эсэх, шударга ёсны хэмжүүрт нийцэж байгаа эсэх асуудал эрх зүйн хэм хэмжээний мөн чанар, түвшинг харуулах нь зүй ёсны хэрэг юм.

Хууль боловсруулахад шүүхийн практик чухал бөгөөд хууль гаргах нь өөрөө олон үе шаттай, бүхэл бүтэн процедур. Хууль гаргах, батлах ажлыг үр дүнтэй, алсыг харсан, шинжлэх ухааны үндэслэлтэй хийж хэвшиж, тогтсон дэг журмыг тогтоохгүй бол түүнийг үргэлжлүүлэн амьдралд зөв тайлбарлаж хэрэглэх, биелүүлэхэд хүндрэл учирч байгаа талаар тодорхой жишээнүүдийг онцлон дурдъя. Хувийн эрх зүйн суурь хууль болох Иргэний хуулийн үзэл баримтлал, системчлэлтэй зарим талаар зөрчилдсөн тусгай хууль цөөнгүй байна.

Жишээ 1:

Үл хөдлөх хөрөнгийн барьцааны тухай хууль /2009/, Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хууль, /2015/, 2006.07.08-ны өдөр батлагдсан Ашигт малтмалын тухай хуулиудын өрсөлдөөн.

Хуульд зааснаар хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тусгай зөвшөөрлийг хууль тогтоомжоор барьцаалахыг хориглоогүй эд хөрөнгийн хамтаар банк, банк бус санхүүгийн байгууллагад барьцаалах эрхтэй. Харин тусгай зөвшөөрөл эзэмшигч нь барьцааны гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол төрийн захиргааны байгууллага энэ тухай барьцаалагчид мэдэгдэх бөгөөд барьцаалагч нь Ашигт малтмалын тухай хуулийн 52 дугаар зүйлд зааснаар Монгол Улсад байгуулагдсан, татвар төлөгч, сонгон шалгаруулалтад оролцсон хуулийн этгээдэд тусгай зөвшөөрлийг шилжүүлэх саналыг тэргүүн ээлжид гаргах эрхтэй гэж үүрэг хангуулах журмыг заасан. Гэвч нөгөө талаас шүүхийн шийдвэрийг сайн дураар биелүүлээгүй бол шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа явагдах боловч тусгай зөвшөөрөл барьцааны зүйл байсан тохиолдолд барьцааны зүйлээс үүргийг хангуулах ажиллагаа дуудлага худалдаагаар хязгаартайгаар явагдах уу, эсвэл Ашигт малтмалын тухай хуулиар явагдах уу хоёр өөр байдлаар зохицуулсан байна. Ийнхүү худалдан борлуулах ажиллагааны өөр өөр журмыг хуулиар зохицуулсан учраас барьцааны зүйл болох тусгай зөвшөөрөл, дагалдах эд хөрөнгөөс үүргийг хангуулах ажиллагаа бодит байдалд тодорхой бус орхигдсон. /Ашигт малтмалын тухай хуулийн 7, 51, 52 дугаар зүйл/

Түүнчлэн, Ашигт малтмалын тухай хууль, Иргэний хуульд зааснаар тусгай зөвшөөрлийн хууль ёсны эзэмшигч нь эзэмшлийн зүйлээ бусдад шилжүүлэх эрхтэй. Гэтэл компанийн хувьд хувьцаа худалдах, бэлэглэх замаар аль ч ажиллагааг нь баримтлахгүйгээр зөвхөн компанийн хувьцаа эзэмшигч өөрчлөгдөж байгаа нь далд аргаар эрх шилжүүлэх ажиллагаа явагдах нөхцөлийг бий болгосон, энэ нь хуулийн үзэл баримтлал, зорилгыг алдагдуулж байна, энэ талаар өнөөдөр хэн ч дуугарахгүй байна.

Жишээ 2:

Даатгалын тухай хуульд зааснаар даатгалын компани мөнгө зээлдүүлэх, холбогдох этгээдийн бусдаас авсан зээлд баталгаа, батлан даалт гаргахыг хориглосон атлаа хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.3-т аливаа этгээдэд барьцаагүй зээл олгохыг хориглосон. Үүнээс үзвэл хориглосон /холбогдох/ этгээдээс бусдад барьцаатай зээл олгож болох агуулгатай байгаа нь зөрчилтэй болсон. Түүнээс гадна санхүүгийн зах зээл дээр үүргийн гүйцэтгэлийг хангах арга болох баталгааны дотроос банк, даатгалын компанийн баталгааг хамгийн найдвартай гэж үздэг үзэл, худалдааны заншил тогтсон байна. Даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлд зааснаар даатгалын компани Санхүүгийн зохицуулах хорооноос гаргасан журмын хүрээнд бизнесийн үйл ажиллагаа эрхлэх эрхтэй ба баталгаа гаргах нөхцөлийг зохицуулсан хянах эрх зүйн орчин байхгүй. Гэтэл өнөөдөр даатгалын компаниуд баталгаа гаргах ажиллагааг аль хэдийн явуулж, холбогдох маргаан шүүхээр шийдвэрлэгдсээр байна.

Дээрх тохиолдолд шүүх хэм хэмжээг төсөөтэй хэрэглэх, эсвэл Иргэний хуулийн зарчимд нийцүүлэн хуулийг хэрэглэх үндэслэл байх боловч зарчмын хувьд хэм хэмжээ тогтоож, хууль тогтоогчийн эрх мэдэлд халдах вий гэдгээс сэргийлсэн байдалтай хандаж ирсэн, хувийн эрх зүйд чухал үр нөлөөтэй эдгээр асуудал үндсэндээ хуулиар оновчтой шийдвэрлэгдэж чадаагүй орхигдсон байдалтай байна.

Жишээ 3:

Түүнчлэн, Санхүүгийн түрээсийн тухай хууль, Хөдлөх хөрөнгийн барьцааны тухай хууль батлагдсан хэдий ч Иргэний хуультай давхардсан учраас тэр бүр хэрэглэгдэхгүй байна.

1.2. Хууль тогтоогч хэм хэмжээ тогтоохдоо тогтолцооных нь хувьд хэрэгжих боломжтой, ойлгомжтой, зөрчилгүй норм бий болгох нь хууль тогтоогчийн эрх хэмжээ бөгөөд үүрэг нь байдаг. Иймхүү ерөнхийлөн тогтоосон хэм хэмжээг хэрэгжүүлэх ажиллагааных нь хувьд эрх зүйн дэд акт бий болгож хэрэгжилтийг зохион байгуулах нь гүйцэтгэх эрх мэдлийн чиг үүрэг байдаг бол, тухайн харилцаанаас үүссэн маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны хүрээнд шүүх хуулийг хэрэглэх, ингэхдээ зөв тайлбарлаж, зөв хэрэглэх ёстой болно.

Хувийн эрх зүйн төртэй харилцах харилцаа нь эрх зүйд тулгарч буй сорилтуудын нэг юм. Хувийн эрх зүйн хүрээнд төрийн үзэл баримтлал байхгүй байсан ч хувийн эрх зүй нь үргэлж нийгмийн бодлогоос хараат гэж АНУ-д үздэг бол Европт төр хувийн эрх зүйн эрх мэдлийн эцсийн эх үүсвэр хэдий ч хувийн эрх зүйн хүрээнд шийдвэр гаргахад чухал ач холбогдолгүй гэж үздэг. Төр хувийн эрх зүйн асуудлыг зохицуулахдаа олон нийтэд чиглэсэн бодлогоор бус харин талуудын хоорондын хэвтээ харилцан үйлчлэлд хамаарах зарчмуудын үндсэн дээр харилцааг зохицуулдаг. Төрийн зүгээс энэ талаарх үзэл баримтлал, чиглэлийг хувийн эрх зүйн хууль гаргах бүрт анхаарах шаардлагатай байна.

1.3. Аль ч улс орны 1 дүгээр зүйл худалдаа болсон, эрх зүйг эдийн засгаас тусад нь авч үзэх боломжгүй болсон, энэ хүрээнд үндсэн хуулийн эдийн засаг, үр нөлөө, зардлын судалгаа, эрх зүйд хийх эдийн засгийн шинжилгээ зэрэг судалгааны төрөл чиглэлүүд бий болжээ.

Эрх зүйг шинжлэх ухааны байр сууринд аваачих, хууль нийгмийн эдийн засгийн хөгжилд саад тотгор бус харин зүй зохистой дэмжлэг үзүүлэх, хөгжүүлэх хэрэгсэл болгоход эрх зүй ба эдийн засгийн ухаан жинтэй хувь нэмэр оруулах учраас эдгээр судалгааны салбарыг олон улс хүлээн зөвшөөрч хэрэглэж эхэлсэн, эдгээр судалгааны төрлийг хэрэглэх, арга замыг анхаарах болжээ гэсэн сүүлийн үеийн үзэл санаа, дүгнэлттэй шүүх эрх мэдлийн салбар санал нэг байгаа, өөрөөр ч байх боломжгүй юм. Ингэхдээ, өөрийн улсын зохицуулалтын уламжлалыг эхлээд товч дурдъя.

Монгол улсын Иргэний эрх зүй гол төлөв заншлын хэм хэмжээгээр зохицуулагдаж ирсэн, 12-13 дугаар зуунд иргэний эрх зүйн сэтгэлгээ бий болсныг түүхэн эх сурвалж нотолдог. 1924 онд Үндсэн хууль батлагдсанаар анхны Иргэний хууль гарах үндсэн суурь тавигдсан, үүнээс хойш 1960, 1963, 1994, 2002 онд Иргэний хуулийн шинэчилсэн найруулгыг баталж, 2002 оны Иргэний хуулийг хэрэглээд 19 жилийн хугацаа өнгөрчээ.

Иргэний хууль нь хувийн эрх зүйн хууль тогтоомжийн цөм болохын хувьд ач холбогдлооров Үндсэн хуулийн дараа орох хууль гэж судлаачид үздэг. Хуулийг боловсронгуй болгох асуудал байнга хөндөгдөх нь зүйн хэрэг. Одоогийн байдлаар худалдааны эрх зүй Иргэний хуулиар зохицуулагдаж байна. Худалдааны бие даасан хууль батлан гаргах нь эрх зүйн тогтолцоонд хийгдэх томоохон шинэчлэл байх болно гэж үзэж байгаа. Тусдаа хууль гарснаар Иргэний хуулийн суурь хууль болох зарчмыг нь алдагдуулахгүй, хувийн эрх зүйн салбарын аливаа тусгай хуульд нарийвчилсан зохицуулалт байхгүй үед суурь хууль болох Иргэний хуулийг хэрэглэдэг хууль хэрэглээний концепцоо дагах боломжтой гэж харж байна.

Худалдааны буюу арилжааны эрх зүйг нэгтгэн зохицуулах, эсхүл тусад нь батлан мөрдүүлэх нь аль нь илүү үр өгөөжтэй талаар ялгаатай байр суурь байдаг.

Тодруулбал,

- Зарим улсад худалдааны бие даасан тусгай хууль байхад зарим нь Иргэний болон худалдааны хуулийг нэгтгэх хандлага байна. Тусдаа хууль байхын сөрөг болон эерэг үр дагаврыг судалж, өөрийн хөрсөнд тохирох загварыг оновчтой сонгох ёстой. Худалдааны шинжтэй дотоод асуудал руу нь хэт орсон, хэт иргэнлэг шинжтэй буюу нийтлэг асуудлыг зохицуулах хэлбэрээс зайлсхийж, аж ахуй эрхлэгчийн эрх ашгийг хамгаалж чадаагүй нөхцөл байдал зэрэг хүчин зүйлийг тооцож, төслийн багийнхан ажиллаж байгаа байх гэж итгэж байна.

- аж ахуйн үйл ажиллагааны субьект нь цэвэр аж ахуйн нэгж байх уу, аж ахуй эрхлэгч иргэн хамаарах уу, аль аль нь хамаарах бол аж ахуй эрхлэгч иргэнийг хэрхэн тодорхойлох, тогтоох, тооцох вэ гэдгийг хамтад нь шийдвэрлэх нь хууль хэрэглээнд тодорхой байдал бий болгох юм.

Предпринимательский кодекс РК № 375 V был принят 29 октября 2015 года и действует с января 2016 года. Принципиальная позиция казахстанских цивилистов позволила отстоять нормы ГК РК и первоначальный проект был неоднократно пересмотрен. В действующей редакции кодекс содержит главы и разделы, регламентирующие правовые основы взаимодействия субъектов предпринимательства и государства, субъекты предпринимательства и условия их функционирования, объединения субъектов предпринимательства и условиях их функционирования, взаимодействие субъектов предпринимательства и государства, участие субъектов предпринимательства в нормотворчестве, государственно-частное партнерство, социальная ответственность предпринимательства, социальное предпринимательство, государственное регулирование предпринимательства, полномочия антимонопольного органа, государственную поддержку частного предпринимательства, формы и средства государственного регулирования предпринимательства, разрешения и уведомления, информационные инструменты, техническое регулирование, государственное регулирование цен и тарифов, общественно-значимые рынки, обязательное страхование, государственный контроль и надзор, экономическую конкуренцию, монополистическую деятельность, недобросовестную конкуренцию, основные направления и виды государственной поддержки частного предпринимательства, формы и способы защиты прав субъектов

предпринимательства, ответственность за нарушение законодательства Республики Казахстан в сфере предпринимательства.

Предпринимательский кодекс содержит принципиальную норму о том, что товарно-денежные и иные основанные на равенстве участников имущественные отношения, а также связанные с имущественными личные неимущественные отношения регулируются гражданским законодательством Республики Казахстан. Несмотря на это, принятый правовой акт все же содержит и ряд норм гражданско-правого характера (ст.28 - коммерческая тайна, ст. 23 - субъекты индивидуального предпринимательства, ст. 41 - крестьянское и фермерское хозяйства, ст. 50 -юридические лица и ряд других), что продолжает вызывать критику казахстанских ученых [5].

Во-вторых, принципиальные изменения коснулись правового статуса представителя в гражданском процессе.

Согласно пункта 1 статьи 58 Гражданского процессуального кодекса РК представителями по поручению в суде могут быть: адвокаты; работники юридических лиц - по делам этих юридических лиц, а государственных органов - по делам этих государственных органов; уполномоченные профессиональных союзов - по делам рабочих, служащих; уполномоченные организаций, которым законом, уставом или положением предоставлено право защищать права и интересы членов этих организаций; один из соучастников по поручению других соучастников; лица, являющиеся членами палаты юридических консультантов.

Наибольшие дискуссии в юридической среде вызвали законодательные изменения, касающиеся статуса адвоката и юридического консультанта.

С принятием Закона РК от 5 июля 2018 г. «Об адвокатской деятельности и юридической помощи» введен ряд норм, ограничивающих независимость адвокатуры, введено обязательное страхование деятельности адвокатов, созданы дисциплинарные комиссии адвокатов. Законодательно установлены ограничения выбора одних и тех же лиц на руководящий пост одним сроком. Например, в Президиум коллегии адвокатов, Председателем Президиума и в ревизионную комиссию коллегии адвокатов, в Президиум Республиканской коллегии адвокатов, Председателем и Ревизионную комиссию Республиканской коллегии адвокатов. Данные ограничения подверглись резкой критике в профессиональной юридической среде, в силу отсутствия объективных

причин для изменения сложившейся десятилетиями практики повторного избрания на руководящие посты в структурах адвокатуры [6].

Широкое обсуждение в юридической среде вызвало закрепление в законодательстве статуса юридического консультанта. Раньше представителями в суде, помимо адвокатов, могли быть любые лица, имеющие высшее юридическое образование, допущенные судом по просьбе лиц, участвующих в деле. После принятия Закона РК от 5 июля 2018 г. «Об адвокатской деятельности и юридической помощи» круг представителей по поручению в суде существенно сократился.

Сейчас юридическим консультантом является физическое лицо, имеющее высшее юридическое образование, стаж работы по юридической специальности не менее двух лет, прошедшее аттестацию, являющееся членом палаты юридических консультантов и оказывающее юридическую помощь» (статьей 75 Закона «Об адвокатской деятельности и юридической помощи»). Членство в палате юридических консультантов для лиц, осуществляющих юридическую помощь в виде представительства интересов физических и юридических лиц по гражданским делам, является обязательным (статья 82 Закона РК «Об адвокатской деятельности и юридической помощи»). Размер ежегодных членских взносов должен составлять не менее пятнадцатикратного и не более семидесяти пятикратного размера месячного расчетного показателя, установленного законом о республиканском бюджете на соответствующий финансовый год (в 2021 году эта сумма ориентировочно составила от 100$ до 500$).

Прошло не так много времени с момента реформы и говорить об эффективности института юридического консультанта еще преждевременно, но создание параллельной адвокатуре формы коммерческого представительства и Палат юридических консультантов вызвало серьезное обсуждение в казахстанской юридической среде.

Другой интересной новеллой явились нормы о новой форме управления объектом кондоминиума. В казахстанской юридической литературе исторически значительное внимание уделяется вопросам развития жилищного законодательства. В Закон о жилищных отношениях с момента его принятия 65 раз вносились поправки, но, к сожалению, в сфере его регулирования остается нерешенным массив проблем, требующих законодательного обновления, например, в вопросах реализации прав собственника, управления объектом кондоминиума, прекращения права собственности.

История поправок в редакцию статьи 42 Закона о жилищных отношениях наглядно демонстрирует сложность данного вопроса. В 1997 году в первоначальной редакции статьи 42 Закона о жилищных отношениях содержалось 7 пунктов, регламентирующих общие вопросы организации управления. В пункте 2 рассматриваемой статьи предусматривались следующие формы управления:

1) непосредственное совместное управление всеми собственниками, если их количество не превышало четырех;

2) кооператив собственников помещений (квартир);

3) управление объектом кондоминиума третьими (сторонними) лицами: выборными или наемными физическими лицами - управляющими жилыми домами (менеджерами) или юридическими лицами.

Перечень предлагаемых форм управления не был исчерпывающим и по соглашению участников допускались иные формы управления.

При этом Законом о жилищных отношениях придавалось приоритетное значение кооперативу собственников помещений (квартир) как форме управления объектом кондоминиума, поскольку норма пункта 5 статьи 42 Закона о жилищных отношениях (редакция 1997 года) определяла, что при недостижении собственниками согласия о форме управления объектом кондоминиума любой из собственников, государственный орган (в домах, где приватизирована часть жилых помещений) вправе инициировать образование кооператива собственников квартир (КСК).

По разным причинам другие формы управления, предусмотренные Законом о жилищных отношениях, не получили своего развития и применялись крайне редко и лишь в отдельных населенных пунктах.

Сложившийся опыт организации управления объектом кондоминиума свидетельствовал о неэффективности КСК как формы управления в многоквартирных домах. КСК так и не смогли выполнить своего главного назначения по управлению кондоминиумом. Кондоминиум объединяет в себе смешанный и социально неоднородный состав жильцов: собственники квартир, наниматели частных квартир, наниматели государственных квартир, собственники нежилых помещений. Подобный контингент жильцов (собственников и владельцев) сложно объединить для действенного совместного управления домом. Положение усугублялось отсутствием законодательно определенного механизма мониторинга деятельности КСК, эффективных рычагов

воздействия на органы управления объектами кондоминиума, не исполняющих надлежащим образом обязанности по организации управления домом.

Объективная необходимость совершенствования существующих и поиска новых форм управления требовала от законодателя новой правовой модели регулирования данной группы отношений. Законом РК от 8 июля 2009 года № 163-IV в статью 42 Закона о жилищных отношениях включен пункт 2-1, где были предусмотрены следующие функции органа управления:

1) организация проведения собраний, письменного опроса собственников помещений (квартир);

2) оформления протоколов собрания собственников помещений (квартир) и листов голосования при проведении письменного опроса;

2-1) доведение в письменном виде до сведения новых собственников помещений (квартир) информации о ранее принятых общим собранием собственников помещений (квартир) решениях;

3) организация выполнения решений собрания собственников помещений (квартир);

4) заключение и контроль исполнения договоров с субъектом сервисной деятельности;

5) представление интересов собственников помещений (квартир) по вопросам общего имущества объекта кондоминиума;

6) иные функции, определенные законодательством Республики Казахстан.

В целях дальнейшего совершенствования правового регулирования деятельности органов управления объектом кондоминиума, Законом РК от 29 декабря 2014 года были внесены поправки в подпункт 1 пункта 2 статьи 42 в части изменения количественного ограничения собственников для непосредственного совместного управления. Формулировка указанной нормы была изложена следующим образом: «1) непосредственное совместное управление всеми собственниками, если их количество не превышает двадцати;».

Учитывая, что редакция данной статьи сейчас пересмотрена, анализ данных изменений не представляется необходимым, но законодательная регламентация функций органа управления и корректировка количественного ограничения собственников при

непосредственном управлении однозначно не улучшили практики деятельности органов управления многоквартирного дома.

Кардинальным образом структура и содержание рассматриваемой статьи Закона о жилищных отношениях изменена Законом РК от 26 декабря 2019 года № 284-VI. Теперь, в силу пункта 1 статьи 42 Закона о жилищных отношениях, собственники квартир, нежилых помещений для управления объектом кондоминиума, финансирования его содержания и обеспечения сохранности общего имущества объекта кондоминиума обязаны выбрать одну из форм управления объектом кондоминиума:

1) объединение собственников имущества;

2) простое товарищество многоквартирного жилого дома (простое товарищество).

Заметим существенную особенность новой редакции, заключающуюся в том, что отныне перечень носит исчерпывающий характер и собственники квартир, нежилых помещений ограничены выбором их двух предложенных форм управления, указанных в пункте 1 статьи 42 Закона о жилищных отношениях.

Итак, Законом о жилищных отношениях предусматриваются две формы управления объектом кондоминиума многоквартирного дома:

1. Объединение собственников имущества. В подпункт 16-6) статьи 2 Закона о жилищных отношениях добавлен новый термин объединение собственников имущества многоквартирного жилого дома - юридическое лицо, являющееся некоммерческой организацией, образованное собственниками квартир, нежилых помещений одного многоквартирного жилого дома, осуществляющее управление объектом кондоминиума, финансирующее его содержание и обеспечивающее его сохранность (далее - ОСИ);

2. Простое товарищество. Простое товарищество не является юридическим лицом. По договору о совместной деятельности (простое товарищество) собственники квартир, нежилых помещений обязуются совместно действовать в целях управления объектом кондоминиума и содержания общего имущества объекта кондоминиума (пункт 2 статьи 43-1 Закона о жилищных отношениях).

Рассматриваемый пакет изменений в Закон о жилищных отношениях объясняется необходимостью выстраивания управления отдельным многоквартирным жилым домом по принципу: «одно объединение собственников имущества - один счет», что, по мнению

разработчиков, обеспечит прозрачность расходования средств и улучшит возможности для контроля за процессом их расходования.

В заключение необходимо отметить, что в целях модернизации гражданского законодательства Казахстана в Казахстане четко придерживаются практики разработки общего программного документа, определяющего направления развития законодательства и обозначающего концептуальные направления развития законодательства. Кроме того несомненной положительной чертой разработки правовых актов является активное участие в обсуждении проектов правовых актов ученых и практикующих юристов. Ежегодно Институтом законодательства и правовой информации Республики Казахстан проводятся фундаментальные исследования по направлениям развития законодательства Республики Казахстан. В 2021 году Институтом было проведено исследование на тему «Научное обеспечение законопроектной деятельности в Республике Казахстан». По итогам научного исследования подготовлен аналитический отчет по проблемам конституционного, административного, гражданского законодательства, а также приведены результаты анализа его эффективности. Предложения по итогам фундаментального исследования Института были учтены государственными органами при внесении изменений и дополнений в земельное законодательство, законодательство о выборах и дипломатической службе, микрофинансовой и коллекторской деятельности».

Разрешите также поблагодарить за внимание и выразить уверенность в том, что проведение данного мероприятия внесет реальный вклад в интеграцию юридической науки наших стран и будет способствовать установлению плодотворных и долгосрочных контактов между участниками мероприятия и Институтом законодательства и правовой информации Республики Казахстан, расширению процесса научных правовых исследований, формированию стимулов для дальнейшей совместной плодотворной работы.

Желаю организаторам и всем участникам конференции созидательной работы и творческих успехов!

Список литературы

1) Концепция правовой политики до 2030 года, утвержденная Указом Президента Республики Казахстан К.К. Токаева от 15 октября 2021 года № 674

2) Сулейменов М.К. Предпринимательский кодекс Республики Казахстан: много шума из ничего //online.zakon.kz

3) Карагусов Ф.С. Предпринимательский кодекс и корпоративное законодательство Республики Казахстан (с учетом четвертого варианта концепции предпринимательского кодекса Республики Казахстан) //online.zakon.kz

4) Мороз С.П. О проекте Предпринимательского Кодекса //online.zakon.kz

5) Сулейменов М.К. Кто может быть представителем в гражданском процессе? //online.zakon.kz

6) Сулейменов М.К. Экономическое право и Предпринимательский кодекс: кризис в развитии гражданского права в Казахстане //online.zakon.kz

МОНГОЛ УЛСЫН ЭРХ ЗҮЙН ТОГТОЛЦООНЫ БҮХЭЛЛЭГ (НЭГДМЭЛ) БАЙДЛЫГ ХАНГАХ НЬ

ENSURING THE INTEGRITY OF THE LEGAL SYSTEM OF THE LEGAL OF MONGOLIA

Содовсүрэнгийн Нарангэрэл
Хууль зүй, дотоод хэргийн сайдын зөвлөх, Монгол Улсын Төрийн шагналт, Шинжлэх ухааны гавъяат зүтгэлтэн, Академич, Монгол Улсын Их Сургуулийн Эмерит профессор
Mr. Narangerel Sodovsuren
Advisor to the Minister for Justice and Home Affairs of Mongolia, State Prize Laureate of Mongolia, Merit Scientist, Academician, Emeritus Professor of the National University of Mongolia

Бидний төрөлх эх орон - Монгол Улсын маань эрх зүйн тогтолцоо нь нэгэн цул бүхэллэг байж, үр нөлөөгөө үзүүлэх учраас дараах бүрдүүлбэрээр дүрсэлж болно. Эдгээр нь эмхлэгдэн цэгцлэгдэж, тодорхой чиг үүргийг гүйцэтгэж, өөр хоорондоо зөрчилдөөнгүй, давхцалгүй, харилцан уялдаа холбоотой, авцалдаатайгаар нийтдээ цул нэгдмэл тогтолцоог бүрдүүлэх тул өрөөсгөл байдлаар хандаж болохгүй.

Монгол Улсын *эрх зүйн тогтолцооны үндсэн шинжийг* дараах байдлаар тоймлож болно:

Монгол Улсын эрх зүйн тогтолцоо (Mongolian legal system)

- Монгол Улсын суурь (тулгуур) эрх зүй
- Эрх зүйн эх сурвалж
- Эрх зүйн системчлэл
- Эрх зүйн боловсрол
- Эрх зүйн мэргэжил
- Хууль зүйн шинжлэх ухаан
- Хууль зүйн туслалцаа
- Хууль сахиулах байгууллага
- Хууль тогтоомжийн хэрэгжилт
- Эрх зүйн ухамсар

Эдгээрийг тус бүрээр нь товч авч үзье.

Эрх зүйн тогтолцооны нэгэн чухал үндсэн шинж нь **суурь буюу тулгуур эрх зүй** мөн. Түүнийг дараах байдлаар харуулж болно.



Эдгээрийг бүрдүүлэхэд Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн яам эрх зүйн шинэтгэлийн бодлогыг эрхлэн хариуцдагийн хувиар нэн чухал үүрэг гүйцэтгэж иржээ.

Монгол Улсын орчин үеийн эрх зүйн тогтолцоог нийтийн эрх зүй (латин. jis publienm) ба хувийн эрх зүй (латин. jis privatum) хэмээн хуваах нь эрх зүйн дотоод мөн чанарын хоёр гол талыг тод тусган илэрхийлж, нийтийн болон хувийн ашиг сонирхол нь эрх зүйг шинэтгэх ба эрх зүйг хэрэглэх гол хүчин зүйл болохыг илтгэн харуулна.

Нийтийн эрх зүйн зохицуулалтын зүйл нь 1) төр ба түүний институтын байгууламж ба үйл ажиллагаа; 2) иргэний нийгмийн институт; 3) өөрийн удирдлагын механизм; 4) эрх зүйн тогтолцоо, эрх бүй бүтээх ба эрх зүйг хэрэглэх үндэс; 5) улс хоорондын харилцаа ба олон улсын байгууллагын зарчим, хэм хэмжээ ба институтыг бүрдүүлж байна.

Монгол Улс дахь **нийтийн эрх зүй нь** дараах салбар эрх зүй ба хууль тогтоомжоос[1] бүрдэнэ: 1) үндсэн хуулийн эрх зүй буюу хууль

[1] “Хууль тогтоомж” хэмээх нэр томьёо нь Монгол Улсын эрх зүйд олон жилийн туршид түгээмэл хэрэглэгдэж ирсэн уламжлалтай. Эл нэр томьёо нь хууль дээдлэх ёсыг

тогтоомж; 2) захиргааны эрх зүй буюу хууль тогтоомж[2]; 3) санхүүгийн эрх зүй буюу хууль тогтоомж[3]; 4) эрүүгийн эрх зүй буюу хууль тогтоомж; 5) процессын эрх зүй буюу хууль тогтоомж[4]; 6) олон улсын нийтийн эрх зүй[5]; 7) олон улсын хүмүүнлэгийн эрх зүй[6].

Монгол Улсад хувийн эрх зүйг хөгжүүлэн нийгмийн харилцааг зохицуулахад 1) диспозитив хэм хэмжээг[7] зонхилох байр суурийг эзлүүлнэ; 2) эрх зүйн харилцааны субъектүүдийг эрх тэгш байлгана; 3) субъектүүд эрхээ хэрэгжүүлэхдээ хүсэл зоригоо чөлөөтэй илэрхийлэх боломжийг буй болгоно; 4) субъектүүд хүлээсэн үүрэг ба хийсэн үйлдлийнхээ төлөө өөрийн хариуцлага хүлээнэ; 5) гэрээний зохицуулалтын хэлбэрийг өргөн

хэрэгжүүлэх, нийгмийн амьдралын бүх хүрээнд эрх зүйн шинэтгэл хийх үр нөлөөтэй хэрэгсэл болж дараах үүргийг гүйцэтгэж байна: 1) шударга ёсыг хангах; 2) ардчиллын институтыг бататган бэхжүүлэх, хөгжүүлэх, хангах; 3) ард түмний өөрийн удирдлагыг бэхжүүлэх; 4) засаг төрийн төлөөлөгчдийн байгууллага, шууд ардчиллын институт ба төрийн бус байгууллагын ролийг дээшлүүлэх; 5) олон намын тогтолцоо, ил тод байдлыг хангах; 6) төрийн аппарат түүний үйл ажиллагааны аргыг төгөлдөржүүлэх; 6) хүний эрх, эрх чөлөөг хамгаалах; 7) ардчиллын институтыг бататган бэхжүүлэх, хөгжүүлэх, хангах; 8) нийгмийн тэгш байдлыг хангах; 9) үндэсний эв нэгдлийг хангах зэрэг болно.

Хууль тогтоомж хэмээх нэр томьёо өргөн буюу явцуу утга санааг илэрхийлдэг юм. Эл нэр томьёог Монгол Улсын Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, 45 дугаар зүйл, 63 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт хэрэглэсэн. Явцуу утгаараа Хууль тогтоомжийн тухай хуулийн 1 дүгээр зүйлд заасны дагуу хууль, УИХ-ын бусад шийдвэр юм. Энэ утгаар хууль тогтоомжид хууль тогтоогч нийт улсын хэмжээний зарчмын ач холбогдол бүхий анхны, эхлэлийн шинжтэй хэм хэмжээг хууль тогтоомжид хамааруулсан гэж үзэж болохоор байна.

Өргөн утгаараа нийтээрээ заавал биелүүлэх журмыг бэхжүүлж, ард түмний хүсэл зоригийг төрөөс хэрэгжүүлэх объектив эрх зүйн илрэх гадаад хэлбэр мөн. Хуулиас эхлээд нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын актыг дуустлах эрх бүхий эрх зүй бүтээх байгууллагаас гаргасан *эрх зүйн хэм хэмжээний актын* иж бүрдэл. Өргөн утгаараа хууль тогтоомж нь төрийн механизмын бүтцэд эрх зүй бүтээх холбогдох байгууллагын байр сууриас шалтгаалан тодорхой хэсэгт (хууль тогтоох байгууллагаас баталсан хууль, төрийн тэргүүний зарлиг, засгийн газрын тогтоол, яам, агентлагаас гаргасан эрх зүйн хэм хэмжээний акт зэрэг) хуваагдана. Хууль тогтоомжийг холбогдох эрх зүйн актын зохицуулах нийгмийн харилцааны хүрээг харгалзан салбарт (иргэний хууль тогтоомж, хөдөлмөрийн хууль тогтоомж, эрүүгийн хууль тогтоомж зэрэг) хувааж болдог. Эрх зүйн актын тогтолцооны дээд түвшинд эрх зүйн зохицуулалтын үндсэн зарчмыг тодорхойлсон улс орны *Үндсэн хууль* оршино. Хууль тогтоомж хэмээх нэр томьёо нь эрх зүйд багтана.

[2] Энэхүү салбар эрх зүйд уламжлал ёсоор захиргааны албадлага, захиргааны хариуцлага, захиргааны шийтгэл, захиргааны эрх зүйн зөрчил, тэдгээрийг хянан шийдвэрлэх тухай асуудал хамаарагддаг байсныг Зөрчлийн тухай хууль батлагдсанаас хойш захиргааны эрх зүйн зохицуулалтын зүйлд хамааруулахаа больсон. Эдгээрийг эрүүгийн эрх зүйн зохицуулалт гэж үзэх үндэслэлгүй.

[3] Төсвийн ба татварын хууль тогтоомж багтана.

[4] Үндсэн хуулийн, захиргааны, иргэний, эрүүгийн процесс хамаарагдана.

[5] Монгол Улсын хууль зүйн нэвтэрхий толь., Улаанбаатар., 2021, 312-313 дахь талаас тодруулж үзнэ үү.

[6] Монгол Улсын хууль зүйн нэвтэрхий толь., Улаанбаатар., 2021, 309-310 дахь талаас тодруулж үзнэ үү.

[7] Диспозитив хэм хэмжээний талаар Монгол Улсын хууль зүйн нэвтэрхий толь., Улаанбаатар., 2021, 127 дахь талаас тодруулж үзнэ үү.

ашиглана; 6) субъектүүдийн эрх ашгийг шүүхийн хамгаалалтад байлгана; 7) хувийн буюу явцуу бүлгийн ашиг сонирхлыг түлхүү хангана.

Монгол Улс дахь **хувийн эрх зүй нь** дараах салбар эрх зүй ба хууль тогтоомжоос бүрдэж байгаа болно: 1) иргэний эрх зүй буюу хууль тогтоомж; 2) гэр бүлийн эрх зүй буюу хууль тогтоомж; 3) хөдөлмөрийн эрх зүй буюу хууль тогтоомж; 4) олон улсын хувийн эрх зүй[8].

Нийтийн ба хувийн эрх зүйн хоорондын зохистой харьцааг буй болгохын тулд 1) эрх зүйн бүх салбарт нэгэн адил ашиглагдах хэм хэмжээний ерөнхий технологийг ашиглана; 2) эрх зүйн нэг салбарын хэм хэмжээний ухагдахууныг нөгөөд нь ашиглах боломжтой (жишээлбэл, “хуулийн этгээд”, “төрийн байгууллага” хэмээх ухагдахуун) байлгана; 3) хууль тогтоомжид нийтийн болон хувийн эрх зүйн зохицуулалтын аргыг уян хатан балансжуулна; 4) тухайн эрх зүйн салбарт байхгүй ч гэсэн нөгөө эрх зүйн салбарт байгаа хамгаалалтын институтыг ашиглаж хэрэглэнэ; 5) эдийн засгийн түвшин, нийгмийн хөгжил, шинээр үүссэн нийгмийн харилцаагаар нөхцөлдөн нийтийн ба хувийн эрх зүйн хэм хэмжээ, институт, салбар хоорондын зохицуулалтын хүрээнд дахин хуваарилалтууд явагдана; 6) нийтийн эрх зүйн субъект хувийн эрх зүйн субъект болох ба иргэний эрх зүйн субъект нийтийн эрх зүйн харилцаанд оролцож болох боломжийг буй болгоно; 7) нэг эрх зүйн салбарын ухагдахууныг (жишээлбэл, “хуулийн этгээд”, “төрийн байгууллага” хэмээх ухагдахуун) нөгөөд нь ашиглах боломжийг бүрдүүлнэ.

Эрх зүйн хэм хэмжээ нь нийгмийн тодорхой төрлийн харилцааг зохицуулагч мөн.

Эрх зүйн институт нь нэг төрлийн нийгмийн харилцааг зохицуулсан харьцангуй бие даасан, харилцан уялдаа бүхий бүлэг хэм хэмжээний цогц юм.

Дэд салбар эрх зүй нь тодорхой салбар эрх зүйн томоохон хэмжээний, нарийн бүтэц мөн. Энэ нь аливаа нэгэн салбар эрх зүйн дотоодод онцлог хүрээний харилцааг журамлан зохицуулсан тусгай төрөл юм.

Салбар эрх зүй нь оршин буй нийгмийн харилцааны нэг төрлийн шинжтэй томоохон тодорхой салбар (хүрээ)-ыг зохицуулсан, үндэсний эрх зүйн тогтолцооны харьцангуй бие даасан ба өөрмөц, тогтвортой эрх зүйн хэм хэмжээний цогц мөн. Эрх зүйн зохицуулалтын зүйл ба арга нь нэг салбар эрх зүйг нөгөөгөөс нь зааглан ялгах гол шалгуур болдог юм.

[8] Монгол Улсын хууль зүйн нэвтэрхий толь., Улаанбаатар., 2021, 308 дахь талаас тодруулж үзнэ үү.

Монгол Улсад бие даасан зарим салбар эрх зүйг буй болгон хөгжүүлэх шаардлага буй болсон. Тухайлбал, байгалийн нөөц баялгийг ашиглах ба хамгаалах эрх зүй[9], нийгмийн хангамжийн эрх зүй[10], ял эдлүүлэх эрх зүй[11] зэргийг нэрлэж болох юм.

2015 онд баталсан Эрүүгийн хуульд Эрүүгийн хуулийн нэр томьёо, ухагдахууныг тайлбарлахад захиргааны хэм хэмжээний актыг ашиглаж болохоор заасан нь Эрүүгийн хуулийг төсөөтэй хэрэглэхэд хүргэв.

Эрх зүйн эх сурвалж хэмээх ухагдахуун нь хууль зүйн шинжлэх ухааны зангилаа асуудлын нэг мөн. Түүний ач холбогдол нь нэгдүгээрт, нийгмийн амьдралын олон талт нөхцөл нь эрх зүйн хэм хэмжээний агуулгыг нөхцөлдүүлдэг, хоёрдугаарт, эрх зүйн хэм хэмжээний агуулгыг эрх зүйн үзэл баримтлал, эрх зүйн ухамсар бүрдүүлдэг, гуравдугаарт, хэрэг маргааныг хянан шийдвэрлэхэд удирдлага болгодогт оршино. Өнөө үед Монгол Улсад эрх зүйн дараах эх сурвалжийн төрөл байна.



[9] Манай улсын зарим эрдэмтэд тухайлбал, хууль зүйн шинжлэх ухааны доктор Т. Сэнгэдорж, О.Амархүү нар “Экологийн эрх зүй” хэмээн нэршүүлсэн. Ингэхдээ тэд байгалийн объектыг хамгаалах өнцгөөс нь авч үзсэн. Гэтэл байгалийн объектыг ашиглах, хэрэглэх эрх зүйн зохицуулалт мөн чухалчлагдах ёстой.

[10] Тодорхой иргэдийн (ажилтан, цэргийн албан хаагч, шүүхийн ба прокурорын ажилтан, тахир татуу хүн, хөдөлмөрийн чадваргүй иргэн, тэжээгчээ алдагч зэрэг) тэтгэвэр, тэтгэмжийн хангамжийн журмыг зохицуулна.

[11] 2002 онд “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай” хууль батлагдсанаас хойш зарим эрдэмтэд, судлаачид бие даасан “Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн эрх зүй” буй болсон гэж үзэж, хэд хэдэн ном, гарын авлага гаргасан. Гэвч иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэлийг эрүүгийн ялын гүйцэтгэлтэй хамтатгасан нь иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэлд шүүгчээс тавих хяналтыг үлэмж сулруулсан билээ. Гэтэл манай улсад иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааг шүүх эрхлэн хариуцаж ирсэн түүхэн уламжлалыг алдагдуулсан нь сайн үр дүнд хүргэсэнгүй.

Хууль тогтоомжийн системчлэл нь тодорхой шалгууруар дагаж мөрдөж буй эрх зүйн актыг эмхлэн цэгцлэхэд чиглэгдсэн хууль зүйн үйл ажиллагаа мөн. Хууль тогтоомжийг системчлэх зайлшгүй эрэлт хэрэгцээ нь нэгдүгээрт, шинэ хууль тогтоомж батлагдах байнгын үйл явц явагдаж байгаа, хоёрдугаарт, нөгөө талаар зарим хууль тогтоомж хүчингүй болсон, хуучирсан, хууль зүйн заалтууд өөр хоорондоо зөрчилдсөн, гуравдугаарт, хууль тогтоомжид алдаа, давхардал, бүрхэгдэл, хийдэл байгаа зэрэгтэй шууд холбоотой.

Орчин үед хууль тогтоомжийг системчлэх эмхтгэх, нэгтгэх, төрөлжүүлэх гэсэн гурван үндсэн арга байдаг. Эдгээрийг манай улсад хэрхэн хэрэглэж байгааг товч авч үзье.



Хууль тогтоомжийг эмхтгэх – тодорхой журмаар (он дараалал, цагаан толгойн үсгийн дэс дараалал, зохицуулалтын зүйлээр) нийтэд ашиглуулахаар тодорхой түвшний хэм хэмжээний актыг бүрэн буюу хэсэгчлэн нэгтгэж системчлэх хэлбэр. Эмхтгэх нь дагаж мөрдөж буй хууль тогтоомжийг сахин биелүүлэх, түүний хүртээмжтэй ба олдоцтой байдлыг буй болгох, олон нийтийг хууль тогтоомж болон эрх зүйн хэм хэмжээний бусад актын тухай лавтай мэдээллээр хангах зорилго бүхий төрийн болон бусад байгууллагын байнгын үйл ажиллагаа юм.

Эмхтгэхийн мөн чанар нь эмхэтгэлд оруулсан эрх зүйн хэм хэмжээний агуулгыг хэвээр хадгалж, ямар нэгэн өөрчлөлт оруулахгүй байдгаараа төрөлжүүлэх болон нэгтгэхээс ялгагдана.

Хууль тогтоомжийн эмхэтгэлийг албан ёсны ба албан ёсны бус гэж ангилна. Монгол Улсад хууль тогтоомжийг 1991 оноос УИХ-ын Тамгын газар “Төрийн мэдээлэл” эмхэтгэлд нийтэлж ирсэн. УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасны дагуу ёсчилсон УИХ-ын Тамгын газарт хадгалах хууль тогтоомжийн хувийг албан ёсны эх гэж үзнэ. Албан ёсны бус эмхэтгэлээс шүүх хэрэг хянан шийдвэрлэх болон шинжлэх ухааны ном зохиолд эшлэх ёсгүй.

Хууль тогтоомжийн албан ёсны эмхэтгэлийг УИХ-аас тусгайлан зөвшөөрөл олгосон байгууллага гаргана. Хууль зүй, дотоод хэргийн яам, түүний харьяа Хууль зүйн үндэсний хүрээлэн цуврал байдлаар, мөн сэдэвчилсэн байдлаар эмхэтгэн хэвлэж иржээ.

Монгол Улсын хүчин төгөлдөр үйлчилж буй бүх хуулийг оруулсан “Монгол Улсын хууль” 4 ботийг Засгийн газар, Хууль зүй, дотоод хэргийн яамны шийдвэрийн дагуу 2008 онд Хууль зүйн үндэсний хүрээлэн эрхлэн хэвлүүлжээ. Эл 4 ботийг хэрэглэгчдэд дөхөмтэй хэлбэрээр буюу ботиудад шинээр гарсан хууль, түүнд орсон нэмэлт, өөрчлөлтийг байнга шинэчлэн сольж болохуйц сугалбар хуудастай хэвлэсэн байна. Үүнийг цаашид тогтмол үргэлжлүүлэх явдал шаардлагатай байна.

Албан ёсны бус эмхэтгэлийг байгууллага ба хувь этгээд өөрсдийн санаачилгаар хийнэ. Энэ нь лавлагаа-мэдээллийн зориулалттай болно. Эдгээрт салбар эрх зүйн (ерөнхий эмхэтгэл) буюу эрх зүйн зохицуулалтын тодорхой зүйлээр (тусгай эмхэтгэл) гаргасан хэм хэмжээний актын янз бүрийн эмхэтгэл хамаарагдана. Албан ёсны бус эмхэтгэл нь хууль тогтоомжийг нийтлэх албан ёсны хэлбэр болохгүй.

Монгол Улсын 800 гаруй жилийн турш хуримтлуулсан үндэсний хууль тогтоомжийн нэгдсэн сан хөмрөг бүрдүүлэхэд 2010 оноос эхлэн нийтийн хүртээл болгож ирсэн “Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхэтгэл”-ийн 23 боть чухал үүрэг гүйцэтгэж байна.

Хууль тогтоомжийг нэгтгэх нь эрх зүйн зохицуулалтын агуулгыг өөрчлөхгүйгээр, дагаж мөрдөж буй хууль тогтоомжид ямар нэгэн нэмэлт оруулахгүйгээр ижил төрлийн хэд хэдэн хуулийг нэг хуульд нэгтгэж шинэ хууль буй болгох хууль бүтээх өвөрмөц хэлбэр мөн. Нэгтгэсэн хууль бэлтгэх явцад өмнөх бүх хуулийг тодорхой логик дэс дараалалд байршуулж, ирээдүйн хуулийн ерөнхий бүтцийг боловсруулна. Энэ бүгдийг нэгдсэн найруулга, жигдрүүлсэн нэр томьёотой болгохын тулд тодорхой хянан тохиолдуулах, заалтын цэвэрлэгээ хийх боловсруулалт явагдана. Зөрчилдөөн, давталт, зөвтгөхийн аргагүй сунжруу илүүц байдлыг арилгаж, хуучирсан нэр томьёог засаж, ойролцоо агуулга бүхий хэм хэмжээг нэг зүйл (хэсэг)-д нэгтгэнэ.

Нэг төрлийн хуулиудыг нэгтгэх зорилт нь эрх зүйн зохицуулалтыг их авсаархан болгох, хийдэл, зөрчилдөөн, илүүдэл (лоозон) байдал, дагаж мөрдөж буй хэм хэмжээний хоорондын нийцэлгүй байдлыг арилгах ач холбогдолтой.

Дагаж мөрдөж буй олон хуулийг нийтэд нь шалган цэвэрлэх нь хуучирсан хууль болон түүний тодорхой хэсгийг хүчингүй болгох, холбогдох өөрчлөлт оруулах, дагаж мөрдөж буй зөвхөн хэсэг нь үлдсэн хуулийн янз бүрийн хэм хэмжээг нэгтгэх, тодорхой асуудлаар нэгтгэсэн хууль гаргахад тус дөхөм үзүүлнэ. Энэ учраас дагаж мөрдөж буй нэг төрлийн хуулиудыг нэгтгэхийг хууль тогтоомжийг цэгцлэх нэн чухал чиглэл хэмээн үзэх ёстой. Хууль тогтоомжийн системчлэлийн энэ чухал арга манай улсад ашиглагдахгүй өдий хүрсэнд нухацтай дүгнэлт хийх шаардлагатай болжээ.

Хууль тогтоомжийг төрөлжүүлэх нь нийгмийн харилцааны тодорхой хүрээнд дагаж мөрдөж буй хэм хэмжээний актуудыг үндсээр нь дахин боловсруулах хэлбэр, хууль тогтоомжийг чанар сайтай эмхлэн цэгцлэх арга, түүний нийцэл ба авсаархан байдал, хэсэг бусаг хэм хэмжээнүүдээс цэвэршүүлэх, хуучирсан, зайлшгүй шаардлагагүй хэм хэмжээнээс ангижруулах явдлыг хангаж өгдөг юм. Төрөлжүүлэх үйл явцад дагаж мөрдөж байгаа зайлшгүй шаардлагатай хэм хэмжээг нэгтгэн системчилж, тэдгээрийн агуулгыг дахин хянан үзэж, хэм хэмжээний заалтуудыг дотооддоо авцалдаатай ба уялдан нийцсэн байдлаар томьёолох, нийгмийн харилцааны холбогдох хүрээний зохицуулалтыг дээд зэргээр бүрэн хангах зорилт шийдвэрлэгдэнэ. Төрөлжүүлэх нь дагаж мөрдөж буй хэм хэмжээг дахин шинээр шүүмжлэлтэй ухаж ойлгох, тэдгээрийн хоорондын зөрчилдөөн ба үл нийцлийг арилгах, хуучирсан заалт, хийдэл, давхацсан хэм хэмжээг олж арилгахад чиглэгдэнэ.

Төрөлжүүлэх нь эрх зүй бүтээх хэлбэр мөн. Энэ нь нийгмийн эрэлт хэрэгцээг хангасан шинэ хэм хэмжээ тогтоох, эрх зүйн зохицуулалтын хийдлийг арилгах, хуучирсныг нь эрх зүйн шинэ заалтаар сольж өөрчлөх боломжийг буй болгон. Түүнчлэн төрөлжүүлэх нь хууль тогтоомжийг бүхэлд нь төгөлдөржүүлэн боловсронгуй болгох хэлбэр түүний үр дүн нь өмнөх асуудлаар үйлчилж байсан хэм хэмжээний акт өөрчлөгдөж, тогтвортой агуулга бүхий шинэ хууль тогтоомжийн нэгдсэн акт юм. Хууль тогтоомжийг эмхлэн цэгцлэх ба шинэчлэлийг хослуулах нь төрөлжүүлэлтийн мөн чанар бөгөөд түүнийг эрх зүй бүтээх боловсронгуй, дээд хэлбэр гэж үзвэл зохилтой.

Төрөлжүүлэлтийн үндсэн шинжийг дараах байдлаар тоймлон тодорхойлж болно:

1) Төрөлжүүлсэн актыг нийгмийн амьдралын амин чухал, зарчмын шинжтэй буюу хууль тогтоомж буюу эрх зүйн үндсэн салбар (институт)-ын эрх зүйн үндсийг тодорхойлсон асуудлыг зохицуулахын тулд гаргана. Энэ нь нийгмийн амьдралын тодорхой хүрээнд дагаж мөрдөж буй эрх зүйн актын дотор үндсэн актын байр суурийг эзлэхийн зэрэгцээ холбогдох

салбар эрх зүй буюу эрх зүйн институтын бүх хэм хэмжээний нийтлэг зарчим, үндсэн шинж, агуулгыг томьёолсон байна;

2) Төрөлжүүлсэн акт нь тухайн харилцааг (эд хөрөнгийн, хөдөлмөрийн, гэрлэлт-гэр бүлийн харилцаа, гэмт явдалтай тэмцэх зэрэг) өргөн хүрээнд, бүрэн зохицуулахад чиглэгдэнэ;

3) Хууль тогтоомжийг боловсронгуй болгосны үр дүнд буй болсон төрөлжүүлсэн хууль нь харилцан уялдаа бүхий заалтуудын эмхлэн цэгцэлсэн нэгдмэл хууль болно. Энэ нь эрх зүйн амьдралаар шалгагдсан хэм хэмжээ ба нийгмийн хөгжлийн эрэлт хэрэгцээнээс үүдсэн шинэ заалтыг багтаасан нэгдмэл, дотооддоо уялдаа холбоо бүхий хуулийг буй болгоно;

4) Төрөлжүүлэлт нь урт хугацааны туршид үйлчлэх нэлээд тогтвортой хэм хэмжээг буй болгоно. Төрөлжүүлсэн актын үр нөлөө нь хууль тогтоогч нийгмийн харилцааны хөгжлийн объектив чиг хандлага, хөдөлгөөнийг харгалзан үзэж чадсан эсэхээс шууд шалтгаална;

5) Төрөлжүүлэлтийн зүйл нь хууль тогтоомжийн тогтолцооны салбар ба институтын хуваагдал болно. Төрөлжүүлэх нь хэм хэмжээний актын системчлэгдсэн байдал, тэдгээрийн хууль зүйн нэгдэл ба нийцлийг батагтан бэхжүүлнэ. Төрөлжүүлсэн акт нь хууль тогтоомжийн тодорхой салбар, дэд салбар буюу тухайн институтыг бүрдүүлсэн харилцан уялдаа бүхий хэм хэмжээний актын тогтолцоонд тэргүүлэх байрыг эзэлнэ;

6) Төрөлжүүлсэн акт нь ямагт анги, хэсэг, бүлэг, зүйл зэрэг бусад хуваагдлаас бүрдэх нарийн бүтэцтэй. Энэ нь хэм хэмжээний заалтын тогтолцоог нарийн нягт байршуулсан, хэрэглэхэд тохиромжтой нэг ёсны төрөлжүүлэн нэгтгэсэн хууль юм. Төрөлжсөн хууль нь тодорхой сэдвээр хууль тогтоомжийг нэгтгэх ба системчлэх ашигтай хувилбар, нэг асуудлаарх олон актуудыг дуусгавар болгох үр нөлөөтэй хэрэгсэл болно.

Төрөлжүүлэлтийг 1.**түгээмэл төрөлжүүлэлт** буюу хууль тогтоомжийн үндсэн бүх салбарыг төрөлжүүлсэн цуврал акт; 2.**салбарын төрөлжүүлэлт** буюу тухайн салбарын хууль тогтоомжийг хамруулсан төрөлжүүлэлт; 3.**тусгай (иж бүрдэл) төрөлжүүлэлт** нь эрх зүйн зарим институтыг зохицуулсан акт гэж ангилж болно.

Манай улсад хууль тогтоомжийг төрөлжүүлэх үйл ажиллагаа орхигдсоны улмаас хуулийн тоо дэндүү олширч, тэдгээр нь уялдаа холбоогүй, авцалдаа муутай, нэр томьёо ба ухагдахууны зөрүүтэй, давхардал, илүүдэл ихтэй, байгууллага ба аж ахуйн нэгжийн эрх зүйн байдлыг тодорхойлсон явцуу хандлагатай болжээ. Ийм байдлаас гарах хамгийн зөв гарц нь хууль тогтоомжийг төрөлжүүлэх явдал юм.

Нэг төрлийн харилцааг зохицуулсан хэд хэдэн хуулийг нэг төрөлжсөн хууль болговол хэдхэн даацтай чамбай хуультай болж, тэдгээрийг тогтвортой дагаж мөрдөх, ягштал хэрэгжүүлэх нөхцөл бүрдэх болно. Тухайлбал, *нэгдүгээрт*, эрх зүйн салбараар Иргэний төрөлжсөн хууль[12], Захиргааны зөрчлийн тухай төрөлжсөн хууль, байгалийн нөөц баялгийг хамгаалах ба ашиглах тухай төрөлжсөн хууль[13], даатгалын тухай хууль[14], нийгмийн даатгалын төрөлжсөн хууль[15] зэргийн төслийг боловсруулж батлах. *Хоёрдугаарт*, салбар хоорондын (иж бүрдэл) эрх зүйн чиглэлээр Татварын төрөлжсөн хууль[16], Төсвийн төрөлжсөн хууль, Гаалийн төрөлжсөн хууль зэргийн төслийг боловсруулж батлах.

Эрх зүйн боловсрол бол аливаа улсын эрх зүйн тогтолцооны хөгжлийн түвшинг илэрхийлэх үзүүлэлтийн нэг мөн. Монгол Улсын эрх зүйн тогтолцооны үр нөлөөг дээшлүүлэх нэгэн арга зам нь эрх зүйн орчин цагийн өндөр боловсрол эзэмшүүлэх үйл ажиллагаа мөн. Манай улсад эрх зүйн боловсрол олгож буй төрийн болон хувийн хэвшлийн хууль зүйн цөөнгүй их дээд сургуулиуд буй болж, хөгжил төлөвшлийн шатандаа байна. Аливаа хууль зүйн их дээд сургуулиудын нэр хүнд, сүр хүч нь барилга байшиндаа биш юуны өмнө багшлах бие бүрэлдэхүүний нь чанар чансаа, эрдэм мэдлэг, туршлага, нэр төрд оршиж байдаг гэдгийг онцгой анхаарах цаг болсон. Заадаг судлагдахуундаа нэвтэрхий мэргэшсэн, бусад шинжлэх ухааны ололт дэвшилтэй уялдуулан холбож чаддаг, заах арга зүйг гаргуун эзэмшсэн, судалгаа шинжилгээний ажлын арга барилд сайтар боловсорсон, түгээмэл гадаад хэлний бэлтгэлтэй, багшийн эрхэмсэг ёс

---

[12] Дагаж мөрдөж байгаа Иргэний хуульд 13 хууль буюу нөхөрлөлийн тухай, хоршооны тухай, дампуурлын тухай, зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай, патентийн тухай, санхүүгийн түрээс /лизинг/-ийн тухай, үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай, концессын тухай, барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай, компанийн тухай, хадгаламж зээлийн хоршооны тухай, хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус баялгийн тухай, оюуны өмчийн тухай зэрэг хуулийг төрөлжүүлэн нэгтгэж болохоор байна.

[13] Энд 12 хууль буюу байгаль орчныг хамгаалах тухай, газрын тухай, газрын хэвлийн тухай ашигт малтмалын тухай, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай, хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай, ойн тухай, агаарын тухай, амьтны тухай, усны тухай, түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай, газрын тосны тухай зэрэг хуулийг төрөлжүүлэн нэгтгэж болохоор.

[14] Энд 6 хууль буюу даатгалын тухай, үрийн тариалангийн даатгалын тухай, даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай, жолоочийн даатгалын тухай, банкин дахь мөнгөн хадгаламжийн тухай, эрүүл мэндийн даатгалын тухай зэрэг хуулийг төрөлжүүлэн нэгтгэж болохоор байна.

[15] Энд 7 хууль буюу нийгмийн даатгалын тухай, нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай, нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай, цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай, нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай зэрэг хуулийг төрөлжүүлэн нэгтгэж болохоор байна.

[16] Монгол Улсад татварын ерөнхий хуулиас гадна тодорхой төрлийн татварын тухай 20 гаруй шахам бие даасан хууль үйлчилж байгаа бөгөөд тэдгээрийн нэлээдгүй заалт нь давхардсан шинжтэй байгаа болно.

зүйг ягштал баримталдаг багш шиг багш нараас монголын эрх зүйн боловсролын үр өгөөж шууд шалтгаалж байна.



Шүүхийн ажилтныг (шүүхийн нарийн бичгийн дарга, шүүхийн шийдвэр гүйцэтгэгч зэрэг) бэлтгэдэг сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх шаардлагатай болсон байна.

Хууль зүйн мэргэжил бол хүн төрөлхтний өнө эртний, нэр хүндтэй, эрсдэл ихтэй мэргэжлийн нэг. Монгол Улсын хувьд энэ мэргэжил эрт дээр үеэс буй болсон түүхэн уламжлалтай. “Хуульч – олон хууль уншсан хүмүүн бус, хуульч - хамгийн ёс суртахуунлаг хүмүүн” хэмээсэн хэлц үг байдаг. Их эзэн Чингис хаан Шихихутугийг Монгол төрийн дээд шүүгчээр тохоон томилохдоо гүр улсын хулгай зэлгийг гэсгээж, худлыг мохоож, үхүүлдэх ёстойг үхүүл, яллах ёстойг яллаж бай[17] хэмээсэн айлдвар буулгаж байсныг бид сайн мэднэ.

[17] Монголын нууц товчооны 203 дугаар зүйлийг үзнэ үү.



Хууль зүйн мэргэшлийг ямар нэгэн албан тушаал мэт үзэж болохгүй. Мэргэшил (латин. *qualitas*) гэсэн нэр томьёо нь ямар нэгэн мэргэшилд бэлтгэгдсэн байдлын хэр хэмжээг илэрхийлнэ. Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар тольд "мэргэжлийн тодорхой нэг салбарын гүнзгий мэдлэг боловсрол"[18] хэмээн тодорхойлжээ. Хууль зүйн мэргэшил бүр бусад мэргэшилтэй харьцуулахад өөрийн гэсэн өвөрмөц онцлогтой. Тухайлбал шүүгч шударга ёс, үнэнийг эцэслэн тогтооход, прокурор эрүүгийн мөрдөлтийг хэрэгжүүлж, улсын яллагаа явуулахад, мөрдөгч гэмт хэргийн нотлох баримтыг эрж хайж олоход, өмгөөлөгч хувь хүн ба хуулийн этгээдэд эрх зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэхэд, нотариатч нотариатын үйлдэл хийхэд сайтар мэргэшсэн байна. Практикаас үзэхэд өмгөөлөгч болсон прокурор эхний үедээ үйлчлүүлэгчээ яллах гээд байдаг нь цөөнгүй гардаг. Энэ учраас ялангуяа шүүгч, прокурор, мөрдөгч, өмгөөлөгч, нотариатч зэрэг хууль зүйн тодорхой мэргэшлээр ажиллуулахын тулд эхлээд дадлагажуулах зохих шат дамжлагыг зайлшгүй буй болгож, энэ хугацааг нэр төртэй давж чадсанд нь эрх олгох тогтолцоог буй болгох явдал нэн шаардлагатай болжээ.

Мөнгөөр хуульчдыг худалдаж авах явдал газар авч, харыг цагаан, цагааныг хар болгуулах адал санаархалд хуульчид урхидуулж, нэр хүндээ барж байгаа өнөөгийн ийм нөхцөл байдалд хуульчийн мэргэжлийн ёс зүйд тавих шаардлагыг эрс өндөржүүлэх гарцаагүй шаардлага үүдэгдсэн.

[18] Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь (таван боть). М-С., Улаанбаатар., 2008, 1297 дахь тал.

Хууль зүйн шинжлэх ухаан нь монголын нийгэмд (төр ба эрх зүйн тухай шинжлэх ухааны мэдлэгийг боловсруулах болон тодорхойлох) *танин мэдэхүйн*, (төрийн аппарат, түүний чиг үүрэг ба ажлын арга барил, үйлчилж буй эрх зүйн зохицуулалтыг төгөлдөржүүлэх тухай шинжлэх ухааны үндэс бүхий санал зөвлөмж боловсруулан төр ба эрх зүйн цаашдын хөгжлийн зам, ирээдүйн хувь заяаг онолын үүднээс тодорхойлох) *таамаглах*, (хуулийн амин сүнс нь шударга ёс, үүрэг ба хариуцлага, нинжин сэтгэл, жудаг, нэр төр, үнэн, итгэл, тэсвэр тэвчээр, эв нэгдэл, эелдэг ёс, эс шунахайрал болсон) *ёс суртахууны* гэсэн гурван үндсэн чиг үүргийг гүйцэтгэж байна.



Манай улсад эрх зүй судлал эрхэлсэн байгууллага, бүтэц буй болж, эрдэмтэд нэлээдгүй бэлтгэгдэв. Хууль зүйн шинжлэх ухааны нэн чухал зорилт нь Монгол Улсын туурга тусгаар оршин тогтнохуйн хууль зүйн үндэс суурь, учир шалтгааныг танин мэдэж, хөгжлийнх нь цаашдын чиг хандлага, арга замыг тодорхойлж, үр нөлөөг нь нэгтгэн дүгнэх, санал зөвлөмж дэвшүүлэх явдал мөн. Орчин үеийн шинжлэх ухаан, техник, технологийн ололтод суурилж, үндэснийхээ өвөрмөц онцлогийг харгалзан үзэж Монгол Улсынхаа хууль тогтоомж, түүнийг буй болгож, хэрэгжүүлж буй монголын ард түмний ухамсар, бодит амьдралыг тал бүрээс нь судлахад хууль зүйн шинжлэх ухааны зориулалт оршино.

Хууль зүй судлалын нийтлэг болон салбарын асуудлаар суурь чамбай бүтээл туурвих, шинээр батлагдсан хуулийг шинжлэх ухааны

үүднээс тайлбарлах, дагаж мөрдөж буй хууль тогтоомжийг төгөлдөржүүлэх түүний үр нөлөө, хөгжлийн хэтийн төлөвийн тухай шинжлэх ухаанд суурилсан санал, зөвлөмж боловсруулах зэргээр хууль зүйн практикт шинжлэх ухааны үзүүлэх нөлөөллийг эрс дээшлүүлэх шаардлагатай байна.

Монгол Улсын хууль зүйн шинжлэх ухааны цаашдын хөгжилд дэмжлэг болгоход Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021.06.11-ний өдрийн тушаалаар баталсан жил бүрийн 74 500 000 төгрөгийн төсөв бүхий “Хууль зүй, дотоод хэргийн сайдын нэрэмжит шилдэг бүтээл, шилдэг илтгэл шалгаруулах, грант олгох журам” чухал үүрэг гүйцэтгэх болно.

Хууль зүйн туслалцаа нь Монгол Улсын эрх зүйн тогтолцооны бүрэлдэхүүн хэсэг болон хөгжиж байна.



Нийгэм ба төрийн амьдралын эрх зүйн хүрээг **хууль сахиулах** нь бүрийн байгууллагагүйгээр төсөөлөхийн аргагүй билээ. Эдгээр байгууллага нь эрх зүй, хууль хэрэглэх, эрх зүйн хамгаалалтын тусгай чиг үүргийг хэрэгжүүлж ирсэн.



Хууль сахиулах байгууллага бүр хуулиар ногдуулсан чиг үүргээ биелүүлэхийн зэрэгцээ үйл ажиллагаагаа уялдуулан зохицуулах зайлшгүй шаардлагатай байна. Хууль сахиулах байгууллагын хамтын ажиллагааны үндсэн чиглэл нь:

- Хууль сахин биелүүлэх;
- Иргэдийн эрх, эрх чөлөөг хамгаалах;
- Гэмт хэрэг, эрх зүйн зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх;
- Хуульчдын мэдлэг, ур чадвар, нэр хүнд, ёс зүйг дээшлүүлэх;
- Хуульчдын эрх ашгийг хамгаалах зэрэг болно.

Хууль батлах бол эрх зүйн зохицуулалтын ердөө л урьдчилсан үе шат билээ. Хамгийн гол нь нийтээрээ заавал дагаж мөрдөж, амьдралд хэрэгжүүлсэн тэр л нөхцөлд хууль нийгмийн амьдралыг зохицуулах чиг

үүргээ биелүүлэх болно. Ингээгүй тохиолдолд хууль нь “бичиг цаас” болж үлдэнэ. Хууль хэрэгжүүлэх үйл явцыг дараах байдлаар илэрхийлж болно.



Хууль нь нийгмийн янз янзын харилцааг цэгцлэн журамлаж, хувь хүн, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, төрийн байгууллагад олгосон эрхийг хангаж, хүлээсэн үүргийг биелүүлэхэд үйлчилдэг. Хууль зүйн зохицуулалт нь нийгэмд шударга ёсыг тогтоож, тогтвортой, ирээдүйдээ итгэлтэй байх нөхцөлийг бүрдүүлнэ.

Эрх зүйн ухамсар бол хууль зүйн учир холбогдол бүхий нөхцөл байдалд хүний зан үйлийг зохицуулсан, эрх зүй хийгээд түүнийг хэрэглэх практикийг мэдлэг болон үнэлэлт, эрх зүйн үнэт зүйлийн хэлбэрээр эрх зүйн бодит байдал болгон тусгасан нийгмийн, бүлгийн, хувь хүний ухамсрын хүрээ мөн[19]. Эрх зүйн ухамсар нь эрх зүйн эх сурвалж болох эрх зүйн актад шууд тусгалаа олж, эрх зүйг буй болгох үйл хийгээд хэрэгжилтэд нөлөөлж байдаг.



Эрх зүйн ердийн ухамсар нь амьдралын нөхцөл байдал, хүмүүний хувийн амьдралын туршлага, иргэний олж авсан эрх зүйн боловсролын нөлөөллөөр бүрэлдэн буй болсон, хууль зүйн тодорхой үзэгдлийг хүртэж тусгасан ухамсар мөн. Энэхүү ухамсрыг төлөвшүүлэхэд эрх зүйн мэдээлэл, сургалт, сурталчилгаа чухал нөлөө үзүүлж ирсэн бөгөөд энэ нь Хууль зүй, дотоод хэргийн яамны чиг үүрэгт багтдаг билээ.

Эрх зүйн онолын (шинжлэх ухааны) ухамсар нь олон шинжлэх ухааны уулзварт, эрх зүйн өргөн цар хүрээтэй гүн гүнзгий нэгтгэн дүгнэлт, нийгэм-эрх зүйн бодит байдлын зүй тогтол, тодорхой судалгаа шинжилгээний мэдлэгт тулгуурлан бүрэлдэн тогтдог онцлогтой. Чухамдаа эрх зүйн онолын ухамсар л хууль тогтоох болон хэрэглэх үйл ажиллагааг төгөлдөржүүлэхэд нөлөөлөх учраас сайн онолоос илүү бат бэх зүйл юу ч байдаггүй гэж үзэж иржээ.

Эрх зүйн мэргэжлийн ухамсар бол хуульчийн мэргэжил эзэмшсэн хүмүүний эрх зүйн ухамсар мөн. Энэхүү ухамсар нь шинжлэх ухааны үндэслэлтэй эзэмшсэн бодомж эргэцүүлэл, дүгнэлт, зүй тогтлын зэрэгцээ

[19] С.Нарангэрэл Монголын ба дэлхийн эрх зүйн тогтолцоо., Улаанбаатар., 2001, 153 дахь талыг үзнэ үү.

мэргэжлийн өндөр ур чадвар, ёс зүйгээр бодит ажил хэрэг болон төлөвшиж байна.

Монгол Улсын эрх зүйн тогтолцоо нь эх авсан агуу их түүхэн уламжлалтай. Монгол Улс нэгдэн хүчирхэгжсэн XIII зуунд их эзэн Чингис хаанаар оройлуулсан монголчууд монголын хуулиар дэлхий дахинд амар амгаланг 140 жилийн туршид тогтоож байсан нь хэн ч маргахын аргагүй бодит үнэн. Ингэж чадсаны нууц тайлал нь Чингис хааны “гүр улсыг шударга болгож, гагц жолоонд оруулж чадсан”[20] хэмээсэн айлдварт агуулагдаж байжээ. Чингис хааны дагаж мөрдүүлсэн хуулийн үндсэн агуулга нь ёс суртахуун буюу шударга ёс, эр зориг, үүрэг ба хариуцлага, жудаг, нинжин сэтгэл, итгэл, найрсаг ёсон, нэр төр, үнэнч зан, эв нэгдэл, эс шуналдах, өш хонзон эс өвөрлөх, урвашгүй сэтгэлд оршиж байжээ[21].

Өөрөөр хэлбэл, энэ цаг үед ёс суртахууныг хамгаалахад хуулийн зориулалт оршдог байв. Хожим ёс суртахуун ба хууль хоёрыг өөр хооронд нь зааглан тусгаарласнаас болж, монголчууд төдийгүй хүн төрөлхтөн учраа олохоо байсанд хүрснийг онцлон тэмдэглэж байна.

Перс хэлээр бичигдсэн дэлхийн болон монголын албан ёсны түүх болох СУДРЫН ЧУУЛГАН-д байгаа хожим таван зуу, мянга, арван мянган жилд ч нарт хорвоод төрж, хаан төр барих удмынхан минь аль ч улс түмэнд хэрэглэж болохуйц ёс суртахуун (ёсон), Засгийг (хуулийг) өөрчлөхгүйгээр сахивал мөнх Тэнгэр хишгээ хүртээж, тэд маань өнө мөнхөд гэр хотлоороо энх амар, аз жаргалтай аж төрөх болмуй заа[22] хэмээсэн эл санаагаар илтгэлээ төгсгөхөөс аргагүйд хүрэв.

---oOo---

[20] Монголын нууц товчооны 224 дүгээр зүйл.
[21] Энэ талаар С.Нарангэрэл Хуулийн амин сүнс буюу Чингис хаан, монголчууд. Нэмж засварласан гурав дахь хэвлэл., Улаанбаатар, 2018 номоос тодруулж үзнэ үү.
[22] Үз.: Рашид-ад-дин Судрын чуулган. I боть.., Орос хэлнээс эх хэлнээ хөрвүүлсэн Ц.Сүрэнхорлоо.., Улаанбаатар., 2002, 404 дэх тал; Рашидаддин Шашдирын чуулган. дэд боть.., Англи хэлнээс орчуулж, уялга үг бичиж, тайлбар зүүлт үйлдсэн Г.Аким.., Улаанбаатар., 2013, 448 дахь тал.

МОНГОЛ УЛС ДАХЬ ОЛОН УЛСЫН ХУВИЙН ЭРХ ЗҮЙН ХӨГЖИЛ, БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ АСУУДАЛ

DEVELOPMENT OF PRIVATE INTERNATIONAL LAW IN MONGOLIA, SOME ISSUES TO FURTHER IMPROVEMENT

Энх-Амгалангийн Байгал
Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургуулийн дэд профессор, хууль зүйн доктор
Ms. Baigal Enkh-Amgalan
Associate Professor, School of Law, National University of Mongolia, Ph.D

Хураангуй: *Энэхүү илтгэлд Монгол Улс дахь Олон улсын хувийн эрх зүйн хөгжлийн түүхэн тойм, өнөөгийн эрх зүйн зохицуулалтын тулгамдсан асуудал, дэлхий дахины хөгжлийн чиг хандлагад суурилан цаашид боловсронгуй болгох асуудлыг авч үзлээ.*

Түлхүүр үгс: *Олон улсын хувийн эрх зүй, хувийн эрх зүй, олон улсын шинжтэй хувийн эрх зүйн харилцаа*

Abstract: *This presentation aimed to define development of Private international law and challenging issues in Mongolia and to submit proposals how to improve in the nearest future.*

Keywords: *Private international law, private law, private law relations with foreign element.*

Удиртгал

1992 онд Монгол Улс Үндсэн хуульдаа: “Монгол Улс дэлхийн эдийн засгийн хөгжлийн түгээмэл хандлага, өөрийн орны өвөрмөц онцлогт нийцсэн олон хэвшил бүхий эдийн засагтай байна” хэмээн тунхаглаж, Нийтийн болон хувийн өмчийг хүлээн зөвшөөрсөн билээ.

Энэ үеэс иргэд, хуулийн этгээд бие даан олон улсын хувийн эрх зүйн /цаашид “ОУХЭЗ” гэх/-д харилцаанд өргөнөөр оролцож эхэлсэн бөгөөд 1990-ээд оны эхэн үеэс олон улсын бизнесийн харилцаа, 2000 он гарсаар олон улсын шинжтэй гэр бүлийн харилцаанд оролцох нь огцом нэмэгдсэн. Харин 2010 оноос хойш олон улсын шинжтэй хөрөнгө оруулалт, бизнесийн харилцаанаас үүдэх маргааныг гадаад улсын шүүх болон олон улсын арбитрт хянан шийдвэрлүүлэх нь эрчимтэй нэмэгдэж байна. Эндээс, олон улсын хувийн эрх зүйн зохицуулалтыг ул суурьтай судалж, улам боловсронгуй болгох асуудал чухлаар тавигдаж эхэллээ.

Иймд дараах асуудлын хүрээнд Монгол Улсын ОУХЭЗ-н зохицуулалтын тулгамдсан асуудал, шийдвэрлэх боломжийн талаар илтгэлээ толилуулья.

Нэг. Монгол Улс дахь ОУХЭЗ-н хөгжлийн түүхэн тойм

Монгол Улсын олон улсын хувийн эрх зүйн зохицуулалт нь социалист интеграцийн үед хуучин ЗХУ-ын нөлөөн дор бүрэлдэн тогтсон.[1] XX зууны эхэн үеэс батлагдан үйлчилж байсан иргэний төрөлжсөн хуулиудад ОУХЭЗ-н харилцааг зохицуулсан зарим хэм хэмжээ тусгагдаж ирсэн билээ.

1. 1926 оны БНМАУ-ын Иргэний хууль

Энэ хуульд ОУХЭЗ-н талаар зохицуулалтыг агуулсан тусгай бүлэг байхгүй. Харин гэр бүлийн эрх зүйн харилцааг зохицуулахтай холбогдсон нэг заалтыг ОУХЭЗ-н хэм хэмжээ гэж үзэж болно. Тус хуулийн 56.3 дугаар зүйлийн тайлбарт:

> “Гадаадын харьяат хүмүүн завсраа буюу монголын харьяаттай тус улсын хязгаар дотор эр эм бололцох аваас энэхүү хуулийн ёсоор данснаа тэмдэглэж гүйцэтгэвээс зохимой”

хэмээсэн нь гадаадын иргэд хоорондоо буюу гадаадын иргэн монголын иргэнтэй гэр бүл болоход тус хуулийг баримтлан гэрлэлтийг бүртгэхээр зохицуулжээ. Үүнээс өөрөөр гадаадын иргэн, хуулийн этгээдтэй холбоотой эрх зүйн харилцааг зохицуулсан хэм хэмжээ тусгагдаагүй байна.

2. 1952, 1964 оны Иргэний хууль

1952 онд баталсан 1964 оныг хүртэл үйлчилж байсан БНМАУ-ын Иргэний хуульд олон улсын хувийн эрх зүйн харилцааг зохицуулсан хэм хэмжээ тусгагдаагүй байсан. Харин 1964 оны Иргэний хуулийн[2] “Гадаад улсын иргэн ба аль ч улсын иргэн бус хүмүүсийн иргэний эрхийн чадвар, гадаад улсын иргэний хууль, олон улсын гэрээ хэлэлцээрийг хэрэглэх” хэмээн нэрлэгдсэн 9 дүгээр хэсэг буюу 400-407 дугаар зүйл нь ОУХЭЗ-н харилцааг зохицуулахад чиглэгдсэн анхны бүлэг хэм хэмжээ болсон байна. Энэ хэсэгт гадаадын иргэн, харьяалалгүй этгээдийн иргэний эрхийн чадвар, гадаадын байгууллагатай хийх худалдааны хэлцэл, хэлцэлд хэрэглэгдэх эрх зүйг тодорхойлох, өв залгамжлалтай холбоотой эрх зүйн харилцаанд хэрэглэгдэх эрх зүйг тодорхойлох, гадаадын хуулийг хэрэглэхэд тавигдах хязгаарлалтын асуудлыг тус тус зохицуулсан.

---

[1] Т. Мэндсайхан, Олон улсын хувийн эрх зүйн үндэс УБ 2002., 85 дахь тал.
[2] Иргэний хуулиуд, нэмэлт өөрчлөлтүүд II боть, УБ 2002 он., 310-312 дахь тал.

Энэхүү хуулиас гадна, Монгол Улс нь 1958 оноос эхлэн тухайн үеийн социалист улсуудтай эрх зүйн туслалцаа үзүүлэх гэрээг байгуулж эхэлсэн ба хуульд тусгагдаагүй зарим харилцааг зохицуулсан хэм хэмжээ агуулж байснаараа онцлог юм.[3]

Түүнчлэн, социалист орнуудын хооронд байгуулж байсан олон улсын тээвэрлэлт, худалдаа эдийн засгийн харилцааны талаарх олон талт гэрээнд нэгдэн орж байсан бөгөөд энэ нь Монгол Улсад ОУХЭЗ-н харилцааг зохицуулж байсан, өдгөө ч хүчин төгөлдөр үйлчилж, эх сурвалж болон хэрэглэгдэж байгаа билээ.

3. 1994 оны Иргэний хууль, 1973 оны Гэр бүлийн хууль

1/ 1994 онд шинэчлэн найруулсан Иргэний хуулийн "Олон улсын иргэний эрх зүй" хэмээх 7 дугаар хэсэг нь өмнөх хуулийг бодвол харьцангуй дэлгэрэнгүй зохицуулалт бүхий болсон. Тухайлбал, өмчийн эрх зүйн харилцаа, гэм хор учруулснаас үүсэх үүрэг, итгэмжлэл, хуулийн этгээдийн эрхийн чадварыг тодорхойлох талаар зохицуулалт нэмж тусгагдсан байдаг.[4] Гэхдээ тухайн үеийн ЗСБНХУ-д үйлчилж байсан "Иргэний хууль тогтоомжийн үндсүүд"-ийн ОУХЭЗ-н зохицуулалтыг бараг шууд хуулбарласан гэж үздэг.[5]

Хэдий урьд өмнөх зохицуулалтаас арай дэлгэрэнгүй болсон ч ОУХЭЗ-н хэм хэмжээ үйлчлэх хүрээ, харилцааг тодорхойлоогүй. Тэрчлэн, зөрчилдөөний хэм хэмжээ буцааж заах, гуравдагч орны эрх зүйг заасан тохиолдолд шийдвэрлэх арга зам, зөрчилдөөний хэм хэмжээ гадаадын эрх зүйг бүхэлд нь, эсхүл гагцхүү материаллаг эрх зүйг зааж байгаа эсэх нь тодорхойгүй хэвээр байсан.

2/ 1973 оны Гэр бүлийн тухай хууль.[6]Тус хуулийн "Гадаад улсын харъяат буюу аль ч улсын харъяат биш иргэнд БНМАУ-ын гэр бүлийн хууль тогтоомжийг хэрэглэх, мөн гадаад улсын гэр бүлийн хууль тогтоомж болон олон улсын гэрээ хэлэлцээрийг дагаж журамлах" хэмээх 5 дугаар хэсэгт гадаад элемент бүхий гэр бүлийн харилцаанд хамаарах зохицуулалт тусгагдсан байв. Энэ хэсэгт гэрлэлт бүртгэхэд хэрэглэх эрх зүй /107 дугаар зүйл/, харъяалалгүй иргэдэд тус улсын хууль тогтоомжийг хэрэглэх үндэслэл /108 дугаар зүйл/, гадаад улсад монгол иргэдийн гэрлэлт бүртгэх журам /109 дүгээр зүйл/, хүүхдийн харъяалал бүртгэх /110 дугаар зүйл/,

[3]Олон улсын хувийн эрх зүй /баримт бичгийн эмхэтгэл/, 176-316 дахь тал; Т. Мэндсайхан, Олон улсын хувийн эрх зүйн үндэс, 85-86 дахь тал.
[4]Иргэний хуулиуд, нэмэлт өөрчлөлтүүд II боть, УБ 2002, 519-524 дахь тал.
[5]Т. Мэндсайхан, Олон улсын хувийн эрх зүйн үндэс, 86 дахь тал.
[6]Тус хуулийг "БНМАУ-ын хуулиуд" эмхэтгэлийн 1 дэх ботийн 635-664 дэх талаас бүрэн эхээр нь үзэж болно.

гадаад улсын иргэд хооронд болон монгол улсын иргэн гадаадын иргэнтэй гэрлэсэн гэрлэлтийг цуцлахад хэрэглэгдэх хууль /111, 112 дугаар зүйл/, гэр бүлийн эрх зүйн харилцаанд гадаад улсын хууль хэрэглэх журам /113 дугаар зүйл/ зэрэг зохицуулалтыг агуулж байв. Энд хэрэглэх эрх зүйг тодорхойлсон арга журам нь өнөө мөрдөгдөж буй Гэр бүлийн тухай хууль /1999/ дахь олон улсын хувийн эрх зүйн зохицуулалттай харьцуулан үзэхэд илүү боловсронгуй байсан нь тодорхой харагддаг.

4. 2002 оны Иргэний хууль, 1999 оны Гэр бүлийн тухай хууль

1/ 2002 оны 9 сарын 1-нээс өнөөг хүртэл үйлчилж буй Иргэний хууль дахь ОУХЭЗ-н зохицуулалт нь 1994 оны шинэчлэн найруулсан иргэний хуулиас бараг өөрчлөгдөөгүй хэвээр тусгагдсан. 1999 онд батлагдсан Гэр бүлийн тухай хуульд ч гадаадын элемент бүхий гэр бүлийн харилцааг зохицуулсан хэм хэмжээг ховор тусгасан ба тусгагдсан зарим зөрчилдөөний хэм хэмжээ нь тэр бүр нийтлэг хэрэглэх боломжгүй нь тодорхой харагддаг. Уг хуулиудыг боловсруулан хэлэлцэж байх үед олон улсын хувийн эрх зүйн холбогдолтой хэрэг маргаан нэлээн ховор, шүүх арбитрын практик ч бараг байхгүй байсан. Харин сүүлийн жилүүдэд иргэд олон улсын шинж хамаарал бүхий иргэн, гэр бүл, өв залгамжлалын харилцаанд оролцох нь ихээхэн түгээмэл болж буйтай холбогдон шүүх арбитрт энэ төрлийн маргааныг шийдвэрлүүлэхээр хандах нь ч ихсэх төлөвтэй байна. Үүнээс үүдэн илүү тодорхой, боловсронгуй ОУХЭЗ-н зохицуулалт шаардагдах нь зүй бөгөөд цаашид ОУХЭЗ-н зохицуулалтыг өндөр түвшинд хөгжүүлж чадсан улс орны хууль тогтоомжийг харьцуулан судлах, эрх зүйн туслалцааны гэрээний зохицуулах зүйлийн хүрээг илүү өргөн болгох /тухайлбал, гэр бүл, өв залгамжлал, хөдөлмөрийн эрх зүйн харилцааг зохицуулах хэм хэмжээг илүү нарийвчлан тусгах/, холбогдох бусад олон улсын олон талт гэрээг судлах, шаардлагатай зарим гэрээнд нэгдэн орох нь зүйтэй юм.

2/ Гэр бүлийн тухай хууль. Дээр дурдсан 1973 оны хууль дахь олон улсын гэр бүлийн эрх зүйн заалтуудын нэлээд хэсэг нь 1999 онд шинээр батлагдсан хуульд хэвээр тусгагдсан боловч дотоодын гэр бүлийн эрх зүйн зохицуулалттай холилдож, бүтэц техникийн хувьд өөрчлөгдсөн.[7] Гэхдээ гэрлэгсдийн хоорондын харилцаа, эцэг эх хүүхдийн хоорондын харилцаа, тэжээн тэтгэх үүрэгт хэрэглэгдэх эрх зүй зэрэг ОУХЭЗ-н хэд хэдэн чухал асуудал зохицуулалтгүй орхигдсон нь түүний сул тал болж байна. Түүнчлэн, тус хуульд тусгагдсан зөрчилдөөний хэм хэмжээ нь зарим талаар

[7]Т. Мэндсайхан, Монгол Улсын гэр бүлийн эрх зүй дэх хууль сонгох журмыг зөв хэрэглэх асуудалд. МУИС-ХЗС-ийн Олон улсын эрх зүйн тэнхимийн судалгааны илтгэлийн эмхэтгэл, Улаанбаатар 2006 он., 27 дахь тал.

хэт явцуу буюу гэр бүлийн эрх зүйн харилцааг орон зайн хувьд нэлээд хязгаарласан байдлаар зохицуулсан нь хэрэглэхэд тэр бүр зохимжгүй бөгөөд ерөнхий зохицуулалт бүхий хэм хэмжээ шаардлагатай байгааг харуулдаг.

5. *Хуулиар зохицуулаагүй харилцаа*

Иргэний хуулийн 60-63 дугаар бүлгийн судалж үзэхэд олон улсын хувийн эрх зүйн зохицуулалт хангалттай бус гэж хэлэхээр байна.[8] Өөрөөр хэлбэл тухайн бүлгийн зохицуулах зүйлийн хүрээ, онцлогийг заагаагүй. Зөрчилдөөний хэм хэмжээ буцааж заах, бусад орны эрх зүйг заасан тохиолдолд хэрхэх, статус солигдох үед үүсэх эрх зүйн үр дагавар зэрэг ОУХЭЗ-н ерөнхий ангид хамаарах зарим чухал асуудлууд огт зохицуулагдаагүй орхигдсон байна. Түүнчлэн, нэрийн тухайд хэрэглэгдэх эрх зүй, эд хөрөнгө үндэслэлгүйгээр олж авах буюу баяжих, даалгаваргүйгээр бусдын үүргийг биелүүлэх үүргийн эрх зүйн зохицуулалт, төлөөлөлтэй холбоотой эрх зүйн харилцаанд хэрэглэгдэх эрх зүйг тодорхойлох арга, хуулийн этгээдийн харьяаллыг тодорхойлоход хэрэглэгдэх аргын зохицуулалт дутагдаж байна.

Хоёр. ОУХЭЗ-н өнөөгийн эрх зүйн зохицуулалтад шийдвэрлэвэл зохих асуудал

Хэдийгээр эрх зүйн шинэтгэлийн үр дүнд Монгол Улс дахь ОУХЭЗ-н зохицуулалт зарим талаар боловсронгуй болж ирсэн ч, дараахь асуудлыг шийдвэрлэх нь зайлшгүй чухал байна. Эдгээрийг тоочвол:

- ОУХЭЗ-н харилцааны хүрээ, үндсэн зарчмыг хуульд тусгах;
- Forum shopping-сэргийлэх буюу ОУХЭЗ-н хэм хэмжээг ижилтгэх арга хэмжээнд идэвхтэй оролцох;
- Ordre public (public order)-ийн шалгуурт юуг хамааруулж үзэхийг тогтоох;
- Хууль сонгох боломжийг нээлттэй орхих, хязгаарлах;
- Олон улсын шинжтэй гэр бүлийн эрх зүйн харилцааны зохицуулалт, хүүхдийн тэргүүн дээд эрх ашгийг харгалзан үзэх;
- Олон улсын иргэний процессын эрх зүйн асуудал, шүүхийн харьяалал болон зэрэгцээ процессын ажиллагаа, шийдвэр гүйцэтгэлийн асуудал зэрэг болно. Эдгээрийг тус бүрт нь дэлгэрүүлэн авч үзье.

[8]Хелмут Гроте,МУ-ын Иргэний болон худалдааны эрх зүйн цаашдын хөгжлийн талаархи санал зөвлөмж: Монголын эрх зүйн шинэтгэл 8 жил, Улаанбаатар 2003 он.,205-206 дахь тал.

1. **ОУХЭЗ-н харилцааны хүрээ, үндсэн зарчмыг хуульд тусгах.**

Иргэний хуулийн 60-63 дугаар бүлэг нь чухам ямар эрх зүйн харилцааг зохицуулахад хэрэглэгдэх вэ гэдгийг тодорхойлоогүй. Хэдийгээр, “Олон улсын иргэний эрх зүй” гэсэн нэртэй ч эрх зүйн харилцааны шинжийг тодорхойлоогүй, “шүүх, арбитр шаардлагатай бол...” гэсэн томьёоллыг хэрэглэсэн. Энд, “шаардлагатай бол” гэхээс илүүтэйгээр олон улсын хувийн эрх зүйн харилцаа гэдэгт ямар шинжийг агуулсан харилцааг хамааруулахыг заах нь хууль хэрэглэж буй бүхий л хүнд тодорхой, ойлгомжтой болох юм. Бусад улс орнууд, дийлэнхдээ олон улсын хувийн эрх зүйн харилцааг энд тодорхойлдог ба дор БНСУ, БНХАУ, Швейцарийн Холбооны Улсын хууль дахь зохицуулалтыг харьцуулж үзлээ:

БНСУ-ын ОУХЭЗ-н тухай актын 1 дүгээр зүйл /Act on private international law, 2016/[9]: олон улсын шинж бүхий эрх зүйн харилцаатай холбогдуулан хэрэг хянан шийдвэрлэх харьяаллын зарчим болон хэрэглэгдэх эрх зүйг тогтоох /1.1/

БНХАУ-ын Гадаад шинжтэй иргэний эрх зүйн харилцаанд хэрэглэх хуулийн тухай хууль[10]: Олон улсын шинж бүхий иргэний эрх зүйн харилцаанд хэрэглэх эрх зүйг тодорхой болгох, олон улсын шинж бүхий иргэний эрх зүйн маргааныг зохих журмын /angemessen/дагуу шийдвэрлэх, талуудын хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах /1 дүгээр зүйл/

Швейцарийн Холбооны Улсын ОУХЭЗ-н тухай хуулийн 1 дүгээр зүйлд:

a. Щвейцарын шүүхийн болон захиргааны байгууллагын шүүхийн харьяаллыг;
b. Гадаадын шийдвэрийг хүлээн зөвшөөрөх буюу хэрэгжүүлэх нөхцлүүд;
c. Өрсөлдөөний эрх зүй болон дампуурлын гэрээ;
d. Арбитрт хамаарах асуудлыг зохицуулна хэмээн тус тус заажээ.

Аливаа хууль тогтоомжийн хэрэглэх хүрээ, зохицуулах харилцаа тодорхой байх нь хууль хэрэглэж буй бүхий л хүнд ойлгомжтой тодорхой байдлыг бий

[9]Энэ хуулийг 2016 оны 1 сарын 19-ны өдөр баталсан уг өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилж байна. Дараах линкээр англи хэл дээр үзэх боломжтой: https://law.go.kr/LSW/lsInfoP.do?lsiSeq=179501&viewCls=engLsInfoR&urlMode=engLsInfoR#0000

[10] Энэхүү хууль 2010 оны 10 сарын 28-нд БНХАУ-ын Бүх ард түмний 11 дүгээр хурлын Байнгын хорооны 17 дугаар хуралдаанаар батлагдсан ба 2011 оны 4 сарын 1-нээс хүчин төгөлдөр үйлчилж байна. Дараах холбоосоор англи хэл дээр үзэх боломжтой: https://www.wipo.int/edocs/lexdocs/laws/en/cn/cn173en.pdf.

болгох сайн үр дагавартай. Иймээс Иргэний хуулийн 60-63 дугаар бүлгийн хэрэглэгдэх хүрээг тодорхойлон зааж өгөх нь зүйтэй гэж үзэж байна.

2. Forum shopping-сэргийлэх буюу ОУХЭЗ-н хэм хэмжээг уялдуулах, ижилтгэх

Олон улсын хувийн эрх зүйн зохицуулалтыг ижилтгэх, үндэсний эрх зүйн зохицуулалтыг уялдуулах ажлыг олон улсын байгууллага болон бүс нутгийн нэгдлүүд идэвхтэй явуулж ирсэн. Үүний гол зорилго нь ижил төстэй ОУХЭЗ-н зохицуулалт бий болгох, ингэснээр forum shopping-оос урьдчилан сэргийлэх явдал юм.

Forum shopping хэмээн ойлголтыг ОУХЭЗ судлаачид хамгийн тааламжгүй нэр томьёо гэж үздэг. Учир нь нэхэмжлэгч нь өөрийн нэхэмжлэлийг харьяалан шийдвэрлэж болох хэд хэдэн улсын эрх зүйг судалж, өөрт хамгийн тааламжтай шийдвэр гаргаж болохуйц улсын шүүхэд хандах боломжтой ба үүнийг forum shopping гэж нэрлэдэг, гол шалтгаан нь улс бүрийн ОУХЭЗ-н болон олон улсын иргэний маргааны шүүхийн харьяаллын эрх зүйн зохицуулалт өөр өөр байдагтай холбоотой. Ийм ч учраас, улс орнуудын ОУХЭЗ-н зохицуулалтыг ижилтгэх нь дээрх сөрөг үр дагаврыг арилгах гол аргын нэг юм. Forum shopping-оос урьдчилан сэргийлэх гол аргуудын нэг болох ижилтгэх арга хэмжээг дараах хэлбэрээр хэрэгжүүлдэг:

- ОУ-ын олон талт гэрээ байгуулах /бүлэг асуудал зохицуулсан, тодорхой асуудал зохицуулсан, түгээмэл ба бүс нутгийн шинжтэй гэх мэт/
- Загвар хууль
- Заншлын хэм хэмжээг төрөлжүүлэн эмхэтгэх

3. Ordre public- нийтийн дэг журмын тухай тайлбар

Ordre public буюу нийтийн дэг журмын тухай тайлбар нь гадаадын эрх зүйг хэрэглэх, хүлээн зөвшөөрөх нь нийтийн дэг журамтай зөрчилдөж байгаа тохиолдолд тухайн сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх зорилготой, өвөрмөц шинжтэй “хамгаалах хавхлага” юм. Өөрөөр хэлбэл, зөрчилдөөний хэм хэмжээний дагуу аль нэг гадаад улсын эрх зүйг хэрэглэснээс улбаалан үүсэж болох сөрөг үр дагавраас урьдчилан сэргийлэх зорилготой ойлголт болно. Ийм сөрөг үр дагавар үүсэж байгаа тохиолдолд тухайн гадаадын эрх зүйн хэм хэмжээг хэрэглэхгүй байх тухай яригддаг. Дан ганц гадаадын эрх зүйг хэрэглэх бус, гадаадын шүүх, арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрч биелүүлэх, гадаад улсын шүүхийн даалгаврыг биелүүлэх үед ч нийтийн дэг журамтай үл нийцэх бол түүнийг биелүүлэхгүй байх үр дагавар үүсдэг. Нийтийн дэг журам нь талуудын бие

даасан байдлын зарчмаас дээгүүр тавигдах ба хэрэг маргааныг хянан шийдвэрлэж буй шүүхийн орны эрх зүйн императив хэм хэмжээ болон тус улсын эрх зүйн дэг журмын бүрэн байдлыг хамгаалах боломжийг шүүхэд олгодог хэмээн НҮБ-ын Олон Улсын Худалдааны эрх зүйн комиссын нарийн бичгийн дарга нарын газраас гаргасан “Гадаадын арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрч биелүүлэх журмын тухай конвенцын талаарх тайлбар”-т дурджээ.[11]

Нийтийн дэг журамд чухам ямар нөхцөлийг хамааруулж үзэх талаар улс бүр өөр өөрийн онцлог бүхий үзэл баримтлалтай байдаг ч нийтийн ашиг сонирхол, эрх зүйн үндсэн зарчим, шударга ёсны наад захын хэмжүүрийг зөрчсөн байхыг нийтлэг шалгуур болгон ашиглаж байна. Түүнчлэн, соёл уламжлал, улс төр, шашны үзэл баримтлал ч шалгуур болохыг үгүйсгэхгүй.

Монгол Улсын Иргэний хууль, 540.1-ийг Монгол Улс дахь нийтийн дэг журмын тайлбар хэмээн үзэж болохуй байдаг. Энд:

- Монгол Улсын Үндсэн хууль
- Монгол Улсын Олон улсын гэрээ
- Монгол Улсын бусад хуультай зөрчилдөхгүй бол гадаадын хууль, олон улсын заншлын хэм хэмжээг хэрэглэж болохоор тусгасан. Энд зайлшгүй засварлавал зохих нэг нөхцөл нь аливаа улс орны хуультай зөрчилдөхгүй гадаад улсын хууль байх боломжгүй бөгөөд энэ шалгуурыг хэрэглэх нь гадаадын хууль хэрэглэх нөхцөл боломжийг бүрмөсөн үгүйсгэнэ. Тиймээс бусад хуулийн үндсэн зарчим гэх нэр томьёог хэрэглэх нь илүү зохимжтой гэж үзэж байна.

Нөгөө талаас, зарим улс орон гол төлөв “нийтийн дэг журам” гэх ерөнхий нэр томьёог хэрэглэсэн байх ба үүнийг шүүх практикаараа хэрэглэх хүрээг нь тогтоож, өргөтгөн тайлбарлах боломжийг олгосон болов уу. Тухайлбал, БНСУ10.1.”Гадаад улсын хуулийг хэрэглэх тохиолдолд тухайн зохицуулалт нь БНСУ-ын ёс заншил ба бусад нийгмийн дэг журамд харшилж байвал үүнийг хэрэглэхгүй”, БНХАУ 5 дугаар зүйл: Хэрэв гадаад улсын хуулийг хэрэглэх нь БНХАУ-ын нийгмийн нийтлэг ашиг сонирхолд хохирол учруулахаар бол БНХАУ-ын хуулийг хэрэглэн”, Швейцарийн Холбооны Улс “Гадаад улсын эрх зүйг хэрэглэх нь Швейцарь улсын нийтийн дэг журамд үл нийцэх үр дагаварт хүргэхээр бол түүнийг хэрэглэхийг хориглоно” хэмээн тус тус зохицуулжээ.

[11]“Гадаадын арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрч биелүүлэх журмын тухай конвенцын талаарх ЮНСИТРАЛ-ын тайлбар”. УБ 2021., 237 дахь тал.

4. Хууль сонгох боломжийн хязгаар

ОУХЭЗ-н нэгэн онцлог бол талууд хэрэглэх хуулиа өөрсдөө сонгох боломжийг олгодог явдал билээ. Энд аль хуулийг бус, харин тухайн харилцааг зохицуулсан аль улсын хуулийг сонгох вэ гэдэг асуудал яригдана. Гэхдээ энэхүү боломж нь тодорхой тохиолдолд хязгаарлагддаг. Гэхдээ хязгаарлах үндэслэлийг улс гүрэн өөрөө хуулираа тогтоож өгөх ёстой. Ийнхүү хязгаарлах дараах үндэслэлүүд байх боломжтой:

- Нягт холбооны зарчмаар хязгаарлагдана
- Императив хэм хэмжээний үндсэн дээр хязгаарлах
- Нийтийн дэг журмын зохицуулалтын үндсэн дээр хязгаарлах
- Зарим тохиолдолд олон улсын гэрээнд заасны дагуу хязгаарлагдах

Монгол Улсын Иргэний хуульд ОУХЭЗ-н зарчмууд тусгагдаагүй. Иймд нягт холбооны зарчмын үндсэн дээр хязгаарлалт хэрэглэх боломжгүй ба цөөн тохиолдолд, өөрөөр хэлбэл үл хөдлөх эд хөрөнгөтэй холбоотой хэлцэл, өв залгамжлал болон гэрээслэлийн хувьд л хэрэглэх хуулийн сонголтыг хязгаарлахаар зохицуулсан. Ямар ч тохиолдолд, аливаа улсын нутаг дэвсгэрт заавал дагаж мөрдвөл зохих хуулийн заалтыг зөрчсөн, эсхүл ийм хуулийг дагаж мөрдөхөөс зайлсхийн өөр бусад улсын эрх зүйг хэрэглэхээр сонгосон бол түүнийг хүчингүй гэж үзэх нь илүү зохимжтой. Ингэснээр, өөрийн орны эрх зүй, хууль ёсыг хамгаалах бөгөөд түүнийг зөрчигдөх явдлаас урьдчилан сэргийлэх юм.

5. Олон улсын шинжтэй гэр бүлийн эрх зүйн зарим асуудал

ОУХЭЗ-н хамгийн чухал бөгөөд, хамгийн их маргаан үүсдэг асуудал бол олон улсын шинжтэй гэрлэлт, түүнээс үүдэлтэй эрх зүйн асуудал байдаг. Нэн түрүүнд, гадаадын иргэдийн гэрлэхэд тавигдах шаардлагыг аль улсын эрх зүйгээр тодорхойлох явдал орох ба дийлэнх улс оронд үүнийг гэрлэгсдийн тус бүрийн харьяалсан улсын хуульд захируулдаг. Монгол Улсын Гэр бүлийн тухай хуулийн 6.3-т “гадаадын иргэн, харьяалалгүй хүнтэй гэрлэх асуудлыг Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн дагуу зохицуулна” гэж заасан. Эндээс харахад, гадаадын иргэд ч Монгол Улсын иргэдийн нэгэн адилаар Гэр бүлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасан харшлах шалтгаагүй гэдгээ нотлох үүрэгтэй болно. Гэхдээ нэгэнт гэр бүлийн харилцаанд өөр өөр улсын иргэд оролцож байгаа тул, гадаадын иргэний эрхийг ч хүндэтгэн үзэх нь зөв бөгөөд тус тусын харьяалсан улсын эрх зүйг баримтлах зохицуулалт илүү өргөн хэрэглэгдэж байна.

Нөгөө талаас, дэлхий даяар эрчимтэй явагдаж буй хүн амын шилжилт хөдөлгөөн, дүрвэлт, цагаачлалын улмаас урьд өмнө хуульчдад тулгарч байгаагүй бэрхшээл гарч эхэллээ. Тухайлбал, моногам гэрлэлтийг

л хүлээн зөвшөөрдөг улсад полигам гэрлэлтийг зөвшөөрдөг улсаас ирсэн цагаач иргэн, гэр бүлээ татаж авах хүсэлт тавихдаа өөрийн хууль ёсны 4 эхнэр, тэднээс төрсөн хүүхдүүдийг авчрах хүсэлт тавьсан ба харин цагаачлалын алба болон хуульчид нь чухам аль эхнэрийг нь хууль ёсны эхнэр гэж үзэх вэ хэмээх хүндэн бодлоготой тулгарсан. Учир нь бүх эхнэрийг хүлээн зөвшөөрөх нь өөрийн орны нийтийн дэг журам буюу ordre public-ийг зөрчих боловч нөгөө талаас эхнэр, хүүхдүүдийн хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэн үзэх шаардлага тавигдана. Ийм нөхцөлд хэрхэн шийдвэрлэх талаар одоогоор европын орны хуульчид судалгаа хийж гарцыг эрэлхийлж байна.

Монгол Улс нь өдгөө өөрийн орны хуулийн дагуу гэрлэлтийг бүртгэж байгаа ч цаашид гэрлэгсдийн тус тусын харьяалсан улсын эрх зүйг хэрэглэх, ингэхдээ өөрийн орны нийтийн дэг журам, Гэр бүлийн эрх зүйн үндсэн зарчмыг хамгаалан үлдэх нь зүйд нийцнэ.

Гэр бүлийн эрх зүйн дараагийн нэгэн чухал асуудал бол хүүхдийн тэтгэмж, тэтгэмж олгоход хүүхдийн тэргүүн дээд эрх ашгийг харгалзан үзэх явдал болно. Монгол Улсад шүүхийн практикт, талууд тохиролцоогүй бол дийлэнхдээ хуульд заасан хэмжээгээр л тэтгэмж олгодог ба энэ нь төдийлөн хангалттай хэмжээ биш. Гадаадын иргэн, харьяалалгүй хүнээс хүүхдийн тэтгэмж гаргуулахад заавал хүүхдийн харьяалсан улсын хууль буюу Монгол Улсын хуулийг бус, харин хүүхдийн дээд эрх ашгийг харгалзан үзэж, аль илүү таатай нөхцөл олгож буй улсын хуулийг хэрэглэх боломжтой гэж үзэж байна. Эдгээрээс гадна эцэг эх хүүхдийн харилцаа, гэрлэгсдийн хоорондын харилцаанд хэрэглэх эрх зүй, гадаадын иргэнд хүүхэд үрчлүүлэх эрх зүйн зохицуулалтыг шинэчлэхдээ илүү найдвартай бөгөөд уян хатан зохицуулалтыг хэрэглэх шаардлага тавигдана. Нэн ялангуяа үрчлэлтийн харилцаанд, хүүхдийг халуун дулаан уур амьсгалтай гэр бүлд өсгөх нь хүүхдийн дээд эрх ашигт нийцэх ба энэхүү зорилтыг хангах үүднээс одоогийн байгаа журмыг уян хатан болгох нь зүйд нийцнэ.

6. Олон улсын иргэний процессын эрх зүйн асуудал, шүүхийн харьяалал болон зэрэгцээ процессын ажиллагаа, шийдвэр гүйцэтгэлийн асуудал

Олон улсын эдийн засгийн харилцаа улам өргөжиж байгаатай холбогдон олон улсын иргэний процессын ач холбогдол ч нэмэгдсээр байна. Өөрөөр хэлбэл, шүүхэд олон улсын шинж хамаарал бүхий хэрэг маргааныг шийдвэрлэж буй тоо огцом өсөж эхэлсэн билээ. 1990 онд зах зээлийн эдийн засагт шилжиж, социалист үзэл баримтлал бүхий хууль тогтоомжийг шинэчлэн найруулж, заримыг шинээр боловсруулан батлан мөрдөж эхэлсэн. 1994 оны 5 дугаар сарын 9-ний өдөр баталсан Иргэний

хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль /цаашид ИХШХШТХ гэх/-ийн 235-240 дүгээр зүйлд Олон улсын иргэний хэрэг хянан шийдвэрлэхэд хамаарах зохицуулалтыг тусгасан байв. Олон улсын иргэний хэргийн шүүхийн харьяалал, хэрэглэх олон улсын гэрээ болон харьяаллын төрлүүдийг энд тусгаагүй бөгөөд, тун ерөнхий зохицуулалттай байсан. Харин 2002 оны ИХШХШТХ-д өмнөхөөс илүү дэлгэрэнгүй зохицуулалт тусгахыг эрмэлзсэн ба шүүхийн харьяаллын төрлүүдийг ангилж, зарим төрлийн хэрэг маргааныг нарийвчлан зааснаараа онцлог байна.

Үндэсний хууль тогтоомжоос гадна, Монгол Улс 1958 онд анх Унгар улстай Эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх гэрээ байгуулснаас хойш өдгөө 16 улстай ийм гэрээг байгуулсан. Эрх зүйн харилцан туслалцааны гэрээ нь гол төлөв процессын журам агуулсан байх бөгөөд шүүхийн харьяалал, шүүхийн даалгавар, шүүхийн баримт бичиг гардуулах журам, шүүхийн шийдвэр биелүүлэх журмыг тусгасан байдаг.

Сүүлийн жилүүдэд олон улсын хувийн эрх зүйн салбарт чухлаар тавигдах болсон нэгэн асуудал бол зэрэгцээ процессын ажиллагаа, түүний сөрөг үр дагаврын асуудал юм. Энэ нь нэг хэргээр хоёр улсын шүүхэд эсхүл шүүх, арбитрт зэрэг маргаан үүсэх тухай ойлголт бөгөөд, нэг хэргийг 2 шүүх нэгэн зэрэг шийдвэрлэх боломжгүй, тиймээс аль нэг нь татгалзах ёстой гэх үзэл дээр үндэслэдэг. Зэрэгцээ процессын ажиллагаанаас татгалзвал зохих онолын үндэслэлийг “forum non conveniens”, “lis alibi pendens” гэх ойлголтоор илэрхийлдэг.

Forum non conveniens нь хэргийг шийдвэрлэх зохимжгүй шүүх гэсэн утгатай ба нийтийн эрх зүйт орнуудад түгээмэл хэрэглэдэг. Гол агуулга нь нэг хэргийг 2 шүүхэд зэрэг шийдвэрлэхгүй, аль тохиромжтой шүүхийг тогтоож өгөх явдал юм. Forum non conveniens тогтооход зайлшгүй харгалзан үзвэл зохих асуудал нь:

- Өөр тохиромжтой шүүх байгаа эсэх
- Талууд аль улсад оршин сууж байгаа
- Нотлох баримт аль улсад байгаа, түүнийг олж авахад ямар ажиллагаа шаардагдах
- Аль улсын эрх зүйг хэрэглэж маргаан шийдвэрлэх
- Хөөн хэлэлцэх хугацаа
- Шүүхийн шийдвэрийн биелэгдэх боломжтой байдал

юм.[12] Эдгээрийг харгалзан үзсэний үндсэн дээр хэргийг хянан шийдвэрлэх тохиромжгүй шүүх гэж үзвэл нэхэмжлэлийг хүлээн авахгүй байх нь зүйтэй байна.

[12] Cheshire, North&Fawcett. Private International law. 15th edition. Oxford 2017. P 202; Б. Тамир, Олон улсын хувийн эрх зүй. УБ 2019 он., 108 дахь тал.

Харин Lis alibi pendens нь эх газрын эрх зүйн тогтолцоот улсуудад өргөн хэрэглэдэг зохицуулалт бөгөөд хоёр өөр шүүхэд зэрэг хэрэг үүссэн бол хамгийн эхэнд хэрэг үүсгэсэн шүүх харьяалан шийдвэрлэнэ. Аль нэг улсын шүүх нь онцгой харьяалалтай байгаа эсэхийг хянана, онцгой харьяалал байвал тэр шүүх нь хянан шийдвэрлэнэ гэх үзэл дээр үндэслэсэн зохицуулалт юм. Энэ зарчмыг хуульд тусгасан улс бол Швейцарь бөгөөд зарим олон улсын гэрээнд ч тусгалаа олсон байх нь бий.

Тухайлбал, Швейцарийн ОУХЭЗ-н тухай хуулийн 9 дүгээр зүйлд: “Нэг ижил талууд нэг ижил шаардлага бүхий нэхэмжлэлийг гадаад улсын шүүхэд гаргасан бөгөөд тухайн гадаад улсын шүүх нь Швейцарьт хүлээн зөвшөөрөгдөхүйц шийдвэрийг боломжийн хугацааны дотор гаргахаар хүлээгдэж байгаа тохиолдолд Швейцарийн шүүх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаагаа түдгэлзүүлнэ”, 9.2-т “Швейцарьт хэрэг үүсгэсэн огноог тодорхойлоход хэрэг үүсгэхэд шаардлагатай эхний хянан шийдвэрлэх ажиллагааг эхлүүлсэн огноог баримтална. Эвлэрүүлэх ажиллагаанд оролцох тухай мэдэгдэл хүргүүлсэн байхад хангалттай”, 9.3-т “Швейцарьт хүлээн зөвшөөрөгдөхүйц гадаад улсын шийдвэрийг хүлээн авсан даруйд Швейцарийн шүүх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаагаа цуцална” хэмээн заасан байна.

Параллель процессын ажиллагаа явагдах нь маргааны талуудад цаг хугацаа, зардал ихээр гаргахаас гадна хэрэв 2 шүүх, эсхүл шүүх ба арбитр нь өөр өөр агуулга бүхий шийдвэр гаргасан тохиолдолд түүнийг хэрхэн биелүүлэх вэ гэх чухал асуудлыг хөндөнө. Олон улсын арбитрын ажиллагааны түүхэнд ийм тохиолдлууд гарч байсан ба нэг арбитр нь нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож, харин нөгөө нь 300 сая долларын нөхөн төлбөрийг хариуцагч төлөх ёстой гэсэн шийдвэр гаргаж байв.[13] Иймээс зайлшгүй шийдвэрлэвэл зохих асуудлын нэг болон хувирч байгаа юм. Нөгөө талаас, res judicata хэмээх зарчим ч чухалд тооцогдох болсон ба нэгэнт шийдвэрлэсэн хэргийн хувьд дахин хэрэг үүсгэх боломжгүй гэж үздэг. Гэхдээ энэ нь гагцхүү шүүх буюу арбитрын шийдвэрлэсэн нэхэмжлэлийн агуулгын хувьд яригдах нь зүйтэй бөгөөд талуудын хооронд цаашид өөр асуудлаас үүдсэн маргааныг шүүх хүлээн авч шийдвэрлэх нь зүйтэй.

Арбитрын тухай хуулийн 10 дугаар зүйлд:

10 дугаар зүйл.Арбитрын хэлэлцээр ба шүүхэд нэхэмжлэл гаргах

[13] Ronald S. Lauder v. The Czech Republic, UNCITRAL /харъяалан шийдвэрлэсэн ч нэхэмжлэлийн шаардлагыг хангаагүй/ харин CME Czech Republic B.V. v. The Czech Republic, UNCITRAL /нэхэмжлэлийн шаардлагыг хангасан/

10.1.Арбитрын хэлэлцээртэй боловч шүүхэд нэхэмжлэл гаргасан бөгөөд аль нэг тал тайлбар гаргахаасаа өмнө уг маргааныг арбитрын журмаар шийдвэрлүүлэх хүсэлт гаргасан бол шүүх аль нэг талын хүсэлтээр арбитрын хэлэлцээрийг хүчин төгөлдөр бус, эсхүл биелүүлэх боломжгүй гэж үзсэнээс бусад тохиолдолд шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг дуусгавар болгоно.

10.2.Энэ хуулийн 10.1-д зааснаар нэхэмжлэл гаргасан тохиолдолд арбитр нь шүүхийн ажиллагаа явагдаж байх хугацаанд арбитрын ажиллагааг эхлүүлэх, эсхүл үргэлжлүүлэх, арбитрын үндсэн шийдвэр гаргах эрхтэй гэж заасан нь шүүх болон арбитрт нэгэн зэрэг нэг ижил маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаж болохоор зохицуулсан нь зохимжгүй болжээ.[14] Иймд, аль нэг маргаан таслах байгууллагад маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаж дуусах хүртэл нөгөө нь түдгэлзэх зохицуулалтыг тусгах нь зүйтэй байна.

Гурав. ОУХЭЗ-г хөгжүүлэх зорилт, олон улсын хамтын ажиллагаа

Хэдийгээр ОУХЭЗ-н суурь ойлголт, үндсэн зарчим ихэнх улс орны хууль тогтоомжид тусгалаа олсон ч, орчин үед дэлхий дахинд тулгарч буй хэд хэдэн асуудлын улмаас түүнийг цаашид хөгжүүлэх, улам боловсронгуй болгох хэрэгцээ шаардлага тулгарсаар байна. Үүнд нөлөөлж буй шалгаан нь:

- Улс хоорондын зэвсэгт мөргөлдөөн, дотоодын эмх замбараагүй байдлаас үүдэлтэй дүрвэх хөдөлгөөн эрс нэмэгдсэн,
- Цар тахлаас шалтгаалан аливаа харилцаа улам бүр алсын зайны шинжтэй болж, онлайн худалдаа, үйлчилгээний хэрэгцээ шаардлага улам бүр ихэссэн,
- Хиймэл оюун ухаан, технологийн шийдлийг ашигласан шинэ төрлийн амьдралын хэв маяг бий болох магадлал өндөр болсон (metaverse),
- Цахим төлбөрийн хэрэгсэл

2018 онд ОУХЭЗ-н Гаагийн бага хурлаас Америкийн Олон улсын хувийн эрх зүйн хүрээлэнтэй хамтран судалгаа хийж, ОУХЭЗ-н хувьд ойрын 25 жилд тулгарах асуудлыг тодорхойлон, хөгжүүлэх чиг баримжааг боловсруулан гаргажээ. Нэн тэргүүнд анхаарах, ерөнхий асуудлыг багцлан, ойрын хугацаа, дунд хугацаанд болон урт хугацаанд хөгжүүлэх гэсэн бүлгүүдэд хуваан ангилсныг дор хүснэгтээр үзүүлье.

[14] Энэ зохицуулалтын тухай Д. Дүгэржав, Арбитрын тухай хуулийн товч тайлбарын 34-36 дахь талаас дэлгэрэнгүй үзнэ үү.

№	Ойрын зорилт	Дунд хугацааны	Урт хугацааны
1	Олон улсын эрх зүйн туслалцааг эрчимтэй хөгжүүлэх	Олон улсын эрх зүйг тайлбарлах зохицуулалтын арга хэрэгслийг ижилтгэх	Эдийн засгийн интеграци, хүн амын шилжилт хөдөлгөөн, соёл иргэншлүүдийн мөргөлдөөн зэргээс үүдэн тулгарч буй асуудлыг ОУХЭЗ-н хүрээнд шийдвэрлэх
2	Шинэ техник технологиос үүдэн үүсэж болох асуудлыг ОУХЭЗ-н хүрээнд шийдвэрлэх	ОУЭЗ-г үндэсний эрх зүйд нийцүүлэх /конвенцийг соёрхон батлах, нэгдэн орох/	Шударга ёс, эрх зүйн арга хэрэгсэлд үндэслэн амьдралын чанарыг дээшлүүлж сул талыг хамгаалах ,
3	Шүүхийн харьяалал, олон улсын шүүхийн хамтын ажиллагаа, шүүхийн шийдвэрийн үр нөлөөтэй байдлаар дамжуулан хүний эрхийн хамгаалалтыг сайжруулах	ОУЭЗ-н талаарх улс үндэстний эрх зүйн зохицуулалтыг сайтар судлах, тэдгээрийн хамтын ажиллагааг сайжруулах	Хэрэглэгч болон жижиг дунд үйлдвэр: ОУХЭЗ-н хүрээнд ЖДҮ эрхлэгч болон хэрэглэгчийн интеграцийг дэмжих

Энэхүү хүснэгтээс харахад, ОУХЭЗ-н салбарт нэн тэргүүнд хөгжүүлэх, анхаарах асуудал нь хэрэглэх эрх зүйн зохицуулалтаас илүүтэй шүүхийн харьяалал, олон улсын эрх зүйн туслалцаа, хамтын ажиллагаа бөгөөд үүн дээр суурилан бусад дэд салбарыг хөгжүүлэх, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох боломжтой байна.

ДҮГНЭЛТ

Энэхүү илтгэлийн эцэст дүгнэж үзэхэд, ОУХЭЗ-н харилцаа монгол улсад улам бүр өргөжиж, олон улсын бизнес, гэр бүл, өв залгамжлал, олон улсын шинжтэй иргэний маргаан шүүхэд шийдэгдэх явдал жилээс жилд нэмэгдэж байгаа бөгөөд үүнийг даган эрх зүйн зохицуулалтыг ч улам боловсронгуй болгож, ОУХЭЗ-н хэм хэмжээг зөв зүйтэй хэрэглэх практикийг хэвшүүлэх нь чухал болж байна. Монгол Улс дахь ОУХЭЗ-г хөгжүүлэхэд нэн тэргүүнд авч хэрэгжүүлэх нь зүйтэй дараах алхамууд байна гэж үзлээ:

- Эрх зүйн зохицуулалтыг ойлгомжтой, тодорхой болгох зорилгоор ОУХЭЗ-н тухай хуультай болох;
- Шүүх, арбитрт гадаад улсын хууль хэрэглэх практик, бусад улсын туршлагыг судалж нэвтрүүлэх;
- ОУХЭЗ дэх нийтийн дэг журмыг тодорхойлох шалгуурыг тогтоох;
- ОУИП-ын хувьд, параллел процессын ажиллагаа явагдахаас сэргийлэх зохицуулалтыг хуульд тусгах /эхний ээлжид/;
- ОУХЭЗ-н судалгааны байгууллагын үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, үйл ажиллагаа, зорилго чиглэлийг уялдуулах.

--0--

СОЦИАЛЬНОЕ ПРЕДПРИНИМАТЕЛЬСТВО И РЕФОРМА ЧАСТНОГО ПРАВА В РОССИИ[1]

ОРОСЫН ХОЛБООНЫ УЛС ДАХЬ НИЙГЭМД ТУСТАЙ АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭЛТ БА ХУВИЙН ЭРХ ЗҮЙН ШИНЭТГЭЛ

SOCIAL ENTREPRENEURSHIP AND PRIVATE LAW REFORM IN RUSSIA

Филатова Ульяна Борисовна
Юридический институт, Иркутский государственный университет, профессор кафедры гражданского права, Юридический факультет им. М.М. Сперанского РАНХиГС, профессор кафедры предпринимательского, трудового и корпоративного права, доктор юридических наук, доцент

Ульяна Борисовна Филатова
Оросын Холбооны Улсын Эрхүүгийн Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургуулийн профессор, хууль зүйн доктор

Ms. Uliana Borisovna Filatova
Law Institute, Irkutsk State University, Doctor of Law, Professor of the Department of Civil Law, Faculty of law. M. M. Speranskiy of the Russian Academy of national economy, Professor of the Department of business, labour and corporate law

Аннотация:

Одним из актуальнейших направлений развития современного законодательства России остается правовое обеспечение перехода социальной сферы из государственной в частный сектор экономики. Социальное предпринимательство является одним из факторов, обеспечивающих последовательное, поступательное и устойчивое развитие современного общества в социальной, экологической, образовательной и инновационной сферах.

Социальное предпринимательство не только с правовой, но и с экономической точки зрения представляет собой молодое направление деятельности, а потому методы его правового регулирования в разных государствах различны, начиная от отрицания необходимости в таковом, заканчивая попытками облечь социально-предпринимательские отношения в правовую форму, с целью не только гарантировать социальным предприятиям поддержку, но и

[1] Исследование выполнено при финансовой поддержке РФФИ в рамках научного проекта № 20-011-00222

проследить за качеством оказываемых ими услуг, что мы наблюдаем в современной России.

Хураангуй:

Нийгмийн салбарыг төрөөс эдийн засгийн хувийн хэвшилд шилжүүлэх эрх зүйн зохицуулалт нь Оросын орчин үеийн хууль тогтоомжийн хөгжлийн нэг чухал сэдэв хэвээр байна. Нийгэм, эдийн засгийн харилцаа нь нийгэм, экологи, боловсрол, инновацийн салбар түүний тогтвортой хөгжлийг хангах чухал хүчин зүйлүүдийн нэг юм.

Нийгэм, эдийн засгийн харилцаа нь эрх зүйн үүднээс төдийгүй эдийн засгийн үүднээс авч үзэхэд шинэ чиглэл юм. Иймээс нийгэм, аж ахуйн нэгжүүдэд үзүүлэх эдийн засгийн дэмжлэгийг төрөөс баталгаажуулахаас гадна тэдний үйл ажиллагааны чанарыг хянах, сайжруулахын тулд улс орон бүрийн онцлог эрх зүйн зохицуулалтыг харгалзан үзэж нийгэм, эдийн засгийн харилцааг зөв хэлбэрт оруулах оролдлого хийх нь өнөөгийн ОХУ-д бидний ажиглаж буй нөхцөл болно.

Abstract:

Legal support for the transition of the social sphere from the public sector of the economy to the private sector is an urgent direction of the development of legislation in Russia. Social entrepreneurship is one of the factors that ensure the consistent, progressive and sustainable development of modern society in various spheres.

From the point of view of law and economics, social entrepreneurship is a young field of activity. Therefore, the methods of its legal regulation in different states are diverse. On the one hand, the states deny their necessity, on the other, they are making attempts to clothe social and entrepreneurial relations in a legal form. The purpose of such actions is to support social enterprises and monitor the quality of their services. This is what is typical for Russia.

Согласно статье 6 Конституции Российская Федерация является социальным государством, политика которого направлена на создание условий, обеспечивающих достойную жизнь и свободное развитие человека. В развитие идеи социального государства в пункте втором обозначенной статьи перечисляются субъекты, нуждающиеся в особой социальной поддержке со стороны государства: семья, матери, отцы, дети, инвалиды, пожилые граждане. Обозначены направления государственной деятельности в этой сфере: охрана труда и здоровья людей, установление гарантированного минимального размера оплаты труда, развитие системы социальных служб, установление государственных пенсий, пособий и иных гарантий социальной защиты.

Обычно социальная миссия государства связывается с деятельностью самого государства и создаваемой им системы социальных служб. Так по данным Министерства финансов РФ около 30

% расходной части бюджета РФ составляет направления социальной политики.[1]

Однако ярко выраженной тенденцией последних лет стало активное вовлечение в социальную сферу элементов гражданского общества и всесторонняя поддержка государством социального предпринимательства, что позволяет говорить о том, что в будущем многие функции государства в социальной сфере будут переданы субъектам предпринимательства. В ноябре 2018 года заместитель Председателя Комитета Госдумы РФ по экономической политике, промышленности, инновационному развитию и предпринимательству Дмитрий Сазонов подтвердил потребность в законопроекте о социальном предпринимательстве, отметил, что Правительство РФ будет направлять усилия для развития данного направления. Так, он полагает, что необходимо постепенно увеличивать долю присутствия негосударственных организаций на рынке социальных услуг, достигнув 50% к 2024 году. Кроме того, по его мнению, необходимо создать реестр видов деятельности, которые могут предлагаться на рынке оказания социальных услуг, а также разработать стандарт единого высокого качества их оказания.[2]

Документом свидетельствующими о поступательном развитии государства в обозначенном направлении является «Концепция долгосрочного социально-экономического развития РФ на период до 2020 года».[3] Концепция закрепляет главной целью социального государства развитие человеческого потенциала посредством системных преобразований направленных на повышение конкурентоспособности кадрового потенциала, рабочей силы и социальных секторов экономики, а также улучшающих качество социальной среды и условий жизни людей.

Концепция определяет среди приоритетов социальной политики социальную защиту населения (параграф 8 ч. 3 Концепции), которая планируется осуществляться, в том числе посредством развития сектора негосударственных некоммерческих организаций в сфере оказания социальных услуг. Планируется преобразовать большинство государственных и муниципальных учреждений системы социальной защиты, оказывающих услуги пожилым и инвалидам, в некоммерческие организации и создать механизм привлечения их на конкурсной основе к выполнению государственного заказа по оказанию социальных услуг. Презюмируется, что данные организации будут осуществлять свою деятельность, руководствуясь принципом прозрачности и основываясь на конкурентной системе государственной поддержки. Концепцией

обозначено так же развитие практики благотворительной деятельности граждан и организаций, а также распространение добровольческой деятельности (волонтерства).

Яркой иллюстрацией намерения государства передать реализацию социальной миссии частным организациям коммерческого и некоммерческого характера является Стратегия развития малого и среднего предпринимательства в Российской Федерации на период до 2030 года,[4] в которой отмечается большой потенциал для развития малого и среднего предпринимательства в социальной сфере. При этом предлагается ряд мер, направленных на увеличение доли субъектов малого и среднего предпринимательства в сфере социальных услуг. В частности работа по снятию ограничений для вхождения новых организаций на рынок социальных услуг, создание и развитие специализированных организаций инфраструктуры поддержки в субъектах Российской Федерации, предоставление субсидий на реализацию проектов в области социального предпринимательства, меры по популяризации такой деятельности.

Посредством привлечения к оказанию социальных услуг негосударственных организаций планируется «повысить качество оказания гарантированных государством услуг в социальной сфере» [5].

При этом государство сохраняет за собой важные прерогативы, с одной стороны, определяет круг субъектов, обладающих правом на получение услуг в социальной сфере, с другой, отбирая исполнителей услуг и отслеживая качество их исполнения.

Обозначенная выше государственная стратегия имеет явно выраженное проявление на законодательном уровне. В июле 2019 года в ФЗ РФ «О развитии малого и среднего предпринимательства» были закреплены понятия «социальное предпринимательство» и «социальное предприятие». Под социальным предпринимательством понимается деятельность, направленная на достижение общественно полезных целей, способствующая решению социальных проблем граждан и общества. Социальное предприятие – это субъект малого и среднего предпринимательства, осуществляющий деятельность в сфере социального предпринимательства.

С 1 сентября 2020 года вступил в силу ФЗ РФ «О государственном (муниципальном) социальном заказе на оказание государственных (муниципальных) услуг в социальной сфере» [6], конечной целью которого является повышение доступности и качества социальных услуг.

В ряду нормативных регуляторов необходимо назвать многочисленные Постановления Правительства, которые, в частности: устанавливают правила проведения совместного, проводимого двумя и более уполномоченными органами конкурса в целях оказания одной и той же государственной (муниципальной) услуги в социальной сфере[2]; определяют структуру реестра исполнителей государственных (муниципальных) услуг в социальной сфере в соответствии с социальным сертификатом, порядок формирования информации, включаемой в реестр исполнителей услуг, а также порядок исключения исполнителя государственных (муниципальных) услуг в социальной сфере из реестра таких исполнителей[3]; закрепляют порядок формирования, ведения и размещения реестра соглашений о предоставлении из соответствующего бюджета бюджетной системы РФ субсидий[4]; регламентируют порядок формирования и утверждения государственных социальных заказов на оказание государственных услуг в социальной сфере; утверждают форму и структуру федерального социального заказа; закрепляют правила выбора способа определения исполнителя услуг, внесения изменений в федеральные социальные заказы, правила осуществления уполномоченным органом контроля за оказанием государственных услуг в социальной сфере[5]; устанавливают требования к содержанию предложений участников конкурса на заключение соглашения об оказании государственных (муниципальных) услуг в социальной сфере, к документам, которые могут быть истребованы у участников конкурса, особенности документооборота при проведении конкурса, порядок оценки

[2] Об утверждении правил заключения уполномоченными органами соглашения о проведении совместного конкурса на заключение соглашения об оказании государственных (муниципальных) услуг в социальной сфере: постановление Правительств РФ от 19.02.2021 г. № 224

[3] Об утверждении положения о структуре реестра исполнителей государственных (муниципальных) услуг в социальной сфере в соответствии с социальным сертификатом на получение государственной (муниципальной) услуги в социальной сфере и порядке формирования информации, включаемой в такой реестр, а также правил исключения исполнителя государственных (муниципальных) услуг в социальной сфере из реестра исполнителей государственных (муниципальных) услуг в социальной сфере в соответствии с социальным сертификатом на получение государственной (муниципальной) услуги в социальной сфере: Постановление Правительства РФ от 13.02. 2021г. № 183

[4] Об утверждении правил формирования, ведения и размещения реестра соглашений о предоставлении из соответствующего бюджета бюджетной системы российской федерации субсидий: Постановление Правительства от 01.02.2021 г. № 97

[5] О порядке формирования государственных социальных заказов на оказание государственных услуг в социальной сфере, отнесенных к полномочиям федеральных органов государственной власти, о форме и сроках формирования отчета об их исполнении: Постановление Правительства РФ от 19 ноября 2020 г. № 1891.

и ранжирования предложений, отбора нового исполнителя услуг в случае расторжения соглашения, заключенного по результатам конкурса[6]; и т.д.[7]

Особую роль в создании условий для развития социального предпринимательства играет законодательство субъектов Российской Федерации. В настоящий момент соответствующие законы приняты в 35 субъектах РФ. Они устанавливают различные меры поддержки социальных предпринимателей – от налоговых преференций до предоставления грантов.

Анализируя содержание режима социального предпринимательства, важно отметить, что ключевая цель установления режима социальных предприятий это поощрение такой деятельности, посредством установления стимулирующих и поощрительных мер, спецификой для социального предпринимательства является предоставление государственных мер поддержки. Установление такого особого благоприятствующего режима посредством закрепления мер государственной и иной поддержки характерно не только для России, но и для страна ЕС, США, Великобритании и Канады, Южной Кореи [7].

Показательным в этом плане является уже название статьи 24.1 ФЗ «О развитии малого и среднего предпринимательства в Российской Федерации», которой было введено в правовое поле понятие социального предпринимательства, а именно «Поддержка субъектов малого и среднего предпринимательства, осуществляющих деятельность в сфере социального предпринимательства».

К такой поддержке законом отнесены: обеспечение наличия инфраструктуры поддержки социальных предприятий, финансовая поддержка, в том числе предоставление субсидий, информационная, консультационная, методическая, имущественная поддержка, содействие

[6] Об утверждении правил проведения конкурса на заключение соглашения об оказании государственных (муниципальных) услуг в социальной сфере: Постановление Правительства РФ от 16 ноября 2020 г. N 1842.

[7] См., например: Об установлении дополнительных требований к условиям предоставления государственных (муниципальных) услуг в социальной сфере, доступности государственных (муниципальных) услуг в социальной сфере для инвалидов, штатной численности участника отбора исполнителей услуг (в том числе к наличию и численности работников, имеющих определенные образование и квалификацию), оснащению оборудованием, необходимым для оказания государственных (муниципальных) услуг в социальной сфере, а также требований к документам, которые могут быть истребованы у участников конкурса для подтверждения соответствия указанным дополнительным требованиям: Постановление Правительства РФ от 05.11.2020 № 1789; Об утверждении общих требований к определению предельных допустимых возможных отклонений от показателей характеризующих качество оказания государственной (муниципальной) услуги в социальной сфере и объем оказания такой услуги: Постановление Правительства РФ от 23.10.2020г. № 1728.

в развитии межрегионального сотрудничества, поиске деловых партнеров, организации профессионального обучения и образования.

Предоставление субсидий, грантов и налоговых льгот предусмотрено и законодательством субъектов.

Законом, открывающим новые возможности для социальных предприятий и позволяющим полноценно вовлекать их в развитие социальной сферы, является ФЗ РФ О государственном (муниципальном) социальном заказе. С 1 сентября 2020 года он реализуется в 16 пилотных регионах. Законом предусмотрено использование социального сертификата, дающего право гражданам самостоятельно выбрать организации, оказывающие им социальные услуги.

В 2020 году сведения о социальных предприятиях впервые были внесены в единый реестр малого и среднего бизнеса. Их количество в настоящий момент составило около 3 тысяч среди всех субъектов малого и среднего предпринимательства, которых по состоянию на 10 марта 2021 года в РФ насчитывается около 5 млн. 732 тыс[8]. Лидируют по числу официально зарегистрированных социальных предпринимателей Московская область (291 социальное предприятие), Ханты-Мансийский автономный округ – Югра (201), Республика Башкортостан (193), город Москва (190), Нижегородская область (161).

Понятие «социальное предпринимательство» многогранно, в доктрине под ним понимается предпринимательская деятельность, нацеленная на смягчение или решение социальных проблем, и характеризующаяся следующими основными признаками: социальное воздействие, инновационность, самоокупаемость и финансовая устойчивость, предпринимательский подход (Г.В. Ихсанова).[8] Так же социальное предпринимательство рассматривается как применение образа мыслей, процессов, инструментов и технологий обычного предпринимательства для деятельности на благо общества и экологии (И.А. Галкин).[9] С другой стороны А.А. Бурцева отмечает разницу между дефинициями «приносящей доход деятельности» и «социального предпринимательства» как основных видов деятельности социально-ориентированных организаций.[10] Кроме того, социальное предпринимательство понимается и как новаторская (Е.А. Ветрова[11], Я.С. Гришина[12]) и как организационная деятельность (Е.Л. Зуева, С.Ю. Ховаев).[13]

[8] https://rmsp.nalog.ru/statistics.html

Признак направленности предпринимательства в целом на систематическое получение прибыли идет вразрез как с идей социального предпринимательства, так и с его реальными возможностями. Отсутствие единого подхода к пониманию социального предпринимательства как особой категории ведет к проблемам правоприменения.

В доктрине гражданского права предлагается ряд идей, связанных с пониманием статуса социально ориентированных некоммерческих организаций и обоснованием необходимости выделения их в гражданском законодательстве в самостоятельную группу юридических лиц (А.А. Бурцева).[10] Такой подход представляется вполне обоснованным, так как субъекты, занимающиеся таким ответственным видом деятельности как социальное предпринимательство должны гарантировать качество предоставляемых услуг.

В целях создания развитых социально-экономических отношений в России, что достигается путем построением эффективных отношений между субъектами социального предпринимательства и благополучателями, необходимо уяснение содержания категории «социального предпринимательства».

Сегодня под социальным предпринимательством понимается как предпринимательская, так и иные виды деятельности, направленные на решение социальных проблем и стабильное социально-экономическое развитие общества. Вероятно, стоило бы вообще отказаться от понятия предпринимательства применительно к указанной сфере деятельности, поскольку его основной признак – получение прибыли – исключается из его итогового определения.

Библиографический список:

1. Бюджет для граждан. К Федеральному закону РФ о Федеральном бюджете 2018 года и на плановый период 2019 и 2020 годов. Министерство финансов РФ // URL: https://www.minfin.ru/common/upload/library/2017/12/main/BDG_2018_FINAL.pdf.

2. Новости Государственной Думы Федерального собрания РФ 8.11.2018 г. // URL: http://duma.gov.ru/news/28728/.

3. О Концепции долгосрочного социально-экономического развития РФ на период до 2020 года: Распоряжение Правительства РФ от 17 ноября 2008 г. № 1662-р // Собрание законодательства РФ, 2008. №47. Ст. 5489.

4. Стратегия развития малого и среднего предпринимательства в Российской Федерации на период до 2030 года, утв. распоряжением правительства РФ от 02.06.2016г. № 1083-р. // СПС «Консультант плюс».

5. Пояснительная записка к проекту Федерального закона «О государственном (муниципальном) социальном заказе на оказание государственных (муниципальных) услуг в социальной сфере» // https://sozd.duma.gov.ru/download/E5A60C06-9D0F-4F6C-975E-0C79615AE03C

6. Федеральный закон Российской Федерации «О государственном (муниципальном) социальном заказе на оказание государственных (муниципальных) услуг в социальной сфере» от 13.07.2020 № 189 ФЗ // Электронный ресурс [http://publication.pravo.gov.ru/Document/View/0001202007130053] дата обращения 03.08.2020.

7. Правовое обеспечение социального предпринимательства / Барков А.В., Гришина Я.С., Золотова О.А., Лескова Ю.Г., Морозов С.Ю., Писарев Г.А. Учебное пособие для магистрантов. Ульяновский государственный университет. Ульяновск, 2019. Сер. Магистры права.

8. Ихсанова Г.В. Правовые аспекты социального предпринимательства: зарубежный и российский опыт // URL: http://old.fa.ru/projects/mnsk/.pdf

9. Галкин И.А. Социальное предпринимательство как условие социально-экономического развития // URL: https://docviewer.yandex.ru/view/&lang=ru

10. Бурцева А.А. Социально-ориентированные некоммерческие организации - гражданско-правовое регулирование их статуса и деятельности: предложения по совершенствованию теории и законодательства // Черные дыры в российском законодательстве, 2012. № 5. С. 55-57.

11. Ветрова Е.А. Социальное предпринимательства как фактор развития общества // URL: https://cyberleninka.ru/article/v/sotsialnoe-predprinimatelstvo-kak-faktor-razvitiya-obschestva

Дотоод хэргийн их сургуулийн хувийн эрх зүйн тэнхимийн багш, докторант, цагдаагийн хошууч
Batjargal G.
Lecturer of Department of private law, of Law and Social Science Institute, University of Internal Affairs, Ph.D student, Police Major

Хураангуй: *Иргэний эрх зүй дэх гэрээ, үүргийн гүйцэтгэлтэй холбоотой маргааныг залилах гэмт хэргээс ялгаж зүйлчлэхэд анхаарах асуудал мөн эрх зүйн орчин болон шүүхийн практикт дүн шинжилгээ хийж, сүүлийн үед үйлдэгдэж байгаа гэрээгээр халхавчилсан залилах гэмт хэргийн онцлог шинжийн талаар авч үзсэн.*

Abstract: *This paper addresses the issue of differentiating disputes related to the implementation of contracts and obligations in civil law from fraud as well as an analysis on the civil legal environment and judicial practice and the specifics of recent contract-covered fraud.*

Түлхүүр үгс: *Хууран мэхэлж хийсэн хэлцэл, залилах гэмт хэрэг, үүргийн гүйцэтгэлд саад болох нөхцөл байдал*

Keywords: *Agreement with fraudulent, fraudulent and circumstances that impede obstacles for implementation of the obligations*

Үндсэн хэсэг

Монгол Улсын Үндсэн хуулийн[1] 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөө зөрчихтэй тэмцэх,

[1]Монгол Улсын Үндсэн хууль. Төрийн мэдээлэл. УБ., №1

хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна", 16 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт "Монгол Улсын иргэн хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй" гэж заасан нь иргэний өмчлөх эрхийн үндэс суурийг Үндсэн хуулиар баталгаажуулсан явдал юм.

Эд хөрөнгийг шударгаар олж авах гэдэг нь хууль зүйн утгаараа хууль буюу гэрээний үндсэн дээр өөртөө эд хөрөнгө бий болгох үйл явц юм. Гэтэл иргэн, хуулийн этгээдийн хууль ёсны өмчлөх эрхэд халдаж буй эрүү, иргэний хэрэг маргаан тэр дундаа залилах гэмт хэрэг ихээр үйлдэгдэж, түүний улмаас учирч буй хохирол сүүлийн жилүүдэд эрс нэмэгдэх болсныг хууль сахиулах болон шүүх эрх мэдлийн байгууллагуудын тайлангаас харж болно.

Залилах гэмт хэргийн үйлдэгдэж буй байдлыг бүртгэгдсэн гэмт хэргийн түвшинд сүүлийн 6 жилийн байдлаар буюу 2016 оноос хойшхи үзүүлэлтийг авч үзвэл нийт 25'142 гэмт хэрэг бүртгэгдсэнээс 2016 онд нийт 2165[2] залилах гэмт хэрэг бүртгэгдсэн, 2017 онд 2996[3] гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх онтой харьцуулахад 27.8 хувиар өссөн үзүүлэлт юм. 2018 оны байдлаар нийт бүртгэгдсэн залилах гэмт хэрэг 5372[4] байх бөгөөд энэ нь өмнөх онтой харьцуулахад 79 хувиар өссөн, 2019 онд нийт 4688[5] залилах гэмт хэрэг бүртгэгдсэн ба өмнөх онтой харьцуулахад энэ нь 12.7 хувиар буурсан үзүүлэлт юм. Мөн 2020 онд нийт 4044[6] залилах гэмт хэрэг бүртгэгдсэн байгаа нь өмнөх онтой харьцуулахад 13.7 хувиар буурсан үзүүлэлттэй байгаа нь улсын хэмжээнд бүх нийтийн бэлэн байдал тогтоосон цар тахлын хөл хорионы дэглэмтэй холбоотой байж болох талтай хэмээн судлаачдын зүгээс харж байна.

Харин энэ жил буюу 2021 оны эхний 11 сарын байдлаар нийт 6147[7] залилах гэмт хэрэг бүртгэгдсэн ба энэ нь өмнөх онтой харьцуулахад

---

[2]https://police.gov.mn/resource/policegovmn/media/Statistic_medee/2016_12_sar_medee/2016.12_burtgegdsen_gemt_hereg.pdf Цагдаагийн байгууллагын хэмжээнд 2016 онд бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн мэдээ. Сүүлд үзсэн: 2021.12.10

[3]https://police.gov.mn/resource/policegovmn/media/Statistic_medee/2017_12_sar_medee/2017.12_sar_Burtgegdsen_gemt_hereg.pdf Цагдаагийн байгууллагын хэмжээнд 2017 онд бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн мэдээ. Сүүлд үзсэн: 2021.12.10

[4]https://police.gov.mn/resource/policegovmn/File/2019/01/08/go8kd8smlvmred5n/2018.12%20sar%20medee%20Burtgegdsen%20hereg.pdf Цагдаагийн байгууллагын хэмжээнд 2018 онд бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн мэдээ. Сүүлд үзсэн: 2021.12.10

[5]https://police.gov.mn/resource/information/File/2020/01/06/w3fp8kgj5qn65l7n/2019.12%20sar%20Burtgegdsen%20gemt%20hereg.pdf Цагдаагийн байгууллагын хэмжээнд 2019 онд бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн мэдээ. Сүүлд үзсэн: 2021.12.10

[6]https://police.gov.mn/resource/information/File/2021/01/06/6mom96u9hprz309d/%D1%81%D0%B0%D0%B9%D1%82%20%D0%BC%D1%8D%D0%B4%D1%8D%D1%8D-%D1%85%D1%8D%D1%80%D1%8D%D0%B3.pdf Цагдаагийн байгууллагын хэмжээнд 2020 онд бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн мэдээ. Сүүлд үзсэн: 2021.12.10

[7]https://police.gov.mn/a/5737 Цагдаагийн байгууллагын хэмжээнд 2021 оны эхний 11 сард бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн мэдээ. Сүүлд үзсэн: 2021.12.10

52 хувиар нэмэгдсэн байгаа нь энэ төрлийн гэмт хэрэг хэрхэн өсч, түүний нийгмийн хор аюул төдий хэмжээгээр ихэсч буйг илтгэнэ.

Дээр дурдсан нийт 25142 залилах гэмт хэргээс шүүхээр хянан шийдвэрлэгдсэн 2392[8] эрүүгийн хэрэг байгаа бөгөөд 2016 онд 1 хэрэг, 2017 онд 88 эрүүгийн хэрэг шийдвэрлэгдсэн ба анхан шатны шүүхээр 76, давж заалдах шатны шүүхээр 10, хяналтын шатны шүүхээр 2 эрүүгийн хэрэг тус тус хянан шийдвэрлэгджээ. Харин 2018 онд шүүхээр нийт 405 хэрэг хянан шийдвэрлэгдсэнээс анхан шатны шүүхээр 324, давж заалдах шатны шүүхээр 65, хяналтын шатны шүүхээр 16 хэрэг хянан шийдвэрлэгдсэн. 2019 онд шүүхээр нийт 669 эрүүгийн хэрэг шийдвэрлэгдсэн ба үүнээс анхан шатны шүүхээр 537, давж заалдах шатны шүүхээр 109, хяналтын шатны шүүхээр 23 хэрэг шийдвэрлэгдсэн бол 2020 оны байдлаар нийт 582 хэрэг хянан шийдвэрлэгдэж үүнээс анхан шатны шүүхээр 442, давж заалдах шатны шүүхээр 115, хяналтын шатны шүүхээр 25 хэрэг тус тус шийдвэрлэгдсэн байна.

Харин 2021 оны эхний 11 сарын байдлаар шүүхээр хянан шийдвэрлэгдсэн өмчлөх эрхийн эсрэг эрүүгийн хэрэг нийт 647 байгаа бөгөөд үүнээс анхан шатны шүүхээр 514, давж заалдах шатны шүүхээр 119, хяналтын шатны шүүхээр 16 хэрэг шийдвэрлэгджээ. Хяналтын шатны шүүхээр хянан хэлэлцэж шийдвэрлэгдсэн байдлыг авч үзвэл давж заалдах шатны шүүхийн магадлалыг хэвээр үлдээсэн нийт 8[9] тогтоол, хэргийг хэрэгсэхгүй болгож, шүүгдэгчийг цагаатгасан нийт 2 тогтоол, магадлалыг хүчингүй болгон шийдвэрлэсэн нийт 4[10], магадлалын тодорхой хэсэгт өөрчлөлт оруулан хэвээр үлдээсэн нийт 2 тогтоолыг тус тус Улсын дээд шүүхээс гарсан байна.

Залилах гэмт хэргийн гаралт түүнд ял шийтгэгдэж буй иргэдийн тоо жил ирэх тусам хурдтайгаар өссөөр байгаа нь ажилгүйдэл, ядуурал зэрэг нийгмийн суурь шалтгаан төдийгүй цар тахлын үеийн хөл хорио, хязгаарлалт, цахим орчны хяналтгүй мэдээллийн урсгал, сурталчилгаа, цахим худалдан авалт, сүлжээний бизнес, зуучлалын үйл ажиллагаа ихэссэн мөн амар хялбар аргаар баяжих, мөнгөтэй болох хүсэлтэй хүмүүс олширсон, иргэдийн эрх зүйн мэдлэг, ухамсар дутмаг зэрэг нийгэм, эдийн засаг, технологийн хөгжлийн гэх мэт маш олон хүчин зүйлээс улбаатай бөгөөд төрөөс энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, өмчлөгчийн эрхийг хамгаалах нэгдсэн бодлого хэрэгжүүлэх шаардлага урган гарч байна.

[8]https://shuukh.mn/cases/2/3 Монгол Улсын шүүхийн шийдвэрийн цахим сан. Сүүлд үзсэн: 2021.12.10 14:26
[9]https://shuukh.mn/cases/2/3 Монгол Улсын шүүхийн шийдвэрийн цахим сан. Сүүлд үзсэн: 2021.12.10 14:29
[10]Мөн тэнд

Үүнтэй холбоотой тулгамдаж буй асуудлын нэг нь залилах гэмт хэргийг иргэний эрх зүйн маргаанаас ялган зүйлчлэх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, нэг мөр ойлгох, хэрэглэх явдал юм.

Хууль хэрэглэх практикт энэ төрлийн адил үйлдэлд эрүүгийн хэрэг үүсгэх эсхүл иргэний эрх зүйн маргаан гэж үзэн эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзаж байгаа тохиолдол маш ихээр гарах боллоо. Өөрөөр хэлбэл энэ асуудалд хууль зүйн хувьд өнөөгийн нийгэмд ихээр хэрэглэгдэж байгаа “double standart” үүсээд олон жил болж байна. Үүний сөрөг үр дагавар нь залилах гэмт хэрэг үйлдэгчид өөрийн гэмт хэргээ гэрээ хэлцэл байгуулсан гэж эрүүгийн хариуцлагаас мултарч ял завших нөгөө талаас хэлцэл хийсэн этгээд гэрээний үүргээ биелүүлэх боломжгүй болсон нөхцөлд залилах гэмт хэргийн субьект болж хилсдэх тохиолдол практикт цөөнгүй байна.

Хуулийн практикт гэрээ байгуулсан тохиолдолд залилах гэмт хэрэг болохгүй гэсэн алдаатай түгээмэл ойлголтыг аль хэдийн өөрчлөх, өөр хандлагаар харах цаг болсон байна. Сүүлийн үед үйлдэгдэж байгаа залилах гэмт хэргийн нийтлэг дүр зургийг харвал иргэний эрх зүйн төрөл бүрийн гэрээн дээр үндэслэсэн, нийтэд зарлаж сурталчилсан, олон нийтийг хамарсан, *“албан ёсны”* шинжтэй болсон байна. Виртуал хөрөнгийн зах зээлд олон төрлийн “койн” гарч ирж байгаа энэ цаг хугацаанд олон хүнийг хамарсан их хэмжээний мөнгөний (2 их наяд гаруй) эргэлттэй, манай улсад хууль эрх зүйн орчин бүрдээгүй[11] маш их эрсдэлтэй, учирсан хохирлыг төр хариуцахгүй гэдгийг “Монгол банк” болон төрийн эрх бүхий бусад байгууллагуудаас анхааруулсаар байхад нэмж “койн”-ууд шинээр гарч иргэдийн худалдан авалт улам ихэссээр байгаа нь хадгаламж зээлийн хоршооны олон хохирогчтой, их хэмжээний хохиролтой эрүүгийн хэргийн түүх давтагдахгүй гэсэн баталгаа алга байна.

Түүнчлэн үл хөдлөх эд хөрөнгийн зуучлалын олон улсын хэмжээний сүлжээ байгууллага болох “Remax”-ын Монгол Улс дахь салбартай холбоотой иргэд үл хөдлөх эд хөрөнгө худалдан авахаар их хэмжээний мөнгөө залилуулж орон байрандаа орж чадахгүй байгаа тохиолдлууд багагүй гарсан[12], мөн “Нарны хүү сарны охин” ХХК, “G Time” сүлжээний зэрэг мөрдөн байцаалт, шүүхийн шатанд олон жил болж байгаа хохирогчдын аргыг барж, туйлдуулж байгаа олон эрүүгийн хэргүүдийг дурьдаж болно.

Залилах гэмт хэрэг үйлдэгчдийн арга улам нарийсч хэлцлээр халхавчилсан, сүлжээний, олон хохирогчийг хамарсан шинжтэй болж

[11]“Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэх тухай” хуулийн төсөл боловсруулагдсан, батлагдан гараагүй байгаа.
[12]Туг.mn Хохирогчдын цуврал сурвалжлага, ярилцлага

байгаа нь энэ төрлийн гэмт хэргийг шалгаж шийдвэрлэж байгаа хуулийн байгууллагын ажилтнуудаас эрх зүйн өндөр мэдлэг ур чадварыг шаардах болов. Энэ талаар олон эрдэмтэн, судлаач, практик ажилтнууд судлан авч үзэж өөрийн үзэл бодлоо илэрхийлсэн байна.

Иргэний эрх зүйн талаас авч үзвэл хэлцэл нь иргэний эрх, үүргийг үүсгэх, өөрчлөх, дуусгавар болгоход чиглэсэн, хэлцэл хийгч этгээдийн хүсэл зоригийн илэрхийлэл болсон, эрх зүйн дагуух үйлдэл, үйл ажиллагаа юм. Хэлцэлд агуулга болон хэлбэрийн шаардлага тавигддаг.

Агуулгын хувьд: 1.*Хуульд нийцсэн байх* (Хуульд заасан шаардлагыг зөрчиж хийсэн хэлцэл хүчин төгөлдөр бус байдаг), 2.*Субьектын хүсэл зоригийн илэрхийлэл болсон үйлдэл байдаг учраас хэлцэл хийгч этгээд нь хэлцлийг хийх эрхийн чадвар чадамжтай байх*, 3.*Хүсэл зориг ба түүний илэрхийлэл нь бодитой сайн дурынх байхыг* шаарддаг.

Хэлбэрийн хувьд амаар, бичгээр, бодит үйлдлээр хийгдэж болдог. Иргэний эрх зүй дэх хэлцлийг эдийн засаг болон эрх зүйн тодорхой үр дагаварыг бий болгохын тулд иргэн хуулийн этгээд хооронд байгуулдаг.

Харин Эрүүгийн эрх зүйн талаас авч үзвэл Эрүүгийн хуулийн[13] 17 дугаар зүйлийн 17.3 дахь хэсгийн 1 дэх заалтад залилах гэмт хэргийн үйлдлийн аргыг:

1. Хуурах,
2. Баримт бичиг, эд зүйл, цахим хэрэгсэл ашиглах,
3. Зохиомол байдлыг зориудаар бий болгох,
4. Сүсэг бишрэлийг далимдуулах,
5. Бодит байдлыг нуух замаар бусдыг төөрөгдөлд оруулах,
6. Нэр хүнд, урьдын харилцааны явцад бий болсон итгэлийг урвуулан ашиглах хэмээн нарийвчлан тодорхойлжээ.

Энэ гэмт хэргийн обьектив тал: Бусдын эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг шилжүүлэн авсан идэвхтэй үйлдэл байх ба хохирлын хэмжээ шаардахгүй буюу хэлбэрийн шинжтэйгээр хуульчилсан. Өөрөөр хэлбэл, хуульд заасан аргаар бусдын эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг шилжүүлэн авснаар энэ гэмт хэрэг төгсөнө.

Эрүүгийн хуулийн 17.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт залилах гэмт хэрэг үйлдэх аргыг заасан учраас обьектив талын үндсэн шинжийг илэрхийлж, гэмт хэргийн зүйлчлэлд нөлөөлнө. Өөрөөр хэлбэл, гэмт этгээд гэмт хэргийг хуурах, эсхүл баримт бичиг, эд зүйл, цахим хэрэгсэл ашиглах, эсхүл зохиомол байдлыг зориудаар бий болгох, сүсэг бишрэлийг далимдуулах, бодит байдлыг нуух замаар бусдыг төөрөгдөлд оруулах, эсхүл нэр хүнд, урьдын харилцааны явцад бий болсон итгэлийг урвуулан

[13]Эрүүгийн хууль /Шинэчилсэн найруулга/ Төрийн мэдээлэл. УБ., 2015 он, №7

ашиглах аргаар үйлдсэн байна. Эдгээр аргаас өөр аргаар (хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлэх, хүч хэрэглэхээр заналхийлж довтлох гэх мэт) бусдын эд хөрөнгийг авсан бол залилах гэмт хэрэг үйлдсэн гэж үзэхгүй бөгөөд өмчлөх эрхийн эсрэг бусад гэмт хэргээр зүйлчилнэ.

Гэмт хэргийн обьектив талын шинж болох үйлдлийн аргыг диспозицид заасан нь өмчлөх эрхийн эсрэг бусад гэмт хэрэг, иргэний эрх зүйн зөрчлөөс энэ гэмт хэргийг ялган зүйлчлэхэд ач холбогдолтой.

Бусдын эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг шилжүүлэн авсан гэж хуульд заасан арга хэрэглэж, хохирогчийг төөрөлдүүлсний үндсэн дээр түүний зөвшөөрлийн дагуу хариу төлбөргүйгээр бусдын эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг өөрийн өмчлөлд хууль бусаар авах үйлдлийг хэлнэ.

Хуурах гэж бусдын эд хөрөнгө, өмчлөх эрхийг өөртөө хууль бусаар олж авахын тулд үгээр буюу үйлдлээр эзэмшигч, өмчлөгчийг төөрөлдүүлэхийг ойлгоно.

Баримт бичиг, эд зүйл, цахим хэрэгсэл ашиглах гэж бусдын эд хөрөнгө, өмчлөх эрхийг өөртөө хууль бусаар авахын тулд хуурамч бичиг баримт, эд зүйл, цахим хэрэгсэл, цахим сүлжээ, цахим мэдээлэл, дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэг, техник хэрэгсэл ашиглах, тусгай албаны хувцас, хэрэглэл, цол, тэмдэг хэрэглэж зориудаар төөрөгдүүлэх, дутуу буюу зориулалтын бус, эсхүл хуурамч буюу чанарын доголдолтой эд зүйлээр төлбөр хийх зэргийг ойлгоно.

Зохиомол байдлыг зориудаар бий болгох гэж эд хөрөнгийн эзэмшигч, өмчлөгчийг төөрөгдүүлэх, хууран мэхлэхийн тулд зохиомол байдлыг зориуд бий болгохыг ойлгоно.

Сүсэг бишрэлийг далимдуулах гэж бусдын эд хөрөнгө, өмчлөх эрхийг өөртөө хууль бусаар авахын тулд хохирогчийн сүсэг бишрэл, шашны итгэл үнэмшлийг ашиглан төөрөгдүүлэхийг хэлнэ.

Бодит байдлыг нуух замаар бусдыг төөрөгдөлд оруулах гэж дампуурсан, үйл ажиллагаа нь зогссон, санхүүгийн алдагдалтай, хөрөнгө оруулалт шаардлагатай байдлыг нуух, хуурамч аудитын дүгнэлт гаргуулах зэргээр бусдыг төөрөгдүүлж, эд хөрөнгө, эд хөрөнгийг өмчлөх эрхийг шилжүүлэн авахыг ойлгоно.

Нэр хүнд, урьдын харилцааны явцад бий болсон итгэлийг урвуулан ашиглах гэдгийг шууд ойлгож хэрэглэнэ. Тухайлбал урьд нь эрхэлж байсан ажил, албан тушаал, нэр хүндийг ашиглах, олон жил хамтран бизнес хийсэн, гэрээт борлуулагчаар ажилласан, олон жилийн өмнөөс бие биеэ мэдэх болсон байдал, итгэлийг урвуулах зэрэг хэлбэртэй байж болно.

Субьектив тал: Гэм буруугийн санаатай хэлбэрээр үйлдэгдэнэ. Бусдын эд хөрөнгө, өмчлөх эрхийг буцааж өгөхгүй, хариу төлбөр огт хийхгүй, эсхүл хагасыг нь хийнэ гэсэн субьектив санаа зорилго гэмт

этгээдийн хувьд гэмт үйлдлээ хэрэгжүүлж эхлэхээс өмнө бий болсон байдгаараа залилах гэмт хэрэг нь гэрээний эрх зүйн маргаанаас ялгагдана.

Субьект: Эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан16 насанд хүрсэн, хэрэг хариуцах чадвартай, тухайн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхгүй Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харъяалалгүй хүн, хоёрдмол харъяалалтай хүн байна.[14]

Эрүүгийн хуулийн 17.3 дугаар зүйлтэй агуулга ижил зохицуулалтыг Иргэний хуулийн[15] 58, 59 дүгээр зүйлүүдэд зааж өгсөн байна. Иргэний хуулийн 58-р зүйлд ноцтой төөрөгдлийн улмаас хийсэн хэлцлийн талаар зохицуулсан. Энэ хэлцэл нь хэлцэл хийгч этгээд (нэхэмжлэгч) нь а/хэлцэл хийхдээ хүссэн хэлцлээсээ өөр хэлцлийг зөвшөөрөн хийх, б/агуулгын хувьд төөрөгдөх, в/сэдэлтийн хувьд төөрөгдөх, г/шинж байдлын талаар төөрөгдөх, д/эрхийн талаар төөрөгдөх зэргээр хохирсон этгээдээс хамааралтай түүний болгоомжгүй үйлдлээс шалтгаалдаг тул уг хэлцлийг залилангийн гэмт хэрэг гэж үзэх үндэсгүй.

Харин Иргэний хуулийн 59-р зүйлд зааж өгсөн “хууран мэхэлж хийсэн хэлцэл” нь залилах гэмт хэрэгтэй агуулгын хувьд адил төстэй байдлаар хуульчлагдсан. Хэлцэл хийх зорилгоор бусдыг хууран мэхэлсэн бол мэхлэгдсэн этгээд уг хэлцлийг хүчин төгөлдөр бус гэж тооцуулахаар шаардах эрхтэй. Энэ нь хууран мэхлэгч этгээд бодит нөхцөл байдлын талаар ташаа зүйл баталж, нотлохыг чухалчилна. Мөн хууран мэхлэх үйлдэл эсхүл мэдээллэх үүргээ зөрчин бодит үнэн нөхцөл байдлыг нуун дарагдуулах эс үйлдэхүйгээр илэрч болдог. Энэ хэлцэл нь зарим тохиолдолд залилах гэмт хэргийн шинжийг агуулж байдаг.

Хэлцэл хийх зорилгоор нэг этгээд нь нөгөөгөө санаатай төөрөгдүүлсэн бол хууран мэхэлсэн гэж үзнэ. Хууран мэхлэлт нь хэлцлийн элементүүдийн хувьд төдийгүй хэлцэл хийхэд хүргэсэн нөхцөл байдлуудад нэгэн адил хамаарна.

Энд дурьдсан үндэслэлээр хэлцлийг хүчин төгөлдөр бус гэж тооцоход хууран мэхэлсэн нь идэвхтэй үйлдэл (бодит байдлын талаар зориуд буруу төсөөлөл өгөх зорилгоор худал мэдээлэх), идэвхгүй эс үйлдэл (хэлцэл хийгч нэг тал нь мэдсэн бол хэлцэл хийхгүй байх байсан тийм мэдээ баримтыг хэлэлгүй зориуд санаатай дуугүй өнгөрөх)-ийн хэлбэрээр илэрч болно. Хэлцэл хийхэд нөлөөлөх нөхцөл байдлын талаар гуравдагч этгээд хэлцэл хийгч нэг талын хүсэлтээр буюу санаатайгаар нөгөө талд нь худал мэдээлэл өгсөн бол мөн адил хууран мэхэлсэн гэж

[14] С.Гантулга, Б.Энхболд. Эрүүгийн эрх зүй: тусгай анги /сурах бичиг/. Нэмж засварласан хоёр дахь хэвлэл Улаанбаатар 2020 он 163 дахь тал
[15]Иргэний хууль. Төрийн мэдээлэл. УБ., 2002 он №7

үзнэ. Хууран мэхэлсэн этгээд түүнийхээ төлөө эрүүгийн хариуцлага хүлээсэн эсэх, мөн хууран мэхлэгч нь ямар зорилгоор хууран мэхэлсэн зэрэг нь хэлцлийг хүчин төгөлдөр бус гэж шүүх тооцоход харгалзан үзэх үндэслэл болохгүй.

Ялангуяа практикт түгээмэл тохиолддог иргэний эрх зүйн харилцаанд үүсдэг хууран мэхэлж хийсэн хэлцлийн тухайд Иргэний хуулийн 59-р зүйлийн 59.1 дэх хэсэгт “Хэлцэл хийх зорилгоор бусдыг хууран мэхэлсэн бол мэхлэгдсэн этгээд уг хэлцлийг хүчин төгөлдөр бус гэж тооцуулахаар шаардах эрхтэй. Энэ тохиолдолд хууран мэхэлсэн этгээд ашиг хонжоо олох, эсхүл мэхлэгдсэн этгээдэд гэм хор учруулах зорилготой байсан эсэх нь хэлцлийг хүчин төгөлдөр бус гэж тооцоход нөлөөлөхгүй.” гэж заасан нь хууран мэхэлж гэрээ байгуулсан асуудал нь тэрхүү үүссэн харилцааг эрүүгийн залилах *гэмт хэргээр шалгах боломжийг огтоос хязгаарлахгүй* бөгөөд гагцхүү тухайн гэрээг сонирхогч этгээдээс хүчин төгөлдөр бусад тооцуулж болох хууль зүйн үндэслэл юм. Тиймээс хууран мэхлэгч этгээд ашиг хонжоо олох, баяжих, эсхүл мэхлэгдсэн этгээдийн өмчид гэм хор учруулах зорилготой байсан эсэх нь чухал биш бөгөөд хохирогчийн өмчийг бус харин хүсэл зоригоо чөлөөтэй илэрхийлэх эрх, эрх чөлөөг хамгаалдагаараа[16] залилангийн гэмт хэргээс ялгагдах мөн чанарыг илэрхийлдэг.

Гэрээгээр халхавчилсан залилан гэдэг нь залилан мэхлэх гэмт хэргийг үйлдэхдээ гэрээний төрлийг ашиглаж үйлдэж байгаа аргын нэг юм. Гэрээний харилцаа нь 2 талын итгэлцэл байдаг тул итгэлцлийг алдаж, итгэлийг эвдсэн үйлдэл нь залилан мэхлэх гэмт хэрэг болохгүй. Өөрөөр хэлбэл зохих ёсоор гүйцэтгэх үүргээ хэрхэн биелүүлж байгаа болон түүнд хандаж байгаа хандлагаас шалтгаална. Тухайлбал: гэрээ анхнаасаа биелэгдэх боломжгүй, зээлийг буцааж төлөх бодит баталгаагүй, барьцааны хөрөнгөгүй, хөрөнгө нь эрхийн зөрчилтэй, тухайн эд хөрөнгийг барьцаалах бүрэн эрхгүй этгээд барьцаалсан, хуурамч бичиг, баримт ашиглан гэрээг байгуулсан, үүнийг гэрээний нэг тал мэдсээр байж санаатайгаар нуун далдалж бусдын эд хөрөнгийг завшиж ашиглан хууль бусаар захиран зарцуулах эрх үүсгэдэг. Гэрээний үүргийн биелэлтийг үүрэг гүйцэтгэгч анхнаасаа биелүүлж чадахгүй, хангах боломжгүй байдлыг санаатайгаар нуун дарагдуулсан үүнийг гэрээний нөгөө тал мэдээгүй буюу мэдэх боломжгүй байдаг нь залилан мэхлэх гэмт хэрэг болно. Иргэний эрх зүйн хууран мэхэлж хийсэн хэлцэл нь тухайн гэрээ, хэлцлийг хийхдээ бодит байдлыг гуйвуулан тухайн этгээдийг төөрөгдүүлэн хэлцэл хийх эрх чөлөөг нь хязгаарладгаараа залилан мэхлэх гэмт хэргээс ялгаатай. Жишээ нь санал бодол, үзэмж, байр суурь, зар сурталчилгаа, гоёж

[16]Монгол Улсын Иргэний хуулийн тайлбар. УБ. 2010 он. 110 дахь тал

чимсэн магтаал эсхүл нийтлэг яриа, хэллэг орно. Өөрөөр хэлбэл мэхлэгдсэн этгээд хэлцлийн талаар төөрөгдсөн байдаг. Зээлийн гэрээ, зээлээр худалдах худалдан авах гэрээ, барьцааны гэрээний хувьд хуульд заасан зохих журмын дагуу байгуулагдсанаар үүргийн эрх зүйн харилцаа үүснэ. Үүрэг гүйцэтгэгч гэрээний үүргээ санаатай болон болгоомжгүй хэлбэрээр зөрчсөн тохиолдолд хуульд заасан хариуцлагын, өөрөөр хэлбэл, шаардах эрхийн хэмжээг нэмэгдүүлэх болон түүнийг хязгаарлах эсэхээ талууд чөлөөтэй тохиролцож болно[17]. Энэ нь гэрээний чөлөөт байдлын зарчимтай холбоотой. Үүргээ биелүүлэх боломжгүй болох тохиолдол бүрийг анхаарах ёстой. Энд гэрээний ердийн эрсдэл, гэрээ байгуулагдсанаас хойш нөхцөл байдал ноцтой өөрчлөгдсөн, эсхүл энэ нөхцөл байдлын талаарх талуудын төсөөлөл буруу ташаа болох нь илэрхий болсон, үүрэг гүйцэтгэх хугацаа хэтрэх зэрэг нь үүрэг гүйцэтгэхэд учирсан нөхцөл гэж иргэний эрх зүйд үзэж үүний улмаас учирсан хохирлоо нөхөн төлүүлэх эрх үүсдэг онцлогтой.

Залилан мэхлэх гэмт хэргийн гол онцлог нь гэмт этгээд бусдын эзэмшилд байгаа эд хөрөнгийг өөрийн мэдэлд авч, анхнаасаа эргэж хэзээ ч өгөхгүй гэсэн санаа бодол төрсөн байдаг боловч мөн гэрээгээр хүлээсэн үүрэг нь биелэгдэх боломжгүй болмогц түүгээр шалтаглаж бусдын эд хөрөнгө, эсхүл түүнийг өмчлөх эрхийг бүгдийг буюу заримыг шилжүүлэхгүй байх гэмт санаа зорилго төрж, үүнийгээ хэрэгжүүлэхийн тулд эзэмшигч, өмчлөгчийг төөрөгдүүлэх замаар хуурч мэхлэх, итгэл эвдэх, тодорхой үйлдэл хийсэн нь хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааны явцад тогтоогдвол залилан мэхлэх гэмт хэрэг гэж үзэж эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ[18] гэж тайлбарласан байдаг. Доктор Д.Адьяабазар өөрийн бүтээлдээ[19] залилан мэхлэх гэмт хэргийг иргэний эрх зүйн төстэй харилцаанаас ялгахад үйлдлийн арга биш субьектив санаа зорилгоор ялгаатай гэж үзсэн байдаг бол залилан мэхлэх гэмт хэргийн субьектив гол шинж буюу гэмт этгээдээс гаргаж буй санаа зорилгыг хөдөлбөргүй тогтоох нь онцгой чухал. Энэхүү нөхцөл байдлыг тогтоохдоо ялангуяа хохирогчийн итгэл үнэмшлийг олж авсан арга, гэмт этгээдийн амласан, болзол болгосон зүйл, ажил үйлчилгээ нь бодит байдал дээр биелэгдэх, хэрэгжих боломжтой эсэх, тохиолдлын чанартай бэрхшээл тулгарсан нь үнэн эсэх, уг этгээд урьд нь тухайн төрлийн болон өөр төрлийн гэмт хэрэг үйлдэж байсан эсэхийг тогтоох шаардлагатай[20] гэж үзжээ.

---

[17]“Иргэний хуулийн тайлбар” албан бус тайлбар УБ,2006 он, 846 тал

[18]Улсын Дээд шүүхийн 51 дүгээр тогтоолын 7 дугаар хэсэг

[19]Д.Адъяабазар. “Монгол Улсад залилан мэхлэх гэмт хэрэгтэй хийх эрүүгийн эрх зүйн тулгамдсан асуудал” хууль зүйн докторын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл 2004 он 141 дэх тал

[20]“Криминалистикийн тактик” ред. Ж.Болдбаатар, УБ. 2001 он. 252 дахь тал

Ингэж хохирол учруулсан этгээдийн санаа зорилго, үйлдлийн аргаас гадна бусдад хэлж амлаж байсан зүйл нь хэрэгжих бодит боломжтой байсан уу гэдгийг шалгаж тогтоох нь практикт орхигдож байгаа асуудлын нэг юм. Залилах гэмт хэргийн үндсэн шинжид гэмт этгээд бусдын эд хөрөнгийг итгэл төрүүлэх, хуурч мэхлэх, аргаар авахын зэрэгцээ уг эд хөрөнгийг буцаан төлөх, хариу төлбөр хийхгүйгээр өөрийн болгох зорилготой байдгаараа иргэний эрх зүйн аливаа харилцаанаас ялгагддаг.[21] Гэрээний харилцаа нь Иргэний хууль, тогтоомжийн дагуу үүсч, гэрээний биелэлтийн талаар мэдээлэл солилцож, харилцан гомдлын шаардлага гаргаж, гэрээгээ дүгнэж байсны эцэст эрсдэлд орсны улмаас үүссэн маргааныг, өөрөөр хэлбэл гэрээний эрсдэлийг залилан мэхлэх гэмт хэрэг гэж үзэхгүй.

Харин өөр этгээдийн өмчлөл, эзэмшилд байгаа эд юмс, түүнийг хуулиар тогтоосон хэмжээ, хязгаарын дотор өөрийн үзэмжээр чөлөөтэй эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхийг зөрчиж, үгээр буюу үйлдлээр бодит байдлыг гуйвуулах замаар эзэмшигч, өмчлөгчийг төөрөлдүүлсний үндсэн дээр түүний зөвшөөрлийн дагуу хариу төлбөргүйгээр, өөрийн өмчлөлд авч байгаа, шунахай сэдэлтэй, шууд санаатай үйлдлээс гадна гэрээгээр хүлээсэн үүрэг нь биелэгдэх боломжгүй болмогц түүгээр шилжүүлэхгүй байх гэмт санаа зорилго төрж, үүнийгээ хэрэгжүүлэхийн тулд эзэмшигч, өмчлөгчийг төөрөгдүүлэх замаар хуурч мэхлэх, итгэл эвдэх, тодорхой үйлдэл хийсэн нь тогтоогдвол залилан мэхлэх гэмт хэрэг гэж үзэж, эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.[22] Практикт эхэндээ иргэний эрх зүйн гэрээний харилцаа байсан боловч гэрээгээр хүлээсэн үүрэг нь биелэгдэх боломжгүй болмогц түүгээр шалтаглаж залилан мэхлэх, үүргээ огт биелүүлэхгүй байх гэмт санаа үүсч болдог. Анхаарах зүйл нь бизнесийн үйл ажиллагаа болон ямар нэгэн шалтгаанаар үндсэн зээлээ төлж чадахгүй нөхцөл байдал үүсч болно энэ болгоныг залилан мэхлэх гэмт хэрэг гэж үзэж болохгүй үүнийг мөрдөн шалгах ажиллагааны явцад тогтоох шаардлагатай.[23] Үүргээ зохих ёсоор гүйцэтгэж чадахгүй болсон гэдгээ нөгөө талдаа мэдэгдэж зээлийн гэрээний хугацааг сунгах эсвэл барьцаа хөрөнгийг зарж борлуулах талаар зөвшөөрөл өгсөн гэх мэт асуудлыг Иргэний эрх зүй дэх гэрээний чөлөөт байдлын зарчимтай холбон авч үздэг.

Иргэний эрх зүйн гэрээнээс үүссэн харилцааны явцад бий болсон эрсдэл буюу байгалийн давагдашгүй хүч, нийгэм эдийн засгийн харилцааны зохицуулалтын өөрчлөлт, гэнэтийн осол, өвчин эмгэг, хорио

[21]Улсын дээд шүүхийн 2019.12.16-ны №661 тогтоол
[22]Улсын дээд шүүхийн 2019.10.23-ны №538 тогтоол
[23]Улсын дээд шүүхийн 2019оны 12 сарын 13-ны өдрийн Ү.С нарт холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгож цагаатгасан 646-р тогтоол

цээр зэрэг талуудаас үл шалтгаалах хүчин зүйл буюу нөхцөл байдал урьдчилан тооцоолох боломжгүйгээр гэнэт өөрчлөгдсөний улмаас гэрээний үүрэг биелэгдээгүйг залилан мэхлэх гэмт хэрэг гэж үзэхгүй[24], ялангуяа урдчилан тооцоолох боломжгүйгээр нөхцөл байдал гэнэт өөрчлөгдсөний улмаас гэрээний үүрэг биелэгдээгүй эсэхийг мөрдөгч, прокурор, шүүгч хэргийн нөхцөл байдлыг тал бүрээс нь бүрэн бодитой шалгасны үндсэн дээр тогтоох ёстой. Мөн залилан мэхлэх гэмт хэрэг үйлдэхдээ иргэний гэрээ, хэлцлийг ашиглах явдал нь дээрх гэмт хэргийн нэг арга барил болсон нь хууль ёсны мэт харагддаг нуугдмал байдлыг бий болгож байна. Гэвч бодит байдалд гэмт этгээд хохирогчийн эд хөрөнгө, түүнийг эзэмших эрхийг буцааж өгөлгүй, үнэ төлбөргүй авах гэсэн санаа, зорилгыг анхнаасаа агуулсан байдаг бөгөөд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад түүнийг бүрэн тогтоож чаддаггүй зэрэг төвөгтэй байдал ихээр бий болдог.

Мөн зээлээр худалдан авсан зүйлээ бусдад зарж борлуулсан атлаа үнийг нь төлөөгүй үйлдэл нь дээрх шийнжийг агуулж байгаа тул бусдын итгэлийг эвдэх аргаар залилан мэхэлсэн гэсэн анхан шатны шүүхийн дүгнэлтийг үндэслэлтэй гэж тайлбарлажээ.[25]

Бусдын эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг хууль бусаар байдлаар өөртөө шилжүүлэн авч буй шинж нь залилах гэмт хэрэг болоод иргэний эрх зүйн гэрээний үүргээ биелүүлээгүйгээс үүдэлтэй маргааны аль алинд нь илэрдэг ба практикт ялган зааглахад хүндрэлтэй байдаг.

Залилах гэмт хэрэг нь хуурч, эсхүл баримт бичиг, эд зүйл, цахим хэрэгсэл ашиглаж, эсхүл зохиомол байдлыг зориудаар бий болгох, сүсэг бишрэлийг далимдуулах, бодит байдлыг нуух замаар бусдыг төөрөгдөлд оруулж, эсхүл нэр хүнд, урьдын харилцааны явцад бий болсон итгэлийг урвуулан ашиглаж эзэмшигч, өмчлөгчийн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг шилжүүлэн авах шинжтэй үйлдэгддэг бөгөөд шүүгдэгчийн хувьд гэмт үйлдлээ хэрэгжүүлж эхлэхээс өмнө бусдын эд хөрөнгө, эсхүл түүнийг эзэмших, өмчлөх эрхийг буцааж өгөхгүй, хариу төлбөр огт хийхгүй, хагасыг нь хийнэ гэсэн санаа зорилго, сэдэлтээр дээрх шинжүүдийн аль нэгнээр нь хохирогчийн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг өөрийн эзэмшилд шилжүүлэн авснаараа энэхүү гэмт хэргийн шинж хангагдана.[26]

Гэтэл иргэний эрх зүйн гэрээний хувьд аль нэг талд дээрх гэмт санаа бодол төрөөгүй байдаг бөгөөд хөрөнгө, санхүүгийн болоод бусад гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжтой нөхцөл бүрдсэн үед гэрээний нөгөө талаа хохиролгүй болгох хүсэл эрмэлзлэлтэй байдаг. Мөн

[24]Б.Галдаа “Монгол Улсын Эрүүгийн хууль ба гэмт хэргийн зүйлчлэл”. УБ. 2012 он. 142 дахь тал
[25]Улсын дээд шүүхийн 2017.12.08-ны №306 тогтоол
[26]Улсын дээд шүүхийн 2019.10.30-ны №569 тогтоол

гэрээ нь аль аль талуудын сайн дурын үндсэн дээр, эрх тэгш, чөлөөтэй байгуулснаар хүсэл зориг, ашиг сонирхол нь хангагдаж, эрх үүрэг, үр дагавар үүсч байдаг.[27]

Залилах гэмт хэргийн хохирогч нь хийсвэрлэн бодох оюун ухаан бүхий амьд бие организм байх бөгөөд гэмт этгээдээс хуурамч баримт бичиг хэрэглэх, өөрийгөө хөрөнгө мөнгөтэй хүн болгон итгүүлэх, тусгай албаны үнэмлэх буюу хувцас хэрэглэх, түүнийгээ үзүүлэх гэх мэт янз бүрийн хийсвэр арга хэрэглэхэд түүнд дүн шинжилгээ хийж хариу үйлдэл үзүүлэх чадвартай хүн байна. Энэ явцдаа төөрөлдөх нь энэ төрлийн гэмт хэргийн хохирогч болох үндсэн нөхцөл болно.[28]

Хохирогчийн зүгээс иргэний эрх зүйн харилцаанаас үүдэлтэй маргааныг цагдаагийн байгууллагаар шалгаж шийдвэрлүүлэх сонирхол ихтэй байдгаас энэ төрлийн маргаан иргэний журмаар шийдвэрлэгдэхгүй цагдаагийн байгууллагад ачаалал болж шалгагдаж байгаа нь ажиглагдаж байна. Учир нь иргэдийн дунд цагдаагийн байгууллагад шалгагдах нь айдас бий болгодог тул тухайн хэрэг маргааныг хурдан шийдвэрлүүлэх хөшүүрэг болдог. Мөн иргэний журмаар тухайн маргааныг шийдвэрлүүлэх боломжтой талаар иргэдийн мэдлэг хомс, мөн иргэний журмаар хэргийг хянан шийдвэрлүүлэхэд улсын тэмдэгтийн хураамж төлдөг, иргэний хэргийн шүүх асуудлыг шуурхай шийдвэрлэж чаддаггүй, жил тойрон сунжирдаг, иргэний хэргийн шүүхийн шийдвэр биелэгдэх чадвар муутай, ихэвчлэн хоосон шийдвэртэй хоцордог зэрэг байдал нөлөөлдөг.[29]

Нөгөөтэйгүүр энэ төрлийн гомдол мэдээллийг Цагдаагийн байгууллага хүлээж авах уу, шүүхэд харъяалагдах уу гэдэг нь объектив болоод субьектив хүчин зүйлээс хамаарч харилцан адилгүйгээр шийдэгдэж байна.

Объектив хүчин зүйл гэдэгт хууль тогтоомжийн тодорхой боловсронгуй бус байдлаас хамаарч байгаа бол субьектив хүчин зүйл гэдэгт хууль хэрэглэгчийн мэдлэг, ур чадвар, хандлага, ажлын туршлага түүнчлэн маргалдаж буй талуудтай танил тал бусад байдлаар хамааралтай эсэх нь уг маргааны хувь заяаг хэрхэхийг шийдэж байна.

Энэ төрлийн иргэний хэрэг, залилах гэмт хэргийг шалгаж шийдвэрлэсэн хэргийн материал, шүүхийн шийдвэрүүдийг судлан үзэхэд бусдыг хуурч мэхлэх, хохирол учруулж буй үйлдэл, эс үйлдлийг (иргэний эрх зүйн маргаан, залилах гэмт хэрэг)-ийг гурав ангилж авч үзэж болохоор байна.

---

[27]Ц.Цолмон “Гэрээний эрх зүй”. УБ. 2009 он 54 дэх тал
[28]Улсын дээд шүүхийн 2019.10.14-ны №486 тогтоол
[29]Ц.Гантулгабат “Залилах гэмт хэргийн хүндрүүлэх шинжийг иргэний эрх зүйн маргаанаас ялган зүйлчлэхэд анхаарах асуудал” “ГЭМТ ЯВДАЛТАЙ ТЭМЦЭХ АСУУДАЛ” онол, арга зүйн улирал тутмын сэтгүүл 2018 №3 (65)

1. Иргэний эрх зүйн хэлцэл байгуулсан бөгөөд тодорхой нөхцөл байдлын улмаас гэрээний үүрэг биелэгдэхгүй болсон. Энэ нь хууран мэхлэх санаа зорилго байхгүй.
2. Иргэний эрх зүй дэх хэлцэл байгуулсан боловч гэрээний үүргээ биелүүлэх боломжгүй болсон ба улмаар цаашид үүргээ биелүүлэх хүсэл зорилгогүй болох. Залилах гэмт хэргийн шинжтэй.
3. Гэрээ байгуулсан цагаас үүргээ биелүүлэх зорилгогүй хэлцлээр халхавчилсан залилах гэмт хэргийг анхнаасаа төлөвлөж үйлдсэн.

Энэ төрлийн хэргийн шийдвэрлэж байгаа шүүхийн практикт гарч байгаа нэг алдаа нь бусдыг залилсан гэдгийг мөрдөн байцаалтын явцад нотлох баримтаар хангалттай тогтоож шүүхэд шилжүүлсэн хэргийг яллагдагч нь учруулсан хохирлоосоо их бага ямар нэг хэмжээгээр төлж барагдуулсан явдал нь залилах гэмт хэрэг биш иргэний хэрэг гэж үзэн шийдвэрлэх тохиолдол гарч байна.[30] Залилан мэхлэх гэмт хэргийг тухайн гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээг харгалзан зүйлчлэх ба хохирлын зарим хэсэг нөхөн төлөгдсөн нь хэргийн зүйлчлэлд нөлөөлөхгүй.[31] Энэ талаар гарсан албан ёсны тайлбар байсаар атал хэргийг буруу шийдвэрлэж байгаа нь хууль хэрэглэгчийн эрх зүйн мэдлэг дутмаг, ур чадваргүй гэж үзэх үү эсхүл санаатайгаар хуулийг буруу тайлбарлаж хэрэглээд байна уу гэдэг нь анхаарал татаж байна.

Дүгнэлт, санал

1. Өмчийн эсрэг бусад гэмт хэргүүдээс “залилах” гэмт хэргийн ялгагдах гол шинж нь хувийн эрх зүйн харилцаан дээр суурилж үйлдэгддэг онцлогтой. Өөрөөр хэлбэл залилах хэргийг иргэний эрх зүйн төрөл бүрийн гэрээн дээр үндэслэж хийж байна. Уг гэмт хэрэг нь хохирогчийг хуурч мэхлэн төөрөгдөлд оруулж өөрөөр нь хүлээн зөвшөөрүүлсэн байдаг. Энэ утгаар нь авч үзвэл хохирогчийн гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйтэй (*амар хялбар аргаар мөнгөтэй болох болон богино хугацаанд их ашиг олох хүсэл, төрийн болон бусад байгууллага, хүмүүсээс эрсдэлтэй гэдгийг анхааруулсаар байтал аз сорих, бодит нөхцөл байдлыг шалгаж няглалгүй хайхрамжгүй хандах, эрх зүйн мэдлэг мэдээлэл дутмаг зэрэг*) их бага хэмжээгээр холбоотой.

[30]Т.Ч-д холбогдох эрүүгийн 201626021397 тоот хэргийг шийдвэрлэсэн нийслэлийн Баянгол дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны 2020/ШЦТ/1029 дугаартай цагаатгах тогтоол. Уг цагаатгах тогтоолыг давж заалдах шатны шүүхээс 2021/ДШМ/158 магадлалаар хүчингүй болгосон.
[31]УДШ-ийн 2019.05.31-ний №244 тогтоол

2. Хууль хэрэглэх практикт энэ төрлийн адил үйлдэлд эрүүгийн хэрэг үүсгэх эсхүл иргэний эрх зүйн маргаан гэж үзэн эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзаж байгаа тохиолдол маш ихээр гарах боллоо. Өөрөөр хэлбэл энэ асуудалд хууль зүйн хувьд “double standart” үүссэн байна. Энэ төрлийн гомдол мэдээллийг Цагдаагийн байгууллага хүлээж авах уу, шүүхэд харъяалагдах уу гэдэг нь объектив болоод субьектив хүчин зүйлээс хамаарч харилцан адилгүйгээр шийдэгдэж байна.

3. Иргэний хуулийн 58, 59-р зүйлд заасан ноцтой төөрөгдлийн улмаас хийсэн болон хууран мэхэлж хийсэн хэлцэл нь хэлцлийг хүчин төгөлдөр бусад тооцуулах үндэслэл болохоос биш уг асуудлыг залилах гэмт хэргээр шалгаж болохгүй гэсэн үндэслэл биш юм. Үүнийг практикт аль нэг хуулиар нь шийдэх ёстой гэсэн буруу ойлголтыг халах ёстой.

4. Залилах гэмт хэргийн үндсэн шинжид гэмт этгээд бусдын эд хөрөнгийг итгэл төрүүлэх, хуурч мэхлэх аргаар авахын зэрэгцээ уг эд хөрөнгийг буцаан төлөх, хариу төлбөр хийхгүйгээр өөрийн болгох зорилготой байдгаараа иргэний эрх зүйн маргаанаас ялгагддаг төдийгүй тухайн эд хөрөнгө, мөнгөн төлбөрийн үүргийг гүйцэтгэх, буцаан төлөх боломж байсан уу гэдэг нь иргэний эрх зүйн маргаан залилах гэмт хэргийг ялган зүйлчлэх үндсэн шалгуур болдог. Энэ талаар Улсын дээд шүүхээс албан ёсны тайлбар гаргах шаардлагатай байна.

5. Сүүлийн жилүүдэд өмчийн эсрэг гэмт хэрэг түүн дотроо залилах гэмт хэрэг ихээр үйлдэгдэж олон иргэн, хуулийн этгээдийг хамарч, их хэмжээний хохирол учруулж байгаа нь эдийн засгийн аюулгүй байдалд ноцтой хохирол учруулахуйц нөхцөл байдлыг бий болгож байна. Манай улсын хувьд иргэний эрх зүйн маргаан болон залилах гэмт хэргийг ялган зүйлчлэхэд эрх зүйн орчин харьцангуй бүрдсэн бөгөөд энэ төрлийн хэрэг маргааныг шалгаж шийдвэрлэх хууль сахиулах болон шүүх, прокурорын байгууллагын ажилтнуудын нотлох баримтыг шалгаж тогтоох, үнэлэх, хууль хэрэглэх ур чадвар мөн бусад хүчин зүйлээс хамаарч адилхан тохиолдол харилцан адилгүй шийдвэрлэгдэж байна. Хуулийн практикт ахуйн чанартай хэрэг шалгаж, ажлын ачаалал их байгаа мөрдөгчийн хувьд залилах гэмт хэрэг эсхүл иргэний хэрэг маргаан гэдгийг ялгаж шалгахад хүндрэл бэрхшээлтэй, хууль хэрэглэх, нотлох баримт цуглуулж, үнэлэхэд мэргэжил мэдлэгийн болон тактик арга зүйн алдаа дутагдал их гарч байгаа нь судалгаанаас харагдаж байх тул тэднийг эрх зүй, эдийн засгийн чиглэлээр мэргэшүүлэн бэлтгэх шаардлагатай байна.

Ашигласан эх сурвалж

А. Хууль тогтоомж

- Монгол Улсын Үндсэн хууль. Төрийн мэдээлэл. УБ., №1
- Иргэний хууль. Төрийн мэдээлэл. УБ., 2002 он №7
- Эрүүгийн хууль /Шинэчилсэн найруулга/ Төрийн мэдээлэл. УБ.,2015 он №7
- Улсын Дээд шүүхийн 51 дүгээр тогтоолын 7 дугаар хэсэг
- Улсын дээд шүүхийн 2019.12.16-ны №661 тогтоол
- Улсын дээд шүүхийн 2019.10.23-ны №538 тогтоол
- Улсын дээд шүүхийн 2017.12.08-ны №306 тогтоол
- Улсын дээд шүүхийн 2019.10.30-ны №569 тогтоол
- Улсын дээд шүүхийн 2019.10.14-ны №486 тогтоол
- УДШ-ийн 2019.05.31-ний №244 тогтоол

Б. Ном, гарын авлага

- Д.Адъяабазар. “Монгол Улсад залилан мэхлэх гэмт хэрэгтэй хийх эрүүгийн эрх зүйн тулгамдсан асуудал” хууль зүйн докторын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл 2004 он 141 дэх тал
- Б.Галдаа “Монгол Улсын Эрүүгийн хууль ба гэмт хэргийн зүйлчлэл”. УБ. 2012 он. 142 дахь тал
- С.Гантулга, Б.Энхболд. Эрүүгийн эрх зүй: тусгай анги /сурах бичиг/. Нэмж засварласан хоёр дахь хэвлэл Улаанбаатар 2020 он 163 дахь тал
- Ц.Гантулгабат “Залилах гэмт хэргийн хүндрүүлэх шинжийг иргэний эрх зүйн маргаанаас ялган зүйлчлэхэд анхаарах асуудал” өгүүлэл, “ГЭМТ ЯВДАЛТАЙ ТЭМЦЭХ АСУУДАЛ” онол, арга зүйн улирал тутмын сэтгүүл 2018 №3 (65)
- “Иргэний хуулийн тайлбар” албан бус тайлбар УБ,2006 он, 846 тал
- “Криминалистикийн тактик” ред. Ж.Болдбаатар, УБ. 2001 он. 252 дахь тал
- Монгол Улсын Иргэний хуулийн тайлбар. УБ. 2010 он. 110 дахь тал
- Ц.Цолмон “Гэрээний эрх зүй”. УБ. 2009 он 54 дэх тал

В. Цахим эх сурвалж

- https://police.gov.mn/resource/policegovmn/media/Statistic_medee/2016_12_sar_medee/2016.12_burtgegdsen_gemt_hereg.pdf
  Цагдаагийн байгууллагын хэмжээнд 2016 онд бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн мэдээ. Сүүлд үзсэн: 2021.12.10
- https://police.gov.mn/resource/policegovmn/media/Statistic_medee/2017_12_sar_medee/2017.12_sar_Burtgegdsen_gemt_hereg.pdf

Цагдаагийн байгууллагын хэмжээнд 2017 онд бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн мэдээ. Сүүлд үзсэн: 2021.12.10

- https://police.gov.mn/resource/policegovmn/File/2019/01/08/go8kd8smlvmred5n/2018.12%20sar%20medee%20Burtgegdsen%20hereg.pdf
  Цагдаагийн байгууллагын хэмжээнд 2018 онд бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн мэдээ. Сүүлд үзсэн: 2021.12.10
- https://police.gov.mn/resource/information/File/2020/01/06/w3fp8kgj5qn65l7n/2019.12%20sar%20Burtgegdsen%20gemt%20hereg.pdf
  Цагдаагийн байгууллагын хэмжээнд 2019 онд бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн мэдээ. Сүүлд үзсэн: 2021.12.10
- https://police.gov.mn/resource/information/File/2021/01/06/6mom96u9hprz309d/%D1%81%D0%B0%D0%B9%D1%82%20%D0%BC%D1%8D%D0%B4%D1%8D%D1%8D-%D1%85%D1%8D%D1%80%D1%8D%D0%B3.pdf
  Цагдаагийн байгууллагын хэмжээнд 2020 онд бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн мэдээ. Сүүлд үзсэн: 2021.12.10
- https://police.gov.mn/a/5737 Цагдаагийн байгууллагын хэмжээнд 2021 оны эхний 11 сард бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн мэдээ. Сүүлд үзсэн: 2021.12.10
- https://shuukh.mn/cases/2/3 Монгол Улсын шүүхийн шийдвэрийн цахим сан. Сүүлд үзсэн: 2021.12.10 14:26
- https://shuukh.mn/cases/2/3 Монгол Улсын шүүхийн шийдвэрийн цахим сан. Сүүлд үзсэн: 2021.12.10 14:29
- “Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэх тухай” хуулийн төсөл
- Туг.mn Хохирогчдын цуврал сурвалжлага, ярилцлага
- Улсын дээд шүүхийн 2019оны 12 сарын 13-ны өдрийн Ү.С нарт холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгож цагаатгасан 646-р тогтоол
- Т.Ч-д холбогдох эрүүгийн 201626021397 тоот тоот хэргийг шийдвэрлэсэн нийслэлийн Баянгол дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны 2020/ШЦТ/1029 дугаартай цагаатгах тогтоол. Уг цагаатгах тогтоолыг давж заалдах шатны шүүхээс 2021/ДШМ/158 магадлалаар хүчингүй болгосон.

ИРГЭНИЙ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ХУУЛИЙГ ШИНЭЧЛЭХ ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА

A NEED AND REQUIREMENT FOR REVISION AND REFORM OF THE CODE OF CIVIL PROCEDURE

С.Энхбаяр
Санхүү эдийн засгийн их сургуулийн ахлах багш, хууль зүйн доктор, дэд профессор
S.Enkhbayar
Senior Lecturer of University of Finance and Economics, Ph.D, Associate Professor

Хураангуй:

Иргэний хэргийн шүүх хуралдаан олон удаа хойшлох явдлыг эдийн засгийн механизмтай уялдуулах замаар иргэний хэргийг түргэн шуурхай шийдвэрлэх зохицуулалтыг бий болгох, мөн цар тахлын цаг үед цахим шүүх хуралдааныг хэрхэн удирдан явуулах талаар нэгдмэл ойлголтод хүрээгүй, техник-эдийн засгийн боломжийг хангалтгүй, эрх зүйн зохицуулалтын дутмагшилтай байдлыг шийдвэрлэх, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд прокурорын эрх зүйн байдлыг тодорхой болгох зэрэг иргэний шүүхийн практикт тулгамдаж байгаа асуудлыг хөндсөн болно.

Abstract:

This paper covers a package of outstanding issues facing the current court civil procedure and judicial practice, including a need and requirement for creation of a new regulatory framework for efficient and expedited civil procedure by way a linkage frequent delays in civil cases proceedings with economic mechanism, also addressing the lack of consensus on how to manage the online court trials inadequate technical and economic capacities of courts and lack of sufficient legal regulations during a period of pandemic, as well as clarifying a legal status, role and responsibilities of public prosecutors in civil case proceedings.

Түлхүүр үгс:

Улсын тэмдэгтийн хураамж, шүүхийн зардал, шүүхийн хурал хойшлох, цахим шүүх, прокурор, гуравдагч этгээд.

Key words:

State stamp duty, court expenses, postponement of court trial proceedings, online e-court, public prosecutor, third party.

Өмнөтгөл

Монгол Улсад шинэ Үндсэн хууль батлагдан гарсан цаг хугацаатай холбоотойгоор хувийн эрх зүйн шинжлэх ухаанд шинжлэх ухаан хөгжих, хувийн эрх зүйн хууль тогтоомж бодитоор хэрэгжих боломж бий болсноос хойш 30 жилийг ардаа үджээ. Хувийн өмч хэрэглээний зүйлээр хязгаарлаж байж, дамын наймаа гэмт хэрэг гэж үзэж байсан нийгэмд хувийн эрх зүйн шинжлэх ухааны хөгжлийн тухай ярих боломжгүй юм. Өөрөөр хэлбэл, манай улсад өмчийн бүх хэлбэрийг хүлээн зөвшөөрсөн цаг хугацаатай уялдаатайгаар хувийн эрх зүйн шинжлэх ухаан шинэ түвшинд сонгодог утгаараа хөгжих боломжийг боломж бий болсон.

Материаллаг ба процессын хэм хэмжээнүүд нь өөр хоорондоо шууд хамааралтайгаар нийгмийн харилцааг зохицуулж байдаг. Хувийн эрх зүйн хөгжлийг зөвхөн материаллаг эрх зүйн талаас нь харж, иргэний процессын эрх зүйн хөгжлийг зөвхөн шүүхийн практик гэх агуулгаар харж ирсэн гэж хэлэхэд хилсдэхгүй болов уу.

Хувийн эрх зүйн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх зорилго бүхий процессын эрх зүйн салбарыг шинжлэх ухааны төвшинд судлах, хууль тогтоомжийг хөгжүүлэх хэрэгцээ шаардлага байгаа шүүхийн практикт тулгамдаж буй асуудал, шат шатны шүүхийн процессын зөрүүтэй ойлголт, хууль тогтоомжийг ялгамжтай хэрэглээнээс бид харж болно.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх хууль тогтоомжийн боловсронгуй бус байдал, мөн Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүйн шинжлэх ухааны хөгжлийн зогсонги байдалтай холбоотойгоор эдийн болон эдийн бус баялагтай холбоотой процессын эрх зөрчигдөх, нэг тал нь хуулийн боломжийг ашиглан иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааг удаашруулах, нөгөө тал нь шүүхэд итгэх алдах, шүүхийг нэг талыг барьж байгаа мэт хандлага гаргах нь олонтой тохиолдох болсон бөгөөд шүүх шударга бус байгаа, шүүхийн үйлчилгээ таруу, харилцаан хандлага сул байгаатай холбоотой гэхээсээ илүүтэйгээр хуулийн зохицуулалтын боловсронгуй бус байдалтай шууд холбоотой юм.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийг шинэчлэх хэрэгцээ шаардлагыг нэг өгүүлэг, илтгэлд багтаах боломжгүй тул дараах агуулгаар авч үзэх нь зүйтэй.

1. Шүүхийн улсын тэмдэгтийн хураамжтай холбоотой анхаарах асуудал
2. Цар тахлын үеийн иргэний хэргийн шүүхийн үйл ажиллагаанд анхаарах асуудал
3. Прокурор иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох асуудал гэх агуулгын хүрээнд илтгэлийг цааг өрнүүлье.

Дээрхи асуудал нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд тулгамдаж байгаа асуудлын нэгээхэн хэсгээр дамжуулан Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийг шинэчлэх зайлшгүй шаардлагатай болохыг илэрхийлж байна.

Нэг: Шүүхийн улсын тэмдэгтийн хураамжтай холбоотой анхаарах асуудал

Монгол Улсын Хууль, Монгол Улсын нэгдэн орсон Олон Улсын гэрээнд заасан хүний эрх, эрх чөлөө хууль ёсны ашиг сонирхлоо зөрчигдсөн гэж үзэж байвал аливаа этгээд уг эрхээ хамгаалуулахаар хуульд заасан журмын дагуу шүүхэд нэхэмжлэл, гомдол, хүсэлт гаргах хэлбэрээр мэдүүлэх эрхтэй бөгөөд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа нь эдийн болон эдийн бус баялагтай холбоотой иргэний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, нотлогдож байгаа хэмжээгээр үнэн тогтооход чиглэсэн цогц хууль зүйн дагуух үйл ажиллагаа юм.

Шүүхээс хэрэг хянан шийдвэрлэхтэй холбогдон зайлшгүй зардал гарах бөгөөд уг зардлыг төрөөс санхүүжүүлэх хуулийн зохицуулалттай. Иргэний хэрэгхянан шийдвэрлэх явцад гарсан зарим зардлыг хэргийн оролцогчдоор нөхөн төлүүлдэг онцлогтой. Тухайлбал, Нөхөн төлөх шүүхийн зардалд шинжээч, орчуулагч, хэлмэрчийн болон гэрчийн тээвэр, байр, хоолны зардал, үзлэг, туршилт, таньж олуулах ажиллагаа явуулахад гарсан зардал, эд мөрийн баримт хадгалах зардал зэрэг хамаардаг.

Шүүхийн зардлаас гадна, шүүхээс тодорхой үйл ажиллагаа гүйцэтгүүлсний төлөө хуульд заасан хэмжээ, журмаар төлөх мөнгөн хураамж юм.Өөрөөр хэлбэл улсын тэмдэгтийн хураамж нь шүүхээс эрх зүйн маргааныг шийдвэрлэхтэй холбогдсон үйлчилгээ үзүүлсний төлөө зохигчоос төлж байгаа мөнгөн хөрөнгийг хэлдэг. Улсын тэмдэгтийн хураамж нь шүүхийн зардлыг бүрдүүлэгч гол хэсэг төдийгүй, төрийн байгууллага, тухайлбал шүүхээс тодорхой үйл ажиллагаа гүйцэтгүүлсний төлөө хуульд заасан хэмжээ, журмаар төлөх мөнгөн хураамж юм. Энэ нь улсын төсвийн орлогод орсноор шүүхээс хэрэг хянан шийдвэрлэхтэй холбогдон гарсан зарим зардлыг багасгахад чиглэгддэг.

Иргэний хэргийн шүүх 2016 онд 13,609,351,189 төгрөг[1], 2017 онд 16,588,340,566 төгрөг[2], 2018 онд 11,457,389,803 төгрөг[3], 2019 онд 11,324,543,573 төгрөг[4], 2020 онд 15,900,738,624[5] төгрөгийн тус тус улсын

орлогыг оруулсан байх бөгөөд шат шатны шүүхийн оруулсан орлогын хэмжээгээр харьцуулан авч үзвэл:

Удаа дараа шүүх хуралдааныг хойшлуулж, хэрэг хянан шийдвэрлэх хуульд заасан хугацаа хэтэрч байгаа үндэслэл, хугацааг улсын хэмжээнд 2019 оны 05 дугаар сарын 01-ний байдлаар судалж үзвэл нийт ажиллагаанд байгаа хэргийн 47% нь 1-60 хоног, 20% нь 61-120 хоног, 6% нь 121-150 хоног, 27% нь 151-ээс дээш хоногоор буюу иргэний хэрэг үүсгэснээс хойш 240 хоног /8 сар/ өнгөрсөн байгаа бол 2021 онд хугацаа хэтэрсэн хэргийн тоо нийт маргааны 39 хувийг эзэлж байгаа нь цар тахлын үеийн хөл хориотой шууд холбоотой. Нөгөө талаас цаг хугацаа явах тусам шүүхийн зардал өсдөг бусад улсын жишиг байгааг анхаарахгүй орхиж болохгүй. Өөрөөр хэлбэл, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай холбоотой маргаанд 70,200 төгрөг төлж, шүүхийн үйлчилгээг 2 сараас 24 сарын хооронд авдаг, шүүх хуралдааныг удаа дараа хойшлуулах тохиолдол цөөнгүй байна.

Япон Улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 63 дугаар зүйл (ХХША-г хошлуулсанаас үүсэх хариуцлага)-д “Зохих хугацаанд хариу тайлбар болон нотлох баримтаа ирүүлээгүй, эсхүл тогтоосон хугацааг дагаж мөрдөөгүй, эсхүл талуудтай холбоотой бусад шалтгаанаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хойшлуулсан бол шүүх ХХША-ны шийдвэрээс үл хамааран (ялсан, ялагдсан тал нь аль нь байхаас үл хамааран) ХХША-г хойшилсны улмаас үүссэн зардлыг бүхэлд

[1] Монгол Улсын Шүүхийн тайлан, УБ, 2016 он, 249 дэх тал
[2] Монгол Улсын Шүүхийн тайлан, УБ, 2017 он, 251 дэх тал
[3] Монгол Улсын Шүүхийн тайлан, УБ, 2018 он, 271 дэх тал
[4] Монгол Улсын Шүүхийн тайлан, УБ, 2019 он, 272 дахь тал
[5] Монгол Улсын Шүүхийн тайлан, УБ, 2020 он, 277 дахь тал

нь буюу хэсэгчлэн хариуцуулж болно."[6] гэж заасан бөгөөд шүүх хуралдаан хойшлох бүрт шүүхийн зардал өсч, төлөх төлбөрийн хэмжээ нэмэгддэг тулшүүх хуралдаан хойшлох нь эдийн засгийн агуулгаараа ач холбогдол багатай байдаг.

Жишээлбэл, иргэн Х-нь С ХХК-д холбогдуулан 4,000 төгрөг гаргуулахаар шүүхэд хандаж, шүүх хуралдаан удаа дараа хойшилж, улмаар давж заалдах шатны шүүх, хяналтын шатны шүүхэд гомдол гаргаж, эцэслэн шийдвэрлэгдсэн. Өнөөдрийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 7.1.1-д зааснаар 4550 төгрөг болж байна. Талууд үйл баримтын нотлох зорилготойгоор 12 удаа шүүх хуралдааныг хойшлуулсан бөгөөд шүүхийн зардал болон улсын тэмдэгтийн хураамжийн уялдаа холбоо багатай байгааг илэрхийлж байна.[7]

Нэхэмжлэгч, хариуцагч идэвх санаачлагчтай байлгах үүднээс улсын тэмдэгтийн хураамж, шүүхийн зардлыг шүүх хуралдаан санаатай болон хариуцлагагүй байдлаар хойшлуусан тал хариуцан төлөх зохицуулалтыг бий болгох замаар иргэний шүүхийн хэт удаашрах, хурал бүрд хүсэлт гаргадаг хариуцлагагүй байдлыг эдийн засгийн хөшүүрэг ашиглан шийдвэрлэх боломжтой юм.

Дээрхи зохицуулалтыг бий болгосноор шүүх хуралдаан олон удаа хойшлох эрсдэлийн багасгах, иргэдийн шүүхэд итгэх итгэлийг нэмэгдүүлэх зэрэг эдийн засаг, эрх зүйн олон талт ач холбогдолтой.

Хоёр: Цар тахлын үеийн иргэний хэргийн шүүхийн үйл ажиллагаанд анхаарах асуудал.

Цар тахал дэлхийн олон орны хүн амд халдварлаж, олон сая хүнд халдварлаж, нас баралтын тохиолдол өндөр байгаа нь COVID-19 цар тахал дэлхийн хүн амын ихэнх хувьд сөргөөр нөлөөлж, улсууд хилээ хааж, нийтийг хамарсан хорио цээрийн онцгой дэглэм тогтоож,энэхүү хямрал нь эдийн засаг, хөдөлмөрийн зах зээлийг цочроож эхэлсэн бөгөөдзарим орны бүтээгдэхүүн үйлдвэрлэлд нөлөөлж байсан бол цаашлаад дэлхийн нийлүүлэлтийн сүлжээнд нөлөөлж эхэллээ.

Бизнесийн хэмжээнээс үл хамааран бүх төрлийн бизнес, ялангуяа агаарын тээвэр, аялал жуулчлалын салбарын орлого буурах, дампуурах, ажлын байраа алдах зэргээр ихээхэн бэрхшээлтэй тулгарч байна. Ялангуяа жижиг, дунд үйлдвэр, бизнес эрхлэгчдийн (ЖДҮ) үйл ажиллагаагаа хэвийн явуулахад хүндрэлтэй болж байна.

[6] japanese laws civil procedure code// 109 of June 26, 1996
[7] Монгол Улсын шүүхийн нэгдсэн архив.

Улс хоорондын хөдөлгөөнийг зогсоож, хил хаах, хөл хорио тогтоох зэрэг арга хэмжээ авсны улмаас олон ажилчин, тэр дундаа албан бус эдийн засагт ажиллаж байгаа, эсвэл тохиолдлын чанартай ажил эрхэлдэг хүмүүсийн хувьд ажилдаа ирж очиж чадахгүй, ажил эрхлэх боломжгүйд хүрч, цалин, орлогод нь нөлөөлж байна.[8] Дэлхийн болон дотоодын эдийн засаг хямралтай холбоотойгоор иргэний хэрэг өсч, шүүхийн шинэ цахим ажиллагаа, дижитал шинэчлэлийг шаардах болжээ.

“Цахим Монгол Улс” хөтөлбөрийг тууштай хэрэгжүүлэх замаар цахим шүүхийн бий болгох, цаашлаад цахим хавтаст хэрэг, тоон гарын үсэг, төрийн цахим дата /одоогийн хур систем/-г харилцан ашиглах, нотариатын үйл ажиллагаатай цахим баримтыг нотлох баримтаар үнэлэх асуудал эрх зүйн зохицуулалт шаардаж байна.

Өнөөдөр Иргэний шүүхийн практикт дотоод программ болон цахим систем зэргээр IT шийдэл хязгаарлагдаж, компьютер, технологийн хангамж, чанар муутай байдал ньцахим шилжилт хийх боломжийг хязгаарлах нөхцөлийг бүрдүүлж байна. Нийтийг хамарсан цар тахлын үед шүүхийн үйлчилгээ төдийгүй төрийн маш олон үүрэг функцыг өөрчлөх замаар цахим реформын асуудал дутагдаж байна.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд цахим шилжилттэй холбоотой зохицуулалт байхгүй, мөн шүүх хуралдааны цахимаар явуулахад багагүй хүндрэл тулгарч байна.

Цар тахлын улмаас нийтийг хамарсан хөл хорио тогтоож, хатуу дэглэм тогтоосон цаг үед шүүх хэвийн ажиллаж байсан бөгөөд шүүх хурал зарлах боломжгүй тул цахим шүүх хурал хийж эхэлсэн.

Нийтлэг байдлаар нийтийг хамарсан хөл хорио болон хэсэгчилсэн хөл хорионы үед зарлагдсан шүүх хуралдаан /хэргийн оролцогчдын эзгүйд шийдвэрлүүлэх хүсэлтэйгээс бусад/-ыг тодорхой бус хугацаагаар хойшлуулах, өмгөөлөгчөөс бусад хэргийн оролцогчдыг дуудахгүй байхаар шийдвэрлэж, хүсэлт, тайлбарыг шүүгчийн туслахыг цахим хаягаар авч ажилласан[9]..

Түүнчлэн, нийтийг хамарсан хөл хорио тогтоогоогүй байхад зарим шүүхэд ковид-19 н халдвар голомтлон гарч байгаатай холбоотойгоор хэсэгчлэн хөл хорио тогтоож байсан бөгөөд уг цаг хугацаанд шүүх хуралдааныг цахимаар явуулах, мөн нэхэмжлэгч болон хариуцагч нар шүүх хуралдаанд цахимаар оролцох хүсэлт гаргасан тохиолдолд шүүхээс цахимаар оролцуулж байна. Дараах хүндрэл шүүх хуралдааны дэгийг

[8] Олон Улсын Хөдөлмөрийн байгууллага., //Ковид-19 ба хөдөлмөр эрхлэлтийн үр нөлөө, хариу арга хэмжээ судалгааны тайлан. УБ., 2020 он. 2 дахь тал

[9] Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2021 оны 4 дүгээр сарын 9-ний өдрийн 371 дүгээр “Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаар шуурхай арга хэмжээ авах тухай” захирамж

хэрхэн сахиулах вэ, техникийн боломжоос шалтгаалан онлайн холболтоос шалтгаалсан дуу бүдэг сонсогдох, тасрах тохиолдолд шүүх хуралдааныг оролцогчийг дахин холбогдох хүртэл шүүх хуралдааныг үргэлжлүүлэх үү гэх асуудал гарч ирсэн. Тухайлбал, хэргийн оролцогч шүүх хуралдааны явцад сүлжээ тасраад гарахад мэтгэлцэх зарчмыг хангах, шүүх хуралдаанд оролцох боломжоор хангах зорилгоор шүүх хуралдааныг хойшлуулах уу, эсхүл цааш үргэлжлэх үү гэх асуудал бий болж байна. Шүүх хуралдааны явцад оролцогчийн интернет тасрах, дата дуусах үед талуудын хариуцлага гэх байдлаар шууд үргэлжлүүлбэл процессын алдаа болох магадлал өндөр юм. Оросын холбооны улсын тухайд шүүх хуралдаанд цахимаар оролцох тохиолдолд интернэтийн хурдыг хэмжиж зохих стандарт хангасан тохиолдолд цахимаар оролцохыг зөвшөөрдөг нийтлэг жишиг бий.[10]

Хэргийн оролцогчийн хувьд цахим шүүх хуралдаанд оролцоно гэж хүсэлт гаргасан тохиолдолд шаардлагатай техник хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг хариуцах нь ёс зүйн үүрэг төдийгүй, төрийн нэрийн өмнөөс явагдаж байгаа шүүх хуралдаан болон мэтгэлцэгч талаа хүндэтгэх нь зүй ёсны асуудал юм.

Цаашид цахим шилжилт, дижитал шүүхийг бий болгоход цахим нотлох баримтыг цуглуулах, үнэлэх, цахим шүүх хуралдааны дэг, журмыг зохицуулсан хуулийн зохицуулалтыг бий болгох нь зайлшгүй шаардлага байсныг дурдах нь зүйтэй.

Гурав: Прокурор иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох асуудал

Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд прокурор оролцох, бусдын эрх ашгийг хамгаалж байгаа этгээд оролцох журмыг ИХШХШТХ-ийн 31 дүгээр зүйлд тодорхойлжээ. Тэрээр ИХШХШХТхуулийн 22 дугаар зүйлд заасан хэргийн оролцогч мөн боловч маргааны зүйлийн талаар сонирхолгүй этгээд болно.[11]

Прокурор иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцоход үндсэн хоёр нөхцөл бүрдсэн байна. Үүнд:

а) Төрийн байгууллага иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд прокурор оролцуулах хүсэлт гаргасан байх. Үүнд төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд төрийн байгууллагын ойлголтод хамаарахгүй.

[10] Бюлов, Оскар. Учение о процессуальных возражениях и процессуальные предпосылки / пер. с нем. Д. С. Ксенофонтовой; отв. ред. Д. Х. Валеев. – Москва, 2019.

[11] Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль//Төрийн мэдээлэл, УБ., 2002. №8

б) Прокурор оролцуулах тухай хүсэлт нь төрийн эрх ашиг зөрчигдсөн байна. Прокурор төрийн байгууллагын хүсэлтийг хүлээн авч, төрийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл энэ хүсэлтийн дагуу хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох эсэхийг шийдвэрлэнэ. Төрийн ашиг сонирхол зөрчигдсөн боловч прокурор хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох тухай санал гаргаагүй бол шүүх санаачлагаараа прокурорыг оролцуулах эрх хуульд тусгагдаагүй байна.[12]

Эдгээр нөхцөлд прокурор иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд байгууллагын нэрийн өмнөөс бус гагцхүү төрийн нэрийн өмнөөс оролцоно.

Прокурорыг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулах хүсэлт гаргасан байгууллага нь ИХШХШТХ-ийн 38 дугаар зүйлд заасан журмын дагуу нотлох баримт гаргах, цуглуулах, түүнийг бүрдүүлэх, хүсэлт гаргах үүрэгтэй байна.

Прокурор нь хэргийн оролцогч тул мөн ИХШХШТХ-ийн 25 дугаар зүйлд заасан эрх үүргийг хэрэгжүүлэхийн хамт иргэний хэрэгт итгэмжлэлгүй оролцох, шүүхийн шийдвэрийг давж заалдах, хяналтын шатны шүүхэд гомдол гаргах эрхтэй. Тухайлбал шүүхийн практикт Цагаатгалын нөхөх олговор гаргуулах, Төрийн байгууллага болон төрийн байгууллагын эрх бүхий албан тушаалтны буруутай үйл ажиллагааны улмаас өөрт учирсан хохирлоо төрийн сангаас гаргуулах зэрэг иргэний хэрэгт прокурор оролцох нь нийтлэг байдаг.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд прокурор нь төрийн нэрийн өмнөөс хэрхэн оролцох вэ, төрийн нэрийн өмнөөс хэрхэн нотлох баримт цуглуулж, нотлох үүргээ хэрэгжүүлэх вэ гэх асуудал гарч ирдэг. Судалж үзэхэд талуудын зарчим үйлчилдэг, иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд төрийн нэрийн өмнөөс прокурор хэрхэн оролцох талаар хуулийн зохицуулалт учир дутагдалтай байна.

Төрийн эрх бүхий байгууллага буюу нийтийн эрх зүйн хуулийн этгээдийн хувьд өөрөө иргэний эрх зүйн харилцаанд оролцож, шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй. Шүүхийн практикт төрийн өмнөөс хохирол шаардаж нэхэмжлэл гаргах тохиолдол байсан бөгөөд нэхэмжлэгчээр оролцох боломжгүй гэж Улсын дээд шүүх шийдвэрлэсэн байна. Д.Ө газрын даргаар ажиллаж байхдаа эрх мэдлээ урвуулан 2013 оны 1, 2 дугаар саруудад тус газрын үнэлгээний хорооны дарга ажилчид нараар тендерт шалгарсан мэтээр хурлын тэмдэглэл, зөвлөмж, худалдах-худалдан авах гэрээг хуурамчаар үйлдүүлж төрсөн охин Ө.Ц-с компьютер, түүний дагалдах хэрэгслүүд зэргийг нийт 153,491,500 төгрөгөөр зах зээлийн үнэлгээнээс дээгүүр үнээр худалдан авч үнийн

[12] Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дэлгэрэнгүй тайлбар 2007 он

дүнгийн зөрүүнээс 49,551,500 төгрөг хувьдаа завшиж, байгууллагад онц их хэмжээний хохирол учруулсан гэмт хэрэгт холбогдсон. Хамгийн сүүлд Эрүүгийн хуулийн 150.3-р ял сонсгож, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулж, хийсэн хэргээ хүлээн зөвшөөрч, учруулсан хохирлоо сайн дураар нөхөн төлөх хүсэлт гаргаж, өршөөлд хамрагдах өргөдлийг Б.Ө гаргасан. Нийслэлийн Прокурорын газар хянаад 2016-11- 30-ны өдөр 151 дугаар тогтоол гаргаж, Анхны ардчилсан сонгууль болж байнгын ажиллагаатай парламент байгуулагдсаны 25 жилийн ойг тохиолдуулан баталсан Өршөөл үзүүлэх тухай хуулийн 7.1-р хэргийг хэрэгсэхгүй болгосон. Прокурор энэхүү хохирлыг шаардсан нэхэмжлэл гаргах үндэслэл буюу эрх нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 34.7.8, Прокурорын байгууллагын тухай хуулийн 20.1, 20.4, Иргэний хуулийн 62.3-р олгогдсон. Прокурорын дээд байгууллага нь УЕПГ-р тул өршөөл болон бусад байдлаар хэрэгсэхгүй болгосон эрүүгийн хэргийн улмаас улсад учруулсан төлөгдөхгүй, орхигддог хохирлыг арилгуулах, улсын орлогод оруулахаар Төрийн нэрийн өмнөөс нэхэмжлэл гаргасан. Улсын дээд шүүх Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 34 дүгээр зүйлийн зохицуулалтыг баримталсан нь буруу буюу шүүх хэрэглэх ёсгүй хуулийг хэрэглэжээ. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.7.8 / Төр, нийтийн эрх ашгийг хамгаалах шаардлагатай гэж үзвэл прокурор иргэний нэхэмжлэл гаргах, гарсан нэхэмжлэлийг дэмжих эрхтэй./ дахь хэсэг нь эрүүгийн хэргийг хэлэлцэхэд прокурор оролцох тохиолдолд хамааралтай байх тул хуулийн уг заалт нь төрийн байгууллагын итгэмжлэлгүй прокурор шүүхэд нэхэмжлэл гаргах нөхцөл болохгүй байна.[13]

Сүүлийн жилүүдэд прокурор жижиг дунд үйлдвэрийн зээлийг шаардаж нэхэмжлэл гаргаж байгаа бөгөөд нийтийн эрх зүйн хуулийн этгээдээс шаардах эрх шилжүүлэх эрх олгоогүй байхад нэхэмжлэл гаргасныг зарим шүүх хүлээн авдаг, зарим нь татгалздаг зөрүүтэй практик тогтжээ.

Прокурорын байгууллагын тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1-д “Төр, нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн шүүхэд нэхэмжлэл, тайлбар, гомдол гаргана.” гэх хуулийн зохицуулалтыг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх хуультай уялдуулах нь зүйтэй.

Прокурорын байгууллагын чиг үүрэгтэй холбоотойгоор иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд эрх зүйн байдлын хувьд хэрхэн оролцох нь тодорхой бус. Хяналтын чиг үүрэг хэрэгжүүлэх үү гэдэг нь ойлгомжгүй. Эсхүл, иргэний эрх зүйн харилцаанд төрийн байгууллага нь эрсдэлтэй гэрээ хийж оролцсон бол түүнийг хамгаалан оролцох үү гэх

[13] Shuukh.mn /шүүхийн шийдвэрийн цахим сан/

байдал тодорхой бус байна. Германд прокурор шүүх хуралдааны явцад гэмт хэргийн шинжтэй үйлдэл байгаа эсэхийг тодруулах зорилгоор иргэний процесст оролцдог бөгөөд хэзээ нотлох чиг үүрэгтэй оролцогч гэж үздэггүй, нотлох боломж хязгаартай байдаг[14].

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийг шинэчлэх хэрэгцээ шаардлага нь зөвхөн дээрх гурван жишээнээс гадна олон шүүхийн практикт тулгамдаж байгаа олон асуудлыг хуулийг шинэчлэн найруулах замаар шийдвэрлэх боломжтой юм.

[14] Иоахим Кают “Монгол Улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй”, УБ., 2015. 181 дэх тал.

ШҮҮХИЙН ШИНЭТГЭЛ БА ХУВИЙН ЭРХ ЗҮЙ: ХУУЛЬ ХЭРЭГЛЭЭНИЙ НЭГДМЭЛ БАЙДЛЫГ ХАНГАХАД УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ГҮЙЦЭТГЭХ ЧИГ ҮҮРЭГ, ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ

JUDICIAL REFORM AND PRIVATE LAW: THE ROLE AND PROBLEMS OF THE SUPREME COURT IN UNIFYING THE APPLICATION OF LAWS

Н.Норовсамбуу
Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн
сургуулийн Хувийн эрх зүйн тэнхимийн багш
N.Norovsambuu
Lecturer of National University of Mongolia
School of law, Department of Private law

Хураангуй:

Тодорхой хэрэг, маргааныг шийдвэрлэхэд УДШ-ийн Иргэний танхимын нийт шүүгчдээс аль таван шүүгч нь тухайн хэргийг шийдвэрлэх бүрэлдэхүүнд орохоос хамааraад хууль хэрэглээний ялгаатай байдал бий болж байна. Иймээс танхимын нийт шүүгчийн бүрэлдэхүүнтэй хэрэг маргааныг шийдвэрлэдэг болох нь хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах суурь нөхцөл юм.

Abstract:

Five judges from the Civil Affairs Department of the Supreme Court are trying civil cases in a dispute, which is the cause of the inconsistency in the application of the law. Therefore, in order to unify the application of the law, all judges in the Civil Affairs Department of the Supreme Court must make a trial.

Түлхүүр үгс: *Шүүхийн шинэтгэл, хууль хэрэглээний нэгдмэл байдал, УДШ-ийн бүрэлдэхүүн.*

Key words: *Judicial reform, unification of the application of the law, Supreme Court.*

I. Оршил

2021 оны 01 сарын 15-ны өдөр батлагдсан Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 25-р зүйлийн 25.7.5 дахь хэсэгт Улсын дээд шүүх хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах зорилгоор давж заалдах шатны шүүхийн магадлалыг дараах тохиолдолд хяналтын журмаар хянан шийдвэрлэх талаар заажээ. Үүнд:

а.анхан болон давж заалдах шатны шүүхийн хууль хэрэглээний зөрүүг арилгах;

б.хуулийг Улсын дээд шүүхийн албан ёсны тайлбараас өөрөөр тайлбарлаж хэрэглэсэн;

в.хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ноцтой зөрчил гаргасан нь шүүхийн шийдвэрт нөлөөлсөн.

Өөрөөр хэлбэл, шүүхийн шинэтгэлийн хүрээнд Улсын дээд шүүхийн үндсэн зорилго нь хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах болохыг тодорхой хуульчилжээ.

Өмнөх хуулиудаар хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах асуудлыг тодорхой хуульчилж өгөөгүй байдаг. Тухайлбал, 2012 оны 03 сарын 07-ны өдөр батлагдсан Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 17-р зүйлийн 17.3.1 дэх хэсэгт “Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбарыг тодорхой хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх замаар гаргах бөгөөд тайлбарыг тогтмол нийтлэх” гэж Улсын дээд шүүхийн бүрэн эрхийг тодорхойлж өгсөн. Гэвч тус зохицуулалт нь Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалтад “Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргах;” гэж заасныг зөрчсөн талаар маргаан гарсан.

Энэ талаарх Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг авч үзвэл “*Монгол Улсын Үндсэн хуульд Улсын дээд шүүх ямар замаар Үндсэн хуулиас бусад хуулийг тайлбарлахыг шууд заагаагүй боловч мөн хуулийн Тавьдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “... Хэрэв Улсын дээд шүүхийн шийдвэр хуульд харшилбал түүнийг Улсын дээд шүүх өөрөө хүчингүй болгоно. Улсын дээд шүүхийн тайлбар хуульд харшилбал хуулийг дагаж биелүүлнэ.” гэж заасан. Үүнээс үзэхэд Монгол Улсын Үндсэн хуульд Улсын дээд шүүхийн шийдвэр ба Улсын дээд шүүхийн тайлбар хэмээх ойлголтыг томьёолж, улмаар Улсын дээд шүүхээс хэргийн болон хэм хэмжээний тайлбар гаргах тухай үзэл санааг илэрхийлсэн байна. Иймд Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.1 дэх заалтад Улсын дээд шүүхээс зөвхөн хэрэг, маргааныг хянан шийдвэрлээд гаргасан шийдвэр шууд хуулийн албан ёсны тайлбар болохоор зохицуулсан нь энэ талаарх Үндсэн хуулийн үзэл бариимтлал хийгээд зохицуулалтад үл нийцсэн гэж үзэх үндэслэлтэй байна.*” [1] гэж дүгнэжээ.

Ер нь Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргах бүрэн эрхийг Улсын дээд шүүхэд Үндсэн хуулиар олгосон нь нэг ёсны хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах Улсын Дээд шүүхийн чиг үүргийг хүлээн зөвшөөрч буй явдал юм.

[1] Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.1 дэх заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай, МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ, 2015 оны 3 дугаар сарын 11-ний өдөр, Дугаар 03, Улаанбаатар хот

Гол нь абстракт тайлбар гаргах замаар хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангахын зэрэгцээ тодорхой хэрэг маргааныг шийдвэрлэхэд хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах асуудал чухал байна.

II. Тодорхой хэрэг, маргааныг шийдвэрлэхэд УДШ-ийн зүгээс хуулийг ялгаатай хэрэглэж байгаа талаарх жишээ

Энэ хэсэгт тодорхой жишээ авч адил төрлийн хэрэг маргааныг Улсын Дээд шүүхийн зүгээс хэрхэн ялгаатай шийдвэрлэж байгаа тухай авч үзнэ.

- **ЗӨӨЛИЙН ГЭРЭЭГ ЦУЦАЛСНААС ХОЙШ ХҮҮ ШААРДСАН МАРГААНЫГ ШИЙДВЭРЛЭСЭН ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ШИНЖИЛГЭЭ**[2]

Уг судалгааны хүрээнд банк, зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдээс зээлийн гэрээг цуцалснаас хойших хугацаанд хүү, нэмэгдүүлсэн хүү тооцон нэхэмжилсэн иргэний хэргүүдийг шүүх ялгамжтай, өөр өөрөөр шийдвэрлэж буй асуудлыг хөндсөн байна. Энэ хүрээнд нэхэмжлэлийн шаардлагыг хангасан болон хэрэгсэхгүй болгосон гэсэн төрлөөр шийдвэрүүдийг ангилж, хуулийн ямар зохицуулалтыг үндэслэн ямар тохиолдолд хангасан, ямар тохиолдолд хэрэгсэхгүй болгосныг тодорхойлох байдлаар дүн шинжилгээ хийжээ.

Тус судалгаагаар дүн шинжилгээ хийсэн 20 хэргээс зээлийн гэрээг цуцалснаас хойш хүү, нэмэгдүүлсэн хүү тооцож нэхэмжлэлийг хангасан хэрэг 9, зээлийн гэрээг цуцалснаас хойш хүү, нэмэгдүүлсэн хүү тооцож нэхэмжилсэн шаардлагыг хэрэгсэхгүй болгосон хэрэг 11 байна гэсэн үр дүн гарсан байна.

Судлаачдын зүгээс “*Энэхүү нөхцөл байдал нь цаашлаад банк, санхүүгийн байгууллага (зээлдүүлэгч), бизнес эрхлэгч, иргэдэд (зээлдэгч) тодорхойгүй нөхцөл байдал үүсгэж байгаа бөгөөд тухайн асуудлыг хэрхэн шийдвэрлэх нь хуулиар тухайн асуудлыг хэрхэн зохицуулснаас бус, харин цэвэр шүүгчийн үзэмжээс шалтгаалах буюу шүүгч хуулийг хэрхэн ойлгож хэрэглэхээс хамаарахаар байна*[3]” гэж дүгнэжээ.

Адил төрлийн хэрэг маргааныг ялгаатай шийдвэрлэж буй байдал нь тодорхойгүй нөхцөл байдал үүсгэж байгаатай санал нэгдэж байна.

[2]Л.Анхбаяр нар “ЗӨӨЛИЙН ГЭРЭЭГ ЦУЦАЛСНААС ХОЙШ ХҮҮ ШААРДСАН МАРГААНЫ ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ШИНЖИЛГЭЭ”, Нээлттэй нийгэм форум, “Шүүхийн шийдвэрийн судалгаа”, Цуврал.01, 2021 он

[3] Л.Анхбаяр нар “ЗӨӨЛИЙН ГЭРЭЭГ ЦУЦАЛСНААС ХОЙШ ХҮҮ ШААРДСАН МАРГААНЫ ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ШИНЖИЛГЭЭ”, Нээлттэй нийгэм форум, “Шүүхийн шийдвэрийн судалгаа”, Цуврал.01, 2021 он, 48 дахь тал

- **ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ЯВЦАД УЧИРСАН ХОХИРЛЫН НӨХӨН ТӨЛҮҮЛЭЛТ ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ**[4]

Уг судалгаагаар эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад мөрдөгч, прокурор, шүүгчийн хууль зөрчсөн ажиллагааны улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэхтэй холбоотой иргэний хэргийг шүүхээс хэрхэн шийдвэрлэж байгаа талаар судалсан байна.

Энэ хүрээнд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад мөрдөгч, прокурор, шүүгчийн хууль зөрчсөн ажиллагааны улмаас учирсан эдийн бус хохирлыг Иргэний хуулийн 511 дүгээр зүйлийг төсөөтэй хэрэглэх байдлаар арилгах асуудлыг хөнджээ.

Судлаачдын зүгээс "*УДШ-ийн хэрэг шийдвэрлэсэн тогтоолууд дунд ч эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны улмаас үүссэн сэтгэл санааны хохирлыг Иргэний хуулийн 511 дүгээр зүйлийг төсөөтэй хэрэглэх байдлаар хангасан тохиолдол байхын зэрэгцээ, уг заалтыг төсөөтэй хэрэглэхгүй гэж үзсэн тохиолдлууд байна. УДШ-ээс нэг хуулийн заалтыг хоёр өөр байдлаар тайлбарлаж хэрэглэж буй нь хууль хэрэглээний тогтворгүй байдлыг бий болгож байна*[5]" гэж дүгнэжээ.

- **ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН АШИГЛАЛТААС ҮҮССЭН ГЭМ ХОРЫГ АРИЛГАХ ЗОХИЦУУЛАЛТЫН ТАЛААРХ СУДАЛГАА**[6]

Уг судалгаагаар тээврийн хэрэгслийн ашиглалтаас үүссэн гэм хорыг арилгах иргэний эрх зүйн зохицуулалтыг шүүхийн практикт хэрхэн хэрэглэж байгаа талаар судалжээ.

Энэ хүрээнд автомашиныг фидуцийн гэрээний дагуу өөрийн өмчлөлд шилжүүлэн авсан этгээд нь автомашины эзэмшигч гэж үзэгдэн, тухайн тээврийн хэрэгслийн ашиглалтаас үүдэх гэм хорыг хариуцах эсэх талаар УДШ-ээс ялгаатай шийдвэрлэсэн байдал ажиглагдаж байна.

Хэрэг.01[7]	**Хэрэг.02**[8]
Нэхэмжлэгч Г-гийн нэхэмжлэлтэй хариуцагч "Н" ХХК, А нарт холбогдох, гэм хорын хохиролд 4,18,000 төгрөг гаргуулах тухай	Г, Ж-ийн нэхэмжлэлтэй Хаан банк, И, Б нарт холбогдох 6,126,234 төгрөг гаргуулах тухай иргэний хэрэг.

[4] Н.Норовсамбуу нар "ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ЯВЦАД УЧИРСАН ХОХИРЛЫН НӨХӨН ТӨЛҮҮЛЭЛТ ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ" Нээлттэй нийгэм форум , "Хохирлын үндэсний тогтолцоо" Цуврал 3, 2021 он

[5] Н.Норовсамбуу нар "ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ЯВЦАД УЧИРСАН ХОХИРЛЫН НӨХӨН ТӨЛҮҮЛЭЛТ ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ" Нээлттэй нийгэм форум , "Хохирлын үндэсний тогтолцоо" Цуврал 3, 2021 он, 60 дахь тал

[6] Н.Норовсамбуу нар "ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН АШИГЛАЛТААС ҮҮССЭН ГЭМ ХОРЫГ АРИЛГАХ ЗОХИЦУУЛАЛТЫН ТАЛААРХ СУДАЛГАА", Нээлттэй нийгэм форум , Шүүхийн шийдвэрийн шинжилгээ эмхэтгэл 4, 2020 он

[7] 2019 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр, Дугаар: 001/ ХТ2019/00048 УДШ-ийн тогтоол

[8] 2017 оны 6 дугаар сарын 16-ны өдөр, Дугаар: 001/ ХТ2017/00817 УДШ-ийн тогтоол

нэхэмжлэлтэй иргэний хэрэг.	
2016 оны 05 дугаар сарын 17-ны өдөр Г-ийн эзэмшлийн приус загварын автомашиныг А нь верна загварын тээврийн хэрэгслийг жолоодож яваад Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрмийн 2.7, 8.4, 9.2-т заасныг зөрчиж, зам тээврийн осол гаргасны улмаас Г-д 3,300,000 төгрөгийг хохирол учруулсан. А-нь 2016 оны 1 дүгээр сарын 21-ний өдөр верна загварын автомашиныг барьцаалан “Н” ХХК-иас 1,350,000 төгрөгийн зээл авахдаа зээлийн гэрээ, үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар эд хөрөнгө өмчлөлд шилжүүлэх фидуцийн гэрээ байгуулсан. Зээлийн гэрээний үүрэг бүрэн биелэгдэх хүртэл хугацаанд А-ийн өмчлөлд байгаа автомашиныг “Н” ХХК-ийн өмчлөлд шилжүүлэх гэрээ байгуулж, зээлдэгч буюу А нь автомашинаа унаж ашиглаж байжээ.	Хаан банк ХХК-ийн эзэмшлийн тээврийн хэрэгслийг иргэн И нь Хаан банктай 2014 оны 6 дугаар сарын 4-ний өдөр “Зээлийн гэрээ” болон “Фидуцийн гэрээ” байгуулан худалдан авсан. Уг автомашиныг иргэн Ч жолоодож явахдаа Замын хөдөлгөөний дүрмийн 2.3 дахь заалтыг зөрчсөний улмаас 2015 оны 5 дугаар сарын 10-ны өдөр хашаа, гэрэлтүүлэгч шон, приус маркийн автомашин, Г-ийн гэр бүлийн амьдарч байсан монгол гэр зэргийг мөргөж, улмаар монгол гэрт байсан Г, Ж, О нарыг гэмтээжээ.
УДШ-ийн дүгнэлт: Тээврийн хэрэгслийн онцлогоос хамааран энэхүү эд хөрөнгийн ашиглалтын улмаас бусдад учирсан гэм хорыг өмчлөгч буюу эзэмшигч арилгах үүрэг хүлээдэг нь гэм буруугүйгээр хүлээдэг хариуцлагын төрөл юм. Бусдад гэм хор учруулсан гэм буруутай этгээд буюу тээврийн хэрэгслийн ашиглагч нь өмчлөгчийн ийнхүү бусдын өмнө үүрэг хүлээснээс учирсан хохирлыг арилгах үүргээс чөлөөлөгдөхгүй	**УДШ-ийн дүгнэлт:** Хаан банкны зүгээс Фидуцийн гэрээний 2.4.5 дахь заалтад “... Хөрөнгийг эзэмших, ашиглах явцад бусдын хөрөнгөд учруулсан хохирлыг бүрэн хариуцаж барагдуулна...” гэж заасны дагуу аливаа бусад этгээдүүдэд учруулсан хохирлыг зээлдэгч нар өөрсдөө хариуцахаар тохиролцсон. Иймд иргэн Г, Ж нарын нэхэмжлэлтэй иргэний хэргийн хариуцагч нь Хаан банк биш гэжээ.

болно. Өөрөөр хэлбэл, хариуцагч “Н” ХХК нь өөрт учирсан хохирлыг гэм буруутай этгээдээс шаардах эрхтэй юм.	

Судлаачдын зүгээс “*Хэрэг.02-д осол гарах үед тээврийн хэрэгсэл хэний эзэмшил, ашиглалтад байсныг шалгуур болгон шийдвэр гаргасан нь Иргэний хуулийн 499-р зүйлийн зохицуулалтын зорилгод нийсэн шийдвэр болжээ. Харин өмнөх хэрэг.01-ийн шүүхийн шийдвэрийн адилаар Иргэний хуулийн 499-р зүйлийг тайлбарлавал фидуцийн гэрээний дагуу тээврийн хэрэгслийн өмчлөх эрхийг шилжүүлж авсан байсан хариуцагч ХААН банк нь хохирлыг хамтран хариуцах ёстой гэж дүгнэх боломжтой байв. Энэ нь хэрэг №1(2019-01-10), хэрэг №2(2017-06-16) адилхан Улсын дээд шүүхийн шийдвэр, тэр дундаа хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах ёстой шүүхийн шийдвэр боловч нэг асуудал дээр нэг хуулийн заалтыг өөр өөрөөр тайлбарлан хэрэг шийдэж буйг харуулж байгаа юм. Энэ байдал нь хууль хэрэглээний тогтворгүй байдлыг үүсгэж байна*”[9] гэж дүгнэжээ.

Эдгээр тохиолдлуудаас авч үзвэл тодорхой маргаан шийдвэрлэх явцад УДШ-ийн зүгээс хуулийг ялгаатай хэрэглэх явдал гарч буй юм.

III. Одоо хэрэгжиж буй эрх зүйн орчин хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангаж чадах эсэх

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25-р зүйлийн 25.4 дэх хэсэгт “Улсын дээд шүүх давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг хуульд заасан үндэслэл, журмын дагуу хянан үзэх замаар хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангана” гэж заажээ.

Гэвч энэхүү зорилгыг хэрэгжүүлэхэд зарим зохицуулалт саад болохоор байна. ИХШХШтХ-ийн 176-р зүйлийн 176.1 дэх хэсэгт “Хяналтын журмаар хэргийг Улсын дээд шүүхийн таван шүүгчийн бүрэлдэхүүнтэй хянан хэлэлцэж, энэ хуулийн 114.1-д заасан журмын дагуу шийдвэрээ гаргаж гомдлыг хангасан эсэхийг сонсгоно” гэж заасан нь УДШ-ээс хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах чиг үүргээ хэрэгжүүлэхэд саад болж байна. Өөрөөр хэлбэл, тухайн маргааныг шийдвэрлэхэд танхимын нийт шүүгчдээс аль таван шүүгч нь тухайн хэргийг шийдвэрлэх бүрэлдэхүүнд орохоос хамаараад хууль хэрэглээний ялгаатай байдал бий болж байна. Иймээс танхимын нийт шүүгчийн бүрэлдэхүүнтэй хэрэг маргааныг шийдвэрлэдэг болох хэрэгтэй.

[9] Н.Норовсамбуу нар “ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН АШИГЛАЛТААС ҮҮССЭН ГЭМ ХОРЫГ АРИЛГАХ ЗОХИЦУУЛАЛТЫН ТАЛААРХ СУДАЛГАА”, Нээлттэй нийгэм форум , Шүүхийн шийдвэрийн шинжилгээ эмхэтгэл 4, 2020 он, 95 дахь тал

Цаашлаад хяналтын журмаар гомдол гаргах үндэслэлийг явцуу байдлаар хязгаарлаж хуульчилсан нь хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах УДШ-ийн чиг үүргийг хязгаарлахаар байна. ИХШХШтХ-ийн 172-р зүйлийн 172.2 дахь хэсэгт Хяналтын журмаар дараах үндэслэлээр гомдол гаргана гэж заажээ. Үүнд:

- анхан болон давж заалдах шатны шүүх хуулийг зөрүүтэй хэрэглэсэн;
- хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ноцтой зөрчил гаргасан нь шүүхийн шийдвэрт нөлөөлсөн;
- шүүх хуулийг Улсын дээд шүүхийн албан ёсны тайлбараас өөрөөр тайлбарлаж хэрэглэсэн.

Эдгээр үндэслэл дундаас “анхан болон давж заалдах шатны шүүх хуулийг зөрүүтэй хэрэглэсэн” гэх үндэслэл хэт явцуу болсон гэж үзэж байна. Учир нь шүүхийн практикт анхан болон давж заалдах шатны шүүх аль аль нь хууль буруу хэрэглэсэн тохиолдол түгээмэл байдаг. Гэтэл доод шатны шүүхүүд хууль буруу хэрэглэж байхад УДШ-ийн зүгээс үүнийг хянаж хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангаж боломжгүй байна.

Улмаар ИХШХШТ-ийн 173-р зүйлийн 173.5 дахь хэсэгт “Хяналтын шатны шүүх гомдлыг хүлээн авснаас хойш 21 хоногийн дотор танхимын нийт шүүгчийн хуралдаанаар хэлэлцэж дөрөв, түүнээс дээш шүүгч хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх талаар санал гаргавал энэ тухай тогтоол гаргана”, тус зүйлийн 173.6 дахь хэсэгт “Энэ хуулийн 173.5-д заасны дагуу гомдлыг хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх шийдвэр гаргаагүй бол татгалзсанд тооцож, энэ тухай тогтоол гаргаж, улсын тэмдэгтийн хураамжийг буцаана” гэж тус тус заажээ. Өөрөөр хэлбэл, УДШ-д иргэний хэргийн хяналтын журмаар хянан шийдвэрлэх эсэх нь УДШ-ийн Иргэний танхимын нийт шүүгчийн үзэмжээс хамааралтай болжээ. Энэ зохицуулалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн 50-р зүйлийн 1 дэх хэсгийн 2-т заасан давж заалдах болон хяналтын журмаар доод шатны шүүхийн шийдвэрийг хянан үзэх гэсэн УДШ-ийн бүрэн эрхийг гажуудуулсан байхын үгүйсгэхээргүй байна. Мөн хэргийн оролцогчоос гаргасан хяналтын гомдлыг хүлээн авахаас татгалзсан үндэслэлээ тайлбарлахгүй байхаар хуульчилсан нь мөн анхаарал татаж байна.

IV. Япон улсын хяналтын шатны шүүх иргэний хэрэг хянан шийдвэрлэх тогтолцоо

Хяналтын журмаар гомдол хянан шийдвэрлэх тогтолцоо нь давж заалдах шаттай харьцуулахад хязгаарлагдмал хүрээнд гомдлыг хүлээн авдаг хэдий ч гол зорилго нь хууль бус шүүхийн шийдвэрээр талуудын

ашиг сонирхол хөндөгдөхөөс хамгаалах юм [10] . Түүнчлэн хяналтын журмаар гомдол гаргах үндэслэл нь хууль тогтоомжийн зөрчлөөр л хязгаарлагдахын зэрэгцээ цөөн тооны шүүх хэргийг хяналтын журмаар хэргийг шийдвэрлэдэг учраас хууль тогтоомжийн тайлбар, хэрэглээг орон даяар нэгдмэл болгож, хууль тогтоомжийн тогтвортой байдлыг хангах чиг үүргийг гүйцэтгэдэг[11]. Эндээс харвал талуудын ашиг сонирхлыг хамгаалах нь үндсэн зорилго мөн боловч хууль тогтоомжийн хэрэглээний тогтвортой байдлыг хангах нь бас нэгэн чухал зорилго болох нь харагдаж байна.

ХЯНАЛТЫН ШАТАНД ГОМДОЛ ГАРГАХ ҮНДЭСЛЭЛ

Хяналтын журмаар гомдол гаргахад давж заалдах журмаар гомдол гаргахаас ялгагддаг гол онцлог нь тодорхой үндэслэлээр гомдол гаргаж болдогт байдаг. Түүнчлэн хяналтын шатны шүүх нь шийдвэрийг хууль хэрэглээний талаас нь хянах бөгөөд өмнөх шатны шүүхийн тогтоосон үйл баримтыг хянах чиг үүрэг байдаггүй. Япон Улсын Иргэний процесс хуулийн 321-р зүйлийн 321.1-т “Өмнөх шатны шүүхийн хууль ёсоор тогтоосон үйл баримтад хяналтын шатны шүүх захирагдана” гэж хуульчилснаас үүнийг харж болно.

Япон Улсын Ирэгний процесс хуулийн 312-р зүйлд зааснаар хяналтын шатны шүүх иргэний хэргийг дараах 3-н үндэслэлээр хүлээн авч хянадаг байна.

№	**ХЯНАЛТЫН ШАТНЫ ШҮҮХ**	**ХЯНАЛТЫН ЖУРМААР ИРГЭНИЙ ХЭРЭГ ХҮЛЭЭН АВАХ ҮНДЭСЛЭЛ**		
		Үндсэн хуулийн зөрчил(§312.1)	Абсолют үндэслэл (§312.2)	Шийдвэрт нөлөөлсөн нь тодорхой хуулийн зөрчил (§312.3)
1	Дээд шүүх	Аль аль нь болно.	Аль аль нь болно.	Улсын дээд шүүхэд гомдол гаргах үндэслэл болохгүй.
2	Давж заалдах шүүх			Зөвхөн давж заалдах шүүхэд хяналтын журмаар хандахад болно.

Дээрх хүснэгтээс харвал хяналтын шатны шүүх нь Дээд шүүх байх тохиолдолд зөвхөн Үндсэн хууль зөрчсөн, Абсолют үндэслэл гэсэн хоёр

[10] 新堂幸司『新民事訴訟法』907 頁(弘文堂、第 5 版 3 刷、2013 年)
[11] 同頁

үндэслэлийн аль нэгээр гомдол гаргах боломжтой. Харин хяналтын шатны шүүх нь Давж заалдах шүүх байх тохиолдолд Үндсэн хууль зөрчсөн, Абсолют үндэслэл гэсэн үндэслэлүүдээс гадна шийдвэрт нөлөөлөл үзүүлэх нь тодорхой хууль зөрчсөн үндэслэлээр мөн гомдол гаргаж болохоор байна.

Дээрх 3 үндэслэл шиг хуульд тодорхой заагаагүй ч шүүгч үйл баримтыг өөрийн дотоод итгэл үнэмшлээр тогтоохдоо амьдралын илэрхий туршлагыг зөрчсөн (経験則違反), хэрэг шийдвэрлэх нөхцөл бүрдээгүй байхад хэргийг шийдвэрлэсэн (審理不尽) зэрэг нь хяналтын журмаар гомдол гаргах үндэслэл болно гэсэн шүүхийн практик тогтсон байдаг.

Япон Улсын Иргэний процесс хуулийн 312-р зүйлийн 312.3 дахь хэсэгт “Шүүхийн шийдвэрт нөлөөлөх нь тодорхой хуулийн зөрчил байгаа шалтгаанаар давж заалдах шүүхэд хяналтын журмаар гомдол гаргаж болно” гэж тусгасан. Энэ заалтын эсрэг тайлбарын дагуу Дээд шүүхэд уг үндэслэлээр гомдол гаргах боломжгүй бөгөөд зөвхөн давж заалдах шүүх хяналтын журмаар гомдол хүлээн авах тохиолдолд л үндэслэл болно. Уг заалтад дурдаж буй “хуулийн зөрчил” гэдэгт §312.2-т зааснаас бусад хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн тохиолдлууд, түүнчлэн шүүхийн шийдвэрийн агуулгыг бүрдүүлж буй материаллаг хуулийг буруу хэрэглэсэн зөрчил үүнд хамаарна. Түүнчлэн “шийдвэрт нөлөөлөх нь тодорхой байх” гэдэгт тухайн зөрчил байхгүй байсан бол өөр шийдвэр гарах байсан буюу шийдвэрийн үр дагаварт нөлөөлж байх тохиолдолд л хуулийн зөрчил нь хяналтын журмаар гомдол гаргах үндэслэл болно[12].

ДЭЭД ШҮҮХЭД ХЭРГИЙГ ХЯНАЛТЫН ЖУРМААР ХҮЛЭЭН АВАХ ХҮСЭЛТ ГАРГАХ ТОГТОЛЦОО

Өмнө дурдсанчлан шүүхийн шийдвэрт нөлөөлөх тодорхой хуулийн зөрчил байгаа нь зөвхөн давж заалдах шүүх хэргийг хяналтын журмаар шийдвэрлэх тохиолдолд л гомдол гаргах үндэслэл болох бөгөөд Дээд шүүх хэргийг хяналтын журмаар шийдвэрлэх тохиолдолд уг төрлийн зөрчил нь гомдол гаргах үндэслэл болохгүй. Уг үндэслэлийг Дээд шүүхэд хяналтын журмаар гомдол гаргах үндэслэлээс хасаж буй нь дээд шүүхийн ачааллыг бууруулах зорилготой[13]. Харин үүнтэй дүйцүүлэх байдлаар 1996 онд уг хуульд орсон өөрчлөлтөөр нэгэн шинэ тогтолцоог бий болгожээ. Япон Улсын Иргэний процесс хуулийн 318-р зүйлийн 318.1 дэх хэсэгт “Хяналтын журмаар гомдол гаргах шүүх нь Дээд шүүх байх тохиолдолд өмнөх шатны шүүхийн шийдвэрт Дээд шүүхийн жишиг (Дээд шүүхийн жишиг биш ч давж заалдах шүүхийн тогтоосон жишиг)-тэй зөрчилдөх дүгнэлт байгаа зэрэг бусад хууль тайлбарлахтай холбоотой ач холбогдол

[12]新堂幸司『新民事訴訟法』910 頁(弘文堂、第 5 版 3 刷、2013 年)
[13]和田吉弘『基礎からわかる民事訴訟法』591 頁（商事法務、第 2 版、2012）

бүхий асуудал байна гэж Дээд шүүх үзвэл тухайн хэрэгт талуудаас хүсэлт гаргавал тогтоол гарган хяналтын шатны хувиар хэргийг хүлээн авч болно" гэж зохицуулсан. Уг зохицуулалтаас авч үзвэл хүсэлтийг хүлээн зөвшөөрөх эсэх нь Дээд шүүхийн үзэмжээс шууд хамаарна. Хэрвээ хүсэлтийг хүлээн авах тогтоол гаргавал хяналтын журмаар гомдол гаргасан гэж үзнэ(§318.4). Мөн Дээд шүүх хүсэлтэд дурдсан үндэслэлүүдээс ач холбогдолгүйг нь хасаж болох бөгөөд үлдсэн нь хяналтын журмаар гомдол гаргах үндэслэл гэж үзэгдэнэ(§318.3, §318.4). Гол зорилго нь тодорхой нэг маргааныг шийдвэрлэхийн зэрэгцээ хууль тогтоомжийн тайлбарын нэгдмэл байдал, шүүхийн жишгийн эрх зүй бүрэлдэн бий болоход Дээд шүүх гол үүрэг гүйцэтгэх зорилгоор бий болгосон зохицуулалт юм [14]. Энэ үндсэн хуульд тусгагдсан шүүхээр хамгаалуулах эрхийг зөрчихгүй гэж үздэг бөгөөд хууль тогтоогчийн эрх хэмжээний асуудал юм.

Дээрх үндэслэлүүдээс Үндсэн хуулийг буруу хэрэглэсэн болон процессын ноцтой алдааг орхиод 3 болон 4 дэх үндэслэлүүдийг харьцуулан авч үзье.

№	ХЯНАЛТЫН ШАТНЫ ШҮҮХ	ДАВЖ ЗААЛДАХ ШҮҮХ(§312.3)	ДЭЭД ШҮҮХ(§318.1)
1	Үндэслэл	Шүүхийн шийдвэрт нөлөөлсөн материаллаг болон процессын хуулийн зөрчил	Дээд шүүхийн жишгийг зөрчсөн зэрэг хууль тайлбарлахтай холбоотой зөрчил
2	Талуудын эрх эсэх	Талуудын эрх	Дээд шүүхийн үзэмжээс хамаарна. /Гэхдээ талуудаас хүсэлт гаргасан байх шаардлагатай. /

Япон улсын шүүхийн тогтолцоонд хэргийг 3 шатны шүүхээр хянуулах бололцоог алдагдуулахгүй байхыг зорьж хэргийг шинж чанараар нь ангилан бага үнийн дүнтэй хэрэг бол давж заалдах шүүх хяналтын журмаар хэргийг хянан шийдвэрлэхээр байна.

Дээд шүүх нь хууль тогтоомжийн тайлбар, хэрэглээг орон даяар нэгдмэл байлгах, хууль тогтоомжийн хэрэглээний тогтвортой байдлыг хангах чиг үүргийг гүйцэтгэх боломжийг иргэний процесс хуулийн зохицуулалтуудаар хангахыг зорьсон байна. Үүнд:

- өмнө дурдсанчлан Үндсэн хуулийг буруу хэрэглэсэн, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ноцтой алдаанаас бусад хяналтын

[14]新堂幸司『新民事訴訟法』905 頁(弘文堂、第 5 版 3 刷、2013 年)

журмаар гомдол гаргах үндэслэлийг өөрийн үзэмжээр хүлээн авах эсэхээ шийддэг.

- өмнө нь тогтсон шүүхийн жишиг зөрчигдвөл Дээд шүүхэд хяналтын журмаар гомдол гаргах болдог.

V. Дүгнэлт

УДШ нь Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргах буюу хийсвэр байдлаар хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах эрх зүйн орчин байгаа боловч тодорхой хэрэг, маргааныг шийдвэрлэхэд хууль хэрэглээний нэгдмэл байдал хангах зарчмыг хэрэгжүүлж буй эсэх нь эргэлзээтэй байна.

Мөн тодорхой хэрэг, маргааныг шийдвэрлэхэд хууль хэрэглээний нэгдмэл байдал хангах зарчмыг хэрэгжүүлэх эрх зүйн орчин бүрдээгүй байна.

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

1. Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.1 дэх заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай, МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ТОГТООЛ, 2015 оны 10 дугаар сарын 30-ны өдөр, Дугаар 07, Улаанбаатар хот
2. Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.1 дэх заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай, МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ, 2015 оны 3 дугаар сарын 11-ний өдөр, Дугаар 03, Улаанбаатар хот
3. Л.Анхбаяр нар “ЗӨӨЛИЙН ГЭРЭЭГ ЦУЦАЛСНААС ХОЙШ ХҮҮ ШААРДСАН МАРГААНЫ ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ШИНЖИЛГЭЭ”, Нээлттэй нийгэм форум, “Шүүхийн шийдвэрийн судалгаа”, Цуврал.01, 2021 он https://forum.mn/res_mat/2021/Court%20Report_Series01.pdf
4. Н.Норовсамбуу нар “ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ЯВЦАД УЧИРСАН ХОХИРЛЫН НӨХӨН ТӨЛҮҮЛЭЛТ ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ” Нээлттэй нийгэм форум , “Хохирлын үндэсний тогтолцоо” Цуврал 3, 2021 он https://forum.mn/res_mat/2021/03-Basic%20Report_Victim%20For%20WEB.pdf
5. Н.Норовсамбуу нар “ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН АШИГЛАЛТААС ҮҮССЭН ГЭМ ХОРЫГ АРИЛГАХ ЗОХИЦУУЛАЛТЫН ТАЛААРХ СУДАЛГАА”, Нээлттэй нийгэм форум , Шүүхийн шийдвэрийн шинжилгээ эмхэтгэл 4, 2020 он

https://forum.mn/res_mat/2021/Shuuhiin%20shiidveriin%20shinjilgee%204.pdf

6. 藤田広美『講義民事訴訟法』(東京大学出版会、第 2 版、2011 年)
7. 和田吉弘『基礎からわかる民事訴訟法』（商事法務、第 2 版、2012 年）
8. 新堂幸司『新民事訴訟法』(弘文堂、第 5 版 3 刷、2013 年)
9. http://www.courts.go.jp/
10. Япон улсын иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх хууль.,1996 он
11. Юпп Ёхоахимски “Монгол улсын иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн тайлбар” Мюнхен хот, 2004 он
12. А.Дугармаа нар “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй” Гарын авлага, Уб хот, 2007 он
13. Д.Хуяг “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүйн үндсэн болон тулгамдсан асуудлууд”., Уб хот, 2013 он
14. Улсын дээд шүүх “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дэлгэрэнгүй тайлбар”.,Уб хот, 3 дахь хэвлэл, 2014 он
15. З.Мөнхжаргал “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй-тусгай анги”., Уб хот, 2014 он
16. Йоахим Кают “Монгол улсын иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй” Анхны хэвлэл, Уб хот, 2015 он

ХҮҮХДИЙН ЭД ХӨРӨНГИЙН ЭРХ
PROPERTY RIGHTS OF CHILDREN

О.Отгонтуяа
Дотоод хэргийн их сургуулийн Эрх зүй, нийгмийн ухааны сургуулийн Хувийн эрх зүйн тэнхимийн ахлах багш, цагдаагийн хошууч
Otgontuya.O
Senior Lecturer of Department of private law,
of Law and Social Science Institute,
University of Internal Affairs, Police Major

Хураангуй:
Гэр бүл дэх хүүхдийн эд хөрөнгийн эрх зүйн зохицуулалтын онцлогийг танин мэдсэнээр дүн шинжилгээ хийх, гадаадын зарим орны эрх зүйн зохицуулалтыг судалснаар дүгнэлт санал гаргахад оршино.

Abstract:
An analysis will be made by recognizing the specifics of the regulation of children's property in the family, and conclusions will be made by studying the legal regulations of some foreign countries.

Түлхүүр үгс: *Гэр бүл, хүүхэд, хүүхдийн эд хөрөнгө.*
Key words: *Family, children, children's property rights.*

Оршил:

Гэр бүлийн гишүүдийн эрх, эрх чөлөөг дээдлэх, хүндэтгэх, зөрчихгүй байхад улс орон бүр анхаарлаа хандуулж, тухайн асуудалд хандах хандлага, шийдэл нь түүхэн цаг үеийн улс төр, эдийн засаг, нийгмийн хөгжлийн түвшингээс үл хамаарч харилцан адилгүй зохицуулан, тэдгээрийн эрх, үүргийн харьцаа, шударга ёсны талаарх мэдлэг, туршлагыг хуримтлуулан тасралтгүй хөгжиж ирснийг онцлох нь зүйтэй.

Хүүхэд гэр бүлийн харилцааны оролцогчийн хувьд, гэр бүлийн нэг гишүүний хувьд гэр бүлийн хөрөнгийн эрхийн харилцааны онцгой субьект билээ.

Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 16 дугаар зүйлийн 16.3-т “нийгмийн жам ёсны үндсэн нэгж мөн бөгөөд нийгэм, төрөөр хамгаалуулах эрхтэй”[1] гэж гэр бүл, хүүхдийн эрх, ашиг сонирхлыг ханган хамгаалах талаар улс орнуудын төр, засгийн газрын хүлээх олон улсын үүргийг, харин Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.11-д “Гэр бүл,

[1] Олон улсын гэрээ хэлэлцээрүүд, Уб., 2001

эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална", мөн хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-д "Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна"[2] гэж тус хуульчилсан.

Гэр бүл дэх хүүхдийн хөрөнгийн эрх, түүнийг хэрэгжүүлэхэд эцэг эх, хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн оролцоо, хязгаар, энэ талаар гарсан зөрчилд хяналт тавих, шийдвэрлэх төрийн хяналт байхгүй байна. Хүүхэд оюуны үнэт зүйл бүтээх, өөрт ногдох эд хөрөнгийг өмчлөх, өвлөх эрхтэй болохыг хууль зүйн хүрээнд тодорхойлон зохицуулсан ч практик амьдрал дээр хүүхдийн өмчлөх эрх, тухайлан гэр бүл дэх хуваарьт хөрөнгийн эрх нь зөрчигдөх явдал гэр бүлийн хүрээнд түгээмэл шинжтэй байсаар байна.

Үндсэн хэсэг:

Гэр бүл дэх хүүхдийг эд хөрөнгийн эрхийг дараах хүрээнд судлан илтгэлээ бичлээ. Үүнд:

1. Гэр бүл дэх хүүхдийн эд хөрөнгийн эрхийн үзэл баримтлал
2. Гэр бүл дэх хүүхдийн эд хөрөнгийн эрх зүйн зохицуулалтын уламжлал
3. Гэр бүл дэх хүүхдийн эд хөрөнгийн эрхийн Герман, Швед, Финланд улсын зохицуулалт

Гэр бүл дэх хүүхдийн эд хөрөнгийн эрхийн үзэл баримтлал

Гэр бүл нь гэрлэгчид, тэдэнтэй хамт амьдарч байгаа төрсөн, дагавар, үрчилж авсан хүүхэд болон төрөл, садангийн хүмүүс[3]-ээс бүрдэх ба эдгээр гишүүд эрх зүйн чадамжийн хувьд харилцан адилгүй янз бүр байх боловч тэдний хамтын амьдралын гол мөн чанар нь эд хөрөнгийн бус болон эд хөрөнгийн эрх, үүргээрээ өөр хоорондоо холбогдсон хамтын амьдралтай байхад оршино.

Гэр бүл дэх хүүхдийн эд хөрөнгийн эрх, хуваарьт хөрөнгө, түүний эрх зүйн зохицуулалтын харилцааг зохицуулж буй эрх зүйн хэм хэмжээнүүдийг гэр бүлийн болон иргэний эрх зүйн "салбар дундын институт" гэж тодорхойлж болно. Энэ учир нь Монгол улсын Гэр бүлийн тухай хуулийн зорилт нь "... гэр бүлийн гишүүдийн эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус харилцааг зохицуулна"[4] гэж гэр бүлийн эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулах харилцааны нэг төрөл нь гэр бүлийн гишүүдийн эд хөрөнгийн харилцаа мөн боловч уг хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Гэр бүлийн эд хөрөнгийн харилцааг Иргэний хуулиар зохицуулна" гэж заасан

[2] Монгол Улсын Үндсэн хууль // Төрийн мэдээлэл. 1992. №1.
[3] Монгол улсын Гэр бүлийн тухай хууль // Төрийн мэдээлэл.1999.№30. 3 дугаар зүйлийн 3.1.4 дэх заалт
[4] Монгол улсын Гэр бүлийн тухай хууль // Төрийн мэдээлэл.1999.№30. 1 дүгээр зүйл

нь нэг талаас гэр бүлийн хуулиар нөгөө талаас иргэний эрх зүйн хэм хэмжээгээр “давхар” зохицуулагдах онцлогтой салбар дундын институт гэж тодорхойлж болно.

Хүүхдийн эрхийн тухай конвенц, Хүүхдийн эрхийн тухай хуульд зааснаар 18 насанд хүрээгүй этгээдийн хүүхэд гэх бөгөөд уг этгээд нь Иргэний хуульд заасан чадвартай ч, эрхийн чадамжийн хувьд ялгаатай.

Хүүхдийн насны байдлыг харгалзан

- Иргэний эрх зүйн бүрэн бус чадамж /14-өөс 18 хүртэлх нас/
- Иргэний эрх зүйн зарим чадамж /7-оос14 хүртэлх нас/

Иргэний эрх зүйн чадамжгүй /0-оос 7 хүртэлх нас/ гэж ангилна. Эдгээр чадамжаас хамаарч хүүхэд эд хөрөнгийг эрхээ бие даан болон хууль ёсны төлөөлөгчөөр дамжуулж хэрэгжүүлнэ.

Хүүхэд гэр бүлийн хөрөнгийн эрхийн эрх зүйн харилцаанд гэр бүлийн гишүүдийн хамтран өмчлөх дундын өмчийн харилцааны оролцогч байхаас гадна, хуваарьт хөрөнгө эзэмшиж, ашиглаж захиран зарцуулах эрх бүхий бие даасан оролцогч болно.

Хүүхэд гэр бүлийн эд хөрөнгийн эрхтэй байх нь хүний хувьд зайлшгүй байх жам ёсны нөхцөл хүчин зүйл

- Өсөн торних, хөгжих амьдралын хэрэгцээгээ хангах эдийн засгийн шаардлага
- Гэр бүлийн бусад гишүүдийн үйл хэрэг, эд хөрөнгө, баялаг өвлөн авч үлдэх шаардлага
- Хүүхдийн хөдөлмөрөөр болон бусад хэлбэрээр буй болсон орлогыг өмчлөх захиран зарцуулах Монгол Улсын хуулиар олгогдсон боломж, баталгаануудтай холбоотой.

Гэр бүл дэх хүүхдийн хөрөнгийн эрх нь өмчлөх эрхээр дамжин хэрэгжинэ. Гэр бүл дэх хүүхдийн хуваарьт хөрөнгөнд:

- Өв, бэлэглэлийн журмаар шилжүүлэн авсан эд хөрөнгө, мөнгөн хуримтлал, эд хөрөнгө, эд хөрөнгийн эрх, тэдгээрийг худалдсан арилжсаны үр дүнд олж авсан эд хөрөнгө, мөнгө
- Амин хувийн хэрэгцээг хангахад зориулсан эд хөрөнгө
- Оюуны үнэт зүйлийн үнэ буюу зохиогчийн эрхийн шагнал
- Хувийн авъяас чадвар, ололт амжилтыг сайшаан шагнасны орлого хамаарна.

Жишээ нь, 2012 оны 04 сарын 11-нээс өмнө төрсөн бүх хүүхэд “Эрдэнэс таван толгой” ХК-ны хувьцааны 20 хүртэлх хувь буюу 1072 хувьцааг эзэмших эрхтэй ба энэ нь хүүхдийн хуваарьт хөрөнгө болно. 2019 оны УИХ-ын 96 дугаар тогтоолоор Нийгмийн халамжийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.5[5]–д заасан хүүхдийн мөнгөн тэтгэмжийг

[5] Нийгмийн халамжийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.5. хүүхдийн мөнгөн тэтгэмж

0-18 насны, хүүхдийн мөнгөн тэтгэмж авах хүсэлт гаргасан хүүхэд бүрт сар тутамд бэлэн мөнгөөр олгож байхаар шийдвэрлэсэн мөнгөн тэтгэмж бол хүүхдийн хуваарьт хөрөнгөд хамаарна.

Гэр бүл дэх хүүхдийн эд хөрөнгийн эрх зүйн зохицуулалтын уламжлал:

Гэр бүл дэх хүүхдийн эп хөрөнгийн эрх зүйн зохицуулалтыг Иргэний хуулийн хүрээнд, Гэр бүлийн тухай хуулийн хүрээнд, Хүүхдийн эрхийн хууль тогтоомжийн хүрээнд гэсэн чиглэлээр судлалаа.

Бие даасан анхны Иргэний хууль батлагдсан үеэс эхлэн одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулиудыг судлан авч үзлээ. Үүнд:

1926 оны БНМАУ-ын иргэний хууль[6] нь Монгол Улсын иргэний эрх зүйн салбарын анхны төрөлжсөн хууль бөгөөд тус хуулийн хорин есдүгээр зүйлд аливаа өв хөрөнгийг хууль ёсоор буюу гэрээслэснээр эдлүүлэх, шилжүүлэх явдлыг гагц дор заасан зүйлүүдийг журамлан дагаж гүйцэтгэвээс зохино. Аливаа наснаас нөгчсөн хүний үлдээсэн өв хөрөнгийг шууд залгамжлан эдлэх эрхтэй хүмүүс нь: Наснаас нөгчсөн хүний төрсөн буюу үрчилсэн хүүхэд, Наснаас нөгчсөн хүний эмээс түүний амьд бүхий цаг дор олдсон бөгөөд хожим төрсөн хүүхэд ... гэжээ. Мөн гучин гуравдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Ийнхүү гэрээслэхдээ наснаас нөгчих цаг үеэс дор 18 насан дор хүрээгүй хүүхэд ба жирэмсэн буюу амьдрах чадваргүй болсон хүн дор өв хөрөнгө олгохгүйгээр гэрээсэлж үл болно” гэж заасан байна. Энэ нь хүүхдийн хуваарьт хөрөнгийн эрхийн талаар тус хуулиар зохицуулж байсныг илэрхийлж байна.

1952 оны Иргэний хуульд эрхийн субьект “... 15 нас бол гагцхүү өөрийн эцэг эх буюу асрамжлан тэтгэх хүмүүсийнхээ зөвшөөрөлтэйгээр хэлэлцээнүүдийг хийж болно. Тэд нар бол өөрийн цалин хэрэглэлээ бие даан зарцуулах эрхтэй ба өөрийн ажиллагаагаар бусдад учруулсан хохирлын хариуцлагыг хүлээх болно” гэж 15 нас хүрсэн хүүхэд хуульд нэрлэн заасан хуваарьт хөрөнгөө гэр бүлийн бусад гишүүдээс үл хамааран өөрийн үзэмжээр захиран зарцуулах эрхийг нь хүлээн зөвшөөрсөн зохицуулалтууд хуульчлагджээ.

Мөн хуулийн 300 дугаар зүйлд “хуулиар буюу гэрээсээр өв залгамжлагчдад гагцхүү дор дурдсан хүмүүс байна. Үүнд: 1. нас нөхцөгчийн хань нөхөр, төрсөн ба үрчилсэн хүүхэд, мөн өв залгамжлуулагчийн амьд байх цагт олдоод нас барсны хойно төрсөн хүүхэд, ... “306 дугаар зүйлд “Гэрээслэгч нас барахын үед 18 нас хүрээгүй буюу нас барахыг хүртэл түүний бүрэн тэтгэмжийн дор байсан хөдөлмөрийн чадваргүй бөгөөд хөрөнгө үгүй хүнд хууль ёсоор өв

[6] Сүхбаатар.З, Батбаяр.Б нар Монгол Улсын Иргэний хууль тогтоомж, түүхэн эмхэтгэл, Уб., 2012. 56 дахь тал

залгамжлах эрхийг хасах буюу мөн түүнд ноогдвол зохих хувийг хасах эрхгүй болно" гэж хүүхдийн хуваарьт хөрөнгийн эрхтэй холбоотой зохицуулалтыг хуульчилсан.

1963 оны Иргэний хуульд иргэний эрх зүйн чадамжийг бага нас буюу 15 хүртэлх нас, 15-аас 18 хүртэлх нас, 18 наснаас дээш гэж ангилаад 15-аас 18 насанд хүрээгүй этгээд нь "хиймэгц биелэх, уул этгээдэд хор хүргэхгүй, ахуй, амьдралын чанартай жижиг хэлцэл хийх, бие дааж хөдөлмөрийн хөлс авч байгаа бол түүнийгээ эзэмшин зарцуулах эрхтэй", хуулийн 72 дугаар зүйл: Иргэдийн амины өмчид тэдгээрийн материалын ба соёлын хэрэгцээнд зориулагдсан эд хөрөнгө байж болно. Иргэн бүхэн аминыхаа өмчид хөдөлмөрийн орлого, хуримтлал, орон сууц, мал, амины туслах аж ахуй, хэрэгцээний зүйл, гэрийн эд хогшилтэй байж болно, 375 дугаар зүйл. Өв залгамжлах үндэслэл. "Хууль ёсоор ба гэрээслэлээр өв залгамжлагчид нь гагцхүү өвлүүлэгчийн нас барах үед амьд байсан этгээд, мөн түүний амьд байхад олдоод нас барсны дараа төрсөн хүүхэд байж болно"гэж хүүхдийн хуваарьт хөрөнгийн эрхийг тус тус хүлээн зөвшөөрсөн байна[7].

1994 оны Монгол Улсын Иргэний хуулийн хүрээнд хуулиар гэр бүл дэх хүүхдийн хуваарьт хөрөнгийн эрхийн эрх зүйн харилцааг зохицуулах "гэр бүлийн эд хөрөнгийг дундаа хамтран өмчлөх, гэрлэгчдийн хуваарьт хөрөнгө, гэр бүлийн гишүүдийн дундаа хамтран өмчлөх эд хөрөнгө, түүнээс гишүүнд ногдох хэсгийг тодорхойлох, өв залгамжлалтай холбоотой хэм хэмжээг хуульчилсан байна.

1951 оны "БНМАУ-ын гэрлэх ба гэр бүл, асрамж, тэтгэмжийн тухай хууль" хүчин төгөлдөр үйлчилж эхлэх хүртэл буюу 1926-аас 1952 оны хоорондох 26 жилийн туршид манай улсын хувьд гэрлэлт, гэр бүлийн эрх зүйн харилцаагаа иргэний хуулиар зохицуулж байсан уламжлалтай юм. 1956 оны "БНМАУ-ын гэрлэх ба гэр бүл, асрамж, тэтгэмжийн тухай хууль"-иар гэр бүлийн харилцааг эрх зүйн хувьд төрөлжүүлэн зохицуулах төрөлжсөн хуулийн анхны эхлэл тавигдсан.

1973 оны Гэр бүлийн тухай хууль социалист гэр бүлийн эрх зүйн харилцааг зохицуулсан бие даасан хууль байсан бөгөөд 5 хэсэг 13 бүлэг, 113 зүйлтэй. Хуулийн 2 дугаар зүйлд "БНМАУ-ын гэр бүлийн хуулиар гэрлэх, гэрлэснээ цуцлуулахтай холбогдсон харилцаа, гэрлэгсэд, эцэг, эх, хүүхэд, гэр бүлийн бусад гишүүний хоорондох амины болон эд хөрөнгийн харилцааг зохицуулна. Түүнчлэн хүүхэд үрчлүүлэх, үрчлэн авах, мөн иргэдийг асран хамгаалах, харгалзан дэмжихтэй холбогдсон харилцаа, иргэний гэр бүлийн байдал бүртгэхээс үүсэх харилцааг нэгэн адил

[7] Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхтгэл, V боть, Уб., 2010, 245-272 дахь тал

зохицуулна” гэсэн нь гэр бүлийн гишүүдийн эд хөрөнгийн эрх, үүрэгтэй холбоотой эрх зүйн харилцааг оруулсан байна[8].

Мөн хуулийн 16 дугаар зүйлд Гэрлэгсдийн хамтран өмчлөх дундын өмчийг “Гэрлэснээс хойш аж төрөх хугацаанд бий болгосон эд хөрөнгө, мөнгөн хуримтлал, амины туслах аж ахуй нь гэрлэгсдийн хамтран өмчлөх дундын өмч болно. Нөхөр буюу эхнэрийн хэний нь хөдөлмөрөөр бий болсон, хэн нь эдлэх явдал уг эд хөрөнгийг гэрлэгсдийн хамтран өмчлөх дундын өмч байлгахад саад болохгүй. Энэ хуулийн 18 дугаар зүйлийн 3 дахь ангид заасан зүйл үүнд хамаарахгүй. Гэрлэсний дараа аль нэгнийхээ хуваарьт эд хөрөнгийг чанаржуулан үнэ нь үлэмж нэмэгдсэн бол гэрлэгсдийн хамтран өмчлөх дундын өмч болгон тогтоож болно. Тус бүрийн хуваарьт эд хөрөнгөө бүхэлд нь, эсхүл хэсгийг хамтран өмчлөх дундын өмчид нийлүүлэхээр гэрлэгсэд харилцан тохиролцох эрхтэй“ гэж хуульчилсан байна.

1999 оны Гэр бүлийн тухай хуулийн[9] тэжээн тэтгэх, тэтгүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулж байгаа 38 дугаар зүйлд “хүүхдийн тэтгэлэгийг зөвхөн хүүхдийн хэрэгцээнд зарцуулах, хүүхдийн хэрэгцээнд зарцуулагдаагүй нь тогтоогдсон бол тэтгэлэгийг зориулалтын дагуу зарцуулах асуудлаар тэтгэлэг төлөгч шүүхэд нэхэмжлэл гаргах зэрэг эрх зүйн хамгаалалтын арга замыг хуульчилсан. Хүүхдэд олгож байгаа тэтгэвэр, тэтгэмж бол тухайн хүүхдийн хуваарьт хөрөнгөд хамаарна.

1996 оны Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль бол манай улсын хувьд хүүхдийн эрх, түүнийг хууль зүйн хувьд хамгаалах бие даасан анхны хууль байсан бөгөөд тус хуулийн 5 дугаар зүйлд хүүхдийн амьдрах эрхийн бүрэлдэхүүнд “хүүхэд тэтгэвэр, тэтгэмж хүртэх эрхтэй, 8 дугаар зүйлд нийгмийн амьдралд оролцох эрхийн хүрээнд “хүүхэд өөрийн бүтээсэн оюуны үнэт зүйлийг өмчлөх, хуульд заасан үндэслэл, журмын дагуу өөрт ногдох эд хөрөнгийг өмчлөх, өвлөх эрхтэй” гэж хүүхэд өөрийн бүтээсэн оюуны үнэт зүйлийг өмчлөх, өөрт ногдох эд хөрөнгийг өмчлөх өвлөх эрхтэйг хуульчилсан байна.

Эрх зүйн шинэтгэл, хүүхийн эрх, хамгааллын хүртээмжтэй механизмыг бүрдүүлэх зорилгоор 2016 онд Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай хуулиудыг шинээр болон шинэчилэн баталж хэрэгжүүлэн ажиллаж байна.

Хүүхдийн эрхийн тухай хуулиар “хүүхэд өөрийн бүтээсэн зохиогчийн эрх, шинэ бүтээл, оновчтой саналыг хууль тогтоомжид заасны дагуу өмчлөх, түүний үр шимийг хүртэх, хуульд заасан үндэслэл, журмын

[8] Монгол улсын хуулиуд, 1981
[9] Монгол улсын Гэр бүлийн тухай хууль // Төрийн мэдээлэл.1999.№30

дагуу өөрт ногдох эд хөрөнгийг өмчлөх, өвлөх, ажил, үйлчилгээний хөлс урамшуулал авах эрхтэй ” гэжээ.

Хүүхэд хамгааллын тухай хуулийн дагуу гэр бүл, боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээ, хэвлэл мэдээлэл, цахим орчин, олон нийтийн арга хэмжээ, үйлчилгээ гээд нийгмийн бүхий л орчинд хүүхэд бүрийг үл хайхрах байдал, дарамт, хүчирхийлэл, мөлжлөгийн бүх хэлбэр, эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хариу үйлчилгээ үзүүлэх зорилготой олон талт, цогц, мэргэшсэн үйл ажиллагааг хүүхэд хамгаалал гэнэ. Энэ хуулиар эцэг эх, гэр бүлийн гишүүд, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь хүүхэдтэй холбоотой эрх, үүргээ урвуулан ашиглах, хүүхдийг үл хайхрах, дарамт, хүчирхийлэл, мөлжлөгийн бүх хэлбэр, аливаа гэмт хэрэг, зөрчлөөс хамгаалах арга хэмжээ авна хэмээн гэр бүлийн хүрээнд хүүхэд хамгааллыг тодорхойлсон нь гэр бүл дэх хүүхдийн хөрөнгийн эрх, хуваарьт хөрөнгийн эрхийг хэрэгжүүлэх, хамгаалахад баримтлах үүрэг гэж үзэж байна.

Бусад хууль тогтоомж болох Нийгмийн халамжийн тухай, Эрүүгийн хууль, Зөрчлийн хууль зэрэг хуулиудад хүүхдийн эд хөрөнгийн эрхийн зохицуулж хамгаалсан нь сайшаалтай байна. Тухайлбал, 2012 оны Нийгмийн халамжийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.5-д нийгмийн халамжийн нэг төрөл нь “хүүхдийн мөнгөн тэтгэмж” гэж хуульчлан уг тэтгэмжийг олгох журмыг Засгийн газар батална гэжээ. Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 185 дугаар тогтоолоор баталсан “Хүүхдийн мөнгөн тэтгэмж олгох журам”-д уг тэтгэмжийн мөнгийг олгох харилцааг зохицуулсан болохоос уг тэтгэмжийн зориулалт, хүүхэд энэ тэтгэмжийн талаар эдлэх эрх, тэтгэмжийг зориулалтын дагуу зарцуулаагүй тохиолдолд хүлээлгэх хариуцлагын талаар тухайлсан зохицуулалт тусгагдаагүй байна.

2017 оны Эрүүгийн хуулийн 11.7 дугаар зүйлийн 1.3-д гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг байнга ... хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдсан бол зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр хуульчилсан байна.

Зөрчлийн тухай хуульд хүүхдийн эрхийг зөрчих[10], бусдын эд хөрөнгийг хууль бусаар устгах, гэмтээх[11], гэр бүлийн хамаарал бүхий хүний хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдсан[12] зэрэг зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд

[10] Зөрчлийн тухай хуулийн 6.20 дугаар зүйл Хүүхдийн эрхийг зөрчих
[11] Зөрчлийн тухай хуулийн 8.8 дугаар зүйл Эд хөрөнгө устгах, гэмтээх
[12] Зөрчлийн тухай хуулийн 5.4 дүгээр зүйл Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих

зөрчлийн хариуцлага хүлээлгэхээр заасан байна. Түүнчилэн, 6.20 дугаар зүйлийн 2.2-д “хууль тогтоомжид заасны дагуу өмчлөх, өв залгамжлах, эсхүл ажил үйлчилгээний хөлс, урамшуулал авах эрхийг хязгаарласан; 2.3-д ... хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно” гэжээ. Мөн хүүхдийн хуваарьт хөрөнгөд хамаарах хүүхдийн тэтгэмжийг гурван сараас дээш хугацаанд төлөөгүй нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл албадан сургалтад хамруулж долоогоос гуч хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулахаар хуульчилжээ. Гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол албадан сургалтад хамруулж долоогоос гуч хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулна гэж тус тус хуульчилан тогтоосон билээ.

Гэр бүл дэх хүүхдийн эд хөрөнгийн эрхийн талаарх зарим орны зохицуулалт:

Холбооны Бүгд Найрамдах Герман Улс /ХБНГУ/: Тус улсад иргэний эрх зүйн харилцаа, гэр бүлийн эрх зүйн харилцааг 1900 оны Иргэний багц хуулиар зохицуулж байна. Энэхүү хууль нь ерөнхий анги, үүргийн эрх зүй, эд хөрөнгийн эрх, гэр бүлийн эрх зүй, өв залгамжлалын харилцааг зохицуулж буй 5 дэвтрээс бүрдэнэ[13].

ХБНГУ-ын иргэний болон гэр бүлийн хуулийн дагуу эцэг, эх нь хүүхдийн хөрөнгийг харж хамгаалах үүрэгтэй болохын хувьд хүүхдийн хөрөнгөөс олсон орлогыг зөвхөн хүүхдийн хэрэгцээнд л зарцуулахаас хуульчилсан. Хүүхдийн нэрийн өмнөөс хийгдэх онцгой чухал худалдаа, хэлцлийг гэр бүлийн шүүхийн зөвшөөрөлтэй хийнэ.

Иргэний хуулийн 4 дүгээр дэвтрийн 2 дахь хэсгийн 1526 дахь зүйлд “хүүхдийн хувийн ба өмчийн эрх зөрчигдөн, хүүхэд бие бялдар сэтгэл, санаа, сэтгэцийн хувьд аюултай байдалд орвол Гэр бүлийн шүүх хүүхдийн эрх, аюулгүй байдлыг хамгаалах бүх шаардлагатай арга хэмжээг авах үүрэгтэй. Эцсийн арга хэмжээ нь эцэг, эх байх эрхийг нь хэсэгчлэн болон бүрэн хасах шийдвэр юм. Эцэг, эх асран хамгаалах эрхээ хэтрүүлсэн, хүүхдийнхээ өмнө хүлээсэн үүргээ биелүүлээгүй, хариуцлагатай эцэг, эх байх чадваргүй тохиолдолд эцэг, эх байх эрхийг нь хасна” гэжээ.

Шведийн Вант Улс: Тус улсын Гэр бүлийн дундын хөрөнгийг өвлөх, өмчлүүлэх харилцааг 1987 оны Гэр бүлийн тухай хууль, “Гэр бүл салалтын тухай хууль”, “Гэрлэлтийн тухай хууль”, “Иргэний хууль”, “Хүүхэд ба эцэг эхийн тухай хууль”-аар зохицуулдаг байна.

[13] Герман улсын Иргэний хууль, 2017, 1363-1517 дугаар зүйл

Шведийн Гэр бүл цуцлах тухай хууль[14] нь гэрлэлтийг цуцлах, хүүхдийн тэтгэмж ба эд хөрөнгийг хуваах зэрэг асуудлуудыг шийдвэрлэдэг. Шведэд гэр бүл цуцлах үед дундын эд хөрөнгийг хувиарлахдаа хүүхдэд ямар нэгэн байдлаар хувь хэмжээ оногдуулах тухай заалт байхгүй бөгөөд харин гэрлэлтээ цуцлуулж буй эхнэр нөхөр нь дундын эд хөрөнгөө шүүхийн дагуу хуваан авах эрхтэй байдаг байна. Гэр бүл цуцлуулах үед дундаасаа хүүхэдтэй бол хүүхдийн амьдрах таатай орчин, боловсролын асуудал, сэтгэл санааны болон аюулгүй байдлын талаарх бүхий л асуудлыг хүүхдэд таатай байдлаар бүрэн шийдвэрлэхийг шаардахаас гадна хүүхдийн амьжиргааны зардалд зориулсан тэтгэмжийг эцэг эхийн хэн нэгнээс гаргуулдаг.

Өв залгамжлалын харилцааг 1937 оны хуулиар зохицуулж байна[15]. Энэ хуулийн дагуу эцэг эх нь нас барсан тохиолдолд хүүхэд эд хөрөнгийг гэрээслэлээр болон хуулиар өв залгамжлах эрхтэй байдаг. Тухайлбал, Гэр бүлийн тухай хуулинд “Хэрвээ нас эцэслэсэн хүн гэрлэсэн бөгөөд гэр бүлийн дундын өмчлөлийн хөрөнгө бүхий бол нас барсан хүний эд хөрөнгийг хуваан хуваарилахын өмнө эхлээд заавал гэр бүлийн дундын хөрөнгийг хуваах ёстой. Энэ нь нас барсан хүн хамтран амьдрагч байсан тохиолдолд мөн адил үйлчлэх ба, амьд үлдсэн хамтран амьдрагч нь эд хөрөнгө хуваах хүсэлтийг гаргана. Хэрвээ талийгаач гэрлээгүй хүн байсан бол шууд өв залгамжлагчид нь (хүүхдүүд, ач хүүхдүүд гэх мэт) түүний хөрөнгийг өвлөн авах үндсэн эрхтэй. Эдгээр нь нэгдүгээр өвлөн авах ангид хамаардаг. Хамгийн эхний ээлжинд хүүхдүүд нь өвлөн авна. Хэрвээ талийгаачийн аль нэг хүүхэд түүнээс өөрөөс нь өмнө нас барсан бол (эсвэл өв залгамжилахаас татгалзвал) түүний хүүхдүүдэд нь эрхийг нь шилжүүлнэ.

Шведэд хүүхэд өөрийн эцгээс хөрөнгө өвлөн авах эрхтэй.1970 оны 01 сарын 01-нээс хойш эцэг эх нь албан ёсоор гэрлээгүй байсан ч хүүхэд эцэг, эхийн аль алинаас эд хөрөнгө өвлөн авах тэгш эрхтэй болсон. Урьд өмнө нь зөвхөн хэрвээ эцэг нь эхтэй нь гэрлэсэн бол хүүхэд эцгээсээ эд хөрөнгө өвлөх эрхтэй байв. Зарим тохиолдолд хэрвээ эцэг, эх нь хоорондоо гэрлэхээр сүй тавьсан байсан эсвэл хэрвээ эцэг эд хөрөнгөө өвлүүлэх гэрээслэл үлдээсэн бол гэх зэрэг нөхцөлүүдийг харгалзан үздэг байсан.

1970 оноос өмнө төрсөн бөгөөд эцэг эх нь хоорондоо гэрлээгүй хүүхдэд хөрөнгө өвлөх тухай асуудал үүсэхэд эцэг нь нас барахаас өмнө хүүхдийн тухай тэмдэглэл хотын иргэний бүртгэлийн газар дахь хувийн бичиг баримтад нь орсон, эсвэл хүн амын тоололгын бүртгэлд хүүхэд

[14] Гэрлэлт, гэр бүл цуцлах тухай хууль. http://en.wikipedia.org/wiki/Divorce_law_in_Sweden 12http://www.government.se/content/1/c6/13/83/44/12624b3b.pdf
[15] http://docplayer.ru/48729404-Zakon-shvecii-opublikovan-5-marta-1937-g.html

эцэгтэйгээ хамт эс бөгөөс эд хөрөнгө өвлөн авах эрх үүсэх хэн нэгэнтэй хамт бичигдсэн байх аваас түүнд хөрөнгө өвлөх эрх үүснэ. Хэрвээ тийм бүртгэл тэмдэглэлгүй бол эцгийн нас барсанаас хойш 3 сарын дотор тухайн хүүхэд эд хөрөнгийн эзнээс буюу эзэмшигчээс хувь хүртэх ёстой бусад хүмүүст мэдэгдсэн байх тохиолдолд л өвлөх эрх үүснэ.

Гэрээслэлээр хүүхэд эд хөрөнгө өвлөн авах эрхтэй. Хэн нэгэн хүн өөрийн эд хөрөнгийн өв залгамжлагчаа гэрээслэлээрээ шийдвэрлэх боломжтой. Эхнэр нөхөр хоёр хэн нэгийгээ түрүүлж нас барсан даруйд л хүүхдүүддээ эд хөрөнгөө өвлүүлэхийг хүсч байж болно. Энэ тохиолдолд тэд заавал гэрээслэл үйлдэх ёстой. Ямар ч гэрээслэл хүүхдүүдэд оногдох хууль ёсны хувь хэмжээг өөрчлөхгүй. Гэрээслэлээр эд хөрөнгийг бүхэлд нь өөр хүнд өвлүүлэхээр Гэр бүлийн хуулийн 2.7, 3.2 дугаар хэсэг Өв залгамжлалын тогтоолоор шийдсэн ч хүүхдүүд нь тус тусын хувь хэмжээг шаардах эрхтэй. Тэр хувь хэмжээнээс гагцхүү өөрсдөө л татгалзах эрхтэй.

Финланд Улс: 1929 оны Гэрлэлтийн тухай хууль[16] нь 5 хэсэг 20 бүлэг 142 зүйлтэй, гэрлэлт, гэрлэлт цуцлалт, гэрлэгчдийн хууль ёсны харилцаа, гэрлэгчдийн хамтын эд хөрөнгийн хуваалт, хувийн олон улсын хууль дүрэм зэрэг, гэр бүлийн харилцааны үндсийг хуульчилжээ. Тус хуулийн хүүхдийн эд хөрөнгө өмчлөлтэй холбоотой харилцааг зохицуулсан зүйл заалтуудаас дурдвал: Нэгдүгээр хэсгийн зургадугаар бүлгийн 24 дүгээр зүйлд зааснаар:

- Гэрлэгчдийн хамтран гаргасан өргөдлийн дагуу эсхүл аль нэг талын гаргасан өргөдлийн дагуу шүүх дараах шийдвэрийг гаргана:

- Гэрлэгчдийн талуудаас илүү орон сууцны хэрэгцээтэй байгаа тал нь хамтран өмчлөх дундын орон сууцандаа үргэлжлүүлэн амьдрах эрхтэй.

- Гэрлэгчдийн нөгөө тал нь хамтран өмчлөх дундын орон сууцаа чөлөөлнө.

- Гэрлэгчдийн хамтын хэрэглээний эсвэл нэг талын, хүүхдийн хувийн хэрэглээний хэрэгсэл, гэрийн эд хөрөнгө болон нэг талын эзэмшлийн хөдлөх хөрөнгийг тухайн талдаа хэрэглэх эрхийг олгоно.

Мөн хуулийн 39 дүгээр зүйлд зааснаар гэрлэгчдийн аль нэг талын зөвшөөрөлгүйгээр, нөгөө тал нь дараах эд хөрөнгийг шилжүүлэх эсвэл өмчлөх эрхийг шилжүүлэхийг хориглоно. Үүнд:

- Гэрлэгчдийн талуудын хамтран хэрэглэж буй хамтын эзэмшлийн дундын хөдлөх хөрөнгө

- Гэрлэгчдийн хэн нэгний хэрэглэж буй хэрэгцээтэй хэрэгсэл

- Гэрлэгчдийн хэн нэгний эсвэл хүүхдийн хувийн хэрэглээний хөдлөх хөрөнгө

[16] (234/1929) /Marriage Act (234/1929)/

Дөрөвдүгээр бүлгийн 46 дугаар зүйлд зааснаар Гэрлэгчид харилцан байгуулсан гэрээний дагуу эсхүл шүүхийн шийдвэрийн дагуу гэрлэгчдийн нэг талаас нөгөө талдаа төлөх асран хамгаалах тэтгэлгийн хэмжээ болон хэлбэрийг тогтооно.

Эцэг эхийн хүүхдийн асран хамгаалах эрхийг “Хүүхэд асран хамгаалах тухай хууль”-аар зохицуулна.

1965 оны Өв залгамжлах тухай хууль[17] нь 26 бүлэг 212 зүйлтэй, өв залгамжлах эрх, төрөл садангийн өв залгамжлах эрх, гэрлэгчдийн хоорондын өв залгамжлах эрх, эд хөрөнгийн захиран зарцуулах, эзэнгүй эд хөрөнгийг хураах, гэрээслэл, гэрээслэл хүчингүй болох, өв хөрөнгийн үнэлгээ, өмчийг өв залгамжлагчдад хуваах зэрэг иргэдийн өв залгамжлах харилцааны үндсийг хуульчилжээ. Тус хуульд заасан хүүхдийн эд хөрөнгө өмчлөлтэй холбоотой харилцааг зохицуулсан зүйл заалтуудыг авч үзвэл, Хоёрдугаар бүлгийн 1 дүгээр зүйлд зааснаар: Төрсөн үр удам өв залгамжлах тэргүүн ээлжийн эрхтэй. Хүүхэд бүр өв залгамжлах тэгш эрхтэй. Хэрэв хүүхэд нас барвал, түүний үр удам нь түүнийг орлох ба үр удам бүр тэгш эрхтэй.

Мөн түүнчлэн зургадугаар бүлгийн 2 дугаар зүйлд зааснаар бол хүүхдийн өсгөн хүмүүжүүлэх, тэжээн тэтгэх, боловсрол олгоход эцэг болон эхээс гаргасан зардлыг тус хүүхдийн өв залгамжилсан өв хөрөнгөөс хасаж суутгахгүй. Гэр бүлийн нөхцөл байдлыг харгалзан үзээд, хүүхдэд боловсрол олгоход зарцуулсан нэмэлт зардлыг тухайн нөхцөл байдалд тохирсон шалтгаантай гэж үзвэл суутгаж болно.

Наймдугаар бүлгийн 1 дүгээр зүйлд зааснаар: хэрэв талийгаачийн хүүхдэд өсгөн хүмүүжүүлэх, боловсрол олгоход мөнгө хэрэгцээтэй бол мөн түүнчлэн тухайн хүүхдийг өв залгамжлагчид багтаан оруулсан бол, тухайн нөхцөл байдалд тохирсон шалтгаантай гэж үзвэл, тухайн 18 хүүхдийг 21 нас хүртэл нь тэжээн тэтгэхэд шаардагдах нийт зардлыг хуваагдахгүй цэвэр хөрөнгөөс гарган тэжээн тэтгэнэ. Есдүгээр бүлгийн 1 дүгээр зүйлд зааснаар: Арван найман нас хүрсэн хүн өөрт нь гэрээсэлсэн хөрөнгөө захиран зарцуулж болно. Мөн гэрээслэлийг тухайн хүн нь хүнтэй гэрлэсэн, түүнчлэн арван таван нас хүрсэн, мөн тухайн хүн өөрийн захиран зарцуулдаг хөрөнгөтэй холбоотой тохиолдолд тухайн хүнээр гэрээслэлийг хийлгэж болно.

Дүгнэлт: Харьцуулан судалсан улс орнуудад хүүхдийн өмчлөх эрхийн асуудлыг Иргэний хууль, Гэр бүлийн тухай хууль, (зарим улс оронд Гэр бүл цуцлалтын тухай хууль), Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн хүрээнд зохицуулан хамгаалжээ.

[17] Code of Inheritance (40/1965)

Насанд хүрээгүй хүүхдийн эд хөрөнгөтэй холбоотой асуудлаар эх, эцгийн эрх, үүрэг, хүүхдийн эд хөрөнгө, өмчийг эцэг эх, асран хамгаалагч захиран зарцуулах эрх, энэхүү эрх дуусгавар болох нөхцөл зэрэг асуудлыг нэлээд нарийвчлан зохицуулсан байна.

Дүгнэлт:

Манай улс гэр бүлийн гишүүн болох хүүхдийн хөрөнгийн эрх, түүний дотор хуваарьт хөрөнгийн эрхийн эрх зүйн зохицуулалтын хувьд иргэний болон гэр бүлийн салбар эрх зүйн хүрээнд зохицуулж ирсэн эрх зүйн түүхэн уламжлалтай, улс орны нийгэм, эдийн засгийн хөгжил, эрх зүйн шинэтгэл, Үндсэн хуулийн шинэчлэлийн үр нөлөөгөөр хүний жам ёсны болон зүй ёсны эрхийн хүрээнд үндэсний төр, эрх зүйн сэтгэлгээний онцлог, дэлхий нийтийн хөгжлийн чиг хандлагын дагуу байнга боловсронгуй болж өөрчлөгдөн шинэчлэгдэн ирсэн байна гэсэн дүгнэлтийг хүчин төгөлдөр үйлчилж буй хуулиудын хүрээнд хийсэн судалгааны дүнд дэвшүүлж байна.

Харьцуулан судалсан улс орнуудад хүүхдийн өмчлөх эрхийн асуудлыг Иргэний хууль, Гэр бүлийн тухай хууль, (зарим улс оронд Гэр бүл цуцлалтын тухай хууль), Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн хүрээнд зохицуулан хамгаалжээ.

Дээр дурдсан улс орнуудын гэр бүлийн хууль, иргэний хуульд эцэг, эх болон хүүхдийн өмчийг тусгаарлан эцэг эхийн хөрөнгийг хүүхэд өмчлөхгүй, хүүхдийн хөрөнгийг эцэг эх өмчлөхгүй гэсэн зарчим баримталдаг болох нь харагдаж байна.Мөн хүүхдийн хуваарьт хөрөнгөнд өв, гэрээслэлээр шилжин ирсэн эд хөрөнгө голлож, түүнийг төрсөн цагаас эхлэн түүнд зориулан авсан өгсөн бүх зүйл түүний өмч болдог. Хүүхдийн хөрөнгийг зайлшгүй тохиолдолд захиран зарцуулах бол холбогдох байгууллага, шүүхийн зөвшөөрлөөр хийх ба хүүхдийн өмчийг хамгаалахад төрийн байгууллага, прокурор оролцдог. Эцэг, эх, асран хамгаалагч нь хүүхдийн хөрөнгийг захиран зарцуулах бол адил тэгш эрхтэй байхаас гадна хамтын төлөөлөлөөр шийдэхээр зохицуулагдсан байна. Гэр бүлийн гишүүний хэн нэгний нэр дээр үл хөдлөх хөрөнгө бүртгэлтэй байх нь хамаагүй бөгөөд түүнийг захиран зарцуулахдаа хууль ёсны гэрлэлтийн хувьд эхнэр нөхөр харилцан бие биенээсээ зөвшөөрөл авсан байх ёстой. Хүүхдийн тэтгэмж тэтгэлэгийн асуудлыг нэн тэргүүнд шийдэж төлөвлөгөө гаргасан тохиолдолд шүүх гэр бүл цуцлалтыг шийдвэрлэдэг. Зарим төрлийн эд хөрөнгийн эрхийг насанд хүртэл нь захиран зарцуулж болохгүй байхаар хуульчилжээ.

Мөн насанд хүрээгүй хүүхдийн эд хөрөнгөтэй холбоотой асуудлаарх эх, эцгийн эрх, үүрэг, хүүхдийн эд хөрөнгө, өмчийг эцэг эх, асран хамгаалагч захиран зарцуулах эрх, энэхүү эрх дуусгавар болох нөхцөл зэрэг асуудлыг нилээд нарийвчлан зохицуулсан байна.

Гэрлэлт цуцлах үед хүүхдийн эрхийг хангаж буй эсэх зохицуулалтыг харьцуулан судлахад ихэнх улс орны хууль тогтоомжоор эхлээд заавал хүүхдийн эрхийг хангах арга хэмжээ авч, гэрээ байгуулах, төлөвлөгөө гаргах зэргээр урьдчилсан арга хэмжээ авахыг шаарддаг байна. Ийнхүү урьдчилсан арга хэмжээ аваагүй, хүүхдийн эрх зөрчигдөх нөхцөл байдал үүссэн гэж үзвэд гэр бүл цуцлалтыг хангахгүй байх ч зохицуулалттай улс орон байна. Мөн ихэнх улс орны хуулиар эцэг, эх хэн аль нь гэр бүл цуцалсан ч эцэг, эх, хүүхдээ тэжээн тэтгэх хариуцлагаас чөлөөлөгдөхгүй хэмээн үзсэн байна.

- Өв залгамжлалын хувьд зарим улсын хууль тогтоомжоор хуулийн дагуу өвлөгчдийг эрэмбэлэн дараалал тогтоож байгаа ба өвлүүлэгчийн хүүхдүүд, үүнд үрчилж авсан болон нас барсны нь дараа төрсөн хүүхдүүд мөн орж байгаа ба тэд өв залгамжлагчдын эхний буюу тэргүүн ээлжинд эрэмбэлэгддэг байна.
- Хүүхдийн тэтгэлгийн хувьд ихэнх улс орнууд хүүхдээ асран хамгаалахаар хамт амьдарч буй эцэг, эхийн аль нэгд нөгөө тал нь тэтгэлэг төлөх зохицуулалттай байна. Тухайлбал, хүүхдэд гэнэтийн өвдөх гэх мэт зүйл тохиолдоход тэтгэлгийн хэмжээг нэмж болохоор заасан нь манай улсын Гэр бүлийн тухай хуульд заасан тэтгүүлэгч хүндээр өвчилсөн, сургуульд орсон, тахир дутуу болсон, эмчлүүлсэн зэрэг онцгой нөхцөл үүссэн бол тэтгэлгийн хэмжээг нэмэгдүүлдэгтэй адил байна. Тэтгэлгийн зарцуулалт зөвхөн хүүхдэд зарцуулагдах ёстой гэж зарим улс орон үзсэн байхад зарим нь хүүхдийн тэтгэлэгийг гэр бүлийн хэрэгцээнд зарцуулж болно хэмээн хуульчлан зохицуулжээ.
- Мөн тэтгэлийн хэмжээг тогтоохдоо нийтлэг 2 аргыг хуульд тусган хуульчилж байна гэж үзэж болохоор байна. Үүнд:
    1. Тэтгэлэг төлөгчийн орлогоос хувь тооцон тогтоох
    2. Шууд мөнгөн дүнгээр тэтгэлэг тогтоох гэсэн арга. Ингэхдээ хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс доогуур байж болохгүй хэмээн доод хэмжээг хуульчлан зохицуулсан улс бас байна.

Манай улсын хувьд хүүхдийн тэтгэлгийн доод хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 50 хувь байхаар заасан нь хэт доогуур, бага хэмжээтэй, хүүхдийн наад захын хэрэгцээг хангахгүй байна.

Сонгон судалсан улс орнуудын гэр бүл дэх хүүхдийн хөрөнгийн эрхийн эрх зүйн зохицуулалт, хамгааллын талаарх судалгаа, дүгнэлт нь манай улсын хувьд “харьцуулсан эрх зүйн практик хэсэг[18] буюу нэгэнт байгаа эрх зүйн хэм хэмжээг хууль зүйн практикт шилжүүлэн нутагшуулах замаар тухайн харилцааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох зөвлөмж боловсруулахад үр дүнгээ үзүүлж болох юм.

[18] Нарангэрэл.С., Монголын ба дэлхийн эрх зүйн тогтолцоо, Уб., 2000, 223 дахь тал

Санал:

1. Иргэний хуулийн 127 дугаар зүйлийн 127.2 “Гэр бүлийн гишүүн хуваарьт эд хөрөнгөө өөрийн үзэмжээр эзэмшиж, ашиглаж, захиран зарцуулах эрхтэй” гэснийг гэр бүлийн гишүүн хүүхдийн хуваарьт хөрөнгийн эрхийн эрх зүйн онцлог байдалтай уялдуулан өөрчлөн найруулах

   Мөн Иргэний хуулийн холбогдох заалтуудад “гэр бүлийн гишүүдийн хамтран өмчлөх дундын эд хөрөнгийг банкинд барьцаалахдаа хүүхдэд ногдох хэсгийг барьцаалахгүй байх, үүнд хяналт тавих үүргийг нотариатчид олгох, өв залгамжлах асуудлын тухайд гадаадын ихэнх улсад хууль тогтоомжоор хуулийн дагуу өвлөгчдийг эрэмбэлэн дараалал тогтоож байгаа ба өв үлдээгчийн хүүхдүүд, үүнд үрчилж авсан болон нас барсны нь дараа төрсөн хүүхдүүд мөн орж байгаа ба тэд өв залгамжлагчдын эхний ээлжинд орж байх эрх зүйн зохицуулалтыг нэмэлт өөрчлөлт болгон оруулах” нь хүүхдийн хөрөнгийн эрхийн ирээдүйг хамгаалсан хууль зүйн хамгаалалт болно.
2. Хуулийн эцэг эх, хүүхдийн хоорондын харилцааг зохицуулж буй заалтуудад хүүхдийн хуваарьт хөрөнгө болон, дундын хөрөнгөөс хүүхдэд ногдох хувийг захиран зарцуулсан тохиолдолд хожим насанд хүрсэн хойно нь буцаан нөхөн төлөх үүрэгтэй гэсэн зохицуулалт нэмж оруулах шаардлагатай байна. Учир нь гэр бүлийн дундын хөрөнгөөс хүүхдэд ногдох хувийг эцэг эх нь захиран зарцуулах, зээлийн барьцаанд алдах зэргээр хүүхдийн хуваарьт хөрөнгийн эрхийг зөрчиж байна.
3. Гэр бүлийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.3 “Эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хамгаална” гэсэн заалтыг эцэг эх нь гэрлэлтээ бүртгүүлсэн эсэх, хамт амьдарч байгаа эсэхээс үл хамааран хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах үүрэгтэй гэж өөрчлөн найруулах
4. Гэр бүлийн тухай хуулийн 25 дугаар зүйл. Хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах гэсэн зүйлд “эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь хүүхдийн эрх, ашиг сонирхлыг зөрчсөн бол Зөрчлийн тухай хуулийн 6.20 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэнэ” гэсэн заалт нэмж оруулах.
5. Зөрчлийн тухай хуулийн 6.20 дугаар зүйлийн 2.2 дах заалтад “хүүхдийн хуваарьт хөрөнгийн эрхийг зөрчих” гэж нэмж оруулах.
6. Хүүхдийн тэтгэлгийг тогтоохдоо тэтгэлэг төлөгчийн орлогоос хувь тэнцүүлэх, шууд мөнгөн дүнгээр тогтоох гэсэн олон төрлийн аргачлалыг хэрэглэх.

ЦАХИМ ШИЛЖИЛТ: АЖ ҮЙЛДВЭРЖСЭНИЙ ДАРААХ НИЙГЭМ-СОЁЛ, ЭРХ ЗҮЙН ӨӨРЧЛӨЛТ

ELECTRONIC TRANSITION: POST-INDUSTRIAL SOCIETY AND CULTURE, LEGAL REFORM

Ц.Батбаяр
Дотоод хэргийн их сургуулийн Эрх зүй, нийгмийн ухааны сургуулийн Нийгмийн ухааны тэнхимийн эрхлэгч, доктор, дэд профессор, дэд хурандаа
Batbayar. Ts,
Head of the Department of Social Sciences, University of Internal Affairs, Ph.D, associate professor, lieutenant colonel

Хураангуй: *Аж үйлдвэржсэний дараах нийгмийн тухай үзэл бариmтлал нийгэм-соёл, эрх зүйн орчны өөрчлөлтийн үндэс болох талаар илтгэлд дурдсан болно. Нийгэм-соёлын өөрчлөлтийг танин мэдэх нь эрх зүйд цахим шилжилт хийх, шинэ шинэ бүтээгдэхүүн-үйлчилгээг гаргах онолын үндэс мөн.*

Abstract: *The report states that the concept of post industrialism is the basis for changes in the socio-cultural and legal environment. Recognition of socio-cultural change in the broadest sense is the theoretical basis for the electronic transition to law and the development of new products and services.*

Түлхүүр үгс: *Нийгэм-соёл, аж үйлдвэржсэний дараах нийгэм, онолын мэдлэг, оюуны технологи, үйлчилгээ, эрх зүйн өөрчлөлт.*

Key words: *Socio-cultural, post-industrial society, theoretical knowledge, intellectual technology, services, legal changes/reform.*

ОРШИЛ

“Бүх танин мэдэхүйн эцсийн зорилго бол нийгмийн танин мэдэхүй мөн” гэж Германы суут хүү Макс Вебөр тодорхойлсон байдаг. Илтгэлийн хүрээнд “Хар морийг барихын тулд цагаан морийг барь” гэсэн арга зүйг хэрэглэж, эрх зүйн шинэтгэлийн суурь нь нийгмийн өөрчлөлтийг хэр танин мэдэх арга зүйгээс эхлэх юм.

Эрх зүйн орчныг өөрчлөхийн тулд хүний нийгэмд гарч буй өөрчлөлтүүдийг урьдчилан харж, тунгаан бодож, орчин үеийн дараах нийгмүүдийн гол шинж, мөн чанарыг нь нээн илрүүлж, түүнд үндэслэсэн мөрдлөгөөг гаргах шаардлага буй болсон байна. Энэ нь уг судалгааны шинэлэг тал нь болох бөгөөд ирж буй шинэ үнэт зүйлс, хүний эрхийн үнэт зүйлсэд тохирох хуулийн төслийг боловсруулах, амьдралаас урган гарсан онолын үзэл баримтлалд тулгуурласан хуулийн үзэл баримтлалыг боловсруулах, шинээр сэхээрэх, шинээр харах, өөр хандлага үүсгэх, гарч болзошгүй эрсдлүүдийг тооцоолох, өргөн хүрээний дискурс хийх,

харилцан зөвшилцөх, тохирох буюу хууль нь хүний төлөө байх, илүү уян байхыг нийгэм шаардаж байна.

Хүний нийгэм хатуу зүйлээс уян зүйлд шилжиж буйг хууль, эрх зүйн салбар мэдэрч, үйл ажиллагаандаа өөрчлөлт хийргүй бол нийгмийн өөрчлөлтөөсөө хоцрох хандлагатай байна. Иймд хууль зүйн салбарт орон тооны футурологич ажиллуулж, үйл ажиллагаагаа урьдчилан харж төлөвлөдөг соёл нэвтрээд байна. Орчин үед бүх байгууллага орон тооны футурологичтой болсон бөгөөд нийгмийн өөрчлөлтөд зохицож, эрх зүйн шинэтгэл явагдахаас биш, эрх зүйд тохирч нийгэм өөрчлөгдөх боломжгүй юм.

Аливаа хуулийн төслийг боловсруулахаас өмнө тухайн хуулийн үзэл баримтлалыг шинжлэх ухааны үндэстэйгээр тодорхойлж, эрдэмтдийн саналыг авч, хэрэглэгчдийн ашиг сонирхлыг сонсох нийгмийг хамарсан томоохон дискурс зохион байгуулж, гол үр дүнг нэгтгэж, анализ синтез хийж, амьдралаас урган гарсан хуулийн төслүүдийг боловсруулах шаардлага тулгарч байна. Энэ бол ширээний ард сууж байгаад бичдэг хиймэл, хуурамч онолуудтай адил зүйл биш юм. Нөгөө талаас сайн хуулийг буй болгоход төсөв, зардлын асуудлыг нь шийдвэрлэж өгөх нь шинэтгэлийн үндэс мөн.

Хамгийн гол асуудал бол нийгмийн өөрчлөлтийг судалдаг тусгайлсан хүрээлэнг Дотоод хэргийн их сургууль дээр байгуулж, шинээр буй болж болзошгүй харилцааг амьдралын шинэ хэв маягуудыг танин мэдэж, тэдгээрийн хууль эрх зүйн салбарын шинэтгэлд зориулах инновацийн бүтээгдэхүүн-үйлчилгээг боловсруулах шаардлагатай байна.

ҮНДСЭН ХЭСЭГ

Эрх зүйн шинэтгэлийн хүрээнд бид нийгэм-соёл, хувийн эрх зүйн салбарт гарч буй гол шинжүүдийг танин мэдэх ирээдүйд учирч болох аливаа асуудлыг урьдчилан харах боломжийг нээж өгч байна.

Аж үйлдвэржсэний дараах онол, арга зүйг хувийн эрх зүйн салбарт хэрэгжүүлэх өргөн боломж байгаа бөгөөд уг баримтлалыг эзэмших нь тухайн салбарын мэргэжилтнүүдийн шинэ үүрэг болж байна. Эрхийн салбарт цахим шилжилт хийх нь мэдээлэлжсэн нийгмийн парадигмаар тайлбарлагдаж, тухайн салбарын онолын мэдлэг, мэдээлэл, технологийг үйлчилгээнд шилжүүлэхэд цахим шилжилтийн гол цөм нь оршиж байгаа юм. Үүний тулд хүний нийгэм хэрхэн өөрчлөгдөж буйг мэдрэх, ухаалаг ажиллах, хүний эрхийг хүндэтгэх соёл чухлаар тавигдах болно.

Пост ертөнц гэдэг нь олон утгаар тайлбарлагдах бөгөөд нэг үзэгдэл, мөн чанарыг олон призмээр тусгаж, тайлбарласан байдал юм. Орчин үе гэдэг нийгэм эдийн засаг, соёл, социал өөрчлөлтүүдийн дээд цэгтээ хүрсэн цогц болохыг бид мэднэ. Тэгвэл пост гэдэг дараах, энэ үе

шат дараагийн үе шат хоёрын завсрын нөхцөл байдал, мөн чанар, үнэт зүйлс мөн.

Нийгэм ямар үнэт зүйлс үйлчилж буйгаас шалтгаалж, түүний дараагийн үе шатуудын өөрчлөлт шалтгаалдаг билээ. Өмнө бид нийгмийн хөгжил гэж ярих дуртай байсан бол пост үзэл баримтлал ёсоор нийгэм хөгжөөд байгаа юм биш, харин өөрчлөгдөж байгаа тухай илүүтэй ярих болсон байна.

Барууны нийгмийн өөрчлөлтийг тодорхойлж байгаа үндсэн хоёр чиглэл бол постиндустриализм, постомодерниз билээ. Иймээс хүний нийгэм ямар чиглэлд өөрчлөгдөж буйг судлах, мэдрэх, танин мэдэх нь онол, практикийн чухал ач холбогдолтой байна.

Дээр өгүүлсэн пост гэдэг ойлголт нь 3 шатны хуультай төстэй гуравдагч давлагааны ертөнцийг бүрэлдүүлж байна. Орчин үеийн дараах нийгмийн өөрчлөлтийг тодорхойлох нэг үзэгдлийг эрдэмтэд янз бүрээр нэрлэсэн байна. К.Маркс эдийн засгийн өмнөх, эдийн засгийн, эдийн засгийн дараах; О.Тоффлер нэг дэх, хоёр дахь, гурав дах давлагааны супер аж үйлдвэржсэн нийгэм, постмодернистууд модерны өмнөх, модерны үе, модерны дараах үе; Д.Белл аж үйлдвэржихийн өмнөх, аж үйлдвэржсэн, аж үйлдвэржсэний дараах нийгэм; Т.Маклуэн сонсож байгаа хүний, харж байгаа хүний, сонсож, харж байгаа хүний нийгэм гэх мэт үе шатуудад хувааж судлах хандлага ажиглагдаж байна. Зарим нь бүр өөрөөр томьёолж, нэрлэсэн тал ч бий. Энэхүү нийгмийн өөрчлөлтийн дүр зураг нь байгалийн толинд янз бүрээр тусгагдаж, өөр өөр дүр зургийг буй болгосон байна.

Аж үйлдвэржсэний дараах нийгмийн дүр зураг бүрэлдэн тогтох, уг парадигм үүсэж, хөгжиж, дэлгэрсэн үе шатыг парадигмын онолын үүднээс танин мэдэх нь тун чухал болоод байна. Эдгээр нийгмийн өөрчлөлтүүдийн үр дүнг эрдэмтэд өөр өөрөөр танин мэдэж, нэрлэжээ. Тэд эл нийгэм бол үүрэн холбооны нийгэм, инновацийн капитализм, мэдээлэлжсэн нийгэм, мэдлэгийн нийгэм, виртуалчлагдсан нийгэм, дижитал нийгэм, сүлжээний капитализм, онлайн ертөнц, онлайн хүн, офлайн хүн, 6 дахь тивд оршин суугчдын хил хязгааргүй нийгэм, глобалчлалын үүднээс бол интернационалчлагдсан нийгэм, даяарчлагдсан нийгэм, америкчлал, баруунжилт, стандартын өмнөх нийгэм, стандартчлагдсан нийгэм, стандарт бус нийгэм, хаосын онол, тоглоомын онол, хүмүүс хоорондын тоглоом, виртуаль тоглоом, үйлчилгээний онол гэх мэтчилэн нийгмийн философи, онолын социологийн хүрээнд тайлбарлагдаж буй үндсэн шинжүүдийн үр дүнг аж үйлдвэржсэний дараах нийгмийн онол, арга зүйн үүднээс авч үзвэл дараах дүр зураг ажиглагдаж буйг танин мэдэж, эрх зүйн шинэтгэлийн үйл явцад дараах 9 үр дүнгээс бүтээлчээр хэрэгжүүлэх салбарын өмнө тулгамдаж байна.

Аж үйлдвэржсэний дараах нийгмийн гол шинжийг танин мэдэх эрх зүйн шинэтгэлийн үйл явцыг чиглүүлэхэд их бага хэмжээгээр ашиглах боломж буй гэж судлаачийн зүгээс үзэж байна.

1. Аж үйлдвэржсэний дараах нийгмийн тухай онол, үзэл баримтлалын үүсэл, хөгжлийн хандлагад дүн шинжилгээ хийж үзэхэд:

а/ XX зууны II-хагасаас үйлдвэрлэлд шинжлэх ухаан, боловсролын хүч нөөц, онолын мэдлэг, оюуны технологи түүнийг хэрэгжүүлэх, бүтээх аргуудын олон янз байдал бий болж, мэргэшсэн менежер, технократ, меритократ анги үүссэн нь эрх зүйн орчны өөрчлөлтөд шууд бусаар нөлөөлж байна,

б/ Шинжлэх ухаан технологижиж, технологи шинжлэх ухааншх харилцан хамааралтай үйл явцын үр дүнгээр шинжлэх ухааны үйлдвэрлэлийн шинэ талбарууд, мэдээлэл харилцаа холбооны технологид суурилсан хууль эрх зүйн оюуны үйлдвэрлэлийн бааз бий болсон

в/ Технологийн дэвшлийг дагнасан мэдээллийн үйлдвэрлэлийн төрөл зүйлүүдийн хосгүй олон янз байдал бий болсноор голлон тодорхойлогдож байна.

Д.Белл аж үйлдвэржсэний дараах нийгмийн үндсэн шинж, суурь механизмуудыг тодорхойлохдоо нийгмийн тулгуур үйлдвэрлэл тэнхлэгээ сольж, нийгмийн үйлдвэрлэлийн материаллаг шинж өөрчлөгдөж, оюуны үйлдвэрлэлийн материаллаг бус хийсвэр хэлбэрт шилжих үйл явцыг хүмүүс хоорондын харилцааны өнөөгийн бодит байдлын дүр зурагтай зэрэгцүүлэн судалсан үр дүнг эрх зүйн салбарт хэрэгжүүлэх шаардлагатай байна.

2. Нийгмийн хөгжлийг авч үзэх уламжлалт философийн хандлага өөрчлөгдөж, оюуны үйлдвэрлэл, үйлчилгээ прагматизмд суурилсан хандлага эрчимтэй хөгжих болсон байна. Эл хандлагын хүрээнд онолын мэдлэг, мэдээлэл нь үйлчилгээнд төвлөрөн хөгжиж, компьютерын технологийн дэвшил нь мэргэшсэн ажилтнуудыг шаардаж буйд аж үйлдвэржсэний дараах, супер аж үйлдвэржсэн нийгмийн мөн чанарын нэгдмэл үзүүлэлтүүд тодорхойлогдож байна. Д.Белл, О.Тоффлер нар мэдлэг, мэдээлэл нь нийтэд хүртээмжтэй, хамтын баялаг болж, бодгаль хүнд төвлөрч, амин хувийн шинжтэй болсон үзүүлэлтүүдийг гол болгож, хүн төрөлхтний нийгэм иргэншлийн хөгжлийг бусад сэтгэгчдийн адил гурван шатанд хуваасан нь ижил байгаач, шинэ шалгуур үзүүлэлтийг үндэс болгосон нь онцлог байна

3. Аж үйлдвэржсэний дараах нийгэмд ажлын хэлбэр нь сүлжээ, үйлдвэрлэлийн салбар нь мэдээлэл боловсруулалт, оюуны технологи нь хийсвэрлэлт, зохиомлоор бий болгох, загварчлал, эрх зүйн онолын мэдлэгийн кодчилол болж, мэргэшсэн хуульч, эрх зүйчийн хөдөлмөрийн үр дүн голлох болж байна.

Хууль, эрхийн талаарх олон янзын чадвар авьяас билэгтэй хүмүүсийн нөөц оюуны үйлдвэрлэлд бүрэн хэрэгжсэнээр онолын мэдлэг шингэсэн, чанар, технологийн өндөр төвшинд боловсруулагдсан эрх зүйн бүтээгдэхүүн, үйлчилгээнүүд нь өнөөгийн мэдлэгийн эдийн засгийг тодорхойлогч үзүүлэлт болно.

Эрх зүйн сэтгэлгээний бие даасан байдал, эрх чөлөөний бодгаль хэлбэрүүдэд шилжих болсноор барууны соёлын логик нь рациональ байдлаас иррациональ мэдрэхүйд шилжиж, соёлын хэмжүүр нь мэдрэмж, үнэлэмжийн зүйлс болж, үнэлэмж нь хүмүүс худалдан авахад бэлэн байгаа өртөг шингэсэн эрх зүйн бүтээгдэхүүн, үйлчилгээ болно.

4. Мэдээлэл харилцааны технологи нь нийгмээрээ харилцан ярилцаж, хүн болгоны шинэ санааг тусгаж, оновчтой шийдвэр гаргах өргөн боломжийг олгодог нь постмодерн шинжийн илэрхийлэл бөгөөд хуулийн төслүүдийг нийгмийн дискурсэд оруулах шаардлага байна. Үүнтэй холбоотойгоор хөгжингүй орнуудад нийгмийн хүрээний буюу иргэний нийгмийн философи асуудлууд нийгмийн философийн чухал чиглэл болон хөгжлөө. Мэдээллийн эрин үеийн мөн чанар нь хувийн болон улсын байгууллагын гадна орших, өөрсдийн сүлжээг үүсгэсэн нь харилцагч талуудын бие даасан хараат бус бүтцийг бий болгож, нийгмийн өөрчлөлтийг чанарын шинэ шатанд гаргасан нь нийгмийн хүрээний шинж байдлыг ихээхэн өөрчилж байна. Ингэж нийгэм-эрх зүйн өөрчлөлтийн гол хандлага эрх чөлөөний хэлбэрүүдэд шилжсэнээр автономит агуулга бүхий нийгмийн бүтцүүд бий болох суурийг тавьсан нь орчин үеийн нийгэм мэдлэг, мэдээлэлд тулгуурлан улам бүр боловсронгуй болох чухал хүчин зүйл болсон байна.

Бүтээлч (креатив) аж үйлдвэрлэлийн дөрөвдөгч салбарууд үүссэнээр улс орнууд иргэдийнхээ креатив инергийг ашиглан нийгмээ нээлттэй болгохыг зорьж, бүтээлч мэргэжилтнүүд үйлдвэрлэлийн гол хүчин зүйл, нөөц болсноор өрсөлдөхүйц давуу талыг хурдтай бий болгох үндсэн нөхцөл бүрдэж, креатив хотуудыг бий болгох чиглэлд тэмүүлж байна. Бүтээгч хот, муж, бүсүүд гэх мэт жижиг оюуны фабрикуудад суурилсан бүтцүүд нь эдүгээ үе дэх нийгэм-эрх зүйн өөрчлөлтийн суурь үндэс мөн. Ийм өөрчлөлт нь хүний сэтгэлгээ, ёс зүй, сэтгэл зүй, зан үйл, араншин зэрэг философи, сэтгэл судлал, менежментийн хосолсон хандлагатай судалгааг шаардаж, ийм судалгааны ажил эрчимжих хандлагатай байна.

5. Технологи нь өсөн нэмэгдэж буй бүтээмжийн үндэс, нийгмийн өөрчлөлтийн чухал нөхцөл, мэргэшээгүй хөдөлмөрийг орлогч, мэргэшсэн хөдөлмөрийг улам бүр нарийсган хөгжүүлэгч механизм, шинжлэх ухааны боловсруулалтын үндэс болжээ. Ухаалаг технологи нь цаг, хүч хэмнэсэн, хэрэглэхэд хялбар, ойлгомжтой, мэдээллийг цуглуулах, ангилах, боловсруулах үүргүүдийн хамгийн боловсронгуй хувилбар, өндөр хөгжсөн уураг тархины дотоод зүй тогтолд захирагддаг нь түүний эрхийн философи

шинжийн илэрхийлэл мөн. Эрх зүй нь өөрөө оюуны технологи нь онолын мэдлэг, мэдээлэл, мэдрэмжид тулгуурласан хамгийн оновчтой стратегийг тодорхойлогч болоод байна.

6. Мэдээллийн нийгмийн үндсэн шинж нь түүний сүлжээний бүтцийн зохион байгуулалтын тэгш эрхийн зарчимтай холбоотойгоор, төвлөрөл саарч, зөрчилдөөн буурч, мэдээллийн нөлөө өсж, хөдөлмөрийн хэлбэр өөрчлөгдөж, их өгөгдлийн сан, иргэн-төрийн холбоо хангагдан олон нийтийн санаа бодол гол үүрэгтэй болж, эрүүл мэнд, шинжлэх ухаан, эрхийн боловсролын хөгжил чанарын шинэ төвшинд хүрч, мэдлэгийн зах зээл бүрэлдэн, мэдээллийн боловсруулалт, мэдээллийн дэд бүтцийн өрсөлдөх чадвар нэмэгдэж, мэдээллийн технологийн бүх хэрэгсэл соёлыг залах болсон явдал мөн. Түүнчлэн ҮНБ-ий дийлэнх хэсэг нь мэдээллийн салбарт бүтээгдэж, мэдээллийн нөөцөөс эдийн засгийн бодит нөөцөд шилжлээ. Эдүгээ мэдээлэл нь нийтийн хэрэглээ болж, хэн ч, хэзээ ч, хаанаас ч нэвтрэх боломж бүхий мэдээллийн дэд бүтэц, зах зээл бүрэлдсэнээр нийгмийн интеграци нь нийгмийн хувьсгалыг халж, хүн болгонд ээлтэй, бидний өдөр тутмын амьдралыг баяжуулсан, шинэ мэдээллийн иргэншлийн үнэт зүйлсийг бодгаль төвшинд бий болгож, хүний танин мэдэхүйн боломжийг өргөтгөсөн зэрэг нь цахим шилжилтийн гол шинж мөн.

Цахим шилжилтийн гол философи зарчим нь ил тод, хэрэглэхэд хялбар, энгийн, орон зай, цаг хугацаа, хөрөнгө, хүчийг хэмнэсэн шуурхай, өрсөлдөөнийг хангасан, зохион байгуулалтын оновчтой инженерийн механизмыг бий болгох зэрэг хамаарна. Тусгай зарчим нь хувийн хөрөнгө оруулалт, дэмжсэн, нээлттэй, оюуны үйлдвэрлэл, нөү-хауг дэмжсэн, мэдээллийн тархалтад суурилсан эдийн засгийн даяар шинэ санаа, сонгох эрх, мэдээллийн үйлдвэрлэлийн шинэ арга, технологи, түүний компьютергүй, утасгүй хэлбэр, хүн техникт бус техник хүний хэрэглээнд дасан зохицох, эрх зүйн мэдлэгийн тодорхой хэсгүүдийн дахин үйлдвэрлэлд суурилсан нийгмийн өөрчлөлтийн үйл явцаар тодорхойлогдож, монголд үүрэн холбооны нийгэм цахим шилжилтийн орчин үе дэх практик илрэл боллоо.

7. Аж үйлдвэржсэний дараах буюу мэдээлэлжсэн нийгмийн хүрээнд техник, технологи, сүлжээ, их сургууль, шинжлэх ухааны хүрээлэнгүүд зэрэг XXI зууны оюуны фабрикууд, тэдгээрийн гол хөдөлгөгч хүч болсон мэргэшиж, мэдээлэлжсэн, мэргэжилтэн болох бодгаль хүний тархинд ирээдүйн эрх зүй өөрөө бүтээгдэж, үгүйсгэгдэх нөхцөл үүсээд байна. Ийм учраас оюуны хөдөлмөрийг дэмжих, шинжлэх ухаан технологи, инновацийг тэргүүлэх чиглэл болгох нь орчин үеийн улс орнуудын хөгжлийн бодлогын үндэс мөн. Ийм нөхцөлд манай улс өөрийгөө тэтгэх, өрсөлдөх чадвартай, олон тулгуурт эдийн засагтай болохын тулд аж үйлдвэржсэний дараах буюу мэдээллийн нийгмийн онолын баримтлалын ололттой талуудыг хөгжлийн бодлогын

философи үндэслэл болгож, эрх зүйн онол, практикт нэвтрүүлэх шаардлага бий болж байна.

8. Аж үйлдвэржсэний дараах нийгмийн тухай үзэл баримтлалын олон хувилбарт дүрсүүд, постмодернизм болон бусад пост эрх зүйн онолын чиглэлүүдийг нарийвчлан судлах нь манай эрх зүйчдын хувьд хүчээ сорих шинэ талбар болоод байна. Орчин үеийн дараах нийгэмд онолын мэдлэгийн үнэ цэнэ эрс өсч байгааг анзаарахгүй өнгөрч болохгүй юм.

Цаашид уг баримтлалын онолын гүйцээлтийг гурав дахь мянганы нийгэм-эрх зүйн өөрчлөлттэй уяж, улам боловсронгуй болгож, хөгжүүлэх, эрх зүйн салбарын мэргэжилтнүүдийг эл онолын баримтлалыг өөрийн ажил, мэргэжилд бүтээлчээр хэрэгжүүлэн хөгжүүлэх улмаар даяар мэдээллийн зах зээл, мэдлэгийн эдийн засагт өөрийн орон зайг бий болгох, үүний тулд гаригийн онолын мэдлэг, мэдээллийн баазад нэвтэрч, хууль, эрх зүйн чиглэлээр эрдэм шинжилгээ судалгааны багийг байгуулах, гадаадын мэргэжил нэгт эрдэмтэдтэй хамтран ажиллах боломжийг эрэлхийлэх явдал юм.

Ирээдүйд аж үйлдвэржсэний дараах нийгэмд шилжсэн болон шилжээгүй орнуудын хооронд геополитикийн хамтын ажиллагааны олон тооны загвар бий болох бөгөөд энд монгол улс ямар байр суурьтай байх нь уг онолын үзэл баримтлалыг хэрхэн ухамсарлаж, хууль, эрх зүйн практикт хэрэглээ болгож буйгаар тодорхойлогдох юм.

9. Аж үйлдвэржсэний дараах нийгэмд хүн амын тоон өсөлт нь тэдний амьдрах чадвар, мэдлэг мэдээллийн төлөөх өрсөлдөөнийг нэмэгдүүлснээр онолын мэдлэг, технологи, мэдээллийн хэрэглээ эрс өсж, тухайн ажил, мэргэжлийг хэрэглээ, үйлчилгээ болгох шаардлага урган гарна. Аж үйлдвэржсэний дараах нийгмийн тухай үзэл баримтлалд хийсэн философи-эрхийн шинжилгээний эцсийн үр дүнд уг онолын баримтлал нь хүн төвтэй хөгжлийн загварыг улам төгс болгох арга зүй, механизмыг өөртөө тээж буй явдал мөн.

ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Дээрх 9 судалгааны үр дүнг санал гэж ойлгож, цаашид салбарын онцлогт тулгуурлаж, бүтээлчээр хэрэгжүүлэх шаардлага байна. Уг судалгааны үнэ цэнэтэй гол үндэслэлүүд бол онолын мэдлэг, оюуны болон мэдээллийн технологи, мэдээлэл, үйлчилгээний синтезид эдүгээ үе дэх хүний эрхийн зөрчилдөөнт болон зүй тогтолт үзэгдэл дунд, бодит бус оршин буй үзэгдлийг тайлбарлах, загварчлах, түүний ирээдүйн дүр зургийг шинжлэх ухааны үндэслэлтэй урьдчилан харах нь эрх зүйн онол, арга зүйн хамгийн чухал хэсэг болох нь эл судалгааны үр дүнгээр батлагдаж байна. Мөн гуравдагч сектор нь нэгдэгч, хоёрдогч, дөрөвдөгч, тавдагч секторын суурь болж, онолын мэдлэг, технологи хоёр нь нийгмийн институтид эрх зүйн үйлчилгээ болон биелэлээ олно.

Эцэст нь дүгнэхэд, эрх зүйн салбарын онолын мэдлэг, технологи, мэдээллийг бүтээгдэхүүн-үйлчилгээ болгоход энэ онолыг судалсны онол, практикийн ач холбогдол орших бөгөөд хууль зүйн зөвлөгөө өгөхөөс эхлээд эрх зүйн салбарын бүх үйл ажиллагааг үйлчилгээний технологитой нийгмийн үзэл баримтлалд шилжүүлэх шаардлагатай байна. Энэ нь нийгэм-соёлд гарч буй өөрчлөлтийг мэдэрч, эрх зүйн салбарын шинэтгэлд хэрэгжүүлэх үйл явц мөн.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Нэг. Монгол улсын хууль бусад хууль эрхийн актууд:

1. Монгол улсын үндсэн хууль. УБ., 1992
2. Монгол улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал батлах тухай. (07. 15) УИХ-ын тогтоол № 48. УБ., 2010.
3. Кибер аюулгүй байдлын тухай хуулийн төсөл 2021
4. Мэдээллийн аюулгүй байдлын тухай хуулийн төсөл. МУЗГ МШХХТГ. УБ., 2013.
5. Шинжлэх ухаан технологийн тухай хууль. шинэчлэн найруулсан (12. 28.) МУ. УИХ. УБ., 2006
6. Шинжлэх ухаан технологийн талаар төрөөс баримтлах бодлого. МУ. ИХ-ын 55 дугаар тогтоол, УБ., 1998
7. Инновацийн тухай хууль. МУ. УИХ. (05. 22.) УБ., 2012.
8. Концесийн хууль УБ., 2010. (06 28)
9. Үндэсний аюулгүй байдлын тухай хууль. МУ. УИХ. УБ., 2001..
10. Өндөр технологийн аж үйлдвэрийн талаар төрөөс баримтлах бодлого. (төсөл) УБ., 2010
11. Цахим гарын үсгийн тухай хууль. МУ. УИХ. УБ., 2011.
12.

Хоёр. Монгол хэл дээр хэвлэгдсэн судалгааны бүтээлүүд:

1. Балдангомбо.О. Мэдээлэл харилцаа холбооны салбарын шилдэг илтгэл. УБ., 2007
2. Ганболд.Р. Мэдээллийн технологийн хөгжлийн өнөөгийн байдал, цаашдын зорилт. МУЗГТА, МХХТГ ажлын хэсгийн ахлагч. Ганхуяг. УБ., 2005
3. Друкер.П.Ф. Мэдлэгийн менежмент. УБ., 2007
4. Друкер.П.Ф. XXI зууны менежментийн үүрэг ба сорилт. УБ., 2012
5. Довчин.Ё. Харьцуулсан улс төр. УБ., 2012
6. Өнөржаргал.Л. Мэдлэгийн нийгэм соёлын асуудал. УБ., 2003
7. Сайнхишиг.Г. Нийгмийн тэгш бус байдлыг бууруулах нь нийгмийн бодлогын зорилт мөн. Хиагт 2006, ОУЭШХ
8. Сайнхишиг.Г. Шинжлэх ухаан-техникийн нөхцөл дэх байгаль нийгмийн харилцан үйлчилгээ; Шинжлэх ухаан-техникийн хувсгал ба түүний үр дагавар. УБ., 1974
9. Сүрэнжав.Г. Шинжлэх ухаан технологийн хөгжлийн нөхцөл дэх хөдөлмөрийн нийгэм, философийн асуудал. УБ., 2002,
10. Тоффлер.О. Эрх мэдлийн огцом хувирлууд. УБ., 2007
11. Чулуунбаатар.Г. XX, XXI зууны зааг үеийн монгол дахь иргэний нийгмийн төлөвшил, хөгжил. УБ., 2000.
12. Чулуунбаатар.Г. XX, XXI зууны зааг үеийн монголын нийгэм иргэншлийн өөрчлөлт, УБ., 2008

13. Чулуунбаатар.Г. XX, XXI зууны зааг үеийн монголын улс төрийн өөрчлөлт, ардчиллын хөгжил УБ.,2009
14. Чулуунбаатар.Г. Саруул.А, Ган-Өлзий.Б ба бусад. Ардчилсан засаглал, нээлттэй нийгмийн нэвтэрхий толь " UNDP, ННФ УБ., 2006

Гурав. Илтгэл, өгүүлэл, судалгааны тайлан бусад материал:

1. Ц.Батбаяр. "*Ю.В. Яковец. Онолын ирээдүй дэх аж үйлдвэржсэний дараах нийгэм гэдэг үечилсэн хөгжлийн парадигм бүрэлдэж байгаа нь*" ШУАФСЭХ-ийн Философи эрхийн судалал. № XXIII, УБ., 2008.
2. Ц.Батбаяр. "*Орчин үеийн нийгмийн өөрчлөлтийг судлах онол, арга зүйн зарим асуудал*" "Философи, онол практик" МУИС-ийн философийн салбарын 45 жилийн ой УБ., 2010
3. Ц.Батбаяр. "*Постмодерн нийгэм ба философи*" Эрдмийн ертөнц сэтгүүл \1\02\. УБ., 2010
4. Ц.Батбаяр. "*Аж үйлдвэржсэн нийгмээс мэдээллийн нийгэмд*" Эрдмийн ертөнц сэтгүүл \1\01\ УБ., 2011
5. Ц.Батбаяр. "*Мэдлэгийн эдийн засаг ба орчин үеийн нийгмийн өөрчлөлт хандлагад нөлөөлөгч хүчин зүйлс*" өгүүлэл, Эрдмийн ертөнц сэтгүүл \1\06\ УБ., 2012
6. Ц.Батбаяр."*Аж үйлдвэржсэний дараах нийгэм ба үйлчилгээний технологийн асуудалд*" МУИС-ийн НШУС. Философи шашин судлал (PRS) сэтгүүл Volume XIII 65\371\ -т УБ., 2012
7. Ц.Батбаяр. "*Аж үйлдвэржсэний дараах нийгмийн үндсэн хүрээнүүдэд гарч буй өөрчлөлтөд хийсэн философи, социологийн дүгнэлтүүд*" Mongolica ulaanbaatattensia. Volume III. УБ., 2012
8. Ц.Батбаяр. "*Д.Белл. Ирж буй аж үйлдвэржсэний дараах соёл иргэншлийн дүр зураг*". Соёл судлаачдын үндэсний семинар. УБ., 2010.
9. Ц.Батбаяр. "*Хүн төрөлхтний ертөнцөд ирж буй аж үйлдвэржсэний дараах соёл иргэншлийн дүр зургийн тухай философи, социологийн тэмдэглэл*". Нийгэм, хүмүүнлэгийн ухааны тулгамдсан асуудлууд. ЭШБХ, УБ., 2009
10. Ц.Батбаяр. "*Нийгмийн системд иргэний нийгмийн үнэт зүйлсийн эзлэх байр суурь*", Дэлхийн зөн, Боловсрол-2007, ЭШБ, УБ., 2007
11. МХХ-ны салбарын шилдэг илтгэл. Монгол улсын цахим засгийг хөгжүүлэх боломжит арга зам буюу төрийн эрх баригчдад тавих асуулт. УБ., 2007
12. Мэдээлэл холбоо технологийн хөгжлийн судалгаа. УБ., 2008
13. Мэдээлэл, шуудан, харилцаа холбооны салбарын 90 жил, ICT-90-EXPO. УБ., 2011
14. Харилцаа холбооны зохицуулах хорооны 2009-2012 оны үйл ажиллагааны стратеги, УБ., 2009

15. Боловсролын салбарт МХХТ-ийг 2015 он хүртэл хугацаанд нэвтрүүлэх бодлого, стратеги. УБ., 2011. 04. 05
16. Монголын хэвлэл мэдээлэл өнөөдөр. Хэвлэлийн хүрээлэн мэдээлэл судалгааны алба. УБ., 2012

Дөрөв. Гадаад хэл дээр хэвлэгдсэн судалгааны бүтээлүүд:

1. Белл.Д. Грядущее постиндустриальное общество. М., 1998
2. Белл.Д, Иноземцев.В.Л. Эпоха разобщенности. М., 2007
3. Батбаяр.Ц. Информационное общество и его реальное состояние в современной Монголии". "Философия, социология, политология, культурология. № 14, Улан-Үде., 2012
4. Гнедовский.В.М. Проблемы развития постиндустриального общества в городах США. УДК 316.324.8, ББК 71.4(3). М., 2012
5. Дракер.П.Ф. Посткапиталистическое общество. М., 1999
6. Дашпүрэв.Д. Этапы модернизации современного монгольского общества: социально-философский анализ. М., 1995
7. Дашпүрэв.Д. Диалектика соотношения теории и практики в условиях социализма. М., 1997
8. Дынкина.А.А. Мировая экономика: прогноз до 2020 года. М., 2007
9. Ермолаев.С.А. Разруха в академических головах. Почему капиталистическое общество не может быть постиндусртиальным. М., 2008
10. Кеван.К. Революция услуг в мировой экономике. М., 2007
11. Кузьмин.Е.И, Фирсов.В.Р. Формирование информационного общества в XXI веке. СПб., 2006
12. Иванов.Д.В. Виртуализация общества. М., 2002
13. Иванов.Д.В. Эволюция концепции глобализации //Телескоп. №5 М., 2002
14. Иноземцев.В.Л. Капитализм, социализм или постиндустриальное общество? Коммунист. № 4. М., 1991.
15. Иноземцев.В.Л. Расколотая цивилизация наличествующей предпосылки и возможные последствия постэкономической революции. М., 1999.
16. Иноземцев.В.Л. Теория постиндустриального общества как методологическая парадигма российского обществоведения. Вопросы Философии. № 10. М., 1997
17. Иноземцев.В.Л. Две концепции исторического развития: Марксизм и постиндустриализм. Философские исследования. № 3. М., 1997
18. Төмөр-Очир.С. Научно-обоснованное применение выборочного метода как одна из важнейших условий повышения эффективности и качества конкретно-социологических исследовании. УБ., 1982

19. Цэцэнбилэг.Ц. Проблемы модернизации монгольского общества. УБ., 2002
20. Сайнхишиг.Г. Общие закономерности и особенности возникновения и развития социализма в Монгольской Народной Республике. М., 1979
21. Чулуунбаатар.Г. Монгольский вариант восточного пути развития: В поисках новых теоретико-методологических подходов. М., 1993
22. Юзвишин.И.И. Основы информациологии. М., 2001
23. Яковец.Ю.В. Формирование постиндустриальной парадигмы: истоки и перспективы. Вопросы Философии. №1. М., 1997
24. Якунин.В.И. и др ., Постиндустриализм: опыт критического анализа. М., 2012
25. Bell, D. *The Social Framework of the Information Society*. Oxford University press, 1980.
26. Bell, D. Kristol L. *The Crisis in Economic Theory*. NY, 1981.
27. Bell, D. *The End of Ideology*. Cambridge. (Mass.) – London, 1986.
28. Bell, D. *The World and the United States in 2013*. NY, 1987.
29. Bell, D. *Critisism of Post – industrial society*. NY, 1992.
30. Bell, D. *The coming of post–industrial society. A. Venture in social forecasting* N.Y, 1999.
31. Castells, M. *Working-Class Network Society: Communication Technology and information Have-less in Urban China*. NY, 2009.
32. Masuda, Yoneji. *The information society as postindustrial society*. NY,1981.
33. Naisbitt, J. *Megatrend*. NY, 1982.

МОНГОЛ УЛС ДАХЬ ХЭРЭГ, МАРГААНЫ УЛМААС ХОХИРСОН ИРГЭНИЙ ЭРҮҮЛ МЭНД, АМЬ НАС, СЭТГЭЛ САНААНЫ ХОХИРЛЫГ ТООЦОХ ЭРХ ЗҮЙН ШИНЭТГЭЛИЙН АСУУДАЛ

LEGAL REFORM ISSUES IN MONGOLIA IN CALCULATION OF HEALTH, LIFE AND MENTAL HEALTH DAMAGE OF CITIZENS SUFFERED IN DISPUTES

Ч.Отгонсүрэн
Дотоод хэргийн их сургуулийн Хилийн албаны сургуулийн ахлах багш хууль зүйн докторант, дэд хурандаа
Ch. Otgonsuren
Senior lecturer at School of Border Services, University of Internal Affairs, Ph.D student
Lieutenant Colonel

Хураангуй:
Энэ илтгэлээр хүний амь нас, эрүүл мэнд, сэтгэл санааны хохиролд үнэлгээ хийж буй үйл ажиллагааны эрх зүйн өнөөгийн орчин, тулгамдаж буй зарим асуудлын судалж, цаашид олон улсын жишигт нийцүүлэн боловсронгуй болгох арга замыг эрэлхийлсэн зарим дүгнэлт хийж, санал дэвшүүлжээ.

Abstract:
This research examines the current legal environment for calculating human life, health and emotional damage, and some of the challenges, and makes some suggestions for further improvement within international standards.

Түлхүүр үгс: *Хүний амь нас, эрүүл мэнд, сэтгэл санаа, хохирол үнэлгээ.*

Key words: *human life, health, mental health, calculation of damage.*

Аливаа улсын улс төр, нийгэм эдийн засаг дахь өөрчлөлт шинэчлэл нь эцсийн дүндээ хууль болон эрх зүйн бусад актаар дамжин илэрлээ олдог билээ. Хууль бол нийгмийг хөдөлгөгч хүч. Харин тэрхүү хөдөлгөгч хүчийг залан жолоодох эсэх нь тухайн нийгмийн эд эс болсон хүн. Энэ үүднээс авч үзвэл эрх зүйт төрийн мөн чанар нь хүнийхээ эрх, эрх чөлөөг хэрхэн баталгаажуулан хамгаалснаас ихээхэн хамааралтай байдаг байна.

Олон улсын хэм хэмжээнд Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 2.27 дахь заалт “Хүн бүр эдийн болон сэтгэл зүйн хохирлоо нөхөн төлүүлөн эрхтэй”, Монгол улсын Үндсэн хуулийн 16-р зүйлийн 1 дэх хэсэгт “амьд явах эрхтэй”, 14 дэх хэсэгт “Монгол улсын хууль, Олон улсын

гэрээнд заасан эрх эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх эрхтэй", мөн хүний хувийн амьдрал, эрүүл мэнд, нэр төр, алдар хүндийг хүний үндсэн эрх, эрх чөлөөний нэг бүрэлдэхүүн хэсэг хэмээн тодорхойлж хамгаалахаар заасан байна.

Иймээс өнөө цаг үед тулгамдсан асуудлын нэг болоод байгаа хүний амь нас, эрүүл мэнд сэтгэл санааны эдийн бус гэм хор буюу нэр төр гутаах, гүтгэх гэмт хэрэг үйлдэх явдал, түүнийг арилгах, нөхөн төлүүлэх эрх зүйн харилцааны талаар цогцоор нь авч үзэх шаардлага гарч байна.

Манай улсад үнэлгээний үйл ажиллагаа үүсч хөгжөөд 20 гаран жилийн хугацаа өнгөрч байна. Хувийн хэвшлийн төлөвшил, өмчийн харилцааны эрх зүйн өөрчлөлтийг даган үнэлгээний үйл ажиллагааны хэрэгцээ, шаардлага улам бүр нэмэгдэж байгаа тул 2010 онд Хөрөнгийн үнэлгээний тухай Монгол Улсын хууль батлагдаж, үнэлгээний үйл ажиллагааны эрх зүйн үндсийг бүрдүүлсэн байдаг.

Хууль эрх зүйн орчны хувьд Иргэний тухай хуульд хүний амь нас, эрүүл мэнд хохирлыг төлүүлэх тухай 23 заалт, Эрүүгийн холбогдох хууль тогтоомжуудад эрүүл мэнд болон амь настай холбоотой харилцааг зохицуулсан нийт 65 заалт орсон байна. Тухайлбал, Иргэний тухай хуулинд сэтгэл санааны хохирол энэ хуулийн 21 дүгээр зүйл Иргэний нэр, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг хамгаалах; 511 дүгээр зүйл Эдийн бус гэм хорыг арилгах "хохирогчийн сэтгэл санаанд учирсан үр дагавар зэргийг харгалзан нэхэмжлэгчийн шаардлагын хүрээнд мөнгөөр тооцож тогтоох" тухай заалтууд байна.

Дээрх хууль тогтоомжуудад гэмт хэргийн улмаас учирсан хохирлын үнэлгээ тогтоох харилцааг тодорхой түвшинд эрх зүйн зохицуулалтаар тусгасан байна. Харамсалтай нь бодит амьдрал дээр гэмт хэргийн улмаас учирсан хохирлын үнэлгээг тогтоох тогтолцоо учир дутагдалтай, эрх зүйн орчин бүрэн шийдэгдээгүй байна.

Сэтгэл санааны хохирлын үр дагаврыг шийдвэрлэсэн байдал (ЭХХШтХ-ийн 45.4 дүгээр зүйл[1])

Шүүхийн шийдвэрийн цахим сангаас түүвэрлэн судалсан нийт 41 иргэний хэргийн шүүхийн шийдвэрт сэтгэл санааны хохирлыг нэхэмжилсэн байх бөгөөд үүнээс 22 хэрэгт сэтгэл санааны хохирлыг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 45.4 дүгээр зүйлд заасныг үндэслэж, мөнгөн дүнгээр хохирлыг үнэлж, гаргуулахаар шийдвэрлэжээ. Иргэний хуулийн 230 дугаар зүйлийн 230.2-т "Гагцхүү хуульд тусгайлан заасан тохиолдолд эдийн бус гэм хорыг мөнгөөр нөхөн

[1] Нээлттэй нийгэм форумын дэмжлэгтэйгээр хийгдсэн судалгааны тоон мэдээлэл, шийдвэрийн судалгаанаас ашигласан болно.

төлнө” гэж заасан, тус хуульд тусгайлсан зохицуулалт байхгүй учир сэтгэл санааны хохирлыг гаргуулах боломжгүй гэж тайлбарлаж шийдвэрлэсэн 19 тохиолдол байх ба ЭХХШтХ-ийн 45.4 дүгээр зүйлийг “тусгайлсан зохицуулалт” гэж үзээгүй байна.

Өөрөөр хэлбэл шат шатны шүүхээс шийдвэртээ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 45.1 дүгээр зүйл, 45.4 дүгээр зүйлд “...эд хөрөнгийн бус хохирол, сэтгэл санаанд учирсан хор уршгийг мөнгөн хэлбэрээр нөхөн төлүүлэх тухай нэхэмжлэл” гаргах эрх үүссэн гэж үзсэн атлаа тухайн хохирлыг нөхөн төлүүлэх нарийвчилсан зохицуулалт байхгүй гэх зөрчилтэй хууль зүйн дүгнэлт хийжээ. Мөн Иргэний хуулийн 498 дугаар зүйлийн 498.4-т заасан “...хууль бусаар яллагдагчаар татагдсан, ял шийтгүүлсэн, баривчлагдсан, саатуулагдсан буюу гадагш явахгүй гэсэн баталгаа өгсөн, захиргааны журмаар баривчлагдсан этгээдийн зөрчигдсөн эрхийг сэргээсэн тохиолдолд түүнд учирсан хохирлыг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор болон шүүгчийн буруутай эсэхээс үл хамааран төр хариуцан арилгах үүрэгтэй” гэсэн нь мөн хуулийн 230 дугаар зүйлд заасан эдийн бус гэм хорыг мөнгөн хэлбэрээр төлүүлэх “тусгайлан заасан тохиолдол” гэж шууд дүгнэх боломжгүй гэж шийдвэрлэжээ.

Иргэний хэргийн шүүх, шүүгчийн харилцан ялгамжтай байдлаар сэтгэл санааны хохирлыг тооцож олгож байгаа, мөн зарим хэрэгт олгохгүй байгаа шалтгаан тодорхой бус байна. Сэтгэл санааны хохирол нэхэмжилсэн 41 хэргийн 22 хэрэгт сэтгэл санааны хохирлыг тооцож олгосон боловч юуг үндэслэж, хэрхэн тооцож олгосон нь тодорхойгүй.

Жишээ 2. Иргэн У.Б нь Эрүүгийн хуулийн 148 дугаар зүйлийн 148.4-т зааснаар эрүүгийн хэрэг үүсгэж, улмаар Хан- Уул дүүргийн шүүх түүнд 200,000 төгрөгийн эд хөрөнгө хураах, 10 жил 1 сар хорих ял ногдуулсан. Нийслэлийн шүүхэд давж заалдсанаар 2013 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 202 тоот магадлалаар У.Б-д холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгож, түүнийг цагаатгасан. 2011 оны 10 дугаар сарын 25-аас эхлэн шүүхээр цагаатгагдах хүртэл нийт 503 хоног шалгагдаж, 87 хоног цагдан хоригдсон. Нэхэмжлэгч сэтгэл санааны хохиролд 25,000,000 төгрөгийг нэхэмжилсэн бөгөөд шүүхээс онц хүнд гэмт хэрэгт 2 жил мөрдөн шалгагдсан, 10 жил 1 сарын хорих ялаар шийтгүүлсэн, 87 хоног хоригдсон зэрэг нөхцөл байдлыг харгалзан үзэж түүнд учирсан сэтгэл санааны хохирлыг (25,000,000x1/3) 8,000,000 төгрөгөөр тооцон сэтгэл санааны үр дагаврыг арилгуулж, үлдэх 17,000,000 төгрөгийг хэрэгсэхгүй болгосон байна.

Сэтгэл санааны хохирлын хэмжээг тооцон олгохдоо нэхэмжлэгчийн нэхэмжилсэн сэтгэл санааны хохирлын мөнгөн дүнг тооцохдоо ямар нэгэн аргачлал эсхүл жишиг харгалзаагүй бөгөөд анх нэхэмжилсэн үнийн

дүнгийн 30 хувьтай тэнцэх хэмжээний нөхөн олговрыг үзэмжээр тогтоожээ.

Жишээ 3. Д.М-ийг Нийгмийн даатгалын сангаас тэтгэврийн мөнгө давхардуулан авч нийгмийн даатгалын санд 6,832,250 төгрөгийн хохирол учруулсан хэрэгт шалгаад хэргийг хэрэгсэхгүй болгон шийдвэрлэжээ. М нь сэтгэл санаа, эрүүл мэндийн хохиролд 202,219,400 төгрөгийг нэхэмжилсэн байна. Сум дундын иргэний шүүхийн шийдвэрээр мөрдөн шалгагдсаны улмаас сэтгэл санааны хохирлын үр дагаврыг тухайн үеийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ болох 192,000 төгрөгийг 26 сараар үржүүлэн бодож 4,992,000 төгрөгийг олгосон байна.

Мөн сэтгэл санааны хохирлын хэмжээг тогтоохдоо хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хэрэгт шалгагдсан хугацаанд үржүүлэн тооцож мөнгөн дүнг тогтоосон боловч энэ аргачлалаар бодох болсон үндсэн шалтгааныг дурдаагүй ажээ. Монгол Улсад 2017 оноос өмнө үйлчилж байсан 2002 оны Эрүүгийн хуульд гэмт хэргийг ангилах, гэмт хэргийн хохирлын хэмжээг тогтоох болон цагдан хоригдсон хоногийг хорих ялаар солих зэрэгт хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг баримталж байсан ба хөдөлмөрийн харилцааны энэ ухагдахууныг шүүхийн практикт өнөөг хүртэл сэтгэл санааны хохирлыг тооцоход хэрэглэж байгаа нь зохисгүй юм.

Жишээ 4. 1995 оны 2 дугаар сарын 6-ны өдөр уурын зууханд иргэн Б нь шатсан байдалтай олдсон хэрэгт иргэн Г-г 22 жилийн турш холбогдуулан шалгасан. Г нь 15 жил гадуурхагдан доромжлуулж сэтгэл санааны хувьд хүнд нөхцөлд байж байгаад 2011 оны 12 дугаар сарын 21-ний өдөр өвчний улмаас нас барсан. Түүний эхнэр 21 жилийн дараа тухайн хэргийг цагаатгаж шийдвэрлэсний дараагаар шүүхэд сэтгэл санааны хохиролд 500,000,000 төгрөгийг нэхэмжилсэн байна. Шүүхээс Б-г 77 хоног цагдан хоригдсон, 1995 оны 5 дугаар сарын 15-ны өдрөөс 2016 оны 6 дугаар сарын 14-ний өдрийг хүртэл 21 жил бусдын батлан даалтад өгөх таслан сэргийлэх арга хэмжээтэй байлгасан зэргийг харгалзан сэтгэл санааны хохиролд 10,000,000 төгрөгийг гаргуулахаар шийдвэрлэсэн

Жишээ 5. Нэхэмжлэгч О нь 2016 оны 1 дүгээр сарын 5-ны өдөр хүнийг алах гэмт хэрэгт сэжиглэгдэн 2016 оны 1 дүгээр сарын 6-ны өдрөөс шүүгчийн захирамжаар баривчлагдан МУ-ын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 91 дүгээр зүйлийн 91.1 дэх хэсэгт (хүнийг санаатай алах) зааснаар ял сонсгож яллагдагчаар татагдан 119 хоног цагдан хоригдсон. Нэхэмжлэгч сэтгэл санаанд учирсан хохирлын үр дагаварт 10,000,000 төгрөг нэхэмжилснийг хангаж шийдвэрлэсэн байна.

Сэтгэл санааны хохирлын үр дагаврын хохирлыг мөнгөн дүнгээр үнэлж, барагдуулахаар шийдвэрлэсэн 22 иргэний хэргийн шүүхийн шийдвэрээс 7 хэрэгт *(10 сая төгрөгөөс дээш мөнгөн дүнгээр сэтгэл санааны хохирлын*

үр дагаврыг үнэлсэн, эсхүл тухайн хэрэгт цагдан хоригдсон) ЭХХШтХ-ийн 45 бүлэг, Иргэний хуулийн 498 дугаар зүйлд заасан заасан хэм хэмжээг үндэслэж, нэхэмжилсэн үйл баримтыг үнэлэхгүйгээр нийтлэг байдлаар 10,000,000 төгрөгөөр тогтоожээ. Энэ нь тодорхой цаг хугацаанд шийдвэрлэсэн жишгийг харгалзан гаргасан шийдвэр байж болох талтай. Мөн сэтгэл санааны хохирлын мөнгөн дүнг тогтоосон үндэслэл бүхий баримт байдаггүй учир шүүгчийн дотоод итгэл үнэмшил, тухайн хэргийн өмгөөлөгчийн ур чадвар, нотлох баримт цуглуулж, бэхжүүлсэн байдал, нэхэмжлэлийн шаардлагын хүрээнд сэтгэл санааны хохирлыг шийдвэрлэж байна. Зарим тохиолдолд сэтгэл санааны хохирлыг нотлох баримт шаардахгүйгээр барагдуулж, зарим тохиолдолд заавал олон нийтийн сүлжээ, хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэгдэж, цагдан хоригдсон байх ёстой гэж үзэж хэргийг шийдвэрлэжээ.

Жишээ 6. УДШ-ийн 2018 оны 12 дугаар сарын 4-ний өдрийн 1759 дугаартай Б.О-гийн нэхэмжлэлтэй хэрэгт “.... Б. О-гийн 50,000,000 төгрөг гаргуулах шаардлага нь 21 жилийн турш сэжигтэн, яллагдагч, таслан сэргийлэх арга хэмжээтэй байснаас өөрт учирсан хохирлоо “сэтгэл санааны хохирол” гэж илэрхийлсэн байна. О-гийн шүүхэд гаргасан хүсэлтийн агуулга, хэрэгт авагдсан баримт, тайлбараас үзэхэд тэрээр хилс хэрэгт нийт 134 хоног цагдан хоригдсон, 21 жил сэжигтэн, яллагдагч байсан, 21 жил таслан сэргийлэх арга хэмжээтэй байснаас сэтгэл санаа, эд хөрөнгө, нэр төрд учирсан хохирлоо гаргуулахаар шаардсан. Нэхэмжлэгч нь “... энэ хэргээс болж ажилгүй болсон, хамгийн бага хэмжээгээр тэтгэвэр тогтоолгосон, үр хүүхдээ харж хандаж, боловсрол эзэмшүүлж чадаагүй, нутаг орныхон дунд гэмт хэрэгтэн нэр зүүсэн, талийгаачийн гэр бүлийнхэн түүнтэй алуурчин гэж харьцдаг байсан, орох байх газаргүй болж хог түүж амьдарч байсан, бусдын дарамт, сүрдүүлэгт байсан...” тухай тайлбарыг шүүхэд ирүүлсэн байна. Хэрэгт авагдсан баримтаас үзэхэд О-гийн дээрх тайлбарыг няцаах баримтгүй, түүнчлэн гэрч нарын мэдүүлгээр түүний эрх чөлөөнд халдаж байсан гэж үзэхээр нөхцөлүүд гарч байжээ. О-гийн холбогдсон эрүүгийн гэмт хэргийн ангилал, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 86 дугаар зүйлийн 1, 200 дугаар зүйл гэх хоёр зүйл ангиар сэжигтэн, яллагдагчаар татагдан шалгагдаж, улмаар 21 жилийн хугацаанд сэжигтэн, яллагдагчаар тооцогдсон, түүнд авсан цагдан хорих, бусдын даалтад өгөх таслан сэргийлэх арга хэмжээ авагдаж байсан хугацаа зэргийг харгалзан 50,000,000 төгрөгийг нэхэмжлэгчид олгохоор анхан шатны шүүх шийдвэрлэснийг буруутгахгүй. Нэгэнт Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар “...эд хөрөнгийн бус хохирол, сэтгэл санаанд учирсан хор уршгийг мөнгөн хэлбэрээр нөхөн төлүүлэх тухай нэхэмжлэл” гаргах эрхийг нэхэмжлэгчид олгосон байхад зөвхөн Иргэний хуульд тусгайлсан зохицуулалт байхгүй гэсэн үндэслэл

зааж хүсэлтийг хэрэгсэхгүй болгох нь Иргэний хуулийн 1 дүгээр зүйлийн 1.2-т заасан "...иргэний эрх үүргийг ямар нэг хязгаарлалтгүйгээр хэрэгжүүлэх, зөрчигдсөн эрхийг сэргээлгэх, шүүхээр хамгаалуулах зарчим"-д нийцэхгүй. Иймээс О-д холбогдуулсан эрүүгийн хэргийн зүйл, анги, тэрээр 134 хоног цагдан хоригдсон, 21 жилийн турш сэжигтэн, яллагдагч байсан, 21 жил таслан сэргийлэх арга хэмжээтэй байсан нь хэрэгт авагдсан баримтаар тогтоогдож байх тул Иргэний хуулийн 511 дүгээр зүйлийг төсөөтэй хэрэглэж, 230 дугаар зүйлийн 230.2-т зааснаар нэхэмжлэгчид учирсан хохирлыг гаргуулах нь Иргэний хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2-т нийцнэ" гэж дүгнээд сэтгэл санааны хохирол гаргуулан шийдвэрлэжээ

Ийнхүү иргэний хэргийн хяналтын шатны шүүхээс нэхэмжлэгчийн онцлог байдал, олон жилийн сэтгэл санааны дарамтад орж байсныг харгалзан сэтгэл санааны хохирол гаргуулан шийдвэрлэжээ. Гэвч өөр нэг шийдвэрт нэхэмжлэгч эдийн бус бус гэм хорыг нэхэмжлэх эрхтэй ч түүнийг хангахгүй гэсэн дүгнэлтийг хийсэн байна. Тухайлбал УДШ-ийн 2020 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн 179 дугаартай хэрэгт "....Процессын эрх зүйг зохицуулсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 45.4 дүгээр зүйлийн 1-д болон Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д эдийн бус гэм хорын хохирол гаргуулахаар шүүхэд хандах эрхтэйг журамласан явдал нь тухайн нэхэмжлэлийг хангах хууль зүйн үндэслэл болохгүй" гэж шийдвэрлэжээ.

Мөрдөгч, прокурор, шүүгчийн хууль зөрчсөн ажиллагааны улмаас учирсан эд хөрөнгийн хохирлыг нөхөн төлүүлэх, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд, эрүүл мэнд, сэтгэл санааны үр дагаврыг арилгуулах болон тэтгэвэр, тэтгэмж авах, орон сууц эзэмших болон бусад эрхээ нөхөн сэргээлгэх эрхтэй холбоотойгоор иргэний журмаар хянан шийдвэрлэгдсэн шүүхийн шийдвэрийн цахим санд байгаа нийт 96 шүүхийн шийдвэртэй танилцаж үзэхэд дараах нөхцөл байдлууд тогтоогдлоо. Үүнд:

- Нэхэмжлэгчийн гаргасан нэхэмжлэлээс хууль зүйн туслалцаа авахад төлсөн хөлсийг хамгийн их буюу 79 хэрэгт, хууль бусаар цагдан хоригдсон, хэрэгт шалгагдсаны улмаас хүний аваагүй цалин хөлс болон амьжиргааны үндсэн эх үүсвэр болж байсан хөдөлмөрийн бусад орлогыг 59 хэрэгт гаргуулахаар шийдсэн байна. Өөрөөр хэлбэл одоогийн шүүхийн практикт дээрх хоёр төрлийн хохирлыг гаргуулан шийдвэрлэх практик тогтжээ.
- Цагдан хоригдсон 1 хоногийг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнд тэнцүүлж олгож байгаа бол, зарим тохиолдолд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэг сард хуваан дүйцүүлэн тооцуулж олгож байна. Мөн сэтгэл санааны хохирлыг тогтсон үнийн дүнгээр биш хэрэгт

шалгагдсан хугацаагаар нь хөдөлмөрийн хөлсний доод үнээр дүйцүүлж авсан тохиолдол ч байна.

- Нэхэмжлэгчийн өмгөөлөгч, итгэмжлэгдсэн төлөөлөгчийн ур чадвар, нэхэмжлэлийн шаардлага, нотлох баримт цуглуулж, тооцуулах зэрэг асуудал нь иргэний хэргийн шүүхийн шийдвэрт шууд нөлөөлжээ. Тухайлбал, нэхэмжлэгчийн өмгөөлөгч, итгэмжлэгдсэн төлөөлөгч ур чадвар сайтай бол цагдан хоригдсон хоногийн мөнгөн дүн, олох ёстой байсан орлого, цалин хөлс, сэтгэл санааны хохирлыг өндөр мөнгөн дүнгээр тооцуулан шийдвэрлүүлдэг. Эндээс шүүх хуулийг харилцан адилгүй хэрэглэж, хохирлыг илт зөрүүтэй тогтоож байна хэмээн дүгнэж болохоор байна.

Одоогийн байдлаар Монгол Улсад энэ чиглэлээр судалгаа, шинжилгээний ажил төдийлөн хийгдээгүй, гадаадын зарим улс орнуудын туршлагыг судлах зэргээр л хязгаарлагдаж байгаа ба энэхүү салбарын хувьд харьцангуй шинээр судлагдаж нийгэм, эдийн засгийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн судлах зэрэг асуудлуудыг нэн яаралтай шийдвэрлэх хэрэгтэй болж байгаа билээ.

Энэ чиглэлээр судалгааны шинжилгээний ажлыг түлхүү явуулахын зэрэгцээ Монголын криминалистикийн холбооноос хэрэгжүүлж буй судалгаа, төслийн ажилд үе шаттайгаар судлаачийн зүгээс оролцож, хэрэг маргааны улмаас учирсан эдийн засгийн, эд хөрөнгийн хохирлыг үнэлгээг тогтоох асуудлыг судлаж байна.

Эрх зүй өндөр хөгжсөн зарим улс оронд гэм буруутай этгээдээс сэтгэл санааны хохирлыг нэхэмжилж барагдуулах, гэм буруутай этгээд тогтоогдоогүй бол эд хөрөнгө бие эрхтэнд учирсан хохирлоос гадна сэтгэл санаанд учирсан хохирлыг төрөөс нөхөн төлж барагдуулдаг тогтолцоо байдаг. Тухайлбал, Их Британи улс бага зэргийн сэтгэл санааны хохирлыг 1290- 4900 фунт стерлингээр үнэлдэг байна. Харин дунд зэргийнх бол 4.9-45 мянга, хүнд зэргийн сэтгэл санааны хохирол учирсан хэмээн үзвэл 45-96 мянга хүртэлх фунт стерлингээр үнэлж, тооцдог аж. Эдгээрийг төгрөгт хөрвүүлэн тооцож үзвэл сэтгэл санааны хохирлыг 4-300 сая хүртэлх төгрөгөөр үнэлдэг байна. Хойд хөршийн Иргэний хуульд “Сэтгэл санааны хохирол гэдэг нь иргэний хувийн эдийн бус эрх, эсхүл түүнд хамааралтай эдийн бус баялгийг зөрчсөн үйлдлийн улмаас учирсан болон бусад хуульд заасан тохиолдолд биеийн болон сэтгэл санааны зовлон шаналал байна” хэмээн томъёолжээ.

Сэтгэл санааны хохирол, амь насны хохирлыг үнэлж буй байдал

Сэтгэл санааны хохирлыг мөнгөн хэлбэрээр төлөх ба хохирогчид учирсан биеийн болон сэтгэл санааны зовлон шаналалын шинж чанар,

хохирол учруулсан нөхцөл байдал зэргийг харгалзан нөхөн төлбөрийн хэмжээг шүүх тогтоож байхаар хуульчилсан байна.

Харин урд хөршийн хувьд эдийн бус гэм хорыг тооцох аргачлалгүй ч тухайн хэргийн нөхцөл байдлыг харгалзан шүүхээс тогтоодог аж.

Германы хувьд сэтгэл санааны гэм хорыг арилгахад тусгай аргачлал боловсруулсан бөгөөд үүнийг шүүх шийдвэр гаргахдаа мөрдлөг болгодог байна.

Хохирлын хэмжээг тодорхойлохдоо хариуцагчийн гэм буруу, хохирогчид бий болсон сөрөг үр дагавар, хариуцагчийн эд хөрөнгийн байдал зэргийг харгалзан үздэг. Өмнөд Солонгосын хувьд сэтгэл санааны хохирлын суурь төлбөрийг 80 сая вонноор үнэлдэг аж. /Монголоор 191.200.000/ сая төгрөг.

Хүний эрхийн хуульч М.Ичинноров нэгэн илтгэлдээ “Хүний алтан амийг мөнгөөр үнэлэх боломжгүй ч мөнгөн дүнгээр илэрхийлдэг систем байдаг. Хүний амь насны эдийн засгийн үнийг тооцохдоо дундаж наслалтаас насыг нь хасаж, дотоодын нийт бүтээгдэхүүний нэг хүнд ногдох тоогоор үржүүлж гаргадаг жишиг бий. Үүгээр бодоход монгол хүний эдийн засгийн үнэ цэнэ 150-300 сая орчим төгрөг болохоор байна. Гадаадын зарим оронд 50, 125 мянган ам.доллараас эхлээд долоон сая ам.доллараар тооцож байна” хэмээн дурджээ.

Дээрх байдлаар Олон улсын судалгааны мэдээллүүд ихээхэн байгаа боловч Монгол улсад дараах аргачлалыг Монголын хохирол үнэлэгчдийн холбооны гишүүд сэтгэл санааны хохирлын хэмжээг тооцох аргачлалыг 2016 онд боловсруулжээ.

Аргачлалыг хэрхэн хэрэгжүүлэх талаар товч харуулахад:

- Алдагдсан боломжийн үнэлгээ
- Сэтгэл санааны хохирлын үнэлгээ
- Шууд зардал буюу баримтаар нотлогдох хохирлуудыг багтаан эрүүл мэнд, сэтгэл санааны хохирол үнэлгээг тооцоолохоор тогтоосон.

Алдагдсан боломжийн хохирлын үнэлгээ (АБХҮ):

Статистик мэдээнээс Монгол хүний дундаж наслалтын мэдээллийг авч, тэтгэвэрт гарах нас, ажил эрхлэх насны зөрүүгээр идэвхтэй ажиллах жилийг тооцоолно. Тухайн хохирсон хүний ажлаас гарсан өдрөөс тэтгэвэрт гарах өдрийг хүртэл тооцоолж нийт хэдэн өдөр ажиллах боломжоо алдсаныг сард (АБА) шилжүүлж сарын цалингаар (СЦ) үржүүлэн нийт цалингийн алдагдлыг гаргана.

АБХҮ=АБА сарын тоо* СЦ

Шууд зардал буюу шууд хохирлын үнэлгээ (ШЗХҮ):

Шууд зардлыг тухайн хохиролтой холбогдон гарсан баримтаар нотлогдох эмчилгээний зардал (ЭЗ) болон бусад баримтаар нотлогдох зардлуудын (ББНЗ) нийлбэрээр тооцоолно.

ШЗХҮ= ЭЗ+ББНЗ

Сэтгэл санааны хохиролын үнэлгээ (ССХҮ):

Сэтгэл санааны хохирол тооцооллыг мөнгөн дүнгээр илэрхийлэхэд дотоодын нийт бүтээгдэхүүнийг (ДНБ) хүн амын тоонд харьцуулан нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүнийг (НХНДНБ) гаргаж үржүүлэгчээр (МХҮХ-ноос гаргасан 5.5) үржүүлэн хүний амь насны үнэлгээг гарна. Гарсан тоог хуанлийн хоногт (ХХ) харьцуулахад нэг өдрийн сэтгэл санааны хохирлын суурь үнэлгээ(НӨССХСҮ) гарна.

Хохирлоос үүссэн үйлдэл байдал	Итгэлцүүр
Сэхээн амьдруулах	5.0
Мэс засал, хагалгаа	4.0
Эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн	2.0
Зовиуртай байсан	2.0
Энгийн зовиур	1.0
Хөдөлмөрийн чадвар алдалтын хувиар	0-1.0

Энэхүү үржүүлэгч болон итгэлцүүрийг МХҮХ-ноос боловсруулан гаргасан болно.

Сэтгэл санааны хохирлын нийт үнэлгээг гаргахад эмнэлэгт хэвтсэн хоногийг (ЭХХ) дээр тооцоолон гаргасан сэтгэл санааны хохирол тооцох нэг өдрийн суурь үнэлгээг холбогдох итгэлцүүрээр үржүүлэн гаргана. Бусад дээрх итгэлцүүрт хамаарах хохирол үүссэн байвал энэ аргачлалаар тооцоолон гаргах боломжтой байна.

ССХҮ=(НХНДНБ*Үржүүлэгч)/ ХХ)*ЭХХ*итгэлцүүр

Дээрх алдагдсан боломжийн хохирлын үнэлгээ, сэтгэл санааны хохирлын үнэлгээ, шууд зардлуудын хохирлын үнэлгээний нийлбэр нь эрүүл мэнд, сэтгэл санааны нийт хохирлыг (ЭМССХҮ) тооцоолох үнэлгээ болж байна.

ЭМССХҮ=АБХҮ+ШЗХҮ+ССХҮ

Дүгнэлт, санал

Хүний амь нас, эрүүл мэнд гэдэг хүний хамгийн нандин зүйл түүнийг үнэлэх боломжгүй зүйл мэт санагдаж байсан үе саяхан байсан. Гэхдээ хэн нэгэн хохирч байгаа бол түүний хохирлыг арилгах төлөх, эмчлэх нь зүй ёсны хэрэг.

Иймд Монгол улс дэлхий нийтийн жишгийг дагаж хүний амь нас, эрүүл мэнд, сэтгэл санааны гэм хорыг үнэлэх үнэлгээний аргачлал боловсруулах, Сэтгэл санааны гэм хорын асуудлыт зөвхөн нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутааснаар хязгаарлах биш, Иргэний хуулийн 511-р зүйлд гэмт хэргийн улмаас хохирогчид учирсан амь нас хохироосны сэтгэл санааны гэм хор, эрүүл мэнд хохироосны сэтгэл санааны гэм хорыг арилгах гэж нэмж оруулах шаардлага байна.

Хүний амь нас, эрүүл мэнд, сэтгэл санааны гэм хорын нэхэмжлэлийн шаардлагыг тодорхой хэмжээнд хангаж шийдвэрлэж байгаа боловч сэтгэл санаанд учирсан гэм хорыг мөнгөөр тооцоход бэрхшээлтэйн улмаас энэ асуудлыг шүүхүүд өөр өөрийн арга барил, шүүгч өөрийн дотоод итгэлд тулгуурлан шийдвэрлэж байгааг буруутгах аргагүй бөгөөд цаашид тус үнэлгээний аргачлалын дагуу хийсэн шинжээчийн дүгнэлтийг харгалзан үзэж шийдвэрлэдэг болох боломжтой.

Мөн Хохирлын үнэлгээний цогц хуулийн төсөл боловсруулах, батлуулах зэрэг ажлуудыг хийж эхлүүлэх нь зүйтэй юм.

Шүүхээс хүний амь нас, эрүүл мэнд, сэтгэл санааны маргааныг хянан шийдвэрлэхдээ нэхэмжлэгчид эрүүл мэнд, сэтгэл санааны гутрал бий болсон эсэх, ашиг орлогын тооцоо, гэм хорын хохирлын хэмжээ, үг хэллэгийн тайлбар зэрэг тусгай мэдлэг шаардсан асуудлыг шийдвэрлэх боломжийг нарийвчлан зохицуулах арга хэмжээг нэн даруй авч хэрэгжүүлэх нь чухал байна.

--0--

ЭВЛЭРҮҮЛЭН ЗУУЧЛАХ АЖИЛЛАГААНЫ ХӨГЖЛИЙН ОРЧИН ҮЕИЙН ЧИГ ХАНДЛАГА

CONSTITUTIONAL DEVELOPMENT MODERN TRENDS

Ч.Мягмарбаяр
Хил хамгаалах ерөнхий газрын
Хууль, эрх зүйн хэлтсийн хуулийн зөвлөх,
дэд хурандаа
Ch. Myagmarbayar
General Department of Border Protection
Legal Adviser, Legal Division,
Lieutenant Colonel
Ж.Уганчимэг
Дотоод хэргийн их сургуулийн Эрх зүй, нийгмийн ухааны
сургуулийн Хувийн эрх зүйн тэнхимийн
дэд профессор, ахмад
J.Uuganchimeg
Department of Private Law, Law and Social Science institute,
University of Internal Affairs
Associate Professor, Captain

Хураангуй: *Хувийн эрх зүйн шинэчлэлийн хүрээнд шүүхийн ачааллыг бууруулах, маргаан шийдвэрлэх сонголтот хувилбарыг хөгжүүлэх зорилгоор Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийг 2012 онд баталсан. Эвлэрүүлэн зуучлал манай улсын хувьд харьцангуй шинэлэг харилцаа тул дэлхий дахины чиг хандлагыг судлан, өөрсдийн үзэл санааг дэвшүүлэх зорилгоор уг сэдвийг сонгон авч, санал бодлоо хуваалцахыг зорилоо.*

Summary: *The Law on Mediation was adopted in 2012 to reduce the workload of the judiciary and to develop options for resolving disputes within the framework of private legal reform. Because mediation is a relatively new relationship for our country, we chose to study the global trends and then share our views on this topic in order to advance our ideas.*

Түлхүүр үгс: *Эвлэрүүлэн зуучлал, иргэний эрх зүйн маргаан, хөдөлмөрийн ганцаарчилсан маргаан, гэр бүлийн маргаан, орчин үеийн чиг хандлага.*

Keywords: *Mediation, civil law disputes, individual labor disputes, family disputes, current trends.*

Удиртгал:

Манай улсын хувьд мэргэд өвгөдөөс үлдээсэн эв эеэ хичээх тухай сургаалаар баялаг орон билээ. Харин 21-р зууны эрх зүйн тогтолцоонд энэхүү сургаал бүрэн дүүрэн хэрэгжих нөхцлийг бүрдүүлж, шүүхийн ачааллыг бууруулах, нөгөө талаас маргаан шийдвэрлэх сонголтод хувилбарыг хөгжүүлэх үүднээс эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийг 2012 онд батлан иргэний эрх зүйн маргаан, хөдөлмөрийн ганцаарчилсан маргаан, гэр бүлийн маргаанд эвлэрүүлэн зуучлалыг хэрэглэхээр хуульчилсан. Энэ хүрээнд иргэний хэргийг анхан шатны журмаар хянан шийдвэрлэж буй 33 шүүхэд ажиллах орон тооны 42 эвлэрүүлэн зуучлагчийг сонгон бүртгэж, шүүхийн тамгын газрын даргын тушаалаар томилсноор шүүх дэх эвлэрүүлэн зуучлалын ажиллагаа хэрэгжих нөхцлийг бүрдүүлсэн.

Монгол Улсад эвлэрүүлэн зуучлах тогтолцоо бүрэлдэн тогтоод багагүй хугацаа өнгөрч байгаа хэдий ч эрх зүйн зохицуулалтын хувьд шийдвэрлэх, тулгамдаж байгаа асуудлууд цөөнгүй байна. Тухайлбал, иргэн, хуулийн этгээд эвлэрүүлэн зуучлах ажиллагааны ач холбогдол, процессын давуу байдлыг ухамсарлаагүй, мөн эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд хүндэтгэлгүй хандах, ирэхгүй байх, гэр бүлийн маргааны тухайд эвлэрүүлэн зуучлах ажиллааг зөвхөн урьдчилан шийдвэрлэх журам, шүүхийн шат дамжлага мэтээр буруу ойлгох, нөгөө талаас эвлэрүүлэн зуучлагчийн орон тоо бага, зуучлагчийн сургалт дутмаг, тогтвор суурьшилтай ажиллах боломж муу зэрэг нь эрх зүй, зохион байгуулалтын арга хэмжээг сайжруулж, боловсронгуй болгох шаардлагыг нөхцөлдүүлж, сэдвийг судлах хэрэгцээг бий болгож байна. Иймд гадны орны жишгийг өөрийн орны эвлэрүүлэн зуучлалын тогтолцоотой харьцуулан судалж, зохих дүгнэлт, саналыг дэвшүүлэхийг зорилоо.

1.Эвлэрүүлэн зуучлах үйл ажиллагааны тухай ойлголт, эрх зүйн зохицуулалт

Эвлэрүүлэн зуучлал гэдэг нь маргалдагч талуудыг гуравдагч этгээдийн оролцоотойгоор харилцан тохиролцоонд хүргэх ажиллагаа бөгөөд шүүхийн бус аргаар хэрэг маргааныг шийдвэрлэх ажиллагааны нэг төрөл юм.

Эвлэрүүлэн зуучлах ажилагааны давуу талыг дараахь байдлаар тодорхойлж болно.

1. Шүүхээр маргаан шийдвэрлүүлэхтэй холбогдон үүсэх зардалтай харьцуулахад зардал харьцангуй бага
2. Хурдан шуурхай- хуульд зааснаар эвлэрүүлэн зуучлах ажиллагааг 30 хоногт багтаан явуулдаг.

3. Нээлттэй бус байдаг- талууд оролцуулахыг зөвшөөрснөөс бусад этгээдийн хувьд хаалттай
4. Талуудын хоорондын харилцааг хадгалж үлдэх боломжтой.
5. Үйл явцыг зохигч удирдах боломжтой байдаг.
6. Уян хатан байдлаар тохиролцоонд хүрэх боломжтой.

2019-2021 оны хооронд эвлэрүүлэн зуучлагчид гаргасан 11814 өргөдлөөс 1400 өргөдлийг хүлээн авахаас татгалзаж, 1081 өргөдлийг хүсэлт гаргагч өөрийн хүсэлтээр өргөдлөө эргүүлэн татаж, 7710 өргөдлийг шийдвэрлэж, 1671 өргөдлийн үлдэгдэлтэй байна. /График №1/

Шийдвэрлэсэн 7710 өргөдлөөс 5735 буюу 74.4 хувьд нь эвлэрэл амжилттай болж, 1975 буюу 25.6 хувьд нь эвлэрэл амжилтгүй болсон байна. Эвлэрэл амжилттай болсон хувь нь 2019 оны хагас жилд 73.7 хувь байсан бол 2020 онд 0.7 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Монгол улсад Эвлэрүүлэн зуучлалын эрх зүйн орчин хожуу бий болсон ч Монголчууд бидний хувьд уламжлагдан ирсэн ойлголт юм. Тухайлбал: Монголчууд Ахаа алд хүндэл...., мэргэдийн үгийг өв болгон хичээ гэх мэтээр эв еийн тухай сургаалыг дагаж амьдрал ахуйд гарсан маргаанаа /гэр дотроо гэрийн эзэн хэрэг заргыг шүүж, нэгэн хот айл дунд гарсан маргааныг өвгөд настангаа сонсож/ шийдвэрлэдэг байсан.

Эвлэрүүлэн зуучлалыг сүүлийн үед АНУ, Европ, Австралийн олон нийт, хуульчид өргөнөөр хэрэглэж байгаагаас гадна Азийн орнуудын шүүхийн практикт эрчимтэй нэвтэрч байна. Эвлэрүүлэн зуучлах ажиллагааг 20-р зуунд АНУ болон Европын улс орнууд хөдөлмөрийн маргаанд хэрэглэж байсныг эс тооцвол орчин үеийн эвлэрүүлэн зуучлалын эрх зүйн үндсийг тавьсан хүн бол харвардын Их сургуулийн профессор Франк Сандер гэж үздэг. Тэрээр 1976 оны “Паунд” эрдэм шинжилгээний хурал дээр “Маргааныг шийдвэрлэх өөр арга замууд” илтгэлдээ анх “Alternative dispute resolution- шүүхийн бус журмаар маргаан шийдвэрлэх” гэдэг нэр томъёог анх хэрэглэснээр энэ салбарын эцэг хэмээн нэрлэгдэх болсон.[1]

Үүнээс хойш АНУ-ын туршлагаас Канад, Герман, Австрали, Шинэ зеланд, Скандиновын болон Зүүн Европын орнууд зуучлалыг шүүх болон арбитрын практикт нэвтрүүлэх хөтөлбөр хэрэгжүүлсний үр дүнд шүүхийн бус аргаар маргаан шийдвэрлэсэн хэргийн тоо жилээс жилд нэмэгдэж, дээрх аргыг олон улсын худалдаа, интернетийн сүлжээ, үйлчилгээ эрчимтэй хөгжиж байгаа бусад салбарт өргөн хэрэглэх болжээ.

Эвлэрүүлэн зуучлалын давуу талуудыг дэлхий дахинд дараахь байдлаар тодорхойлж байна.

[1] “Хууль дээдлэх ёс” сэтгүүл №6,МУИС-ХЗС-ийн дэд профессор, хууль зүйн ухааны доктор Д.Ганбаатар “Гадаадын орнуудын туршлага ба эвлэрүүлэн зуучлах ажиллагааны үр дагаврыг үнэлэх нь” 61-62 дахь тал.

- Хувийн нууцтай холбоотой мэдээлэл олон нийтэд задардаггүй;
- Ажиллагаа нь уян хатан;
- Процессын харилцан буулт хийх, зөвшилцөх, хүлээцтэй байх чадвартай;
- Мэтгэлцээнийг хамтын ажиллагаагаар солих;
- Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардал, зарлагыг багасгах.

2.Эвлэрүүлэн зуучлах үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг харьцуулан судлах нь

Япон улс: Эвлэрүүлэн зуучлах тогтолцооны 100 гаран жилийн арвин их түүхтэй, улсуудын нэг юм.

Эвлэрүүлэн зуучлах ажиллагааг ADR буюу шүүхийн бус журмаар маргаан шийдвэрлэх арга гэж нэрлэдэг. Япон Улсын ADR-ын төрлүүд:

1. Эрх зүйн ADR Шүүх дэх эвлэрэл (Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх хууль) Шүүх дэх иргэний хэрэг эвлэрүүлэн зуучлах ажиллагаа, гэр бүлийн хэрэг эвлэрүүлэн зуучлах ажиллагаа (Иргэний хэрэг эвлэрүүлэн зуучлах тухай хууль, Гэр бүлийн хэргийг шүүхийн 33 журмаар шийдвэрлэх хууль)

2. Захиргааны ADR Барилгын маргаан хэлэлцэх хороо: Барилгын ажил гүйцэтгэх гэрээтэй холбоотой маргаан (Барилгын тухай хууль) Байгаль орчны бохирдлын улмаас иргэний эрүүл мэндэд хохирол учруулсантай холбогдолтой иргэний маргаан (Байгаль орчны бохирдлын улмаас иргэний эрүүл мэндэд хохирол учруулсан асуудлыг зохицуулах хороо байгуулах тухай хууль, Байгаль орчны бохирдлын улмаас иргэний эрүүл мэндэд хохирол учруулсантай холбогдолтой маргааныг шийдвэрлэх тухай хууль) Хөдөлмөрийн хороо: Хөдөлмөрийн хамтарсан маргаан (үйлдвэрлэгчдийн эвлэрлийн тухай хууль)

3. Олон нийтийн ADR Японы худалдааны арбитрын нийгэмлэг: Худалдааны маргаан Японы өмгөөлөгчдийн холбооны авто ослын зөвлөгөө өгөх төв: Авто ослын маргаан Өмгөөлөгчдийн холбооны арбитрын төв: Бүх төрлийн иргэний болон гэр бүлийн хэрэг маргаан Оюуны өмчийн арбитрын төв: Оюуны өмчийн эрхтэй холбоотой маргаан Орон сууцны маргааны талаар хэлэлцэх хороо: Орон сууцны барилгын асуудалтай холбоотой маргаан зэрэг дараах төрлийн ADR -ийн үйлчилгээ явуулдаг байна.

Хууль эрх зүйн орчны хувьд анх 1922 онд Газар байшингийн түрээстэй холбоотой маргааныг эвлэрүүлэн зуучлалаар зохицуулах тухай хууль батлагдаж, 1948 онд Гэр бүлийн хуульд эвлэрүүлэн зуучлах зохицуулалтыг тусгаж, 1951 онд Иргэний хэрэг шийдвэрлэх тухай хуулиуд,

2004 онд “ Шүүхээс гадуур маргаан шийдвэрлэх механизмыг өргөнөөр ашиглах тухай хууль” батлагджээ. Үүнээс үзэхэд газар нутаг бага, хүн ам ихтэй улсын хувьд газрын болон үл хөдлөх хөрөнгийн түрээстэй холбоотой маргаан их байдаг бөгөөд хэрэг маргааныг эвийн журмаар шийдвэрлэхийг зорьж энэ тогтолцоог хөгжүүлсэн нь маш үр дүнтэй ажил болсон гэж үздэг. Тус улс хувийн хэвшлийн ADR-ийг түлхүү бэхжүүлэх бодлого барьж байгаа нь анзаарагдсан. Хувийн хэвшлийн ADR-ийг баталгаажуулж, шүүхийн ADR-тай өрсөлдөхүйц хэмжээнд болгох зорилтыг төрийн оролцоотойгоор хэрэгжүүлдэг байна. Энэ нь шүүхээс гадуур маргаан шийдвэрлэх оновчтой механизмыг сонгох боломжийг бүрдүүлэн, иргэний эрх, ашиг сонирхлыг зохистой байдлаар хангахад оршдог. Япон улсад Шүүгч 2684, Прокурор 1679, Өмгөөлөгч 26964 байдаг байна.

Япон улсад дараах төрлийн Иргэний хэрэг маргаанд эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулдаг. Үүнд:

а.Байр орон сууц, барилга байгууламж ба ашиглалттай холбоотой маргаан:

- Газрын төлбөр эс бол газрын түрээсийн төлбөрийн үнийн дүнг өөрчлөн тогтоох тухай шаардлага.
- Тариалангийн газар, тариалангийн аж ахуй эрхлэхэд дагалдах газар, барилга байгууламж ба бусад тариалангийн аж ахуйн зориулалттай хөрөнгийн түрээстэй болон ашиглалттай холбоотой маргаан
- Арилжааны маргаан
- Уул уурхай үйлдвэрлэлийн ажиллагаанаас шалтгаалан олон нийтийг хамарсан гамшиг үүссэнтэй холбогдсон нөхөн төлбөрийн маргаан.
- Суудлын автомашин жолоодохтой холбогдсон хүний амь нас, бие махбод хохирсонтой холбогдсон нөхөн төлбөрийн маргаан.
- Үйлдвэрлэлийн ажиллагаанаас шалтгаалан олон нийтийг хамарсан гамшиг үүсэх, нарны гэрлийн тусгалыг хаах, салхины урсгал хаах гэх мэтийн хүний өдөр тутмын амьдралын ашиг сонирхлыг хөндсөнөөс үүссэн маргаан.
- хөдөлмөрийн гэрээ бий эсэх тухай болон бусад хөдөлмөрийн харилцаатай холбогдох асуудлын тухай ажил олгогч ба ажилчин хоёрын хооронд үүссэн иргэний маргаан гэх мэт.

  б.Гэр бүлийн хэрэг маргааны төрөл:

  - Хүүхдийн асран хамгаалагчийг өөрчлөх, хүүхдийн тэтгэлэг шаардах, гэрлэлтийн зардал хуваарилах, хүүхэд гаргаж өгөх, өв хөрөнгө хуваах эхний ээлжид маргалдагч талууд харилцан яриагаар дамжуулан өөрсдөө бие даан маргаан шийдвэрлэхийг

зохистойд тооцох тул ихэнхдээ эвлэрүүлэн зуучлах ажиллагаагаар шийдэхийг урьтал болгодог хэдий ч шүүхийн хянан шийдэх ажиллагаагаар шийдэж ч болно. Зөрчил ихтэй маргааны хувьд эхлээд эвлэрүүлэн зуучлах ажиллагааны журмаар өргөдөл гаргах ба харилцан тохиролцож чадаагүй тохиолдолд шүүхийн хянан шийдвэрлэх журамд шилжин, шүүхээр эцсийн байдлаар шийдэгддэг.

- Гэрлэлт, үрчлэлтийг хүчингүйд тооцуулах, захиргааны журмаар цуцлуулсан гэрлэлт болон үрчлэлтийг хүчингүйд тооцуулах, эцэг эх үр хүүхдийн холбоо байхгүй болохыг тогтоох, эцэг тогтоох, үгүйсгэх гэх мэт.
- Гэр бүл цуцлах болон гэрлэгсдийн эв зүйг нь олуулах, хүлээн авахаар хүлээгдэж буй өвийн тухай гэх мэт хэрэг маргаанд шүүхийн оролцоотой талуудад эвлэрэх боломж олгодог байна.

Тус улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 89 дүгээр зүйлд: Шүүх нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аль ч шатанд эвлэрүүлэхээр оролцох, эсвэл томилогдсон шүүгч буюу даалгавар хүлээн авсан шүүгчээр эвлэрүүлэх оролдлого хийлгэж болно. Иргэний хэрэг эвлэрүүлэн зуучлах ажиллагааны тухай хуулийн 16 дугаар зүйл болон Гэр бүлийн хэрэг маргааныг шүүхийн журмаар хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 21 дүгээр зүйлд: Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны үр дүн шүүхийн шийдвэртэй адил хэмжээнд үйлчлэхээр зуучлах ажиллагааны хүчин төгөлдөр байдлыг тусгаж өгсөн зэргээс үзэхэд Япон улсын шүүх эвлэрэлийн тогтолцоонд чухал үүрэг гүйцэтгэдэг байна.

Хятад Улс: Бүгд Найрамдах Хятад Улсад /цаашид "Хятад" гэх/ 2010 оны 8 дугаар сарын 28-ны өдөр "Бүгд Найрамдах Хятад Улсын Ард төвтэй эвлэрүүлэн зуучлалын тухай хууль" / 2011.01.01 -ээс хэрэгжиж эхэлсэн/ батлагдсанаар Хятадын ард иргэд ADR-ийг илүүтэй сонирхон ашиглах болсон. Хятадад иргэд хоорондын маргаан жилээс жилд нэмэгдэж, Ардын шүүхийн ачаалал нэмэгдсэнээс гадна, "эвсэг нийгэм" -ийг бий болгох зорилгын дор маргалдагч талуудын хэн хэний ашиг сонирхлыг ханган маргааныг уян хатан шийдвэрлэдэг "эвлэрүүлэн зуучлал" гэх мэт шүүхийн бус журмаар маргаан зохицуулдаг механизмын ач холбогдлыг дахин авч хэлэлцэх болсон нь энэхүү хууль батлагдах үндсэн хүчин зүйл болсон гэж үздэг. Монголд ч гэсэн шүүхийн ачаалал их, ард иргэд маргааныг эвийн журмаар шийдвэрлэх сонирхол өндөр байгаа бөгөөд эвлэрүүлэн зуучлах тогтолцоог нэвтрүүлэх хэрэгцээ шаардлагын хувьд Хятадтай адил нөхцөлд байгаа гэж хэлж болно. Иймд Хятадын шинээр хуульчлагдсан эвлэрүүлэн зуучлах тогтолцооны талаар товчхон танилцуулахыг зорилоо.

1. Хятад улсын ADR-ын тогтолцооны Ерөнхий дүр зураг Хятадад эвлэрүүлэн зуучлалыг хэрэгжүүлэгч субъектээс нь шалтгаалан дараах гурван төрөлд ангилдаг байна.[2]

• Ард төвтэй Эвлэрүүлэн зуучлал: Ардын Эвлэрүүлэн Зуучлах Хорооноос хэрэгжүүлдэг эвлэрүүлэн зуучлах үйл ажиллагаа

• Захиргаа төвтэй Эвлэрүүлэн зуучлал: Төр захиргааны байгууллагаас хэрэгжүүлдэг эвлэрүүлэн зуучлах үйл ажиллагаа

• Шүүх төвтэй Эвлэрүүлэн зуучлал: Ардын шүүхээс хэрэгжүүлэн явуулдаг эвлэрүүлэн зуучлах үйл ажиллагаа.

Дээрх гурван төрлөөс "Ард төвтэй эвлэрүүлэн зуучлал"-ын талаар товч авч үзье. Ард төвтэй эвлэрүүлэн зуучлал нь Хятад улс үүсэн байгуулагдсанаас хойш өргөн дэлгэр хэрэглэгдэж ирсэн маргаан шийдвэрлэх арга юм. Ард төвтэй эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 28-31 дүгээр зүйлүүдэд зааснаар ард төвтэй эвлэрүүлэн зуучлалыг “Ардын Эвлэрүүлэн Зуучлах Хороо” хэрэгжүүлэх ба тус хороог хот тосгон, хувийн компаниудын дэргэд, шаардлагатай бол үйл ажиллагааны төрлөөр төрөлжүүлэн байгуулж болно. Хороо нь 3-9 хүний бүрэлдэхүүнтэй бөгөөд нэг ахлах гишүүнийг сонгон томилно. Ардын Эвлэрүүлэн Зуучлах Хорооны чиг үүрэгт иргэд хоорондын маргааныг эвлэрүүлэн зуучлахаас гадна, эвлэрүүлэн зуучлалаар дамжуулан хууль тогтоомж, төрийн бодлогыг иргэдэд таниулах, ард иргэдийг хууль дээдлэх ёсонд сургах, иргэд хоорондын маргаанаас урьдчилан сэргийлэх, төрийн захиргааны байгууллагад үйл ажиллагаагаа тайлагнах зэрэг орно.

Ардын эвлэрүүлэн зуучлагчид тавигдах шаардлага: Эвлэрүүлэн зуучлагчийн хувиар хэргийг шийдвэрлэхэд оролцох этгээдийг Ардын эвлэрүүлэн зуучлагч гэнэ. Тус хуулийн 13 дугаар зүйлд зааснаар Ардын эвлэрүүлэн зуучлагч нь Ардын эвлэрүүлэн зуучлах хорооны гишүүн эсхүл хорооны урилгаар ажиллах этгээд байна. Ардын Эвлэрүүлэн Зуучлагч нь үнэнч шударга, ажил үүрэгтээ идэвх зүтгэлтэй, тодорхой хэмжээний боловсрол, улс төрийн байр суурь, хуулийн мэдлэгтэй 18 насанд хүрсэн Хятад улсын иргэн байна. Ардын Эвлэрүүлэн Зуучлагч нь талуудаас зуучлалын хураамж авахгүй. Түүнчлэн, зарчмын хувьд цалин хөлсгүй ажиллах боловч, өөрийн албан ёсны ажлаасаа чөлөө авч эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд оролцсон тохиолдолд улсаас тэтгэмж авах тухай уг хуулийн 16 дугаар зүйлд заажээ.

Өргөдөл гаргах: Ард төвтэй Эвлэрүүлэн зуучлалыг иргэний хэрэгт хэрэглэнэ.

Ард төвтэй Эвлэрүүлэн зуучлалыг маргааны аль нэг тал өргөдөл гаргаснаар эсхүл Ардын Эвлэрүүлэн зуучлах хорооны зааварчилгааны

[2] Харада Изүми. "Mediation system" гарын авлага. УБ., 2010 он., 27

дагуу эхлүүлнэ. Аль ч тохиолдолд, маргааны аль нэг тал эвлэрүүлэн зуучлалаас татгалзаж буйгаа тодорхой илэрхийлсэн тохиолдолд эвлэрүүлэн зуучлалыг явуулж болохгүй. Жич: Тус хуульд Ард төвтэй эвлэрүүлэн зуучлалын журмаар өргөдөл гаргах газар нутгийн харьяаллын талаар заалт байхгүй бөгөөд Ард төвтэй эвлэрүүлэн зуучлалын журмаар хэрэг хүлээн авах журмын талаар ч заалт байхгүй. Ардын эвлэрүүлэн зуучлах хороо өргөдлийг хүлээн авахдаа тухайн маргаан нь өөрийн үйл ажиллагааны хүрээнд нийцэж байна гэж үзсэн бол өргөдлийг хүлээн авч эвлэрүүлэн зуучлах ажиллагааг эхлүүлж болно.

Ардын эвлэрүүлэн зуучлагчийг сонгон томилох: Тодорхой хэргийг хариуцан ажиллах Ардын эвлэрүүлэн зуучлагчийг Ардын эвлэрүүлэн зуучлах хорооноос сонгон томилж эсхүл талууд өөрсдөө сонгож болдог. Хэрэг тутамд нэг буюу хэд хэдэн зуучлагч ажиллана. Ардын эвлэрүүлэн зуучлагч нь шаардлагатай тохиолдолд талуудын зөвшөөрлийн дагуу тэдний төрөл садангийн хүмүүс болон хөрш, хамтран ажиллагсдыг эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд урьж оролцуулж болохоос гадна, тодорхой салбарын мэргэжлийн мэдлэгтэй хүмүүсийг урьж оролцуулж болдог.

Эвлэрүүлэн зуучлах ажиллагааг хэрэгжүүлэх: Ардын эвлэрүүлэн зуучлагч нь эвлэрүүлэн зуучлах ажиллагааг явуулахдаа хуулийн 3 дугаар зүйлд заасан эвлэрүүлэн зуучлалын үндсэн зарчим буюу 1. Маргалдагч талуудын хүсэл зоригийн чөлөөт илэрхийлэл, эрх тэгш байдлыг хангах зарчим, 2. Хууль тогтоомж, төрийн бодлогыг чандлан сахих зарчим, 3. Маргааныг хэрхэн шийдвэрлэх тухай маргалдагч талуудын сонголт хийх эрхийг хүндэтгэх зарчмуудыг баримтлан, ашигласан хууль тогтоомжоо тодорхойлон, ёс журамтай байж, үнэнч шударгаар ажиллах ёстой бөгөөд тохиромжтой хугацааны дотор эвлэрүүлэн зуучлах ажиллагааг хэрэгжүүлэх үүрэгтэй.

Эвлэрүүлэн зуучлах уулзалтыг зуучлалын өрөөнөөс гадна тухайн маргааны "үүссэн газар" явуулж болно.

Талуудын эрх: Ард төвтэй Эвлэрүүлэн зуучлалд оролцогч талууд дараах эрхийг эдэлнэ /Ард төвтэй Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 23 дугаар зүйл/.

1. Ардын эвлэрүүлэн зуучлагчийг сонгох, хүлээн зөвшөөрөх эрх;

2. Эвлэрүүлэн зуучлах ажиллагааг хүлээн зөвшөөрөх, татгалзан гарах, дуусгавар болгохыг шаардах эрх;

3. Эвлэрүүлэн зуучлах ажиллагааг хаалттай эсхүл нээлттэй явуулахыг шаардах;

4. Өөрийн хүсэл зоригийг илэрхийлэх, өөрийн хүслээр эвлэрлийн тохиролцоонд хүрэх эрх.

Талуудын үүрэг: Ард төвтэй Эвлэрүүлэн зуучлалд оролцогч талууд дараах үүрэг хүлээнэ / Ард төвтэй Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 24 дүгээр зүйл/.

1. Бодит нөхцөлийн талаар үнэн зөв мэдүүлэх үүрэг;

2. Эвлэрүүлэн зуучлалын дүрэм журамд захирагдан, ардын эвлэрүүлэн зуучлагчийг хүндэтгэн харьцах үүрэг;

3. Эсрэг тал эрхээ хэрэгжүүлэхэд хүндэтгэлтэй хандах үүрэг. Жич: Ардын эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд талууд дээрх үүргээ биелүүлээгүй тохиолдолд хүлээлгэх хариуцлагын талаар заалт байхгүй .

Эвлэрүүлэн зуучлах ажиллагаа дуусгавар болох: Ард төвтэй эвлэрүүлэн зуучлалын журмаар талууд харилцан ярилцсан хэдий ч эвлэрэхгүй тохиолдолд тухайн ажиллагааг дуусгавар болгоно. Энэ тохиолдолд Ардын эвлэрүүлэн зуучлагчийн зүгээс талуудад хуулийн дагуу арбитрын журмаар, захиргааны журмаар, шүүхийн журмаар эрхээ хамгаалж болох тухай мэдэгдэх үүрэгтэй.

Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны тэмдэглэл: Ардын эвлэрүүлэн зуучлагч эвлэрүүлэн зуучлах ажиллагааны явцыг тэмдэглэх үүрэгтэй. Түүнчлэн, Ардын эвлэрүүлэн зуучлах хороо нь хэргийн бүртгэл хийж, ажиллагааны тэмдэглэл, эвлэрлийн гэрээ зэргийг боловсруулах, хадгалах үүрэг хүлээнэ.

Эвлэрлийн гэрээ боловсруулах: Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны дүнд талууд тохиролцоонд хүрсэн бол эвлэрлийн гэрээ боловсруулж болно. Эвлэрлийн гэрээнд дараах агуулгыг тусгаж болно. Үүнд:

1. Талуудын талаар ерөнхий мэдээлэл, Тухайлбал, овог нэр, хаяг, албан тушаал, нас зэрэг орно. Гэр бүлийн маргааны хувьд талууд хоорондоо ямар холбоотой болохыг мөн бичнэ. Маргааны нөхцөл, маргааны гол зүйл, талуудын хэн буруутай болох, маргааны шалтгаан, маргаан үүсгэсэн этгээд зэргийг бичнэ. Жич, эвийн журмаар маргааныг шийдвэрлэх үүднээс талуудын хэн нь буруутайг бичих нь зохисгүй тохиолдол байх тул эвлэрлийн гэрээнд бичих эсэхийг маргааны нөхцөл байдлыг харгалзан шийдэх нь зүйтэй.

2. Тохиролцсон агуулга, үүргээ гүйцэтгэх арга хэлбэр, хугацаа. Мөнгөн төлбөр хийх үүргийн хувьд төлбөрийн хэмжээ, төлбөр хийх эцсийн хугацаа, хувааж төлөх эсэх, бэлэн мөнгөөр төлөх, банкаар шилжүүлэх эсэх. Талууд эвлэрүүлэн зуучлах ажиллагааг нээлттэй болон хаалттай явуулахаар шаардаж болно. Талууд энэ асуудлаар санал зөрөлдсөн тохиолдолд хэрхэх талаар тодорхой заагаагүй. Эвлэрүүлэн зуучлагчид гар хүрэх зэргээр эрүүгийн хууль тогтоомж болон бусад хууль тогтоомжид

харшлах үйлдэл хийвэл тухайн хууль тогтоомжийг үндэслэн хариуцлага хүлээлгэнэ.[3]

Эвлэрлийн гэрээ хүчин төгөлдөр болох: Эвлэрлийн гэрээ нь талууд гарын үсэг зурж, тамга дарж, ардын эвлэрүүлэн зуучлах хорооны тамга дарагдсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно. Эвлэрлийн гэрээг талууд тус бүр нэг хувь авч хадгалах ба ардын эвлэрүүлэн зуучлах хороонд нэг хувь нь хадгалагдан үлдэнэ.

Хүчин төгөлдөр бус эвлэрлийн гэрээ, эвлэрлийн гэрээг хүчингүй болгох: Дараах тохиолдолд, эвлэрлийн гэрээг хүчин төгөлдөр бусад тооцно.

1. Төрийн болон гуравдагч этгээдийн ашиг сонирхлыг хөндсөн;
2. Хууль бус зорилгын дагуу хийгдсэн;
3. Нийтийн эрх ашгийг хөндсөн;
4. Хууль зөрчсөн;
5. Ардын эвлэрүүлэн зуучлах хорооны албадлагын дагуу эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явагдсан.

Дараах тохиолдолд эвлэрлийн гэрээг хүчингүй болгож болно.

1. Ноцтой төөрөгдлийн улмаас хийсэн;
2. Эвлэрлийн гэрээ байгуулах үед талуудын эрх тэгш байдал хангагдаагүй нь тодорхой байсан;
3. Залилан мэхэлж, айлган сүрдүүлж хийсэн.

Эвлэрлийн гэрээний биелэлтийг хянах: Ардын эвлэрүүлэн зуучлах хороо нь эвлэрлийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг талуудаас шаардах ёстой. Эвлэрлийн гэрээ байгуулсны дараа талуудын хооронд гэрээний үүргийн биелэлтийн тухай болон гэрээ хүчин төгөлдөр эсэх тухай маргаан үүссэн тохиолдолд аль нэг тал нь Ардын шүүхэд нэхэмжлэл гаргаж болно.

Эвлэрлийн гэрээг шүүхээр баталгаажуулах: Ард төвтэй эвлэрүүлэн зуучлах тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1-33.3-т зааснаар эвлэрлийн гэрээ байгуулснаас хойш 30 хоногийн дотор талууд Ардын шүүхэд хандан тухайн гэрээг шүүхээр баталгаажуулах хүсэлт тавьж болно. Ардын шүүх эвлэрлийн гэрээг хүчин төгөлдөр гэж баталгаажуулсан тохиолдолд талуудын аль нэг нь үүргээ биелүүлэхгүй бол эсрэг тал нь албадан гүйцэтгүүлэхээр хүсэлт гаргах эрхтэй. Ардын шүүх хуулийн дагуу эвлэрлийн гэрээг хүчин төгөлдөр бус гэж баталгаажуулсан бол, талууд Ард төвтэй эвлэрүүлэн зуучлалын журмаар эвлэрлийн гэрээг өөрчлөх эсхүл шинээр эвлэрлийн гэрээ байгуулж болох ба түүнчлэн Ардын шүүхэд нэхэмжлэл гаргах эрх нь нээлттэй байна.

[3] 2012 он №2/37/ Хууль дээдлэх ёс

Эвлэрлийн гэрээг нотариатаар баталгаажуулах: Эвлэрлийн гэрээнд "үүргийн гүйцэтгэлийн тухай заалт" байгаа тохиолдолд, талууд нотариатын байгууллагад хандан тухайн гэрээг баталгаажуулах хүсэлт гаргаж болох ба ингэснээр тухайн гэрээний үүргийг албадан гүйцэтгүүлэх боломжтой болно. Үүнээс гадна, талууд эвлэрлийн гэрээний агуулгаар "төлбөрийн захирамж" гаргуулахаар шүүхэд хүсэлт тавьж болох бөгөөд энэ тохиолдолд төлбөрийн захирамжид гомдол гаргахгүй бол тухайн захирамж нь шүүхийн шийдвэртэй адил хүчин төгөлдөр болно.

Ард төвтэй эвлэрүүлэн зуучлалын тухай хууль нь урьдаас хэрэгжиж ирсэн ард төвтэй эвлэрүүлэн зуучлах тогтолцоог хуульчлан тодорхой болгосон тул хууль батлагдсанаар энэ тогтолцоонд ямар нэг томоохон өөрчлөлт ороогүй юм. Хууль батлагдсанаар шинээр бий болсон зарим нэг тогтолцооноос хамгийн чухал нь "эвлэрлийн гэрээг шүүхээр баталгаажуулах" тухай заалт юм. Шүүх төвтэй эвлэрүүлэн зуучлалын хувьд эвлэрлийн гэрээг эртнээс баталгаажуулж ирсэн байна. Уг хуулийн 33 дугаар зүйлд зааснаар Ардын эвлэрүүлэн зуучлах хорооноос явуулсан эвлэрүүлэн зуучлах ажиллагааны дүнд эвлэрлийн гэрээ байгуулсан тохиолдолд талууд шаардлагатай гэж үзвэл эвлэрлийн гэрээ хүчин төгөлдөр болсон өдрөөс 30 хоногийн дотор Ардын шүүхэд хандан тухайн гэрээг шүүхээр баталгаажуулахаар хамтран хүсэлт тавьж болно. Ард төвтэй эвлэрүүлэн зуучлах тогтолцоо нь талуудыг чөлөөтэй оролцож, татгалзах эрхийг хамгаалсан байдаг хэдий ч, талуудын зүгээс "эвлэрчих юмсан", "үүргээ биелүүлчих юмсан" гэсэн сэтгэл зүйн сэдэл илүүтэй төрдөг. Өөрөөр хэлбэл, өөрийн амьдардаг тосгоны хэмжээнд эсхүл ажлын газрын хэмжээнд Ардын эвлэрүүлэн зуучлах хороо нь байгуулагддаг ба гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх эсэх дээр Хороо хяналт тавьж байдаг тул энэ хүрээн дэх нийгмийн харилцаагаа хадгалж үлдэх сонирхлын үүднээс талууд үүргээ биелүүлэхээс өөр аргагүй болдог талтай гэж үздэг. Хуулиар эвлэрлийн гэрээг шүүхээс баталгаажуулах тогтолцоог бий болгосон нь эвлэрлийн гэрээг албадан гүйцэтгүүлэх боломжийг хангасан юм. Энэхүү заалт нь Ард төвтэй эвлэрүүлэн зуучлалыг ард иргэд өргөнөөр ашиглахад түлхэц болж өгнө гэж үздэг байна. Сүүлийн үед зурагт радио, сонин хэвлэлээр эвлэрүүлэн зуучлалын тухай танилцуулах болсон бөгөөд ард иргэдийн дунд эвлэрүүлэн зуучлалын талаар сонирхох хандлага харагдаж байна. Монгол улсад эвлэрүүлэн зуучлах тогтолцооны талаар Америкийн Нэгдсэн Улс болон Япон улсын туршлагаас судалсан байх тохиолдол харьцангуй их хэдий ч, хөрш орон болох Хятад улсын ADR-ын тогтолцооны талаар бараг судлагдаагүй байна. Гэсэн хэдий ч шүүхийн ачаалал их, иргэдийн зүгээс маргааныг эвийн журмаар шийдвэрлэх сонирхол их байдаг зэрэг нь Монгол, Хятад хоёр улсын хувьд төстэй хүчин зүйлүүд юм. Мөн АНУ-ын USAID- ын дэмжлэгтэйгээр

эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулдаг /Украин, Боливи, Өмнөд африк/ зэрэг орнуудад эвлэрүүлэн зуучлах ажиллагааг сүүлийн жилүүдэд өргөн хэрэглэх болжээ.

3. Монгол улс дахь эвлэрүүлэн зуучлах ажиллагаа, өнөөгийн байдал

Манай улсын хувьд эвлэрүүлэн зуучлалыг нэвтрүүлэх ажлыг Япон улсын JICA олон улсын хамтын ажиллагааны байгууллагын санаачлагаар 2010 оны 05-р сард эхлүүлсэн ба үүнээс үндэслэн эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийг баталсан билээ.

Уг хуулийн 3-р зүйлд зааснаар:

Эвлэрүүлэн зуучлалд хамаарах маргааны төрөл нь:

- Иргэний эрх зүйн маргаан
- Хөдөлмөрийн ганцаарчилсан маргаан
- Гэр бүлийн харилцаанаас үүссэн маргаан юм.

Мөн эдгээрээс бусад харилцаанаас үүссэн маргаанд эвлэрүүлэн зуучлалыг зөвхөн тусгайлан хуульд заасан тохиолдолд хэрэглэж болно" гэжээ.

Эвлэрүүлэн зуучлах ажилагааны талууд нь:

- Иргэн
- Хуулийн этгээд
- Хуулийн этгээдийн эрхгүй байгууллага байна.

Монгол улсын хувьд эвлэрүүлэн зуучлах ажиллагаан дахь шүүгчийн оролцоог хуульчлахдаа тэрээр уг ажилагааг эхлүүлэхэд голлох үүрэгтэй болохыг зааж өгсөн. Тухайлбал:

- Шүүгч маргалдагч талуудад эвлэрүүлэн зуучлалын талаарх мэдээллийг бүрэн өгөх үүрэгтэй.
- Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2-т "Шүүх ....шүүхэд иргэний хэрэг үүсгэхээс өмнө болон хойно, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны шат бүрт талуудыг эвлэрэх боломжоор хангаж, эвлэрүүлэн зуучлагчийн туслалцаа авах талаар сануулах үүрэгтэй" гэж хуульчлан зааж өгсөн байна. Ийнхүү хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үе шатанд шүүгч талуудад эдлэх эрхийг тайлбарлан өгөхдөө "Эвлэрүүлэн зуучлагчийг туслалцаа авах талаар сануулах үүрэгтэй ба ингэхдээ зохигч болон тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчөөс нотлох баримт гаргаж өгөх үед нь шууд зохигчид болон эсвэл төлөөлөгч, өмгөөлөгчөөр дамжуулан сануулж болно".
- Шүүгч эвлэрүүлэн зуучлалыг хэрэглэх нь зохистой маргаан болон зохисгүй маргааныг тодорхойлох чадвартай байх ёстой. Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т " ...Шүүгч

эвлэрүүлэн зуучлалыг хэрэглэх нь зохистой гэж үзэж санал болгосон...” гэж заасан нь дээр дурьдсан чадварыг шүүгчээс шаардаж байгаа хэрэг юм. Мөн түүнчлэн уг хуулийн 3.1-т “иргэний эрх зүйн маргаан, хөдөлмөрийн ганцаарчилсан маргаан болон гэр бүлийн маргаанаас үүссэн маргаанд эвлэрүүлэн зуучлалыг хэрэглэнэ” гэж заасан нь эдгээртэй холбоотой бүхий л маргаанд эвлэрүүлэн зуучлалыг хэрэглэх нь зохистой гэсэн үг биш юм.

- Эвлэрүүлэн зуучлах ажиллагаан дахь шүүгчийн гол оролцоо нь эвлэрлийн гэрээг баталгаажуулж, захирамж гаргах явдал юм. Дээрхи хуулийн 27.2-т “Шүүх дэх эвлэрүүлэн зуучлагчийн дэмжлэгтэйгээр байгуулсан эвлэрлийн гэрээг тухайн шатны шүүгч баталгаажуулж, захирамж гаргана” гэж заасан. Харин төрийн болон төрийн бус байгууллага дахь эвлэрүүлэн зуучлагчийн дэмжлэгтэйгээр байгуулсан эвлэрлийн гэрээг шүүхээс баталгаажуулахгүй бөгөөд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд хандах эрх нь нээлттэй байдаг.

  Манай улсын хувьд эвлэрүүлэн зуучлагч нь:

  - Эрх зүйн бүрэн чадамжтай;
  - Дээд боловсролтой;
  - Сургалтанд хамрагдаж гэрчилгээ авсан байх;
  - Эрх бүхий байгууллагын эвлэрүүлэн зуучлагчийн нэрсийн жагсаалтад бүртгэгдсэн байх;
  - Ял шийтгэлгүй байх шаардлагуудыг тавьдаг.

Герман улсад зуучлагчийн үүргийг өмгөөлөгч, эвлэрүүлэх албад, нотариатч болон үйл ажиллагааны янз бүрийн шинжээч нар гүйцэтгэдэг байна.

Япон улсын хувьд дээрхи улсуудаас ялгаатай нь уламжлал, ёс заншилд тулгуурладаг ба 40-70 настай бол эвлэрүүлэн зуучлагч болдог.

Дүгнэлт

Иргэний эрх зүйн маргааныг Эвлэрүүлэн зуучлах журмаар шийдвэрлэх онцлог нь талууд анхны уулзалтаар эвлэрэх магадлал маш өндөр байдаг ба ихэнхи хувь нь хамаатан сандан болон найз нөхдийн хооронд хийгдсэн гэрээ, хэлцэлтэй холбоотой байдаг байна. Иргэний эрх зүйн маргааны хувьд дан ганц эд хөрөнгийн харилцаа голлодог тул хохирол нөхөн барагдуулсан тохиолдолд эвлэрүүлэх магадлал гэр бүлийн маргаанаас туйлын өндөр юм.

Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2.3-т “Талууд эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд идэвх санаачлагатай оролцох, эвлэрүүлэн зуучлагчийн дуудлага товлосон уулзалтанд хүрэлцэн ирэх үүрэгтэй” гэж заасан байдаг.

Гэр бүлийн холбогдолтой маргааны дийлэнхи хувь нь гэрлэлт цуцлалттай холбоотой маргаан байдаг бөгөөд талууд олон жил амьдраагүй, талуудын аль нэг нь өөр хүнтэй гэр бүлийн харилцаатай эсхүл хамтран амьдардаг болсон мөн үр хүүхэдтэй болсон зэрэгтэй холбоотойгоор эвлэрүүлэх ажиллагаа үр дүнгүй болдог. Мөн нөхрийн хувьд хүүхдийн тэтгэмж, тэтгэлгийн асуудлаас зайлсхийн товлосон уулзалтад ирэхгүй байх нь практикт түгээмэл гардаг. Хэрэв дээр дурдсан урьдчилсан нөхцөл байдал байвал эвлэрүүлэн зуучлалд хандахгүйгээр шууд шүүхээр шийдвэрлүүлэх байдлаар зохицуулж өгөх нь зүйтэй. Үүнээс үүдэн гэр бүлийн маргаанд эвлэрүүлэн зуучлагчийн чадвар, идэвхи оролцоо маш чухал болох нь харагдаж байна.

Санал

Манай улсын хувьд нэн тэргүүнд гэр бүлийн хөгжилд анхаарах шаардлагатай бөгөөд гэр бүлийн боловсрол олгох үндэсний тогтолцоог бий болгох, анхан шатны шүүх бүрт гэр бүлийн дагнасан шүүх байгуулж, мэргэшсэн сэтгэл зүйч, хуульчдыг ажиллуулан эрх зүйн орчинг бүрдүүлэх шаардлагатай гэж үзэн дараахь саналыг дэвшүүлж байна.

- Гэр бүлийн маргааныг эвлэрүүлэн зуучлахтай холбогдсон эрх зүйн орчинг уян хатан болгох;
- Япон улсын адилаар гэр бүлийн шүүх байгуулах, гэр бүлийн зөвлөгөө өгөх газруудыг нээн ажиллуулах, Гэр бүлийн эвлэрүүлэн зуучлагчдыг сэтгэл зүйч, хуульчдаар хийлгэх зэрэг болно.

Ашигласан материал:

- Монгол улсын Үндсэн хууль 1992 он
- Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль 2012 он
- Иргэний хууль 2002 он
- Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль 2002 он
- Гэр бүлийн тухай хууль 1999 он
- Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн онол, арга зүйн тайлбар УБ.,2015 он
- Эвлэрүүлэн зуучлагчдад зориулсан гарын авлага УБ.2014 он
- Эвлэрүүлэн зуучлалын гарын авлага. УБ.,2015 он
- Шүүхийн тайлан. 2016 он
- Хууль дээдлэх ёс сэтгүүл 2013-2016 он

МОНГОЛ УЛС ДАХЬ МӨНГӨН ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ

THE LEGAL REGULATION AND CHALLENING PROBLEM FOR CASH LOAN ACTIVITY IN MONGOLIA

П.Долгормаа
Их Засаг Олон Улсын их сургуулийн
Хууль зүйн сургуулийн ахлах багш
Б.Нацагдорж
Их Засаг Олон Улсын их сургуулийн
Хууль зүйн сургуулийн Хууль зүйн сургуулийн
багш, доктор, дэд профессор
P. Dolgormaa
Senior teacher of Law School of IZIU,
Mongolia, Master of Law
B.Natsagdorj
Assistant professor of Law School of IZIU,
Mongolia, Ph.D

Хураангуй:

Хувийн эрх зүйн шинэтгэлийн хүрээнд энэхүү салбар эрх зүйн гол хууль болох Иргэний хуулийн зарим зохицуулалт болох иргэд хоорондын, барьцаалан зээлдэх журмаар хуулийн этгээдээс олгож байгаа зээлийн гэрээний эрх зүйн харилцааны явцад хэрэгжүүлж байгаа бусад эрх зүйн эх сурвалжийн үр нөлөө, энэ төрлийн шийдвэрлэж байгаа шат шатны шүүхийн шийдвэр өөр хоорондоо ойлголтын зөрүүтэй байгаа байгаа нь хууль, холбогдох хэм хэмжээ тогтоосон эх сурвалжуудын практик хэрэглээнд эргэлзээтэй байдлыг бий болгож байна. Энэ талаар Монгол улсын Шүүхийн Ерөнхий зөвлөлөөс гаргасан судалгааны тайланд "шүүхээр шийдвэрлэгдэж байгаа хэрэг маргааныг шийдвэрлэсэн шийдвэр тогтвортой байх нь олон нийтийн шүүхэд итгэх итгэлийг нэмэгдүүлэх гол хүчин зүйл байдаг тул гурван шатны шүүхийн шийдвэр нь хууль хэрэглээний нэгдмэл байх, аливаа хуулийг нэг мөр ойлгох явдлыг хангах нь чухал"[1] *хэмээн дурджээ.*

Иймээс илтгэлийн сэдвийн хүрээнд Монгол улсын шүүхийн 2016-2021 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр хүртэл шийдвэрлэсэн шийдвэрт, шийдвэрлэсэн хэрэг, маргааны бодит тохиолдолд, энэ төрлийн үйл

[1] ШЕЗ-ийн Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэн "Давж заалдах болон хяналтын журмаар хэргийг хянан шийдвэрлэсэн шийдвэрийн үндэслэл"., УБ., 2019 он

ажиллагаа эрхэлдэг, иргэн, зарим хуулийн этгээдийн үйл ажиллагаанд оролцох зарим төрийн байгууллагын гаргасан болон гадаадын улс орны ажиллагаанд хэрэгжүүлдэг эрх зүйн зохицуулалтын талаар судалгааг үндэслэл болгосон ба эрх зүйн орчинг шинэчлэх, нарийвчилсан зохицуулалт бүхий хуулийг батлан гаргаж, нийгэмд бий болсон нөхцөл, байдал, хүндрэлүүдийг шийдвэрлэх хууль зүйн гарц гаргалгаа, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх асуудлын талаар санал, дүгнэлтээ илэрхийлсэн болно.

Abstract:

There have been many discrepancies between the decisions made by different levels of Court, which has been a source of harmful legal ambiguity in the field of private law. Of note, in such legal ambiguities created, is the Civil Law of Mongolia, or more specifically, provisions of the Civil Law, other relevant laws regarding and the legal relationships that arises from the issuance of loan with a pledge from a legal person to persons.

In its research report, The Judicial General Council of Mongolia has stated that "it is of utmost importance to ensure that the different levels of Courts have a standardized understanding, in terms of, using the law and applying the law when deciding a civil suit, as consistency between court decisions is one of the biggest factors in increasing the public's trust of the Courts.

"Therefore, we have compiled and based our report on the decisions made by the Mongolian Courts, dating from 2016 to November 30th of 2021 and studies done by governmental agencies and international organizations on the decisions' effects on persons and legal persons, within the practical and relevant field of activity, with the ultimate goal of reforming the legal field and providing our opinions on the current solutions offered in terms of law regulations and other relevant pressing issues.

Түлхүүр үгс: *Мөнгөн зээлийн үйл ажиллагаа /зээл, барьцаалан зээлдэх зээл/ мөнгө хүүлэлт, "зээл чөлөөлөх ажиллагаа", "өдрийн зээл", зээлдэгч, зээлдүүлэгч.*

Key words: *Cash loan activity/ loan, mortgage lending/ lending money at interest, loan closing activity, day to day loans, loan holder and lender.*

ОРШИЛ

Хувийн эрх зүйн салбарын эх сурвалж болох Иргэний хууль 1926-2002 онуудад нарийвчилсан зохицуулалт бүхий хуультай өнөөг хүртэл хөгжиж ирсэн түүхтэй. Одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль 2002 онд шинэчлэгдэн батлагдаж эдүгээ 19 дэх жилдээ хэрэглэж, хэрэгжүүлж байна. Гэвч нийгмийн өнөөгийн хэрэгцээ шаардлагад энэхүү хуулийн суурь үзэл баримтлалд үл нийцэх зохицуулалт нь хуулийнхаа

хүрээнд ч, холбогдох бусад хууль, журам, стандарт цөөнгүй байсаар, хэрэгжүүлсээр л байна. Тухайлбал, Иргэний хуулийн Хорин дөрөвдүгээр бүлэг “Зээл”, “Барьцаалан зээлдэх журмаар зээл олгох” гэрээний эрх зүйн зохицуулалт, нь улс орны хөгжил, нийгмийн хэрэгцээ шаардлагад үл нийцэн, хуулийн практик хэрэглээнд оновчтой биш, ойлголтын зөрүү улам гүнзгийрсээр байна.

Иймд Монгол улс дахь мөнгөн зээлийн үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт, тулгамдсан асуудалд илтгэлээ иргэд хоорондын зээл болон барьцаалан зээлдэх журмаар зээл олгох /ломбард/ гэрээний эрх зүйн харилцааг зохицуулсан өнөөгийн хүчин төгөлдөр хууль, стандартын хүрээнд уг харилцаанд үүсч буй зарим бодит нөхцөлд байдалд дүгнэлт хийх зорилгоор энэ төрлийн хэрэг, маргааныг шийдвэрлэсэн шүүхийн практик, бусад эх сурвалжид судалгаа хийж, дор дурдсан чиглэлээр асуудал дэвшүүлж, санал дүгнэлтээ илэрхийлсэн болно.

НЭГ: Иргэд хоорондын зээл болон барьцаалан зээлдэх журмаар зээл олгох гэрээний эрх зүйн зохицуулалт, шүүхээр шийдвэрлэсэн хэргийн болон бусад эх сурвалжид хийсэн судалгаа:

1. Монгол улс дахь эрх зүйн зохицуулалтын эх сурвалж талаар:

2002 оны Монгол улсын Иргэний хуулийн Хорин дөрөвдүгээр бүлэг, 2001 оны Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, түүнд 2015.01.29-ний өдөр өөрчлөлт оруулсан хуулийн 5 дугаар зүйлийн 5.2, Стандартчлалын үндэсний зөвлөлийн 2017оны 35 дугаар тогтоолоор батлагдсан MNS 5274:2017 “Барьцаалан зээлдүүлэх үйлчилгээ. Нийтлэг шаардлага” стандарт, 2020 оны “Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль” зэрэг хууль, стандартаар дээрх харилцааг зохицуулсаар байна.

Орчин үеийн технологийн хурдацтай хөгжлийн эрин үед зээлийн үйл ажиллагаа нь хялбар болохын хэрээр зах зээлийн эдийн засгийн эргэлт сайжрах боломж бололцоо байгаа үед хүчин төгөлдөр хэрэгжиж буй хууль, эрх зүйн орчны хөгжил “хожимдож” яваач хараад хэлэхгүй, ярихгүй орхиж чадалгүй асуудлыг хөндөхийг санал бодлоо илэрхийлэхийг хичээсэн болно.

“Монгол Улсын Шүүхийн тайлан”-ын сүүлийн гурван жилийн тайлангаас үзэхэд Улсын хэмжээнд Зээлийн гэрээний маргаан 22,237 буюу нийт хэрэг маргааны 20 орчим хувийг дангаар эзэлж байгаа ба үүнээс илтгэлийн сэдвийн хүрээнд хамрагдах тоон судалгаанаас харж болно. /хавсралт №1 судалгаа 2016-2021.11.30/



Дээр дурдсан судалгаанаас үзэхэд энэ төрлийн зээлийн гэрээний нийгэм, эдийн засгийн харилцаанд үзүүлэх ач холбогдлыг харж болох төдийгүй Монголын нийгмийн салшгүй хэсэг, хүмүүсийн амьдралын төлөв байдлыг илтгэх нэгэн индикатор болжээ.

Өнгөрсөн хугацаанд хууль санаачлах эрх бүхий субъект нь энэ төрлийн эрх зүйн зохицуулалтыг шинэчлэн санаачлах бүрэн эрхийнхээ хүрээнд хуулийн төслийг боловсруулан, УИХ-аар хэлэлцүүлэх ажлыг нэг биш удаа хийсэн ч эцэслэн шийдвэрлэгдэж чадахгүй явсаар өнөөдрийг хүрчээ. Тухайлбал, Улсын Их Хурлаас 2015 оны 12 сарын 03-ны өдөр Иргэний хуульд нэмэлт өөрчлөлт оруулж зээлийн гэрээг хүүтэй байгуулахыг хориглосон боловч Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2016 оны 5 сарын 25-ны өдрийн 07 дугаарт дүгнэлтээр “иргэн өөрийн өмчлөлийн зүйл болох мөнгөн болон бусад хөрөнгөө хариу төлбөртэйгээр бусдын өмчлөлд шилжүүлэх замаар шударгаар ашиг олох, өмчлөлийн зүйлээ өөрийн үзэмжээр захиран зурцуулах эрхийг хязгаарласан” гэсэн агуулгаар Иргэний хуулийн 281.3 дахь хэсгийг “Зээлийн гэрээ нь хариу төлбөргүй байна” гэсэн нэмэлт өөрчлөлтийг хүчингүй болгож шийдвэрлэсэн, 2014 онд “Барьцаалдан зээлдэх журмаар зээл олгох үйл ажиллагааны тухай хууль”-ийн төсөл, 2018 онд “Зээлийн хүүгийн хязгаар тогтоох болон мөнгө хүүлэлттэй тэмцэх тухай” хуулийн төслийг өргөн барьсан . Тус хуулийн төсөлд банк, зээлийн үйл ажиллагаа явуулах эрх бүхий хуулийн этгээдийн зээлийн хүүгийн дээд хэмжээг хуулиар тогтоохоор , түүнээс давсан хүү тогтоосон тохиолдолд “Мөнгө хүүлэлт” гэж үзэхээр тус тус заасан, 2021 оны нэгдүгээр сард Засгийн газраас “Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай” хуулийн төслийг УИХ-д тус тус өргөн барьжээ.

Дээрх дурдсан эрх зүйн шинэчлэлийн үр дүнд мөнгөн зээлийн үйл ажиллагаа явуулах этгээдүүдэд шаардлага тавьж, бүртгэлжүүлэхээс гадна зээлийн, барьцааны, батлан даалтын гэрээ байгуулах зэрэг зохицуулалт, мөнгөн зээлийн зуучлалын үйл ажиллагаа эрхлэх, ийм зээлийг хянах, маргаан таслах зохицуулалт бий болж, “ломбард”, “өдрийн зээл”, “зээл чөлөөлөх” гэх мэт хуульчлагдаагүй нэр томьёо, эдгээр хуульд үл нийцэх үйл ажиллагааны эрсдэлээс зээлдэгчид үүсэх санхүүгийн хүндрэл, дарамт шахалтад орж, цаашлаад гэмт хэргийн золиос болохоос сэргийлэх эрх зүйн орчин бий болох боломж бүрдэнэ, барьцааны зүйлтэй холбоотой хулгай, залилангийн хэрэг буурч, татвар төлөлт шударга болно гэсэн тухайн үеийн хууль боловсруулагчдын үзэл бодол бодит биелэлтээ олохгүй өнөөг хүрсэн байна.

2. Гадаадын зарим улс орнуудын эрх зүйн зохицуулалт, түүний онцлог:

Дэлхий зарим улс оронд зээлийн хүүгийн дээд хязгаарыг хуулиар тогтоож, “мөнгөн хүүлэлт”-ийн эсрэг тэмцэх зохицуулалтыг өөр өөрийн улс орны онцлогт тохирсон иргэний, гэрээний төдийгүй эрүүгийн эрх зүйн хэм хэмжээний хүрээнд гэмт хэрэгт тооцож, эрүүгийн хариуцлага хүлээлгэх хэмжээнд хүртэл эрх зүйн орчноо бий болгосон байна.

Дэлхийн банк, Европын Холбооны судалгааны байгууллагуудаас гаргасан судалгааны тайланд дэлхийн зарим улс зээлийн хүүгийн дээд хэмжээг тогтоосон тухай дурдсан байна. Зээлийн хүүгийн дээд хэмжээг тогтоох эрх бүхий субьектын хувьд дийлэнх орнуудад Төв банк нь тус эрхийг эдэлж байгаа бол цөөн тохиолдолд шүүх , хууль тогтоох дээд байгууллага , эсхүл Сангийн сайд нь хүүгийн дээд хэмжээг тогтоодог байна . Дийлэнх улс орнуудын хувьд бодит хүүгийн хувь , эсхүл жилийн хүүгийн хувиар зээлийн хүүгийн дээд хэмжээг тогтоож , түүнд шимтгэл хураамжийг оруулан тооцдог бол цөөн хэдэн оронд нэрлэсэн хүүгийн хувиар зээлийн хүүгийн дээд хэмжээг тогтоосон “мөнгөн хүүлэлт”-ийг төрийн бодлого, эрх зүйн зохицуулалтын хэмжээнд авч хэрэгжүүлдэг байна .

Хариуцлага тооцох механизм: Зээлийн хүүгийн хэмжээг хууль тогтоомжоор хязгаарлах эрх зүйн зохицуулалт нь зээлийн бодит өртгийг үнэн зөвөөр тодорхойлж боломжит хүүг зээлдэгчид санал болгох , тэдэнд зээлийн хүүгийн дарамт үзүүлэхээс сэргийлэх ач холбогдолтой юм .

Дараах 3 төрлийн хариуцлагын механизмыг тогтоомжид тусгасан байдаг . Үүнд

а/ Иргэний хэргийн журмаар хариуцлага хүлээлгэх /Хэргийг шийдвэрлэх явцад гэрээнд тусгасан үндсэн зээлийн хүү болон хүүгийн хүүг хуулиар зөвшөөрөгдсөн хэмжээнд хүртэл буулгах буюу , эсхүл гэрээг хүчингүй болгох/, б/ Эрүүгийн хариуцлага хүлээлгэх /хорих буюу торгууль

оногдуулах/ в/ Захиргааны хариуцлага /үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг нь хүчингүй болгох/

Зарим улс орны эрх зүйн зохицуулалтын онцлог: Чех-Мөнгө хүүлэлтийн тухай харилцаанаас олж буй ашиг орлого нь хүлээж буй үүрэгтэй харилцан тохиромжгүй тохиолдлууд буюу ерөнхийдөө өндөр хүүтэй зээлийг ойлгодог. 2003 онд Дээд шүүхийн тайлбараар мөнгө хүүлэх гэрээ гэдэгт гэрээний нөгөө талаасаа хамааралтай оюун ухааны хувьд сул дорой этгээдтэй, мөн хувь хүний туршлагагүй байдал зэргийг урвуугаар ашиглан гэрээгээр хүлээсэн үүрэг нь харилцан адилгүй буюу эрс ялгаа бүхий үүргийг гүйцэтгэхээр амласан, үүрэг хүлээхээр заасан гэрээг хамруулахаар тайлбарласан байна. Иргэний хууль дахь мөнгө хүүлэлтийн гэрээ нь гэрээний нэг тал дээр дурдсан нөхцөл байдлаар байгуулсан гэдгийг нөгөө тал нь мэдэж байсан, мэдэх боломжтой байсан гэрээг хамааруулахаар заажээ. Энэ тохиолдолд гэрээг хүчингүй болгохоор заасан байна. 2004 оны дээд шүүхийн тайлбараар зээлийн хүүгийн хэмжээг ёс зүйн зохист хэмжээтэй холбон үзсэн буюу тухайн зээлийн төрөлд арилжааны банкнуудаас тогтоосон ердийн хүүгийн хэмжээг 4 дахин нэмэгдүүлсэн хэмжээг хууль бусад тооцож гэрээг хүчингүй гэж үзэхээр тогтоосон байна. Мөнгө хүүлэх асуудлыг Эрүүгийн хуульд мөн тусгасан ба аливаа этгээд нь харилцан адилгүй буюу эрс ялгаа бүхий үүргийг амласан, үүрэг хүлээхээр заасан.

Болгар-Үүрэг ба гэрээний тухай хуулийн 10 (3)-р зүйлээр мөнгө хүүлэлтийг хориглосон ба нэмэгдүүлсэн хүүг Төв банкнаас тогтоосон хүүгийн хэмжээнээс хэтрэхгүй байхаар зохицуулсан. Худалдааны тухай хуулийн 294-р зүйлд заасны дагуу нийлмэл хүүг арилжааны байгууллагууд хоорондоо хэрэглэж болохоор заасан.

Герман-Мөнгө хүүлэлт нь Иргэний хуулийн 138-р зүйлд ёс зүйн зохист хэмжээг зөрчих гэсэн томьёоллоор илэрхийлэгдсэн.

1. Нийтийн бодлого, ёс суртахууны эсрэг аливаа хэлцэл, мөнгөн шилжүүлэг зэрэг нь хүчингүй байна.
2. Хэн нэгний хүндрэл бэрхшээлтэй, туршлагагүй, сул дорой нөхцөл байдлыг ашиглан түүнийг, эсхүл гуравдагч этгээдийг авч буй үр ашигтай нь илтэд үл тохирох аливаа үйлдэл хийлгэх, хийлгэхээр амлалт авах, өөртөө мөнгө болон санхүүгийн ашиг олж авах нь хориотой.

Эрүүгийн хуулийн 291-р зүйл. Бусдын хүндрэл бэрхшээл, туршлага дутмаг байдал, эрүүл бус, байдлыг ашиглан, материаллаг ашиг өөрт нь эсхүл бусад этгээдэд олгогдохоор эсхүл тийм төрлийн амлалтыг орон байрны түрээс, эсхүл түүнтэй холбоотой бусад үйлчилгээний замаар, зээл олгох замаар, бусад төрлийн

үйлчилгээний өртөг, олж авч буй ашигтай нь илтэд үл дүйцэж байвал 3 жил хүртэлх хугацаагаар хорих буюу торгууль ногдуулна.

Люксембург-Иргэний хуульд зааснаар шүүхээс зээлдүүлэгч нь зээлдэгчийн туршлагагүй байдлыг ашиглан өөрийн гаргаж буй эрсдэлтэй харьцуулахад хэт өндөр хүү болон бусад илт өндөр ашиг орлого олохоор байна гэж үзвэл гэрээний хүүг хуулиар тогтоосон хэмжээнд буулгаж, шийдвэрлэх боломжтой. Эрүүгийн хуулиар 1 сараас 1 жил хүртэл хугацаагаар хорих, эсхүл 500-25000 евро хүртэл торгох санкцтай. Банкнаас бусад этгээд нь нэг жил хүртэлх хугацааны зээлд нийлмэл хүү тооцохыг хориглодог.

Испани-Мөнгө хүүлэлтийн эсрэг хуульд зааснаар хүүгийн хэмжээг зөвшөөрөн гэрээ байгуулах нь чөлөөтэй зүйл боловч гэрээгээр тогтоосон хүү болон хууль тогтоомжоор тогтоосон хүүгийн хувьд хэмжээ хоорондын харилцаа, зах зээлийн ханш гэх мэт олон зүйлийг харгалзан тогтоох ёстой. Харин хүний зайлшгүй шаардлагатай хэрэгцээт үеийг далимдуулан өндөр хүү тогтоосон бол тухайн гэрээг хүчингүйд тооцно.

Европын Холбооны улс орнуудын мөнгө хүүлэлтийн эсрэг эрх зүйн зохицуулалт

№	Улс	Хэрэглэсэн байдал	Зээлийн хүүгийн дээд хэмжээг хуульд тусгасан эсэх	Бусад
1	Чех	Иргэний хуулийн 3-р хэсэг, Эрүүгийн хууль 40-2009	Дундаж хэмжээг 4 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх	Шүүхийн тайлбараар тогтоосон
2	Герман	Иргэний хуулийн 138, Эрүүгийн хуулийн 291	Ёс зүйн зохист хэмжээ, дундаж хэмжээг 2 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх.	-
3	Люксембург	Иргэний хуулийн 1907-р зүйл, Эрүүгийн хуулийн 494-р зүйл, Иргэний хуулийн 1154-р зүйл (Анатоцизм/ нийлмэл хүү)	Үгүй	Шүүх хүүгийн хэмжээг бууруулах эрх хэмжээтэй

4	Испани	Мөнгө хүүлэлтийн эсрэг хууль	Хэрэглээний зээлийн тухай хуулийн 19-р зүйл хуулиар “овердрафт зээлд-тогтоосон хүүгийн хэмжээнээс 2.5 дахин нэмэгдүүлсэн”	-
5	Болгар	Гэрээний болон үүргийн хуулийн 103-р зүйл	Үгүй	-

ХОЁР: Мөнгөн зээлийн гэрээний эрх зүйн харилцааны эрэг болон сөрөг үр дагаварын талаар:

а/ ЭЕРЭГ ТАЛ НЬ: Банк, санхүүгийн байгууллагууд иргэдэд зээл олгохдоо өндөр шаардлага тавьдаг, олон төрлийн баримт бичиг шаарддаг, зээлийн судалгаанд хугацаа их зарцуулдаг зэрэг нь иргэдэд хүндрэлтэй байдгаас зах зээлд ломбард буюу барьцаалан зээлдэх газрын эрэлт, хэрэгцээ байсаар байна. 2018 оны зургадугаар сард Монгол банкнаас иргэдийн хэрэглээний зээлийн хувьд өр, орлогын хязгаарыг тогтоож өгсөн. Энэхүү шийдвэрээр сард төлөх зээлийн үндсэн болон хүүгийн төлбөр нь сарын орлогын 70 хувиас хэтэрч болохгүй гэж заасан. Ингэж зээлийн таазыг тогтоосон нь банкнууд хэрэглээний зээл олгохоо багасгаж, иргэд ломбард болон хувираа зээл олгогч хувь хүнээс мөнгө зээлэх хандлага ихэссэн байдаг.

Амьдралын бодит үнэн: Коронавируст цар тахал улс оронд тархсан үеэс ломбардыг зорьж амь амьдралаа залгуулахын тулд түүнийг зорих “зээлдэгч”-ийн тоо өссөн үү л гэхээс буураагүй. Түүнчлэн нийгмийн тодорхой бүлгийн хэрэгцээг жишээ болгон авч үзвэл: Цөөнгүй оюутны хувьд хамгийн үнэтэй хөрөнгө бол “гар утас, зөөврийн компьютер” нь тулгамдсан шаардлагатай хэрэглээгээ хангахын тулд “ломбард”-ын барьцаанд тавьж түр зуурын хэрэгцээгээ хангана. Зарим эцэг, эх банкнаас зээл авч чадахгүй бол хүүхдийнхээ сургалтын төлбөр олохын тулд үе дамжиж ирсэн эмээл, хазаар, хөөрөг зэрэг үнэт эдлэлээ барьцаанд тавина. Зарим нэг залуу хосуудын хувьд ч мөнгөн хэрэгцээ гарах ч ердийн үзэгдэл. Тухайлбал: гадаад орнуудад ажиллах, амьдрах шаардлагаар виз мэдүүлэх, ахуйн хэрэгцээн цалин хөлс хүрэлцэхгүй цалингаас цалингийн хооронд амьдрах нөхцөлд “бэлэн мөнгөн”-ний хэрэгцээгээ хангахын тулд өөртөө байгаа үнэтэй гэсэн эд зүйлсээ “ломбард”-д тавьж тухайн үед бий

болсон хүндрэлээ давдаг нь нууц биш болжээ. Энэ байдлыг нэгэн судлаач “Монголын нийгмийн салшгүй хэсэг, хүмүүсийн амьдралын төлөв байдлыг илтгэх нэгэн индикатор болсон” гэсэн нь хошин ч өнөөгийн амьдралын бодит үнэн төрх төдийгүй хэрэгцээтэй нөхцөл байдлыг бага ч гэсэн шийдвэрлэж байгаа нь эерэг тал гэж үзэх юм даа.

б/ СӨРӨГ ТАЛ НЬ: Барьцаалан зээлдүүлэх журмаар зээл олгох газар зээлдэгчид зээл олгохдоо зээлийн хүүг богино хугацаанд, Монгол банкнаас зарласан хүүгийн хэмжээнээс дээгүүр тогтоох, барьцааны хөрөнгийг үнэлэн авахдаа “хэт доогуур үнэ тогтоож” барьцаанд авах, зээлдэгч зээлийн гэрээний үүргээ зохих ёсоор биелүүлээгүй, хугацаа хожимдуулах гэх мэтээр зээлдэгч талын сул талыг ашиглан барьцааны хөрөнгийг үнэгүйдүүлэх, Иргэний хуулийн 286 дугаар зүйлд зааснаар худалдан борлуулж, үүргийн гүйцэтгэлийг хангуулах, энэ тухай мэдэгдэх хэлбэр, хугацааг зохицуулсан боловч барьцаа хөрөнгийн үнэлгээ, худалдан борлуулах харилцаанд баримтлах журмыг мөрдөхийг хүсдэггүй, зээлдэгчид үүргээ гүйцэтгэх мэдэгдэхдээ утас руу “мэссэч бичих, /сүлжээгүй газарт байсан бол.../гэх мэт зохицуулалтыг хэрэглэдэггүй.

Түүнчлэн Барьцаалан зээлдэх журмаар зээл олгох зээлийн гэрээний харилцааны явцад зээлдэгч буюу иргэдээс шүүхэд гаргасан нэхэмжлэлийн шаардлага, тайлбар, хариуцагчийн татгалзал, тайлбарт дурдсанаар түүнчлэн хууль ёсны эрх ашгаа зөрчигдсөн талаарх холбогдох газруудад гаргасан гомдолд “ломбардууд иргэдийн хөрөнгийг бага үнээр барьцаанд авдаг, барьцаалсан эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, аюулгүй байдал хангалтгүй, хүү болон хугацааг дураараа тогтоодог, барьцааны хугацаа дуусахад барьцаалсан эд хөрөнгийг борлуулахдаа эзэнд нь мэдэгддэггүй” гэсэн гомдол мэдээллүүд нийтлэг гаргадаг байна.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын “Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн төслийн үзэл баримтлал”-д дурдсан тоон мэдээлэлд “манай улсад 1000 орчим ломбард ажиллаж байгаагаас 872 нь Улаанбаатарт. ...2017 оны гуравдугаар сард Нийслэл болон дүүргүүдийн цагдаагаас “Ломбард” нэртэй нэгдсэн арга хэмжээ явуулахад 2016 оноос эхлээд нэг жил гурван сарын хугацаанд үйл ажиллагаа явуулж байгаа 598 ломбард бүртгэжээ. Эдгээр ломбардад зах зээлийн хамгийн доод ханшаар үнэлэхэд 32.43 тэрбум төгрөгөөр үнэлэгдэх хөрөнгө барьцаанд байсан” гэж,

2020 оны наймдугаар сард ШӨХТГ-аас 180 ломбардын үйл ажиллагааг шалгахад барьцааны эд зүйлийг зах зээлийн үнээс 50-80 доогуур үнэлдэг, хугацаа нь дуусмагц сануулах мэссэж явуулж дараагийн өдрөөс нь зөрүү тооцохгүйгээр үл маргах журмаар худалдан ломбардын орлого болгодог нь тогтоогджээ. Мөн хугацаа дуусахаас өмнө эд зүйлээ эргүүлж авсан ч гэрээнд заасан хоногоор хүү тооцож авдаг зөрчил

илэрчээ. ...Зээлийн гэрээтэй холбоотой маргаануудын 20 гаруй хувийг бүртгэлгүй, тусгай зөвшөөрөлгүй ч ашгийн төлөө байнга зээл олгодог компаний, иргэнтэй холбогдох маргаан эзэлдэг. ...2010-2020 онд зээлийн гэрээнээс үүдэлтэй 1700 орчим залилангийн хэрэг бүртгэгджээ. Ялангуяа 2014 оноос эрс өсч жилд дунджаар 300 орчим ийм гэмт хэрэг гарч байна”[2] гэсэн бодит баримтуудыг дурджээ.

Дээр дурдсан нөхцөл байдлаас үзэхэд Барьцаалан зээлдэх журмаар зээл олгох зээлийн гэрээний харилцаанд үүссэн сөрөг үр дагаврын талаарх бодитой, үнэн бодит мэдээлэл гэж үзэж илтгэлдээ дэвшүүлсэн зарим үндэслэлд иш татаж оруулсан. Эдгээр нь энэ төрлийн үйл ажиллагаанд нарийвчилсан зохицуулалт бүхий эрх зүйн орчин үгүйлэгдэж байгаагийн нэг тод жишээ төдийгүй энэхүү гэрээний харилцаан дахь ялангуяа иргэний буюу зээлдэгчийн хууль ёсны эрх ашиг сонирхол зөрчигдсөн тохиолдолд хууль эрх зүйн хамгаалалт учир дутагдалтай байгаагийн илрэл юм.

Шүүн таслах ажиллагааны практикт тодруулбал, эрүүгийн хэрийг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад Барьцаалан зээлдэх журмаар зээл олгох үйл ажиллагаа эрхлэн явуулж байсан этгээд тухайн байрны аюулгүй байдал, хамгаалалт бэхэлгээ, камержуулалт гэх мэт наад захын хамгаалалтын шаардлага хангаагүйгээс бусдын их хэмжээний үнэт эд зүйлсийг хулгайн гэмт хэргийн холбогдогчийн “олз” болгож, зарж борлуулан зээлдэгчийн эрхийг ноцтой зөрчсөн тохиолдол гарч байсан нь цөөнгүй. Үүний үр дагаварт хэргийн холбогдогч, ломбардын үйл ажиллагаа эрхлэгч этгээд хохирлыг барагдуулах асуудалд багагүй маргаан үүсч үргэлжилсэн байдаг. Зүй нь зээлдэгч, зээлдүүлэгчийн хооронд байгуулагдсан гэрээний тохиролцоонд хариуцлагын талаар тохиролцсон тохиолдолд зээлдүүлэгч хариуцлага хүлээнэ. Гэтэл энэ талаар гэрээнд тодорхой тохиролцоогүй бол эрсдэлийг хэнд хэрхэн хувиарлах эсэх асуудал гарна.

“**Зээл чөлөөлөх**” гэх нэр томьёо хуульд зохицуулагдаагүй. Гэтэл Иргэний хуульд заасан энэхүү гэрээний төрлөөр халхавчлан гэрээ байгуулж, зээлдэгчийн үл хөдлөх хөрөнгийг холбогдох хуульд заасан арга, журмаар өөрийн өмчлөлд шилжүүлэн зээлийн төлбөрөө төлөх боломжгүй болмогц уг үл хөдлөх хөрөнгийг захиран зарцуулан, зээлдэгч /нас өндөр иргэд байсан/-ийн өмчлөх эрхийг “луйвардан авах” тохиолдол гарч байсан төдийгүй шат шатны шүүхийн хууль хэрэглээний зөрүүтэй практикаас тэд тодорхой хугацаанд “үндэслэлгүй хөрөнгөжсөн” байдаг. /Орхон аймагт/

[2] Хууль зүй, дотоод хэргийн сайдын “Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн төслийн үзэл баримтлал”

Дээрх тохиолдлын өнөөгийн сонгомол хэлбэр бол “**өдрийн зээл**” гэж нэрлэгдэх “мөнгө хүүлэлт”. Энэхүү зээлийн хэлбэр нь ихэнх тохиолдолд Нарантуул, Хархорин гэх мэт худалдааны төвлөрсөн төвүүдэд лангуу түрээслэгчдийн дунд түгээмэл хэрэглэдэг зээлийн нэг хэлбэр болж “хөгжсөн”.

Зээлийн гэрээний зохицуулалтыг “халхавчлан” хийгдэж буй эдгээр аман гэрээгээр хэлбэржсэн зээлийн гэрээний хуульд үл нийцсэн ажиллагаа нь нэг талаас зээлдэгч тал нь хүндрэл багатайгаар тухай үеийнхээ эдийн засгийн хэрэгцээ хангаж байгаа ч сөрөг үр дагавар нь одоо хүчин төгөлдөр үйлчилж буй Иргэний хуулийн заалт хэрэгжихгүй орхигдсон.

Энэ тохиолдолд зээлдүүлэгч нь “мөнгө хүүлж, үндэслэлгүй хөрөнгөжиж”, зээлдэгч их хэмжээний хүү төлж эдийн засгийн хүндрэлд орох төдийгүй зээлдэгч олсон ашиг тодорхой тооцогдохгүй учраас татвар ногдуулах боломжгүй “нуугдмал” болж хувирдаг байна.

Шүүхийн практикт энэ төрлийн хэрэг маргааныг шийдвэрлэхдээ гэрээний тогтвортой байдлыг хангах агуулгаар хууль зөрчиж хүчин төгөлдөр бус гэрээ хийгдсэн тохиолдолд зээлдүүлэгч, зээлдэгчийн тайлбар бусад нотлох баримтаар зээл авсан, хүү төлсөн нь нотлогдсон гэсэн үндэслэлээр зээлдүүлэгчийг үндэслэлгүйгээр хөрөнгөжсөнийг дэмжсэн шийдвэрүүд гарсаар байна. Иргэний хуульд заасан хэлбэрийн шаардлага хангаагүй гэрээний гүйцэтгэлийг хангаж шийдвэрлэж байгаа практикаас харахад ХУУЛИЙГ ХЭН ХЭРХЭН дагаж мөрдөж хэрэгжүүлэх вэ гэх асуулт хариултгүй ....

Түүнчлэн бусдын эд зүйлсийг эрх зүйн бус үйлдлээр олж авсны эцэст “мөнгөн” болгон хувиргах хамгийн боломжит газар нь “ломбард” гэдэг болох нь зарим нэг байгууллага, судлаачийн тоон судалгаанаас ажиглагдаж байна. Тухайлбал, хулгайлах гэмт хэргийг үйлдэхдээ олж авсан эд зүйлийг хамгийн амар хялбар аргаар мөнгөн болгож авах газар нь ломбард.

ГУРАВ: Барьцаалан зээлдэх журмаар зээл олгох гэрээний эрх зүйн зохицуулалтын цаашид боловсронгуй болгох асуудалд санал болгох нь:

Нийгэмд барьцаалан зээлдэх журмаар болон иргэд хоорондын зээлийн хэрэгцээ нэмэгдэж байгаа нь цаашид барьцаалан зээлдүүлэх үйлчилгээг нарийвчилсан зохицуулалт бүхий хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгож, үүрэг хариуцлагатай болгох, түүнийг хянан зохицуулах эрх, үүрэг бүхий субъектийг тодорхйо болгож, үйл ажиллагааг нь хуулиар зохицуулах гэх мэт нь нийгмийн зайлшгүй шаардлага. Зөвхөн Санхүүгийн зохицуулах хорооноос журам, дүрмээр зохицуулах асуудал нэгэнт биш болжээ.

Барьцаалан зээлдэх журмаар олгох болон энгийн зээл буюу “иргэд хоорондын зээл” тодруулбал Иргэний хуулийн 281 дүгээр зүйлд зааснаар олгож буй зээлийг бүртгэлжүүлэх нь

-тэдгээрийн орлогод ноогдох татвар тодорхой болж татвар нь бодитой төлөгдөнө

-зээлийн хүү нь Монгол банкнаас зарласан хүүгийн хязгаарын дотор байснаар зээлдүүлэгчийн үндэслэлгүй хөрөнгөжилт хязгаарлагдаж, зээлдэгчдийн “хуулиас давсан хүүгийн ачаалал” багасах эерэг нөхцөл байдал бий болно.

-Шүүхийн шийдвэрийн тогтвортой байдал нэмэгдэж, нарийвчилсан зохицуулалтай хууль эрх зүйн орчин бий болсноор түүний хэрэгжилтэд ялангуяа маргаантай нөхцөл байдал нэг мөр болох эерэг үр дагавар бий болно.

-Гэмт хэрэг үйлдэж олсон эд зүйлсийг мөнгөн болгон хувиргах эрүүл бус эрх зүйн үйлдэл хязгаарлагдаж, гэмт хэргийн гаралт буурахад нөлөөлөхийн зэрэгцээ энэ төрлийн гэмт хэргийн гаралт багасаж эд хөрөнгөөр хохирогсдын эрх ашиг тодорхой хэмжээгээр хамгаалагдах нөхцөл бүрдэнэ.

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

1. Улсын Их Хурлын Тамгын газар. Судалгааны эмхэтгэл. XXVI боть. УБ 2018 он.
2. ШЕЗөвлөлийн Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэн “давж заалдах болон Хяналтын журмаар хэргийг хянан шийдвэрлэсэн шийдвэрийн үндэслэл” УБ 2019 он.
3. Хууль зүй, дотоод хэргийн сайдын “Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн төслийн үзэл баримтлал”
4. Д.Байгальмаа “Барьцаалан зээлдүүлэх үйлчилгээний өнөөгийн байдал, эрх зүйн орчин болон бусад орнуудын туршлага” харьцуулсан судалгаа. 2012 он.
5. Б.Бадамгаравын 2020.8.18 нд бичсэн “Ломбардуудыг бүртгэлжүүлэхээр төлөвлөжээ.
6. Шүүхийн шийдвэрийн цахим сан 2019-2021 он.

THE LEGAL BACKGROUND OF CIVIL LAW IN MONGOLIA

МОНГОЛ ДАХЬ ИРГЭНИЙ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН КОДЧИЛОЛ

Namsrai.B
Ph.D. student at University of Pйcs, Hungary
Баттулгын Намсрай
Унгар улсын Печийн их сургуулийн докторант

Хураангуй

Монгол дахь иргэний төрөлжсөн хуулийн кодчиллын түүхийг судалж энэхүү илтгэлийг бичлээ. Тодруулбал, 1926 оноос хойшхи иргэний хуулиудын онцлог, 1998 онд эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр хэрэгжиж эхэлснээр иргэний эрх зүйн салбарт бий болсон өөрчлөлтийн талаар авч үзсэн болно.

Abstract

This short essay is connected the legislative history of Civil law in Mongolia. Under research, the legislation period of Civil law is divided into two sections. Including 1926, when the first civil law was adopted, and 1998, when private-sector laws were adopted as part of legal reform.

Түлхүүр үг

Хуульчилах, Иргэний төрөлжсөн хууль, Хууль зүйн реформ, Дэд хуулиуд

Key words

Codification, Civil Code, Legal Reform, Sub-Laws

Early codification process

Customary norm is the earliest tradition of Mongolian legislation and Moral law[1]. From ancient times oral contract was one of the main forms of a deal between people. It is believed that the agreements reached the middle of the two sides to determine the quantity, timing, and quality of items to be exchanged and to define each other's responsibilities had a legal content.

“Scientists explain that civil law in Mongolia has gone through four stages from the third century BC to the present.[2] Notably ancient and middle age code

[1] Tudev, L. (2000). *Oral Law*
[2] Usually, classify that the Mongolian Civil law into chronological and in connection with Civil Code revisions

of laws Ikh Zasag[3] and Statutes[4] with precedents of Yuan Dynasty, the Khalkh Juram[5] governed contract, inheritances, trade, as well as disputes between families and citizens." (Boldbaatar, J., Lundeejantsan, D. 1997. *Historical Tradition of State and Law.* chapter.1)[6]

The contemporary history of civil law in Mongolia can be classified that the period when private law was regulated by the merely general Civil Code (since 1926) and the period when the sub-laws emerging separated from the Civil Code (since 1998).

My research covers the history of the last 100 years, which is the period since the first enactment of the Civil Code. This is a short term of history compared to the 19th century when the French Civil Code was first enacted in Europe.

> As civil law came into practice throughout Europe, the role of local custom as a source of law became increasingly important particularly as growing European states sought to unify and organize their individual legal systems.
>
> Throughout the early modern period, this desire generated scholarly attempts to systematize scattered, disparate legal provisions and local customary laws and bring them into harmony with rational principles of civil law and natural law.
>
> Emblematic of these attempts is the Dutch jurist Hugo Grotius' 1631 work, Introduction to Dutch Jurisprudence, which synthesized Roman law and Dutch customary law into a cohesive whole.
>
> In the eighteenth century, the reforming aspirations of Enlightenment rulers aligned with jurists' desire to rationalize the law to produce comprehensive, systematic legal codes including Austria's 1786 Code and Complete Civil Code of 1811, Prussia's Complete Territorial Code of 1794, and France's Civil Code of 1804[7]. Such codes, shaped by the Roman law tradition, are the models of today's civil law systems. (*The Common Law and Civil Law Traditions*. 2018. Berkeley Law)

---

[3] "See also", Pochekaev, R. (2016) *Chinggis Khan's Great Yasa in the Mongol.* Golden Horde Review vol.4

[4] "See also", Makabe, K. (2017) *Law in Mongol and Post Mongol World.* China Review International. vol.23. p.108

[5] Code of medieval Mongolia (enacted in 1709)

[6] "See also", Narangerel, S. (2001) *Historical Overview of Mongolian Law., &* Batbayar, B., Sukhbaatar, Z., & Oyundelger, P. (2012) *History of Mongolian Civil Law;* Nyamsuren, Ch. (1998) *Theory of law*

[7] "See also", Antonio, S. (2017) A History of Law in Europe. Cambridge University Press. p.457

Civil law was a key component and an individual branch of legal study in Mongolia. As in most countries, civil law has been widely used in legal practice, so it is more developed than other branches of law.

After the victory of the Mongolian People's Revolution and Independence legal reforms began in Mongolia. Following the adoption of the first Constitution in 1924, the Civil Code was one of the enacted new laws.

The first Civil Code of Mongolia was enacted and published in 1926 under the title "Compendium of Laws and Rules to be obeyed by the People." The code was the first unified law in the history of Mongolia and it brought great progress in legal science and people's social life. The Code was amended several times until 1929.

"The earliest Civil Code was drafted based on Mongolia's economic and cultural level, people's life habits, traditional morals and mentality, and no foreign laws were copied. The law was drafted through public consultation and reflection." (MunkhJargal, T. 2004. *Legal Regulation of Economic Relations.* p.47*)*

In point of view, the fundamental Civil Code was not directly copied from the Model law of any country at that time, but it was required study and compare due to the type of codification never been enacted before.[8]

"The purpose of the 1926 Civil Code was to regulate the legal relationships of arose during the life of a citizen and consisted of 10 chapters and 217 articles." (Batbayar, B., Sukhbaatar, Z., & Oyundelger, P. 2012. *History of Mongolian Civil Law.* p.15)

Scope of the first Civil Code was including provisions of social welfare, civil registration, lost property, grounds for declaring dead or missing, inheritance, family rights and obligations, company formation, property rights, debt settlement, collateral, inter-citizen agreements, and contractual obligations, the statute of limitations for civil disputes.[9]

As well provided an opportunity to change the previous feudal social market communication, to create equality of contract law, to eliminate family and cultural backwardness, and to modify the form and content of legislation.

On the other hand, the code was used for political purposes to punish the unequal distribution of wealth at the time and distribute the wealth of the

[8] By the order of the Mongolian Bogd Khan Jurists was studying and inspiring western law since 1911.
"See details", Amarsanaa, J. (2013), *Comparative Law.* p.51
[9] Civil Code, chapter.4. SGA, MGL. (1929)

bourgeoisie to the poor. This is because the law aims to make property rights and obligations as equal as possible.[10]

The Civil Code was the earliest law to create an equal distribution of wealth in social and economic life and to regulate the rights and obligations in civil law relations.

It was the fundamental code to regulate relationships with property, commerce, company, family, and contract law in the private law sector. Furthermore, it guarantees the right to attend toward the court via settling debts arising from civil relations and provided legal coordination for the pledge of property and the conclusion of contracts.

The first Civil Code was in force until 1952 when the next Civil Code was passed. The following Civil Code (1952), historically known as the socialist-style law, had 29 chapters and 319 articles.[11]

Under the law, property rights of citizens and legal entities, contractual obligations, the limitation period for claims, collateral, lease of property, the performance of work under contract, legal assurance, storage and insurance, tenancy contracts, and responsibility of damage to property. Also, the first regulation was ratified that of copyright and the right to inherit inventions. The enactment of an independent law on civil procedure, accompanied by the Civil Code, provided a legal basis for Civil Jurisdiction. These laws are aimed at strengthening the foundations of socialism in Mongolia and establishing socialist economic relations.

In 1963, the second Civil Code was re-enacted and a third new code with 13 chapters and 465 articles was passed. The specifics of this code are aimed at strengthening the socialist economic system, developing state property, and thus limiting the property rights of citizens. The law divides the property into two parts: the state and the public. (Munkhjargal, T. 2006. *History of Mongolian Civil law.* pp.180-185)

In other words, private ownership of property is prohibited by law. A citizen can only have personal the property.[12] Under 1963 Civil Code also aims to strengthen and develop the economy and socialist property of the socialist system, to move from a socialist to a communist system, and to meet the

[10] *Ibid.*
[11] Civil Code, art.38. SGA, MGL. (1952)
[12] Personal property includes items intended for trifle belongings, food, clothes, pocket money, and household.

material and spiritual needs of the people. It can be summed up as a process of redistribution of social wealth and private property.

The state and the law coexist and develop each other. Politics cannot exist without legal regulation, there can be no law without politics. The Civil Code of 1963 is a clear example of the government's policy of using the law to carry out economic reforms in society.

However, as for the 1963 Civil Code compared to the previous law, the structure, systematization, and legal codification have become more sophisticated. For example, the grounds for establishing a civil legal relationship, the legal capacity of a citizen or legal entity, its competence, agreement, power of attorney, the statute of limitations, and the obligations along with responsibilities of various contracts are well defined in detail.[13]

The 1963 Civil Code was amended in 1994. Structurally, it has 58 chapters and 436 articles and consists of property law, obligation law, inheritance law, and international civil law. This Code recognizes private property and provides for the transfer, possession, and use of the intellectual property.

“For the first time, the 1994 Civil Code included a brief provision that intellectual property may be used on a contractual basis. For example, an owner of intellectual property or a patent owner may allow others to use his work for a specific purpose.” (Civil Code, art.285. MGL. 1994)

Under this Civil Code, the subject of the contract for the use of intellectual property shall be the invention, rational proposal, product design, and trademark registered in the state registry. Fees and rewards for the use of intellectual property shall be agreed upon by the parties to the contract unless otherwise provided by law.

Besides, the parties shall specify the method, form, amount, scope, term, rights, duties, responsibilities, and other conditions provided by law for the use of the intellectual property.[14]

The Code has provided personal rights including to have property and non-property, enter into transactions, obtain inherited property and rights, bequeath, establish a legal entity, run a business without establishing a legal entity, and choose a place of residence, occupation. And opportunities fulfilled to engage in other activities not prohibited by law.

[13] “See also”, Munkhjargal, T. (2006) *History of Mongolian Civil law.* p.185
[14] Civil Code, art.285, 287. SGA, MGL. (1994)

Under the Code, it guaranteed the rights of a legal entity and defined it as a subject in civil legal relations.[15] Also, the Code regulated the legal capacity, registration, location and, representation of legal entities, business responsibilities, grounds for liquidation, and the legal status for companies, cooperatives, non-governmental organizations, religious organizations, and foundations. On the ground at the time, there was no company, bankruptcy laws.

Thereafter, the earliest Laws on Partnerships, Companies and Cooperatives in 1995, the Bankruptcy Law in 1997, and the revised Company Law were adopted in 1999. The 1999 Company Law governed the establishment, registration, and reorganization of a company, its management, control structure, shareholder rights and obligations, and the liquidation of a company.

Chapter 3 of the 1994 Civil Code was dealt with types of transactions, its legal validity, licenses, notaries and, stock exchange transactions, Chapter 4 represents citizens and legal entities, Chapter 5 and 6 coordinate with statute of limitations, forms of ownership, rights, and obligations of owners, movable and immovable property, securities, property of the family, other issues of the family law, and the right to own, possess, and use land. (Civil Code, Chapters. 3-6, MGL.1994)

The Family, Land, Securities, and the Notary Laws were not separated from than civil code at that time. Thereafter, were passed the first Securities and Land Laws in 1994, the Notary Law in 1997, and the Family Law in 1999.

The Family Law established procedures and conditions for marriage, divorce, annulment of marriage, property and non-property relations of family members, adoption of children, foster care, maintenance. The Law on Notaries defined the organization and principles, the legal status of notaries, and the legal basis for certifying transactions, property rights, and documents of a legal entity.

The Securities Law regulated the issuance, sale, trading, storage, payment, and settlement of securities, protection of investors' interests, and control over the activities of issuers and other participants in the securities market. And the Law on Land regulated land possession, use, and other related issues for citizens, business entities, and organizations.

Chapter 8 to 33 of the 1994 Civil Code was coordinating a contract of apartment ownership, public property, possessions of religious organizations,

[15] *Ibid, art.21*

property of foreign citizens and legal entities, guarantees of property rights, civil legal protection, the law of obligations, and all types of trade and employment agreements.

Although this code was enacted after the transformation of Mongolia's social structure, it was not able to meet modern codification requirements. Thus a legal tradition was being maintained since 1926 to the first legislation on civil law and its procedure came into force until 1998.

The age of Reforms (1998-present)

In 1998, the Parliament of Mongolia approved the Legal reform program.[16] The program has created the conditions for diversification of legislation, elimination of justice gaps, development of the private law sector, and the expansion of research by universities with private law departments.

Since the adoption of the Legal Reform Program in 1998 field laws enacted by Parliament such as Cooperatives, Bankruptcy, Labor Laws in 1999, Family Law in 2002, Civil Code in 2002, Bond, Advertisement, Land Privatization, and Arbitration Laws in 2003, Water Transport, Consumer Protection, Insurance laws in 2004, Copyright Law in 2006, Patent, Competition Laws in 2010, Law on Company in 2011, Law on Investment in 2013, Law on Standardization in 2018, The support of small and medium enterprises and services, Business Entity Income Tax Laws in 2019, Law on Intellectual property in 2020, Law on Trademarks and Geographical indications in 2021.[17]

With the enactment of these laws, the private legal sector has been reformed and become more sophisticated. Before the Legal reform Program, many relationships were regulated merely by the Civil Code. So these laws are called subdivisions of civil law of Mongolia.

The background of the Mongolian Civil Law has been a long history of oral and written law in early times, written and case law in the Middle Ages, and socialist and continental law since the 20th century. However, the former legal tradition has changed rapidly over the last 30 years or so.

> Since 1990, Mongolia has moved rapidly to establish the legislative framework necessary for a market economy. The basic elements- laws on property, the creation and winding-up of business entities, contracts, and a fair marketplace- are now in place, as well as laws governing more complex areas such as banking, securities, tax, and accounting.

[16] The Mongolian Government adopted the Legal Reform Program in 1998. This five-year strategy, developed with support from USAID and GTZ Germany
[17] "See details", legalinfo.mn

The Civil Code, which was enacted in 1994 contains provisions governing the transfer of ownership and draws a distinction between ownership and possession.[18]

The Business Entities Law was drafted hurriedly and was based on a conservative Hungarian law passed in 1988 during the early stages of that country's transition process. The new Law on Companies and Partnerships was based on a variety of European and North American models.

Under both the Business Entities Law and the Law on Companies and Partnerships, two types of company were and are permitted limited liability and joint-stock. The former resembles the German GmbH, the French SARL, or the British private company. The joint-stock company is the approximate equivalent of the German AG, the French SA, or the British public company. The new law introduces significant changes, simplifications, and improvements to the former regime. (Ross, C. 1995. *Developing Mongolia's Legal Framework: A Needs Analysis.* Asian Development Bank Report)

The establishment of a business in Mongolia by a foreign concern is covered by the Foreign Investment Law of 1993. Its stated purpose is the encouragement of foreign investment, the protection of the property of foreign investors, and the regulation of their operations. The law guarantees foreign investors no less fair treatment than that accorded to Mongolians.

The general law on the contract is found in the 1994 Civil Code. Apart from certain restrictions on the rights of minors and persons lacking capacity, all physical and legal persons have the right to enter into contracts. Although oral contracts may be valid, a large number of transactions will fall within the exceptions to this. For example, any contract between legal persons must be in writing and so must any contract to be performed in the future.

Consumer protection law gives the consumer the right to use quality products and services that comply with established standards. Producers must label goods or package with the quality, price, date of manufacture, and warranty period. Unfair Competition Law is designed to restrict state control over the competition of business entities in the marketplace and to regulate other activities impeding fair competition. (*Ibid*)

[18] “See details”, http://www.asianlii.org/asia/other/ADBLPRes/1995/1.html

One significant aspect of codification development was that nongovernmental organizations' role increases for drafting laws. For example in the context of legal Reform new family law was passed in 1999. Mongolian Women Lawyers' Association played an important role in its drafting.[19]

Since then, NGOs and citizens' representatives have been actively involved in drafting the law. The adoption of the Law on Legislation in 2015 confirmed the policy of incorporating public opinion into the law.[20]

> In Mongolia, since the new Constitution of 1992, more than five hundred laws have been adopted.[21] These laws have become the core of a complex regulatory regime of the newly emerging market economy. In 1998 the Parliament adopted the Legal Reform Program that is a strategic document and action plan for carrying out the reform. The program reflects the need for the next stage of legal reform and encompassed the conceptual policy of the Mongolian Government and Society as a whole. (Mongolia: *Legal Needs Assessment Report,* 2000. World Bank. p.14)

To my way of thinking, while it is good to pass many laws that are needed in society during the legal reform process, there is still a need to improve the quality rather than the quantity, and also it is needed to package and eliminate duplication of similar laws. In the future, it is important that the regulations are interconnected logically.

"In past years, there has been an increase in the number of laws and becoming tendency to change them in a short period of time." (Sociological Research Report on Legal Reform in Mongolia, 2006. Hanns-Seidel Stiftung. pp.53-60)

Following the Legal reform program (1998), Institutional reform of the Judiciary began in 2009 with the enactment of a set of laws on the Judiciary. However, this reform has not been implemented for a long time due to western court system is considered unsuitable for our country. As part of judicial reform, the number of judges and their salaries has been doubled.[22]

This suggests that judicial reform since 2009 has not been yet effective in improving civil law and capacity building of judges. But reform was mainly aimed at strengthening the criminal justice system and combating corruption and other organized crime.

---

[19] "See also", Sheldon, S. (1999) *Mongolia in 1998 and 1999,* Survey of Asia. vol.40. p.133
[20] Law on Legislation, art.38. MGL. (2015)
[21] Nowadays 798 laws in effect. "See details", https://legalinfo.mn/mn
[22] In 2021, a revised version of the Law on Courts of Mongolia was approved. As a result, the 2012 Judicial Package was repealed.

Exacerbating the problem is Mongolia's process for selecting judges. In other legal systems, judges come from the bar of practicing lawyers, and often have practical experience in commercial litigation. By contrast, the judiciary in Mongolia is often a "career" position, meaning that many judges may rise from the ranks of judge's assistant with neither practical experience in commercial transactions nor an academic background in the subject matter. Judges have frequently voiced support for the idea of additional training in these areas.

The adjudication of commercial cases has taken on increasing importance as Mongolia continues along the path of strengthening its market economy. Efficient and fair enforcement of contracts is necessary for the functioning of any market economy.

The process of converting from a centrally-planned to a market-based economy is ongoing, and market-supporting institutions are not yet well developed. The legal system is not perceived to be an efficient arbiter of commercial disputes, and there are many problems where the law and commerce intersect. Contract enforcement, bankruptcy, alternative dispute resolution (ADR) secured transactions are areas largely neglected by Mongolia's system of legal education. (Jay, C. 2009. The Judicial Reform Program in Mongolia: *Accomplishments, Lessons Learned, and Recommendations for the Future.* Final Project Report. p.20)

In another view, the key to judicial reform is the education of judges, their ability to apply the law, and the speedy resolution of civil disputes. This is because, over the past 30 years, legal reform has not been considered in the narrow context of the legislation, the judiciary, or the education of lawyers.

The first phase of legal reform was the reformation of the Constitution and other laws. There also were independent analyses of the draft constitution by scholars and professors from the U.S. and Germany. The next aspect of stage-one reforms was the rewriting of the legal code to create appropriate rules that govern newly created market based relationships. Mongolians had basic necessities, for legal reforms to be successful, any arising social concerns in a transition must also be countered. The goal of rule of law[23] initially must be the achievement of the minimalist requirements.

[23] A set of principles, or ideals, for ensuring an orderly and just society. "See details", https://www.americanbar.org

However, the rule of law reform should be valued by its fundamental effects arising from its definition, as well as its peripheral effects primarily social progress. Having discussed both the elements of a procedurally minimalist rule of law and the judgment methodology, the actual consummation of the rule of law reform program is the critical problem for post-Socialist or transitional states.

